



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ
ШҮҮХИЙН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

**СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН
ЭМХЭТГЭЛ
(2018 ОН)**



УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

**JUDICIAL GENERAL COUNCIL
JUDICIAL RESEARCH, INFORMATION AND TRAINING INSTITUTE**



ULAANBAATAR, MONGOLIA
2019

DDC
363.251001 42
C-701

ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН:

- О.Амгаланбаатар Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга
- Ц.Мандах Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн захирал, хууль зүйн ухааны доктор /LL.D/
- Б.Отгон Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн ахлах референт

ЭМХЭТГЭСЭН:

- Ч.Содхүү Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судлаач-багш

СУДАЛГААНЫ БАГИЙН ГИШҮҮД:

Судлаачид

- Ч.Содхүү
Л.Галбаатар
Б.Хонгорзул /LL.M/

Хамтран ажилласан судалгааны байгууллага:

- Улсын дээд шүүхийн Практик судлалын хэлтэс
Хууль зүйн үндэсний хүрээлэн



DDC
363.251001 42
C-701

EDITED BY

Amgalanbaatar O. Executive Secretary General, Judicial General Council
Mandakh Ts. Director, Judicial Research, Information and Training Institute /LL.D/
Otgon.B Senior Officer, Judicial Research, Information and Training Institute

COMPILED BY

Sodkhuu Ch. Researcher-Trainer, Judicial Research, Information and Training Institute



Researchers:

Sodkhuu Ch.
Galbaatar L.
Khongorzul B. /LL.M/

Involved research organizations:

Court Practice and Research Division of
the Supreme Court
National Legal Institute

ӨМНӨТГӨЛ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн нь бүх шатны шүүхийг судалгаа, мэдээллээр хангах, шүүн таслах ажлын болон захиргааны ажлын практикийг судлах, шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг сургаж дадлагажуулах хуульд заасан чиг үүргийг 2014 оны 4 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлж байна. Шүүхийн судалгааны чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд тус хүрээлэн нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн захиалгаар бодлогын судалгаа, шүүхийн практикийн судалгаа, лавлагаа, зөвлөмж боловсруулж, шүүгч, судлаач, олон нийтийн хүртээл болгодог.

Энэхүү эмхэтгэлээр 2018 онд тус хүрээлэнгээс бие дааж болон бусдаар гүйцэтгүүлсэн судалгааны бүтээгдэхүүнийг эмхэтгэн эрхэм шүүгч, шүүхийн захиргааны ажилтнууд, судлаач, хуульчид Та бүхэнд толилуулж байна.

Энэ удаа шүүн таслах ажиллагааны практик, тэр дундаа иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны практикт хамаарах судалгааг голлон эмхэтгэхийн зэрэгцээ шүүх судлал, шүүхийн эрх зүйн хүрээнд тулгамдсан зарим асуудалд голчлон чиглэсэн суадлгаа, лавлагааг эмхэтгэсэн болно. Түүнчлэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн захиалгаар хараат бус хөндлөнгийн судалгааны байгууллагаар шүүгчийн ажлын ачааллыг тооцох судалгааг анх удаа гүйцэтгүүлсэн бөгөөд энэхүү чухал судалгааны тайлангийн бүрэн эхийг энэ эмхэтгэлээр Та бүхний хүртээл болгож байна. Цаашид судалгааны нэр төрөл, агуулгыг чанаржуулж сайжруулах, судалгааны үр дүнг эргэлтэд оруулж, бодлогын шийдвэрт тусгах чиглэлээр цөөнгүй ажил хүлээж байгааг дурдах нь зүйтэй.

Эмхэтгэлд орсон судалгаа, лавлагаа, зөвлөмж зэрэг бүтээгдэхүүн нь энэ чиглэлээр шимтэн судалдаг хэн бүхний цаашдын судалгааны ажилд дэмжлэг болно гэж найдаж байна. Эмхэтгэлтэй танилцаж, судалсан Та бүхэн цаашид боловсронгуй болгох, сайжруулах тал дээр санал, зөвлөмж, шүүмжээ манай хаягаар ирүүлэхийг хүсье.

Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын
хүрээлэнгийн захирал, хууль зүйн ухааны доктор

Ц.Мандах

ГАРЧИГ

СУДАЛГАА	9
ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ШҮҮХ ХУРАЛДААН ХОЙШЛОХ БУЮУ УДААШИРЧ БУЙ ШАЛТГААН НӨХЦӨЛ	10
1. ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ХУГАЦАА	10
2. ШҮҮХ ХУРАЛДААН ХОЙШЛОХ ҮНДЭСЛЭЛ, АНГИЛАЛ.....	15
3. НЭГДСЭН ДҮГНЭЛТ	48
4. НЭГДСЭН САНАЛ.....	50
ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭР ШҮҮХИЙН ХЯНАЛТАД БАЙХ НЬ: ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ БОЛОН ЕРДИЙН ШҮҮХИЙН ХАРЬЯАЛЛЫН АСУУДАЛ	56
НЭГ. ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭР ШҮҮХИЙН ХЯНАЛТАД БАЙХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА	56
ХОЁР.ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ХҮРЭЭ БА ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭР.....	59
ГУРАВ.ДҮГНЭЛТ.....	69
ДӨРӨВ.САНАЛ	70
ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ ЗӨРЧСӨН ГЭХ ҮНДЭСЛЭЛЭЭР УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНААР ШИЙДВЭР, МАГАДЛАЛЫГ ХҮЧИНГҮЙ БОЛГОЖ, ХЭРГИЙГ ДАХИН ХЭЛЭЛЦҮҮЛЭХЭЭР АНХАН, ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХЭД 2015-2017 ОНД БУЦААСАН ИРГЭНИЙ ХЭРГИЙН СУДАЛГАА.....	72
НЭГ.УЛСЫН ХЭМЖЭЭНД ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ИРГЭНИЙ ХЭРГИЙН ЕРӨНХИЙ ТООН ҮЗҮҮЛЭЛТ.....	72
ХОЁР.ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХЭЭС ШИЙДВЭР, МАГАДЛАЛЫГ ХҮЧИНГҮЙ БОЛГОЖ, ХЭРГИЙГ ДАХИН ХЯНАН ШИЙДВЭРЛҮҮЛЭХЭЭР БУЦААСАН ХЭРЭГ	73
ГУРАВ.ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХЭЭС ШИЙДВЭР, МАГАДЛАЛЫГ ХҮЧИНГҮЙ БОЛГОЖ, ХЭРГИЙГ ДАХИН ХЯНАН ШИЙДВЭРЛҮҮЛЭХЭЭР БУЦААСАН ҮНДЭСЛЭЛ:.....	74
ДҮГНЭЛТ	76
ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАААНД ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ НЭВТРҮҮЛЭХ НЬ	81

УДИРТГАЛ.....	81
НЭГ. ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ТУЛГАРЧ БУЙ АСУУДАЛ	81
ХОЁР. ГАДААД ОРНУУДЫН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ.....	85
ГУРАВ. ДҮГНЭЛТ.....	87
ДӨРӨВ. САНАЛ.....	88
ШҮҮГЧИЙН АЖЛЫН АЧААЛАЛ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН	90
УДИРТГАЛ.....	90
НЭГ.ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХИЙН АЖЛЫН АЧААЛАЛ.....	95
ХОЁР.ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН АЖЛЫН АЧААЛАЛ	113
ГУРАВ.ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН АЖЛЫН АЧААЛАЛ.....	136
ДӨРӨВ.ДҮГНЭЛТ, САНАЛ.....	157
ХАВСРАЛТ.АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ОРОН ТОО, АЖЛЫН НОРМАТИВЫГ ХАНГАХ НЬ:.....	168
ЛАВЛАГАА	182
ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ШҮҮГЧ ӨӨРИЙН ДОТООД ИТГЭЛ ҮНЭМШЛИЙГ ТАЛУУДАД ИЛ БОЛГОХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА: ЯПОН УЛСЫН ЖИШЭЭН ДЭЭР.....	183
Оршил	183
Хоёр. Шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлийг талуудад ил болгохын ач холбогдол.....	184
Гурав. Шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлийг талуудад ил болгоход анхаарах зүйлс.....	185
Дөрөв. Монгол Улсын нөхцөл байдал.....	185
Дүгнэлт	187
ШҮҮГЧИЙГ ТОМИЛОЛТООР АЖИЛЛУУЛАХ ЗОРИЛГО, НӨХЦӨЛИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЭХ СУРВАЛЖ, СТАНДАРТ БОЛОН БУСАД УЛСЫН ТУРШЛАГА...	189
Нэг.Шүүхийн бие даасан байдлын тухай НҮБ-ын 1985 оны зарчим	189
Хоёр. Европын шүүхийн зөвлөлийн сүлжээний зөвлөмж /ENCJ/.....	190
Гурав.Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн зөвлөмж /CCEJ/	190

Дөрөв.Гадаадын зарим улс дахь шүүгчийг томилолтоор ажиллуулах зохицуулалт	191
ХОЁР. ЯПОН УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БОЛОН ОНОЛЫН ТАЙЛБАР	195
ГУРАВ. ДҮГНЭЛТ	198
“БАРЬЦАА АВАХ” ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ОНЦЛОГ	199
Нэг. Монгол Улсын эрх зүйн зохицуулалт, уламжлал.....	199
Хоёр.Гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт, онцлог.....	201
Гурав.Дүгнэлт	204
Дөрөв.Санал	206
ТӨРИЙН АЛБАН ХААГЧ АЖИЛ, АЛБАН ТУШААЛААС ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР ЧӨЛӨӨЛӨГДСӨНТЭЙ ХОЛБООТОЙ ХОХИРОЛ УЧИРСАН БАЙДАЛ.....	207



СУДАЛГАА



ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ШҮҮХ ХУРАЛДААН ХОЙШЛОХ БУЮУ УДААШИРЧ БУЙ ШАЛТГААН НӨХЦӨЛ¹

1. ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ХУГАЦАА

1.1. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааны тухай

Шүүн таслах ажиллагааны зорилт нь иргэний хэргийг хуулиар тогтоосон цаг хугацаанд нь зөв шийдвэрлэх явдал юм. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн /цаашид ИХШХШтХ гэх/ 71 дүгээр зүйлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг тодорхой заасан ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуульд заасан хугацаанд явагдах учиртай юм.² Ийнхүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг хуулиар тогтоосон нь хэргийг түргэн шуурхай хянан шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлдэг.

Иргэний хэргийг шийдвэрлэхэд зайлшгүй дагаж баримтлах, шүүх болон хэргийн оролцогчдоос тодорхой үйл ажиллагаа гүйцэтгэх ба гүйцэтгэж болох цаг хугацааны үеийг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа гэнэ.³

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг:

- хуулиар тогтоосон;
- шүүхээс тогтоосон гэж ангилна.

Хуулиар тогтоосон хугацаа: ИХШХШтХ-аар тогтоож өгсөн, хэргийн оролцогчдын хүсэл зоригоос үл хамаардаг хугацаа юм.⁴ Үүнд, ИХШХШтХ-ийн 66, 119, 163, 166.2, 170, 173.2, 174 дүгээр зүйлүүд хамаарна.

Хуулиар тогтоосон хугацаа нь шүүх нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс эхлээд шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх шүүгчийн захирамж гарах хүртэлх хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон бүхий л ажиллагааг хамарсан байдаг.⁵ Өөрөөр хэлбэл хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоногийн, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор шүүх иргэний хэргийг шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх хугацааг шүүгчдийн зөвлөгөөнөөс ИХШХШтХ-ийн 71 дүгээр зүйлд зааснаар сунгасан бол энэхүү сунгасан хугацаанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгох ёстой.⁶

¹ Тус судалгааг Шүүхийн ерөнхий зөвлөлийн захиалгаар Хууль зүйн үндэсний хүрээлэн гүйцэтгэв.

² Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, Монгол Улсын дээд шүүх, УБ., 2014 он, 202 дахь тал.

³ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй гарын авлага, УБ., 2007 он, 41 дэх тал.

⁴ Д.Хуяг, "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа", "Хууль дээдлэх ёс" сэтгүүл, УБ., 2010 он, цуврал 29, Дугаар 2, 25 дахь тал.

⁵ "Шүүгчийн гарын авлага", Эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэх онол, арга зүй, УБ., 2004 он, 189 дэх тал.

⁶ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, Монгол Улсын дээд шүүх, УБ., 2014 он, 233 дахь тал.

Харин хуулиар тогтоох боломжгүй зарим хугацааг шүүхээс тогтоож өгдөг. Тухайлбал, шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ерөнхий хугацааны дотор өөрийн санаачилгаараа хуулиар тодорхой хугацаа заагаагүй ажиллагаанд хугацаа тогтоож буй зохицуулалтыг хэлнэ.⁷ Үүнд:

- шинжээчийн дүгнэлт гаргуулах;
- нотлох баримт албадан гаргуулахаар үүрэг өгөх;
- шүүх хуралдааныг хойшлуулж, хуралдаан болох товыг шинээр тогтоох;
- туршилт, үзлэг хийх, таньж олуулах ажиллагаа явуулах хугацааг тогтоох;
- хилийн чанадад болон өөр орон нутагт нотлох баримт бүрдүүлэх ажиллагаа явуулахаар зохих байгууллагад хугацаатай даалгавар өгөх;
- шүүхийн зардлыг нөхөн төлүүлэх, хойшлуулах, хэсэгчлэн төлүүлэхээр хугацааг заах зэрэг болно.

Энэхүү процесс ажиллагааг ИХШХШТХ болон Улсын дээд шүүхээс гаргасан тайлбарт дараах байдлаар тусгажээ.

Хүснэгт 1

Хуулийн зүйл заалт	Тайлбарт
<p>71.1. Хуулиар өөр хугацаа тогтоогоогүй бол хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоног, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ.</p>	<p>Хуулийн 76.1.1-д “энэ хуулийн 71.1-д заасан хугацаа дууссан бол...хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамж гаргана” гэж заажээ. Зарим тохиолдолд шүүх хуулийн 71 дүгээр зүйлд заасан хугацаа дууссан байхад шүүх хуралдааныг хойшлуулах замаар хэрэг хянан шийдвэрлэх хугацааг сунгасан гэж үздэг нь алдаатай юм. Шүүх хуралдаан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн хэсгийн нэг болохын хувьд хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх хугацааны дотор хийгдэх ёстой.</p> <p>Иргэний хэрэг хянан шийдвэрлэх хугацааг бусад хуульд өөрөөр заасан тохиолдолд л энэ хуульд заасан хугацааг баримтлахгүй байх боломж үүснэ.</p> <p>Энэ хэсэгт заасан хугацаа нь хэрэг хянан шийдвэрлэх дээд хугацаа юм. Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримт хангалттай бүрдсэн гэж үзвэл шүүгч иргэний хэрэг үүсгэснээс хойш 60 хоногийн дотор хэзээ ч шүүх хуралдааныг товлох эрхтэй. Гагцхүү шүүгчийн энэ ажиллагаа хэргийн оролцогчийн эрхийг зөрчөөгүй, тэдгээрийн мэтгэлцэх боломж бүрэн дүүрэн хангагдсан байх учиртай.</p>
<p>71.2. Энэ хуулийн 71.1-д заасан хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.</p>	<p>Хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх хугацааг тухайн шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөн 30 хүртэл хоногоор сунгаж болно.</p> <p>Шүүгчийн зөвлөгөөн нь хэрэг ямар учир шалтгаанаар хугацаандаа шийдвэрлэгдэх боломжгүй болсон, цаашид ямар ажиллагаа хийгдэх шаардлагатай байгааг судлан үзэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэд хоногоор сунгахыг тухай бүрт шийдвэрлэнэ. Тухайн хэргийн онцлог, учир шалтгааныг нарийвчлан судлалгүй, ёс төдий хандаж, хэрэг хянан шийдвэрлэх хугацааг шууд 30 хоногоор</p>

⁷ ИХШХШТХ-ийн 71 дүгээр зүйлийн 71.3.

	сунгадаг зохисгүй практик тогтоосныг шүүхүүд анхаарах нь зүйтэй.
71.3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусад хугацааг энэ хуулийн 71.1- д заасан хугацааны дотор шүүх тогтоож болно.	<p>Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа тус бүрийг ямар хугацаанд явуулахыг шүүх тогтоож болдог. Харин тухайн ажиллагааг явуулах хугацааг хуульд шууд заасан бөгөөд хугацаа тогтоох эрх шүүхэд хуулиар олгогдоогүй бол энэхүү ажиллагаа хуульд заасан хугацаанд явагдах ёстой. Хуулиар тогтоосон хугацааг шүүх өөрөөр тогтоох боломжгүй юм.</p> <p>Харин хуульд зөвхөн дээд хугацааг заасан бол тэр хугацааны дотор, түүнийг хэтрүүлэхгүйгээр ажиллагаагаа явуулах үүрэгтэй. Хэрвээ хуульд доод хугацааг заасан бол тэр хугацааг өнгөрсний дараа ажиллагаагаа явуулах ёстой болно.</p> <p>Хэргийн оролцогчид зориулсан хугацааг хуульд заасан эрхийн дагуу шүүх өөрчлөн тогтоож байгаа бол хуульд заасан хугацааг хязгаарлах үндэсгүй юм.</p>

Бусад орны туршлагаас үзвэл ОХУ-ын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд иргэний хэргийг шүүхээр шийдвэрлүүлэх тухай хүсэлт ирсэн бол түүнийг хүлээн авсан өдрөөс хойш 2 сарын дотор шийдвэрлэх бөгөөд ажилд буцаан авах, тэтгэвэр, тэтгэмж тогтоолгохоор ирүүлсэн хүсэлтийг хүлээн авснаас хойш 1 сарын дотор шийдвэрлэнэ гэж маргааныг зааг ялгаатайгаар шийдвэрлэх хугацааг хуульчилж өгсөн байна.⁸

Мөн шүүх оролцогч талуудын аль нэг нь шүүх хуралдаанд ирээгүйгээс хурлыг хийх боломжгүй гэж үзсэн эсхүл талуудын аль нэг нь сөрөг нэхэмжлэл гаргасан, нэмэлт нотлох баримт гарган өгсөн, нэмэлт нотлох баримт бусдаас гаргуулахыг шаардсан тохиолдолд талуудын хүсэлтээр шүүн таслах ажиллагааг 60 хүртэл хоногийн хугацаагаар сунгаж болохоор заасан байна.⁹

1.2. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх хугацааг тооцох нь

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг хуанлийн он, сар, өдөр, гаригаар буюу жил, улирал, сар, долоо хоног, хоног, цагаар тодорхойлно. Мөн хугацааг зайлшгүй бий болох үйл явдлаар тодорхойлж болно.¹⁰ Тухайлбал, хэргийн оролцогчийн аль нэг талын өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүх хуралдаанд оролцох боломжгүй гэдгээ мэдэгдэж, шүүх хуралдааныг хойшлуулах хүсэлт гаргасан байна. Шүүх хүсэлтийг хүлээн авах үндэслэлтэй гэж үзвэл шүүх хуралдааныг хойшлуулж хуралдааны товыг шинээр тогтооно.

Хугацааг эхэлсэнд тооцох:

- түүнийг тогтоосон он, сар, өдрөөс;
- үйл явдал эхлэх үеэс;
- үйл явдал болж өнгөрсний дараах өдөр, цагаас.

⁸ Гражданский процессуальный кодекс Российской Федерации, Статья 154.1, 154.2.

⁹ Гражданский процессуальный кодекс Российской Федерации, Статья 169.1.

¹⁰ Иргэний хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1, 71.2.

Хугацааг дууссанд тооцох:¹¹

- тоолох хугацааны эцсийн өдөр ажлын бус өдөр байвал түүний дараагийн өдрөөр;
- үүрэг гүйцэтгэхийн тулд хугацаа тогтоосон бол уг хугацааны эцсийн өдрийн 24 цагийн дотор;
- үүргийг ямар нэг байгууллага гүйцэтгэх ёстой байсан бол зохих журмаар тогтоосон уг байгууллагын ажлын өдөр буюу үйлдвэрлэлийн ажиллагаа дуусах эцсийн цагийн дотор;
- баримт бичгийг тогтоосон хугацааны эцсийн өдрийн 24 цагийн дотор шуудан, харилцаа холбооны байгууллагад шилжүүлсэнээр;
- хугацааг сунгах тохиолдолд хугацаа дууссан үеэс шинэ хугацааг эхлэн тоолсноор.

Дээрх зохицуулалттай адил байдлаар Оросын Холбооны Улсын Иргэний процессын хуулийн 107, 108 дугаар зүйлд хэрэг хянан шийдвэрлэх хугацааг тоолох журам, хугацаа дуусгавар болох зохицуулалтыг тусгасан.¹² Тодруулбал иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуулиар тогтоосон хугацаанд явуулна. Хэрэв хуулиар хугацаа тогтоогоогүй бол шүүх нөхцөл байдлыг харгалзан хугацааг тогтоохоор заасан нь манай ИХШХШТХ-ийн зохицуулалттай ижил байна.

Мөн энэхүү процесс ажиллагааг ИХШХШТХ болон Улсын дээд шүүхээс гаргасан тайлбарт дараах байдлаар тусгажээ.

Хүснэгт 2

Хуулийн зүйл заалт	Тайлбарт
71.4. Хугацаа тоолох, тодорхойлоход Иргэний хуульд заасан журмыг хэрэглэнэ.	Иргэний хэрэг хянан шийдвэрлэх хугацааг тоолох, тодорхойлоход Иргэний хуульд заасан журмыг баримтлана. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуульд заасан хугацааг хэргийн оролцогч өнгөрүүлсэн явдал нь хүндэтгэн үзэх шалтгаантай бөгөөд тухайн хугацаагаар түүний эрх хязгаарлагдсан байдал тогтоогдвол шүүх эрхийн хугацааг сэргээх шаардлага гардаг. Энэ тохиолдолд шүүх энэ зүйлийн 71.4, Иргэний хуулийн 82.4-т заасныг баримтлан асуудлыг шийдвэрлэнэ. Мөн энэ тохиолдолд энэ хуулийн 10.4-т заасныг баримтлах боломжтой.

Гадаад орны туршлагаас үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг талууд өөрсдөө тогтоох, эсхүл хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан шүүх тогтоодог, мөн хуулиар тусгайлан тогтоож өгдөг жишиг түгээмэл байна.¹³ Тухайлбал, ОХУ-ын хуульд зааснаар шүүхээс тогтоосон, эсхүл хуульд заасан

¹¹ Иргэний хуулийн 71 дүгээр зүйл.

¹² Гражданский процессуальный кодекс Российской Федерации Статья 107, 108.

¹³ Б.Хишигбаатар, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа, практик хэрэглээ, Шүүх эрх мэдэл эмхэтгэл, УБ., 2017 он, Дугаар 3, 117 дахь тал.

хугацаа дууссанаас хойш гаргаж өгсөн аливаа баримтыг шүүх үнэлдэггүй, нотолгооны чадвараа алддаг ба хэрэв хэргийн оролцогчид уг хугацааг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх хүсэлт гаргах замаар мэтгэлцэх эрхээ хэрэгжүүлэх боломжтой талаар хуульчилжээ.¹⁴

1.3. Шүүх хуралдаан хойшлох тухай

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад түгээмэл тохиолддог процесс ажиллагаа нь шүүх хуралдааныг хойшлуулахтай холбоотой зохигчдын гаргасан хүсэлтийг шийдвэрлэх ажиллагаа байдаг.

Шүүх хуралдааныг хойшлуулахтай холбоотой үндэслэлийг дараах байдлаар авч үзэж болох юм.¹⁵ Үүнд:

- шүүх шаардлагатай гэж үзэн шүүх хуралдааныг хойшлуулах /ИХШХШТХ-ийн 27.3, 76.1.2, 77.9, 97.1 дэх заалтууд/;
- хуульд шүүх хуралдааныг хойшлуулахаар заасан байх /ИХШХШТХ-ийн 38.9, 90.5, 100.8, 105.2, 123.3, 131.2 дахь заалтууд/;
- зохигчдын хүсэлтээр шүүх хуралдааныг хойшлуулах /ИХШХШТХ-ийн 25.1.3, 105.1, 123.3, 170.1 дэх заалтууд/;
- шүүх хуралдаан хойшлох үндэслэл болохгүй /145.4, 146.4, 148.2, 1551.3 дахь заалтууд/.

Хуульд шүүх хуралдааныг хойшлуулахаар заасан заалтууд нь практикт бүрэн хэрэгжихгүй байх магадлалтай. Тухайлбал, ИХШХШТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.9 дэх хэсэгт “шүүх хуралдааны үед шинээр нотлох баримт шаардагдвал шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулах” эрхийг шүүхэд өгсөн. Уг заалт нь ИХШХШТХ-ийн 105 дугаар зүйлийн 105.2 дахь заалттай хэрхэн уялдаж байгаа эсэх, аль тохиолдолд 38 дугаар зүйлийн 38.9 дэх заалт, аль тохиолдолд 105 дугаар зүйлийн 105.2 дахь заалтыг хэрэглэх эсэх нь эргэлзээтэй байдаг.¹⁶

Мөн шүүгч иргэний хэрэг үүсгэсний дараа зохигч, тэдгээрийн өмгөөлөгч, төлөөлөгч гуравдагч этгээдэд эрх үүргийг нь танилцуулахаар хуульчилсан байна.

Шүүгч хэргийн ачааллаас шалтгаалан (ялангуяа дүүргийн шүүгч нар маш их ачаалалтай ажилладаг) тухай бүр хэргийн оролцогч нарт эрх үүрэг тайлбарлах боломжгүй, нөгөөтээгүүр эрх үүргээ тайлбарлуулах шалтгаанаар хэргийн оролцогч шүүгчтэй уулзах, харилцах, хэргийн талаар хандлага авах нөхцөл бүрддэг.¹⁷

Дээрхээс үзэхэд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуульд заасан хугацаанд явагдахгүй байгаа нь үндсэн зарчим болон хуулийн зохицуулалт нь хоорондоо уялдаагүй, хэргийн оролцогчид эрх зүйн боловсрол муу, шүүхийн

¹⁴ Мөн тэнд.


¹⁵ Т.Энхтуяа, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шүүх хуралдааныг хойшлуулахтай холбоотой зохицуулалт”, Монголын төр, эрх зүй сэтгүүл. УБ., 2013 он, Дугаар 2, 37 дахь тал.

¹⁶ “ИХШХШТХ-ийн хэрэгжилт” хэлэлцүүлэг, 2016 оны 12 дугаар сарын 19 өдөр.

¹⁷ Мөн тэнд.

ачаалал ихтэй зэрэг маш олон шалтгаанаас хамаарч байна. Үүнээс үүдэн шүүх хуралдаан хойшилж байгаа нь энгийн үзэгдэл мэт болсон байна.

Судалгаанд хамрагдсан нийслэлийн 9 дүүрэг, орон нутаг дахь 20 аймгийн Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн 180 шүүгчээс тэдний шийдвэрлэж байсан болон шийдвэрлэж байгаа хэрэг маргаанаас дунджаар нэг хэрэг хэдэн удаа хойшилж байгаа талаар асуулга авахад доорх үр дүн гарсан.



Дээрх үр дүнгээс харахад шүүх хуралдаан дунджаар 3-4 удаа тогтмол хойшилдог болох нь харагдаж байна.

2. ШҮҮХ ХУРАЛДААН ХОЙШЛОХ ҮНДЭСЛЭЛ, АНГИЛАЛ

Практикт шүүх хуралдааныг хойшлуулж байгаа үндэслэлийг хоёр бүлэгт ангилж болох юм. Үүнд:

- Хэргийн оролцогчийн хүсэлтээр;
- Шүүхийн санаачилгаар.

ИХШХШТХ-ийн 25, 26 дугаар зүйлд заасан хэргийн оролцогчийн эдлэх эрх, хүлээх үүрэг нь ИХШХШТХ-ийн 71, 166.2, 174 дүгээр заалтаар зохицуулсан хугацааны дотор багтах ёстой.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдыг 3 хэсэгт буюу шүүх, хэргийн оролцогч, шүүх хуралдаанд оролцогчид хэмээн ангилан авч үзнэ. Шүүх нь энэхүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч гол субъект ба түүний эрх мэдэл, хэрэгжүүлэх чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай хууль, ИХШХШТХ-д тодорхой зааж өгсөн.¹⁸

ИХШХШТХ-ийн 22 дугаар зүйлд “Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, түүнчлэн ИХШХШТХ-ийн 12.1.1-12.1.4 дүгээр зүйлд заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа этгээдийг

¹⁸ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, гарын авлага, УБ., 2007 он, 58 дахь тал.

хэргийн оролцогч” гэж заажээ.¹⁹ Дараах схемээр хэргийн оролцогчийн ангиллыг харуулав.



Судалгааны дүнд²⁰ шүүх хуралдаан хойшилж байгаа дараах нийтлэг үндэслэлүүд тодорхойлогдсон.

1. Хэргийн оролцогчдын хүсэлтээр:

- нэхэмжлэлийн шаардлага нэмсэн буюу өөрчилсөн;
- хэргийн материалтай танилцах хүсэлт гаргасан;
- гэрч, гуравдагч этгээд оролцуулах хүсэлт гаргасан;
- өмгөөлөгч авах, солих хүсэлт гаргасан;
- хүндэтгэн үзэх шалтгаан;
- шинжээч томилуулах хүсэлт гаргасан;
- нотлох баримт гаргуулах хүсэлт гаргасан;
- шүүгчээс татгалзах тухай хүсэлт гаргасан.

¹⁹ Шүүгчийн гарын авлага, Эрүүгийн байцаан шийтгэх болон Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудыг хэрэглэх онол арга зүй, УБ., 2004 он, 163 дахь тал.

²⁰ Нийслэлийн 9 дүүрэг, орон нутаг дахь 20 аймгийн Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн 180 шүүгчээс авсан анкетын судалгаа. /2018 он./



2. Шүүхийн санаачилгаар:

- Шүүх хуралдааны явцад шинээр нотлох баримт шаардагдвал шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулах /ИХШХШТХ-ийн 38.9 зүйл/;
- Зөрчлийн улмаас хэргийн оролцогч, гэрч, шинжээчийг шүүх хуралдааны танхимаас гаргасан тохиолдолд шүүх хуралдааныг хуралдаан даргалагчийн захирамжаар тодорхой хугацаагаар хойшлуулах /ИХШХШТХ-ийн 90.5 зүйл/;
- Хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдолтой нэмэлт тайлбар, нотлох баримтыг урьд нь гаргах буюу санал болгох бололцоотой байсан боловч шүүх хуралдааны үед гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаантай гэж шүүх үзвэл түүнийг хүлээн авч, шинжлэн судлах шаардлагатай гэж үзвэл шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулах /ИХШХШТХ-ийн 105.2 зүйл/;
- Гэрлэгчдийн хэн нэг нь хүндэтгэн үзэх шалтгаанаар ирээгүй бол шүүх хуралдааныг хойшлуулах /ИХШХШТХ-ийн 131.2 зүйл/;
- Хэргийн оролцогчид шүүх хуралдааны тов хүрээгүй тохиолдлоор шүүх хуралдаан хойшлох /ИХШХШТХ-ийн 76.1.2 зүйл/ зэрэг байна.



2.1. Хэргийн оролцогчдын хүсэлтээр шүүх хуралдаан хойшилж буй үндэслэл

2.1.1. Хүндэтгэн үзэх шалтгаан

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, зохигч, тэдгээрийн өмгөөлөгч, төлөөлөгч, гуравдагч этгээдийн зүгээс хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүх хуралдааныг түгээмэл хойшлуулдаг.

Шүүх хуралдаан хойшлуулах хүндэтгэн үзэх шалтгаан /reasonable excuse, justifiable important reason/ гэдэг нь хэргийн зохигчоос гаргасан санал нь хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой, шүүх хуралдааныг хойшлуулах зайлшгүй нөхцөл болсныг ойлгоно. Үүнд:

- Хүндээр өвчилсөн;
- Өвчтэй хүн асарсан;
- Албан томилолтоор гадаад ба дотоодод ажлаар явсан;
- Сургалтад хамрагдсан;
- Хорио цээр тогтоогдсон;
- Байгалийн гамшиг тохиолдсон;
- Гэнэтийн осолд орсон эдгээртэй адилхан үзэх бусад нөхцөл байдлыг хамааруулан үзнэ.²¹

Монгол Улсын хууль, тогтоомжуудад болон Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбарт “хүндэтгэн үзэх шалтгаан” гэдгийг хэрхэн тайлбарлан хэрэглэж байгааг авч үзье.

Д/д	Хууль, тогтоомж	Холбогдох зүйл заалт
1.	Иргэний хууль /2002 он/	<p>221.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал, эсхүл талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс гэрээний хугацааг үргэлжлүүлэх, сунгахыг шаардах боломжгүй нөхцөл байдлыг хүндэтгэн үзэх үндэслэл гэж үзнэ.</p> <p>294.2. Хүндэтгэн үзэх дараах шалтгаанаар талууд гэрээг цуцалж болно:</p> <p>294.2.1. нэг тал нь үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй гэм буруутай бол нөгөө талын санаачилгаар;</p> <p>294.2.2. хөлслүүлсэн сууцны талбай хөлслүүлэгчид өөрт нь буюу түүний ойрын төрөл төрөгсдөд хэрэгцээтэй болсон;</p> <p>294.2.3. хөлслүүлэгчийн санал болгосон зах зээлийн үнэд тохирсон нэмэгдэл хөлс төлөхөөс хөлслөгч татгалзсан;</p> <p>294.2.4. хуульд заасан бусад үндэслэл</p> <p>305.3. Дараах үндэслэлийг хүндэтгэн үзэх шалтгаан гэж үзэж болно:</p> <p>305.3.1. дамжуулан хөлслөгчийн хувийн байдлаас шалтгаалсан, эсхүл татгалзах ноцтой үндэслэл хөлслүүлэгчид байвал;</p> <p>305.3.2. орон сууцны талбайн ачаалал хэт ихэссэн;</p> <p>305.3.3. хууль буюу гэрээнд заасан бусад шалтгаан.</p>
2.	Татварын Ерөнхий хууль /2008 он/	<p>4.1.8. “хүндэтгэн үзэх шалтгаан” гэж:</p> <p>4.1.8.а. өвчтэй;</p> <p>4.1.8.б. эмчилгээ хийлгэж байгаа;</p> <p>4.1.8.в. өвчтөн асарсан;</p> <p>4.1.8.г. томилолтоор гадаад, дотоодод ажилласан;</p> <p>4.1.8.д. сургалтад хамрагдсан;</p> <p>4.1.8.е. нийтийг хамарсан дайчилгаанд хамрагдсан;</p>

²¹ С.Нарангэрэл, Монголын эрх зүйн эх толь бичиг. УБ., 2015 он, 575 дахь тал.

		<p>4.1.8.ё. нийтийг хамарсан аюулт халдварт өвчний улмаас хорио цээр тогтоосон бүсэд хоригдсон;</p> <p>4.1.8.ж. галын болон байгалийн гэнэтийн аюул, эсхүл давагдашгүй хүчин зүйл /усны үер, ган, зуд, аюултай цасан болон шороон шуурга, газар хөдлөлт/ зэрэг шалтгааныг.</p>
3.	Улсын дээд шүүхийн зөвлөмж	<p>"Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай" зөвлөмж /2.1/</p> <p>"хүндэтгэн үзэх шалтгаан" гэдэгт хариуцагчийн оршин суугаа шүүхэд очих боломжгүй, эсхүл хүндрэлтэй байгаа, нэхэмжлэгчийн эрүүл мэнд, эд хөрөнгө, цаг хугацаа болон бусад байдлаас шалтгаалсан бодит, тодорхой нөхцөлийг ойлгох нь зүйтэй.</p> <p>"Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" 33-р тогтоол /2006.07.03/</p> <p>Гомдол гаргагч хүндээр өвчилсөн, хорио цээрийн дэглэм тогтоогдсон, байгалийн болон нийтийг хамарсан гамшиг тохиолдсон зэрэг өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар гомдол гаргах боломжгүй байсан байдлыг ойлгоно.</p> <p>Давж заалдах шатны шүүх хуралдаан, иргэний хэргийг хянан хэлэлцэх давж заалдах шатны шүүхийн ажиллагааны онцлог</p> <p>Хүндэтгэн үзэх шалтгаан гэдэгт тухайн этгээдийг шүүх хуралдаанд оролцох боломжгүй болгосон бодит нөхцөл байдлыг хэлэх бөгөөд уг шалтгааныг хүндэтгэн үзэх эсэхийг шүүх тухай бүрт өөрөө шийдвэрлэх боловч энэ нь нотолгоо, баримтад үндэслэсэн эсэх, шүүхэд урьдчилан мэдэгдсэн эсэхээс шууд хамааралтай болохыг анхаарах нь зүйтэй.</p>
4.	Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Улсын дээд шүүхийн тогтоол/	<p>Уг хуулийн 129 дүгээр зүйлийн 129.3.-т заасан "хүндэтгэн үзэх шалтгаан" гэдэгт энэ зүйлд заасан хугацааны дотор гомдол гаргагч хүндээр өвчилсөн, хорио цээрийн дэглэм тогтоогдсон, байгалийн болон нийтийг хамарсан гамшиг тохиолдсон зэрэг өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар гомдол гаргах боломжгүй болсон байдлыг ойлгоно. Харин хууль мэдэхгүй явдал нь хүндэтгэн үзэх шалтгаан болохгүй.</p>
5.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Улсын дээд шүүхийн тогтоол/	<p>Уг хуулийн 38 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан "хүндэтгэн үзэх шалтгаан" гэж гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй, санал хураах байр, өдрийг зайлшгүй өөрчлөхөөс өөр аргагүй онцгой нөхцөл байдлыг хэлнэ.</p>
6.	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль /2003 он/	<p>Уг хуулийн 15.1.2.бараа, ажил, үйлчилгээний доголдлын талаар гарсан гомдлыг барагдуулах үед хүндэтгэн үзэх шалтгаан гарсан /нийтийг хамарсан хорио цээр/, худалдагч /үйлдвэрлэгч, гүйцэтгэгч/ өвдсөн, нас барсан, дампуурсан, татан буугдсан, тодорхой шалтгааны улмаас түүний үйл ажиллагаа түр болон бүрмөсөн зогссон тохиолдолд доголдлыг арилгах хугацааг хойшуулахаар хэрэглэгчтэй тохиролцох.</p>
7.	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Улсын дээд шүүхийн тогтоол/	<p>Уг хуулийн 23 дугаар зүйлийн 23.8-д заасан "...хүндэтгэн үзэх шалтгаан..." гэдэгт эрүүл мэндийн байдал, албан томилолтоор явсан, ар гэрт нь гачигдал гарсан, хорио цээрийн дэглэм тогтоогдсон, байгалийн болон нийтийг хамарсан бусад гамшиг тохиолдсон зэрэг хувь хүнээс өөрөөс нь үл хамаарах нөхцөл байдлыг ойлгоно.</p>

Тэгвэл ИХШХШТХ-д “Хүндэтгэн үзэх шалтгаан” гэснийг Улсын дээд шүүхийн тайлбарт дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Хүндэтгэн үзэх шалтгаан гэдэгт зохигч өвчтэй байх, Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадуур байсан, эсхүл гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл нөлөөлсөн гэх мэт хугацаа алдах зайлшгүй, эсхүл харгалзан үзэж болох нөхцөл бүрдсэн байхыг ойлгоно. Хүндэтгэн үзэх шалтгааныг урьдчилан тодорхойлох боломжгүй тул тухай бүрт шүүх өөрийн итгэл үнэмшилд тулгуурлан асуудлыг шийдвэрлэнэ. Харин хугацаа хэтрүүлсэн этгээд энэхүү хэтрүүлсний учир шалтгааныг нотлох баримтыг шүүхэд гаргаж өгөх үүрэгтэй. Нотолгоо баримтгүй хүсэлтийг хангах үндэслэлгүй болно.²²
- Хүндэтгэн үзэх шалтгаан гэдэгт нэхэмжлэгч өөрөө хүнд өвчтэй, эсхүл жирэмсэн, ахуй амьдралын хувьд амьжиргааны доод түвшингийн хэмжээнээс доогуур орлоготой, нэн ядуу болон бусад шалтгааны улмаас хариуцагчийн оршин суугаа шүүхэд очих боломжгүй байгаа тохиолдлыг хамааруулан ойлгоно.²³
- Хүндэтгэн үзэх шалтгаан гэдэг нь шүүх хуралдаанд хүрэлцэн ирэх боломжгүй нөхцөл байдал бий болсон байхыг ойлгох бөгөөд хуралдаан эхлэхээс өмнө урьдчилан мэдэгдэх учиртай. Ийнхүү хүндэтгэн үзэх шалтгаантай байгаа тухайгаа мэдэгдэж, хуралдаанд биечлэн оролцох хүсэлтээ илэрхийлсэн тохиолдолд хуралдааныг хойшлуулж болно.²⁴

Хүндэтгэн үзэх шалтгаан нь хэргийн оролцогчдын хүсэл зоригоос үл хамаарсан шинжтэй нөхцөл байдал бий болсныг ойлгох ба урьдчилан мэдэх боломжгүй зайлшгүй шинжийг илэрхийлж байгаа ерөнхий ойлголт хэмээн дээрхээс дүгнэж болох юм.

Зайлшгүй шинжид:

- Өвчтэй байх;
- Албан томилолтоор явсан;
- Ар гэрт нь гачигдал гарсан;
- Хорио цээрийн дэглэм тогтоогдсон;
- Байгалийн болон нийтийг хамарсан бусад гамшиг тохиолдсон;
- Сургалтад хамрагдсан гэж нийтлэг байдлаар тодорхойлж байна.

Нийслэлийн 9 дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хэмжээнд дээрх шалтгаанаар шүүх хуралдаан хойшилсон шүүгчийн захирамжийг 2013-2017 оны байдлаар шүүхийн статистик мэдээллээс нэгтгэн харвал /давхардсан тоогоор/:

²² ИХШХШТХ-ийн 120.3 дугаар зүйл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, Монгол Улсын дээд шүүх, УБ., 2014 он, 321 дэх тал.


²³ ИХШХШТХ-ийн 126.2 дугаар зүйл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, Монгол Улсын дээд шүүх, УБ., 2014 он, 330 дахь тал.

²⁴ ИХШХШТХ-ийн 148.2 дугаар зүйл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, Монгол Улсын дээд шүүх, УБ., 2014 он, 368 дахь тал.



- Нийслэлийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2013-2014 оны шүүх хуралдаан хойшилсон шүүгчийн 1000 захирамжтай танилцахад 2013 онд 387, 2014 онд 117 хэрэг маргаан хүндэтгэн үзэх гэсэн үндэслэлээр;²⁵
- 2015 онд нийт 28021 хэрэг, маргаан хойшилсноос 743 буюу 2.7 хувь нь хүндэтгэн үзэх гэсэн үндэслэлээр
- 2016 онд нийт 18125 хэрэг, маргаан хойшилсноос 2198 буюу 12.1 хувь нь хүндэтгэн үзэх гэсэн үндэслэлээр
- 2017 онд нийт 20586 хэрэг, маргаан хойшилсноос 2266 буюу 11 хувь нь хүндэтгэн үзэх гэсэн үндэслэлээр тус тус хойшилсон байна.

Орон нутаг дахь 20 аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хэмжээнд дээрх шалтгаанаар шүүх хуралдаан хойшилсон шүүгчийн захирамжийг 2013-2016 он, 2017 оны эхний хагас жилийн байдлаар шүүхийн статистик мэдээллээс нэгтгэн харвал: /давхардсан тоогоор/



- 2013 онд нийт 1652 хэрэг, маргаан хойшилсноос 557 буюу 33.7 хувь нь хүндэтгэн үзэх гэсэн үндэслэлээр;
- 2014 онд нийт 1950 хэрэг, маргаан хойшилсноос 512 буюу 26.2 хувь нь хүндэтгэн үзэх гэсэн үндэслэлээр;
- 2015 онд нийт 2917 хэрэг, маргаан хойшилсноос 974 буюу 33.4 хувь нь хүндэтгэн үзэх гэсэн үндэслэлээр;

²⁵ 2013-2014 оны дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн статистик мэдээллийг "Шүүхийн төрөлжсөн" архиваас шүүх хуралдаан хойшлуулсан 1000 шүүгчийн захирамжийг түүвэрлэн гаргасан болно.

- 2016 онд нийт 3351 хэрэг, маргаан хойшилсноос 742 буюу 22.1 хувь нь хүндэтгэн үзэх гэсэн үндэслэлээр;
- 2017 оны эхний хагаст нийт 1715 хэрэг, маргаан хойшилсноос 378 буюу 22 хувь нь хүндэтгэн үзэх гэсэн үндэслэлээр хойшилсон байна.

Судалгаагаар²⁶ шүүгчдийн зүгээс “хүндэтгэн үзэх шалтгаан”-ыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Өвчтэй /хэргийн зохигч, өмгөөлөгч, шүүх хуралдаан даргалагч/;
- Шүүх хуралдаан давхцах /өмнө нь товлогдсон тохиолдолд/;
- Байгалийн давагдашгүй нөхцөл, хорио цээр;
- Албан ёсоор зохион байгуулагдсан сургалт семинар;
- Ар гэрийн гачигдал;
- Албан томилолтоор явсан;
- Ээлжийн амралттай байх;
- Хэргийн оролцогчдыг заавал оролцуулах хүсэлт гаргасан;
- Иргэдийн төлөөлөгчдийг шүүх хуралдаанд оролцуулах хүсэлт гаргасан;
- Шинжээчийн дүгнэлт дахин гаргуулах;
- Нутаг орны алслагдсан байдал;
- Нотлох баримт гаргуулах зэргийг хүндэтгэн үзэх шалтгаан гэж ойлгодог гэсэн нийтлэг хариултыг өгчээ.

Тэгвэл өмгөөлөгчид “хүндэтгэн үзэх шалтгаан”-ыг тодорхойлохдоо ихэнх тохиолдолд практикт үүсдэг шалтгааныг тодорхойлон бичсэн байна. Дараах хүснэгтээс үзнэ үү.

Хүснэгт 3

№	Хүндэтгэн үзэх шалтгаанд	Тоо	Сонголтын хувь	Тохиолдлын хувь
1	Хурал давхардсан	27	29.3%	64.3%
2	Өвчтэй	35	38.0%	83.3%
3	Шүүх хуралдааны тов мэдэгдээгүй	3	3.3%	7.1%
4	Нотлох баримт гаргах	6	6.5%	14.3%
5	Гачигдал бий болсон	3	3.3%	7.1%
6	Албан томилолтоор явсан	8	8.7%	19.0%
7	Гэрч ирээгүй	1	1.1%	2.4%
8	Хэргийн материалтай танилцах	3	3.3%	7.1%
9	Өмгөөлөгч авах	4	4.3%	9.5%

²⁶ Нийслэлийн 9 дүүрэг, орон нутаг дахь 20 аймгийн Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн 180 шүүгчээс авсан анкетын судалгаа. /2018 он/

10	Хорио цээрт орсон	1	1.1%	2.4%
11	Танхим хүрэлцээгүй	1	1.1%	2.4%
Нийт		92	100.0%	219.0%

Анкетын судалгаанаас харахад Улсын дээд шүүхээс гаргасан ИХШХШТХ-ийн тайлбарт байснаас илүү өргөн утгаар хүндэтгэн үзэх шалтгааныг тодорхойлон хүсэлтийг шийдвэрлэн шүүх хуралдааныг хойшлуулж байна. Тухайлбал, нотлох баримт гаргах, өмгөөлөгчийн хурал давхацсан, өмгөөлөгч авах хүсэлт гаргасан, ээлжийн амралттай зэрэг үндэслэлүүд үүнд хамаарч байна.

Дүгнэлт

Хүндэтгэн үзэх шалтгаан гэдэг нь зайлшгүй, урьдчилан мэдэх боломжгүй, давагдашгүй шинжийг өөртөө агуулдаг. Шүүх хуралдаан хойшлуулах нөхцөл болохын хувьд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид нь тухайн байдлыг шүүх хуралдааны өмнө урьдчилан мэдэгдэх эсхүл нотлох баримтаар баталгаажуулах шаардлагатай. Шүүгчдээс болон өмгөөлөгчдөөс авсан судалгааны үр дүнг харьцуулан харуулбал:



/Өмгөөлөгчдөөс авсан судалгаа/ Хүснэгт 4

№	Үндэслэл	Тоо	Сонголтын хувь	Тохиолдлын хувь
1.	Хүндэтгэн үзэх шалтгаан	50	18.3%	94.3%
2.	Нотлох баримт гаргуулах	51	18.7%	96.2%
3.	Өмгөөлөгч авах, солих	47	17.2%	88.7%
4.	Хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдээгүй	48	17.6%	90.6%
5.	Шүүгчээс татгалзах	44	16.1%	83.0%
6.	Зөрчлийн улмаас хэргийн оролцогч, гэрч, шинжээчийг шүүх хуралдааны танхимаас гаргасан	33	12.1%	62.3%
Нийт		273	100.0%	515.1%

Дээрх судалгаанаас²⁷ үзэхэд хүндэтгэн үзэх шалтгаан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хойшлох нийт үндэслэлийн 18 хувь буюу зонхилох шалтгааны хоёрдугаарт бичигдэж байна.

Санал

Хүндэтгэн үзэх зайлшгүй нөхцөл байдал аль ч үе, цаг хугацаанд тохиолдож болох хэдий ч шүүх хуралдаан хойшлуулах үндэслэл болохын хувьд дараах урьдчилсан нөхцөлийг хангах шаардлагатай гэж үзэж болохоор байна. Үүнд:

- Тухайн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдод зайлшгүй нөхцөл байдал үүссэн;
- Шүүх хуралдаан эхлэхээс өмнө мэдэгдсэн байх;
- Хүндэтгэн үзэх шалтгаанаа нотлох баримтыг шүүхэд гаргаж өгөх зэрэг дээрх урьдчилсан нөхцөлийг шүүгч шалтгаан тогтоож байх;
- Шүүгч нотлох баримт болон өөрийн итгэл үнэмшилд тулгуурлан шүүх хуралдааныг хойшлуулсан захирамж гаргах.
- Мөн шүүх хуралдаан давхацсан тохиолдолд эхэлж тов гарсан шүүх хуралдаанд оролцох, шүүх хуралдааны тов гаргахдаа өмгөөлөгчийг хуралтай эсэхийг тодруулан шүүх хуралдааныг товлодог байх шаардлагатай байна.

Үндэслэл нэмэгдэх тусам шүүх хуралдаан хойшлогдох нь гарцаагүй юм. Иймд хүндэтгэн үзэх шалтгааныг нэг бүрчлэн дурдан хуульд тусгах нь хуулийг нэг мөр хэрэглэх, тайлбарлах, нөгөөтээгүүр иргэний хэрэг хянан шийдвэрлэх зорилтыг хангаж, хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх иргэдийг хууль дээдлэх үзэл санаагаар хүмүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх юм.

2.1.2. Шинжээч томилуулах хүсэлт гаргасан

²⁷ Нийслэлийн 9 дүүрэг, орон нутаг дахь 20 аймгийн Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн 180 шүүгч, 53 өмгөөлөгчөөс авсан анкетын судалгаа.

Шүүхээс томилогдсон эрх бүхий мэргэжлийн байгууллага, мэргэжилтэн, мэргэшсэн ажилтны бичгээр гаргаж буй үнэлэмжийг шинжээчийн дүгнэлт гэж ойлгодог.²⁸

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шинжлэх ухааны үндэслэлтэй, тооцоо, тоо бүртгэл, урлаг, утга зохиол, техникийн зэрэг тусгай мэдлэг шаардагдах тохиолдолд шүүх хэргийн оролцогчийн хүсэлтээр шинжээч томилдог.

Шинжилгээ гэдэг нь тусгай мэргэжил эзэмшсэн этгээдээс шинжлэх ухааны тодорхой салбарын онол, арга зүйг хэрэглэн бодит материал дээр судалгаа хийх зорилгоор хуульд заасан журмын дагуу үйл ажиллагаа явуулж, тодорхой асуудалд шинжлэх ухааны үндэслэлтэй хариулт өгөх явдал юм.²⁹

Шинжилгээг дотор нь:³⁰

- Анхны шинжилгээ
- Нэмэлт шинжилгээ
- Дахин шинжилгээ
- Комиссын шинжилгээ
- Иж бүрэн шинжилгээ гэсэн төрлүүдэд хувааж үздэг.

Шинжээчийн анхны дүгнэлт тодорхойгүй буюу бүрэн биш болсон тохиолдолд түүнийг нөхөн гүйцэлдүүлж дүнг бүрэн гаргах зорилгоор нэмэлт шинжилгээ хийгддэг.

Өмнөх шинжээчийн дүгнэлт үндэслэлгүй буюу зөв эсэх нь эргэлзээтэй байгаа тохиолдолд тухайн асуудлаар давтан хийгддэг шинжилгээг дахин шинжилгээ гэдэг. Энэ тохиолдолд анхны шинжилгээ хийсэн шинжээчийг дахин шинжилгээ хийх бүрэлдэхүүнд оролцуулдаггүй.

Комиссын буюу бүрэлдэхүүнтэй шинжилгээг нэг төрлийн мэргэжлийн гурваас дээш шинжээч явуулдаг.

Иж бүрэн шинжилгээ явуулахад хэд хэдэн төрлийн мэргэжлийн шинжээчид оролцож, дүгнэлт гаргадаг.

Шүүх шинжилгээний цар хүрээ, онцлог, шинжлэгдэх объектын тоо хэмжээг харгалзан шинжилгээ хийх хугацааг тогтоох ёстой.

Шүүх хүсэлтийг хангаж, захирамж, шүүхийн тогтоол гарган шинжээч томилсон тохиолдолд ИХШХШТХ-ийн 80 дугаар зүйлийн 80.1.8-д заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.

²⁸ Г.Даваадорж, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шинжээчийн дүгнэлт, түүнийг тойрсон асуудал, Шүүхийн шинжилгээ эмхэтгэл, УБ., 2017 он, Дугаар 2, 26 дахь тал.

²⁹ Монгол Улсын дээд шүүхийн зөвлөмж, 2008 оны 10 дугаар сарын 10-ны өдөр.

³⁰ Мөн тэнд.

Энэхүү процесс ажиллагааг ИХШХШТХ болон Улсын дээд шүүхээс гаргасан тайлбарт дараах байдлаар тусгажээ.

Хүснэгт 5

Хуулийн зүйл заалт	Тайлбарт
25.1.3. ... шинжээч томилуулах болон энэ хуулийн 48 дугаар зүйлд заасан ажиллагааг гүйцэтгүүлэх...	<p>/Хуулийн 47 дугаар зүйл. Шинжээч, түүний эрх, үүрэг, шинжээчийн дүгнэлт/ Хэрэг хянан шийдвэрлэхэд шинжлэх ухаан, тооцоо, тоо бүртгэл, урлаг, утга зохиол, техникийн зэрэг тусгай мэдлэг шаардагдах асуудлыг тодруулахын тулд хэргийн оролцогч шинжээч томилуулахыг шүүхээс хүсч болно.</p> <p>Бичгээр гаргасан хэргийн оролцогчийн хүсэлтэд ямар асуудлыг тодруулах шаардлагатай байгаа, шаардлага, татгалзал, тайлбарын ямар үндэслэлийг нотлох зорилгоор, ямар байгууллага, мэргэжилтнээр дүгнэлт гаргуулах саналтай байгааг тусгана. Шинжээчээс дүгнэлт гаргахад шаардагдах ямар баримтыг гаргаж өгч буйг мөн дурдана.</p> <p>Шүүхийн оролцоогүйгээр хэргийн оролцогч өөрийн хүсэлтээр аливаа мэргэжлийн байгууллагаар гаргуулсан дүгнэлт, тодорхойлолт зэрэг нь шинжээчийн дүгнэлт гэж тооцогдохгүй хэдий ч бичмэл нотлох баримтын хувьд түүнийг шүүх үнэлнэ /хуулийн 40, 46 дугаар зүйл/.</p>

Практикт шинжээч томилуулах шаардлагагүй эрх зүйн маргаанд хэргийн оролцогчид шинжээч томилуулах хүсэлт гаргах нь олонтоо байгаа бөгөөд шүүх ИХШХШТХ-ийн 47 дугаар зүйлийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэхгүй байдлаас шүүхийн практикт шинжээч томилох асуудал янз бүр байгаа харагдаж байна. Өөрөөр хэлбэл, шинжээчийн дүгнэлт нь тухайн хэрэгт хамааралтай, нэхэмжлэлийн шаардлага болон хариуцагчийн татгалзлыг нотлох нотолгоо болж чадах эсэхийг олж харах ёстой.


Шинжээч томилуулах тухай ямар ч ач холбогдолгүй хүсэлтийг хангах нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааших шалтгааны нэг болж байна.

Нийслэлийн 9 дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн дээрх шалтгаанаар шүүх хуралдаан хойшилсон шүүгчийн захирамжийг 2013-2017 оны байдлаар шүүхийн статистик мэдээллээс нэгтгэн харвал /давхардсан тоогоор/:



- Нийслэлийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2013-2014 оны шүүх хуралдаан хойшилсон шүүгчийн 1000 захирамжтай танилцахад 2013 онд 53, 2014 онд 92 хэрэг маргаан шинжээч томилуулах гэсэн үндэслэлээр;³¹
- 2015 онд нийт 28021 хэрэг, маргаан хойшилсноос 221 буюу 0.8 хувь нь шинжээч томилуулах гэсэн үндэслэлээр;
- 2016 онд нийт 18125 хэрэг, маргаан хойшилсноос 507 буюу 2.8 хувь нь шинжээч томилуулах гэсэн үндэслэлээр;
- 2017 онд нийт 20586 хэрэг, маргаан хойшилсноос 580 буюу 2.8 хувь нь шинжээч томилуулах гэсэн үндэслэлээр тус тус хойшилсон байна.

Орон нутаг дахь 20 аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хэмжээнд шинжээч томилуулах, нотлох баримт гаргуулах шалтгаанаар шүүх хуралдаан хойшилсон шүүгчийн захирамжийг 2013-2016 он, 2017 оны эхний хагас жилийн байдлаар шүүхийн статистик мэдээллээс нэгтгэн харвал /давхардсан тоогоор/:



- 2013 онд нийт 1652 хэрэг, маргаан хойшилсоноос 161 буюу 9.7 хувь нь шинжээч томилуулах, нотлох баримт гаргуулах гэсэн үндэслэлээр;
- 2014 онд нийт 1950 хэрэг, маргаан хойшилсоноос 251 буюу 12.8 хувь нь шинжээч томилуулах, нотлох баримт гаргуулах гэсэн үндэслэлээр;
- 2015 онд нийт 2917 хэрэг, маргаан хойшилсоноос 348 буюу 12 хувь нь шинжээч томилуулах, нотлох баримт гаргуулах гэсэн үндэслэлээр;
- 2016 онд нийт 3351 хэрэг, маргаан хойшилсоноос 601 буюу 18 хувь нь шинжээч томилуулах, нотлох баримт гаргуулах гэсэн үндэслэлээр;
- 2017 оны эхний хагаст нийт 1715 хэрэг, маргаан хойшилсоноос 314 буюу 18.3 шинжээч томилуулах, нотлох баримт гаргуулах гэсэн үндэслэлээр тус тус хойшилсон байна.

Судалгааны дүнд³² шинжээч томилуулах хүсэлтийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хойшилж байгаа нь нэн тулгамдсан асуудал биш гэж үзэж болохоор байна.

³¹ 2013-2014 оны дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн статистик мэдээллийг "Шүүхийн төрөлжсөн" архиваас шүүх хуралдаан хойшлуулсан 1000 шүүгчийн захирамжийг түүвэрлэн гаргасан болно.

Дүгнэлт

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн оролцогчдын шинжээч томилуулах хүсэлт гаргаж байгаа дийлэнх хэсгийг хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө үнэлүүлэх, ажлын гүйцэтгэл, эрүүл мэнд, эмнэлгийн, байгаль орчин, нөхөн сэргээлт, санхүү тооцооны асуудалтай холбоотой эдийн засгийн шинжээч томилуулах хүсэлт эзэлж байгаа нь судалгаанд хамрагдсан шүүгчийн захирамжаас харагдаж байна.

Хэдийгээр ИХШХШТХ-ийн 25.1.3 дахь хэсэгт заасан хэргийн оролцогчдын эдлэх эрхэд шинжээч томилуулах хүсэлт хамаарч байгаа ч шүүх тэдний гаргасан хүсэлт болгоныг хангаж шинжээч томилно гэсэн ойлголт биш гэдгийг анхаарах шаардлагатай.

Шинжээчийн дүгнэлтийг заасан хугацаанд ирүүлэх, хугацаандаа ирүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэдэг механизмыг идэвхжүүлж өгснөөр шинжээчийн дүгнэлтээс шалтгаалж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширдаг, хүмүүсийг залхааж чирэгдүүлдэг байдал үгүй болох юм.³³

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т зааснаар эрх бүхий этгээд шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамждаа шинжилгээ хийх хугацааг тусгах шаардлагатай бөгөөд мөн хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар шинжилгээний байгууллага, тогтоол, захирамж, хүсэлтийг хүлээн авсан өдрөөс эхлэн хугацааг тооцдог. Гэвч шинжилгээ хийлгэх цар хүрээ, онцлог, шинжилгээний объект зэргийг харгалзан үзэлгүй шинжээч томилсон захирамж, тогтоолдоо хийсвэр хугацаа заах явдал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд түгээмэл байна.³⁴

Шинжээч томилуулах тухай зохигчийн хүсэлтийг хангах эсэхийг шийдвэрлэхгүй орхигдуулах, эсхүл хуульд заасан үндэслэлээс гадуур санаачилгаараа шинжээч томилох зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн алдаа гарч байна.³⁵

Мөн судалгаагаар шүүхийн зүгээс бусад байгууллагаас нотлох баримт гаргуулах, даалгавар гүйцэтгүүлэх зэрэг ажиллагааг хийдэг хэдий ч эдгээр байгууллага нь шаардсан нотлох баримтыг шүүхээс тогтоосон хугацааны дотор ирүүлдэггүй нь шүүх хуралдаан хойшлох бас нэг үндэслэл болж байна. Энэ нь шинжилгээ хийлгэх шаардлагатай нотлох баримтын хувьд ч гарч байгаа асуудал юм. Хэрэв тогтоосон хугацаанд нотлох баримтыг ирүүлэх боломжгүй, шинжээчийн дүгнэлт гаргах боломжгүй бол энэ тухайгаа шүүхэд мэдэгдэж, хугацаа сунгуулах хүсэлтийг гаргаж байх шаардлагатай.

³² Нийслэлийн 9 дүүрэг, орон нутаг дахь 20 аймгийн Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн 180 шүүгч, 53 өмгөөлөгчөөс авсан анкетын судалгаа.

³³ Г.Даваадорж, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шинжээчийн дүгнэлт, түүнийг тойрсон асуудал, Шүүхийн шинжилгээ эмхэтгэл, УБ., 2017 он, Дугаар 2, 28 дахь тал.

³⁴ Мөн тэнд.

³⁵ Монгол Улсын дээд шүүхийн зөвлөмж, 2008 оны 10 дугаар сарын 10-ны өдөр

Санал

Шүүх хуульд заасан журмаар шинжээч томилохдоо дараах хэд хэдэн үндэслэлд анхаарлаа хандуулах шаардлагатай. Үүнд:

- Шинжээч томилуулах тухай хэргийн оролцогчийн хүсэлт нь хууль зүйн үндэслэлтэй, хэрэгт ач холбогдолтой эсэхийг сайн нягтлан үзсэний үндсэн дээр хүсэлтийг хангах асуудлыг шийдвэрлэж байх;
- Шинжилгээний дүгнэлт гаргуулах хугацааг шинжилгээ хийлгэх объектын онцлогийг харгалзан маш нарийн тогтоож өгөх;
- Шүүхээс тогтоосон хугацааны дотор шинжилгээний хариуг ирүүлж байх, хугацаандаа ирүүлээгүй тохиолдолд хэрхэн зохицуулах талаар хуульд тодорхой тусгаж өгөх шаардлагатай.

2.1.3. Нотлох баримт гаргуулах хүсэлт гаргасан

Хэргийн оролцогчдоос өөрийн шаардлага ба татгалзлаа үндэслэж байгаа, шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, хуульд заасан арга хэрэгслээр олж авсан бодит нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ.³⁶

Дээр дурдсанаас үндэслэн иргэний хэргийг шүүх хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий хуульд заасан арга хэрэгслээр илэрхийлэгдэж байгаа мэдээллийг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь нотлох баримт хэмээн тодорхойлох боломжтой юм.

Нотлох баримтыг олох аргаар нь анхдагч ба дамжмал нотлох баримт гэж ангилна.³⁷ Нэхэмжлэлийн үндэслэл, хариуцагчийн татгалзлыг баталж байгаа, эсхүл үгүйсгэж байгаа нөхцөл байдлыг байгаа байдлаар шууд сонсож мэдсэнээр нь тодорхойлохыг анхдагч нотлох баримт гэнэ. Ямар нэгэн эх сурвалжаас дамжуулан авсан баримт сэлтийг дамжмал нотлох баримт гэнэ.

Мөн нотлох баримтыг нотолгооны шинжээр нь шууд ба шууд бус нотлох баримт гэж ангилна.³⁸ Хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг шууд нотолж, батлан эсхүл үгүйсгэж байгаа нотлох баримтыг шууд нотлох баримт гэнэ. Шууд бус нотлох баримт нь хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг шууд тодорхойлохгүй, харин түүнийг шууд бусаар нотолдог.

Иргэний хэргийн хувьд түгээмэл хэрэглэдэг нотолгооны хэрэгсэлд бичмэл нотлох баримт, шинжээчийн дүгнэлт, гэрчийн мэдүүлэг, хэргийн оролцогчид, тэдгээрийн өмгөөлөгч төлөөлөгчөөс гаргасан тайлбар зэрэг хамаарна.

³⁶ ИХШХШТХ-ийн 37 дугаар зүйлийн 37.1.

³⁷ А.Дугармаа, Ж.Наранцацрал, "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй" гарын авлага, УБ., 2007 он, 81 дэх тал.

³⁸ Мөн тэнд.

ИХШХШТХ-д заасны дагуу зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч болон өмгөөлөгч нь өөрийн шаардлага болон татгалзлын үндэс болж байгаа байдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй.³⁹

Талууд хууль ёсны эрх ашгаа хамгаалах, нотлох боломжийг шүүх хэрхэн хангаснаас шүүхийн шийдвэр үндэслэл бүхий гарах эсэх нь хамаардаг ба нотлох баримттай холбоотойгоор “нотолгооны зүйл” хэмээх ойлголт гарч ирдэг. Энэ нь иргэний хэргийг бодитой, үнэн зөв, шийдвэрлэхэд ач холбогдол бүхий шүүхээс тогтоох ёстой нөхцөл байдлыг ойлгоно.⁴⁰

Процессын ажиллагаа нь хуульд заасан журмын дагуу явагдахад тодорхой эрэмбэ дараалалтай байх шаардлагатай.

Шүүхийн нотолгоо нь мөн ялгаагүй эрэмбэ дараалал, уялдаа холбоо бүхий үе шатуудыг дамжин хэрэгждэг.⁴¹ Үүнд:

- Нотлох баримт гаргах;
- Нотлох баримт цуглуулах;
- Нотлох баримт бүрдүүлэх;
- Нотлох баримт шалгаж судлах;
- Нотлох баримт үнэлэх.

Эдгээр таван үе шат нь өөр хоорондоо болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тодорхой үе шат бүртэй харилцан уялдаа холбоотой оршино.

Нотлох баримт гаргах - нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлага, хариуцагч нь татгалзлынхаа үндэслэлийг баталж байгаа үйл ажиллагаа ба шүүх хуралдаанд бэлтгэх үе шаттай салшгүй холбоотой. Учир нь шүүхээс шүүх хуралдааны өмнө нотлох баримт гаргаж өгөх үүргийг /эрх/ зохигчид хүлээлгэдэг;

Нотлох баримт цуглуулах - хэргийн оролцогч шүүх хуралдаанд бэлтгэх үе шатанд хэрэгт холбоотой нотлох баримтаа хуульд заасан арга, хэрэгслээр цуглуулдаг;

Нотлох баримт бүрдүүлэх - хэргийн оролцогч нь өөрөө олж авах боломжгүй нөхцөл үүссэн бол түүний хүсэлтээр шүүх нотлох баримтыг бүрдүүлдэг;

Нотлох баримтыг шалгаж судлах - шүүх хуралдааны явцад шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны оролцогчид нотлох баримтын нотолгооны ач холбогдлыг бататгах, нэмэлт тодотгол хийх, эсхүл түүнийг үгүйсгэх зэргээр шалгаж судалдаг;

Нотлох баримт үнэлэх - шүүгч, хэрэгт цугларсан нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор харьцуулж байгаа явц юм.

³⁹ ИХШХШТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.1.

⁴⁰ “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй” гарын авлага, УБ., 2007 он, 82 дахь тал.

⁴¹ З.Мөнхжаргал, Монгол Улсын иргэний хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй, УБ., 2009 он, 203 дахь тал.

Эдгээр үе шат нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шат буюу давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанд хэрэгжинэ.

Шүүхийн нотолгооны ажиллагааг ийнхүү тодорхой үе шатанд хуваах нь уг ажиллагааг дэс дараалалтай, эмх цэгцтэй, ойлгомжтой, зөв, бүрэн гүйцэд явуулах нөхцөлийг хангах, үе шат бүрт гүйцэтгэвэл зохих ажиллагааны агуулгыг хангах, хуулийн дагуу зохих ёсоор нь гүйцэтгэх явдлыг баталгаажуулах ач холбогдолтой юм.

Энэхүү процесс ажиллагааг ИХШШТХ болон Улсын дээд шүүхээс гаргасан тайлбарт дараах байдлаар тусгажээ.

Хүснэгт 6

Хуулийн зүйл заалт	Тайлбарт
<p>105.1.Шинэ нотлох баримт бүрдүүлэх ба хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон бусад асуудлын талаар хэргийн оролцогчоос гаргасан хүсэлтийг бусад оролцогчийн саналыг сонсмогц шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч даруй шийдвэрлэнэ.</p>	<p>Энэ заалтаас үзвэл хэргийн оролцогчоос гаргасан хүсэлт шинэ нотлох баримт бүрдүүлэх ба хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон бусад асуудалтай холбоотой бөгөөд энэ зүйлийн нэг, хоёр дахь хэсгийн заалт нь хоорондоо холбоотой зохицуулалт гэж үзэхээр байна.</p> <p>Хэргийг шүүх хуралдаанаар хэлцүүлэх захирамж гаргахаас өмнө хэрэгт авагдаагүй, хэргийн бусад оролцогч танилцаагүй баримтыг хэрэгт хавсаргах, бусад этгээдээс гаргуулан авах хүсэлтийг шүүх хуралдаан дээр гаргасныг энэ хэсэгт заасан "...шинэ нотлох баримт бүрдүүлэх... хүсэлт гаргасан..." гэдэгт хамааруулан ойлговол зохино.</p>
<p>105.2.Хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдолтой нэмэлт тайлбар, нотлох баримтыг урьд нь гаргах буюу санал болгох бололцоотой байсан боловч шүүх хуралдааны үед гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаантай гэж шүүх үзвэл түүнийг хүлээн авч, шинжлэн судлах шаардлагатай бол шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулж болно.</p>	<p>Хүндэтгэн үзэх шалтгаантай гэж шүүх үзвэл түүнийг хүлээн авч, шинжлэн судлах шаардлагатай бол шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулж болно.</p> <p>Шүүхийн практикаас үзэхэд шүүгч, шүүх бүрэлдэхүүн шүүх хуралдаан хойшлуулах хүсэлтийг дийлэнх тохиолдолд хангадаг боловч хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдолтой нэмэлт тайлбар, нотлох баримтыг урьд нь гаргах буюу санал болгох бололцоотой байсан эсэх, хүсэлтийг шүүх хуралдааны үед гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаантай эсэх, энэ нь баримтаар тогтоогдсон эсэх талаар дүгнэлт хийхгүй захирамж, тогтоол гаргаж байгаа нь шүүх хуралдааныг ИХШШТХ-д заагаагүй үндэслэлээр хойшлуулах нөхцөлийг бүрдүүлдэг байна.</p>

Судалгааны дүнгээс:


Нийслэлийн 9 дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хэмжээнд дээрх шалтгаанаар шүүх хуралдаан хойшилсон шүүгчийн захирамжийг 2013-2017 оны байдлаар шүүхийн статистик мэдээллээс нэгтгэн харвал /давхардсан тоогоор/:



- Нийслэлийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2013-2014 оны шүүх хуралдаан хойшилсон шүүгчийн 1000 захирамжтай танилцахад 2013 онд 53, 2014 онд 92 хэрэг маргаан нотлох баримт гаргуулах гэсэн үндэслэлээр;⁴²
- 2015 онд нийт 28021 хэрэг, маргаан хойшилсноос 567 буюу 2.2 хувь нь нотлох баримт гаргуулах гэсэн үндэслэлээр;
- 2016 онд нийт 18125 хэрэг, маргаан хойшилсноос 1755 буюу 9.6 хувь нь нотлох баримт гаргуулах гэсэн үндэслэлээр;
- 2017 онд нийт 20586 хэрэг, маргаан хойшилсноос 2013 буюу 9.67 хувь нь нотлох баримт гаргуулах гэсэн үндэслэлээр тус тус хойшилсон байна.

Орон нутаг дахь 20 аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хэмжээнд дээрх шалтгаанаар шүүх хуралдаан хойшилсон шүүгчийн захирамжийг 2013-2016 он, 2017 оны эхний хагас жилийн байдлаар шүүхүүдийн статистик мэдээллээс харвал /давхардсан тоогоор/:

Гэхдээ орон нутгаас ирүүлсэн статистик мэдээлэл нь нотлох баримт гаргуулах гэсэн ганц үндэслэлээр гаргаж ирүүлээгүй бөгөөд шинжээч томилуулах гэсэн хүсэлттэй хамтад нь статистик дүн гарсан байгааг харгалзан үзнэ үү.



- 2013 онд нийт 1652 хэрэг, маргаан хойшилсноос 161 буюу 9.7 хувь нь шинжээч томилуулах, нотлох баримт гаргуулах гэсэн үндэслэлээр;


⁴² 2013-2014 оны дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн статистик мэдээллийг "Шүүхийн төрөлжсөн" архиваас шүүх хуралдаан хойшлуулсан 1000 шүүгчийн захирамжийг түүвэрлэн гаргасан болно.

- 2014 онд нийт 1950 хэрэг, маргаан хойшилсноос 251 буюу 12.8 хувь нь шинжээч томилуулах, нотлох баримт гаргуулах гэсэн үндэслэлээр;
- 2015 онд нийт 2917 хэрэг, маргаан хойшилсноос 348 буюу 12 хувь нь шинжээч томилуулах, нотлох баримт гаргуулах гэсэн үндэслэлээр;
- 2016 онд нийт 3351 хэрэг, маргаан хойшилсноос 601 буюу 18 хувь нь шинжээч томилуулах, нотлох баримт гаргуулах гэсэн үндэслэлээр;
- 2017 оны эхний хагаст нийт 1715 хэрэг, маргаан хойшилсноос 314 буюу 18.3 шинжээч томилуулах, нотлох баримт гаргуулах гэсэн үндэслэлээр тус тус хойшилсон байна.

Дүгнэлт

Шүүхийн практикт шүүх хуралдаанд бэлтгэх үе шатанд нотлох баримт гаргах, цуглуулах, бүрдүүлэх зэрэг ажиллагаа нь хангалттай түвшинд хийгдэхгүй байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хойшлох, удаашрах үндэслэл болж байна.

Судалгааны дүнгээс:⁴³



/Өмгөөлөгчдөөс авсан судалгаа/ Хүснэгт 7

№		Тоо	Сонголтын хувь	Тохиолдлын хувь
1.	Хүндэтгэн үзэх шалтгаан	50	18.3%	94.3%
2.	Нотлох баримт гаргуулах	51	18.7%	96.2%
3.	Өмгөөлөгч авах, солих	47	17.2%	88.7%
4.	Хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдээгүй	48	17.6%	90.6%
5.	Шүүгчээс татгалзах	44	16.1%	83.0%

⁴³ Нийслэлийн 9 дүүрэг, орон нутаг дахь 20 аймгийн Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн 180 шүүгч, 53 өмгөөлөгчөөс авсан анкетын судалгаа.

6.	Зөрчлийн улмаас хэргийн оролцогч, гэрч, шинжээчийг шүүх хуралдааны танхимаас гаргасан	33	12.1%	62.3%
	Нийт	273	100.0%	515.1%

Дээрх судалгааны дүнгээс шүүхийн практикт зайлшгүй зохицуулах ёстой асуудал нь зохигч тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчдөөс өөрийн шаардлага болон татгалзлаа нотолж буй процесс ажиллагаа нь шүүх хуралдааны хойшлуулж байгаа гол үндэслэлүүдийн нэг болсныг харуулж байна.

Мөн хэргийн оролцогчийн хүсэлтээр аливаа байгууллага, иргэнээс нотлох баримт шаардан гаргуулах ажиллагаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед нэлээдгүй гардаг хэдий ч тухайн нотлох баримт шаардсан этгээд шүүгчийн захирамжид заасан хугацааг хэтрүүлж баримтыг ирүүлэх, огт ирүүлэхгүй байх, материал дутуу явуулах, удаа дараа шаардуулах зэргээс шалтгаалан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширдаг байна.

Шүүгч хэргийг шийдвэрлэхдээ тал бүрээс нь бүрэн бодитой хандах зарчимд тулгуурлах боловч нотлох баримтад үндэслэхгүйгээр шийдвэр гаргах нь шүүхийн шийдвэр хууль ёсны гарсан эсэхэд эргэлзээ үүсч иргэдийн шүүхэд итгэх итгэл алдрах аюултай.

Санал

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед хэргийн оролцогчийн хүсэлтээр аливаа байгууллага, иргэнээс нотлох баримт шаардан гаргуулах ажиллагаа түгээмэл хийгддэг хэдий ч тухайн нотлох баримтыг шаардсан этгээд хугацааг хэтрүүлж ирүүлдэг, огт ирүүлэхгүй байх, дутуу явуулдаг бөгөөд тэдэнд хариуцлага тооцох торгуулийн хэмжээ маш бага, тухайн албан тушаалтанд шүүгчийн захирамжийг биелүүлэх, гүйцэтгэх хөшүүрэг болж чадахгүй байх тул дээрх хариуцлагыг чангатгах, шүүгч захирамжаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан арга хэмжээ авдаг болох хэрэгтэй.⁴⁴

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Иргэний процессын хуулийн 356 дугаар зүйлд⁴⁵ заасны адил шүүхээс нотлох баримтыг гаргаж өгөх хугацааг тогтоож өгөх ба хугацаа өнгөрсөн тохиолдолд зөвхөн шүүхийн шийдвэрээр тухайн нотлох баримтыг ашиглах эсэхийг шийдэх ба энэ нь шүүх хурал хойшлох шалтгаан болохгүй хэмээн хуульд тусгах.

Захиргааны хэргийн шүүхэд хэрэгжүүлж байгаа урьдчилсан хэлэлцүүлгийг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэвтрүүлэх зэрэг болно.

2.1.4. Өмгөөлөгч авах болон солих хүсэлт гаргасан

⁴⁴ П.Туяа, Багануур дүүргийн Иргэний хэргийн шүүхийн шүүгч, "ИХШХШтХ-ийн хэрэгжилтэд гарч буй хүндрэл бэрхшээл" сэдэвт хэлэлцүүлэгт тавьсан илтгэлээс, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2016.12.19-ний өдөр.

⁴⁵ Germany Code of Civil procedure, Section 356

Иргэн өөрийн биеэр буюу төлөөлөгчөөрөө дамжуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно.⁴⁶

Монгол Улсын Үндсэн хуулийн арван зурав дугаар зүйлийн 14 дэх хэсэгт Монгол Улсын иргэн нь “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно” эрхийг баталгаатай эдэлнэ.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын 14 дүгээр зүйлд:

- өөрийнхөө сонгон авсан өмгөөлөгчтэй уулзаж, өмгөөлүүлэхэд бэлтгэхэд хүрэлцэхүйц хугацаа, бодит бололцоотой байх;
- өөрөө өөрийгөө өмгөөлөх буюу сонгож авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх;
- хэрэв өмгөөлөгчгүй бол энэхүү эрхийн тухай түүнд мэдэгдсэн байх;
- шүүх таслах ажлын ашиг сонирхол шаардаж байгаа аливаа тохиолдолд тохоон томилогдсон өмгөөлөгчидтэй байх гэж заажээ.

Өмгөөлөгч гэсэн нэр томъёо нь латины “advocatuse” буюу урих уриалах гэсэн үгнээс гаралтай. ИХШХШТХ-ийн 22 дугаар зүйлд зааснаар өмгөөлөгч нь хэргийн оролцогч болох ба өмгөөлөгчийн эрх зүйн туслалцаа авч байгаа талын хүсэлтээр тодорхойлогдох буюу гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдийг төлөөлөхдөө, төлөөлүүлэгчийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалахын тулд хуульд заасан бүхий л арга хэмжээг авах үүрэгтэй оролцоно.

Өмгөөлөгч нь хууль зүйн дээд боловсролтой, ял шийтгэлгүй, тогтоосон журмын дагуу мэргэжлийн сонгон шалгаруулалтад орж, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан иргэн байх ба өмгөөлөгчийг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах нь хэргийн оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хэргийн нотлох баримтыг зөв үнэлэх, хэргийг хууль зүйн үндэслэлтэй түргэн шуурхай шийдвэрлэхэд ач холбогдолтой юм.

Гэвч нөгөө талаараа шүүхийн практикаас харахад иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хэргийн оролцогчид тэр дундаа зохигч, тэдгээрийн өмгөөлөгч, төлөөлөгчөөс шалтгаалан удааширч, хуульд заасан хугацаанд шийдвэрлэгдэхгүй байгаа нь тулгамдсан асуудал болоод байна.

Энэхүү процесс ажиллагааг ИХШХШТХ болон Улсын дээд шүүхээс гаргасан тайлбарт дараах байдлаар тусгажээ.

⁴⁶ ИХШХШТХ-ийн 32 дугаар зүйл.

Хуулийн зүйл заалт	Тайлбарт
<p>32 дугаар зүйлийн 32.4-т “эрх зүйн бүрэн чадамжтай иргэн өөрийгөө сайн дурын үндсэн дээр бусдаар, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно” гэж тус тус эрх зүйн үндсийг нь тодорхойлсон байна.</p>	<p>Өөрийн оронд төлөөлөгч оролцуулсан тохиолдолд иргэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд биеэр оролцох эрхээсээ татгалзсан гэж үзнэ. Хэргийн оролцогчийг төлөөлөгчийн хамт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах явдал шүүхийн практикт байдаг ба энэ нь утга агуулгаараа буруу юм. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогч өөрөө оролцож буй явдал нь төлөөлөгчийн эрх зүйн байдлыг үгүйсгэнэ. Хэргийн оролцогч гэрээний үндсэн дээр өмгөөлөгчийн хамт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болно. Харин өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр өөрийгөө төлөөлүүлэхийн тулд иргэн мэргэжлийн өмгөөлөгчтэй хөлсөөр ажиллах гэрээ байгуулна.</p>

Мөн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд⁴⁷ өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрх болон үүргийн талаар тусгасан байна. Үүнд:

- Хуульч хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсны дараа шүүхэд төлөөлөх эрх нээлгэхээр Улсын дээд шүүхэд бүртгүүлж, энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан өмгөөлөгчийн нэрсийн жагсаалтад бүртгэгдэнэ.
- Шүүхэд төлөөлөх эрх нээлгэхийг хүсч байгаа хуульч өмгөөлөгчийн хариуцлагын даатгалд заавал даатгуулсан байна.
- Хуульч өмгөөлөгчийн нэрсийн жагсаалтад бичигдсэнээр түүний шүүхэд төлөөлөх эрх нээгдэнэ.
- Шүүхэд төлөөлөх өмгөөлөгчийн эрхийг зөвхөн энэ хуулиар хязгаарлана.
- Өмгөөлөгч нь шүүхэд төлөөлөх, шүүн таслах ажиллагаанд оролцох /цаашид "өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх" гэх/ эрхтэй, чөлөөт, бие даасан мэргэжилтэн байна.

Өмгөөлөгчийн үүрэг

Өмгөөлөгч энэ хуулийн⁴⁸ 26 дугаар зүйлд зааснаас гадна дараах үүрэг хүлээнэ:

- үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуульд үл харшлах арга, хэрэгслийг ашиглан бүрэн, тууштай хамгаалах;
- үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг аливаа үйлдэл хийхгүй байх;
- хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

Судалгааны дүнгээс:

⁴⁷ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30, 38 дугаар зүйл.


⁴⁸ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйл.

Нийслэлийн 9 дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хэмжээнд дээрх шалтгаанаар шүүх хуралдаан хойшилсон шүүгчийн захирамжийг 2013-2017 оны байдлаар шүүхийн статистик мэдээллээс нэгтгэн харвал /давхардсан тоогоор/



- Нийслэлийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2013-2014 оны шүүх хуралдаан хойшилсон шүүгчийн 1000 захирамжтай танилцахад 2013 онд 90, 2014 онд 53 хэрэг маргаан өмгөөлөгч авах, өмгөөлөгчөө солих гэсэн үндэслэлээр;⁴⁹
- 2015 онд нийт 28021 хэрэг, маргаан хойшилсноос 581 буюу 2 хувь нь өмгөөлөгч авах, өмгөөлөгчөө солих гэсэн үндэслэлээр;
- 2016 онд нийт 18125 хэрэг, маргаан хойшилсноос 1810 буюу 10 хувь нь өмгөөлөгч авах, өмгөөлөгчөө солих гэсэн үндэслэлээр;
- 2017 онд нийт 20586 хэрэг, маргаан хойшилсноос 1632 буюу 8 хувь нь өмгөөлөгч авах, өмгөөлөгчөө солих гэсэн үндэслэлээр тус тус хойшилсон байна.

20 аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хэмжээнд дээрх шалтгаанаар шүүх хуралдаан хойшилсон шүүгчийн захирамжийг 2013-2016 он, 2017 оны эхний хагас жилийн байдлаар шүүхүүдийн статистик мэдээллээс нэгтгэн харвал /давхардсан тоогоор/



⁴⁹ 2013-2014 оны дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн статистик мэдээллийг "Шүүхийн төрөлжсөн" архиваас шүүх хуралдаан хойшлуулсан 1000 шүүгчийн захирамжийг түүвэрлэн гаргасан болно.

- 2013 онд нийт 1652 хэрэг, маргаан хойшилсноос 122 буюу 7.3 хувь нь өмгөөлөгч авах, өмгөөлөгчөө солих гэсэн үндэслэлээр;
- 2014 онд нийт 1950 хэрэг, маргаан хойшилсноос 146 буюу 7.5 хувь нь өмгөөлөгч авах, өмгөөлөгчөө солих гэсэн үндэслэлээр;
- 2015 онд нийт 2917 хэрэг, маргаан хойшилсноос 209 буюу 7.1 хувь нь өмгөөлөгч авах, өмгөөлөгчөө солих гэсэн үндэслэлээр;
- 2016 онд нийт 3351 хэрэг, маргаан хойшилсноос 419 буюу 12.5 хувь нь өмгөөлөгч авах, өмгөөлөгчөө солих гэсэн үндэслэлээр
- 2017 оны эхний хагаст нийт 1715 хэрэг, маргаан хойшилсноос 197 буюу 11.4 хувь нь өмгөөлөгч авах, өмгөөлөгчөө солих гэсэн үндэслэлээр тус тус хойшилсон байна.

Дээрхээс харахад жил тутам уг шалтгаанаар шүүх хуралдаан хойшилж буй нь өссөн үзүүлэлттэй байна.

Иргэний хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаанд зохигчид эрх, үүргийг тайлбарлах, тухайлбал, хууль зүйн туслалцаа авах эрхтэй болохыг тайлбарладаг. Хэргийн зохигчид эрх үүргээ хангалттай ойлгоогүй, боломжит хугацаанд өмгөөлөгч сонгон авч чадаагүй, эсхүл шүүх хуралдааныг хойшлуулах сонирхолтой байдгаас анхан шатны шүүх хуралдаан дээр өмгөөлөгчгүй оролцдог.

Шүүхээс хэргийн зохигчдод эрх, үүргийг нь хангалттай тодорхой тайлбарладаггүй, зохигчид ойлгоогүй тохиолдолд лавлаж асуудаггүй, эрх зүйн боловсрол дутмаг байдлаас шалтгаалан шүүх хуралдаан хойшлох тохиолдол гардаг.

Зохигч өмгөөлөгч авах, өмгөөлөгчөө солих хүсэлт гаргасны улмаас шүүх хуралдаан хойшилж байгаа шалтгааныг аймаг, нийслэл, сум, сум дундын Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн нэгдсэн мэдээллээс дор харуулав.



Дээрхээс харахад анхан шатны шүүх хуралдаан хойшилж байгаа үндэслэлийн 11.5 хувийг, давж заалдах шатны шүүх хуралдаан хойшилж байгаа үндэслэлийн 27.5 хувийг хэргийн оролцогчдоос өмгөөлөгч авах, солих гэсэн үндэслэл эзэлж байна.

Давж заалдах шатны шүүх нь хэдий өндөр хувьтай байгаа ч нийт хойшлогдож байгаа хэргийн хувьд хэд дахин бага учир нэн тэргүүний зохицуулах

ёстой асуудал биш юм. Харин анхан шатны шүүхийн хувьд зөвхөн өмгөөлөгч авах, солих хүсэлтээр нийт хойшилсон шүүх хуралдааны 11.5 хувийг эзэлж байгаа нь хэргийн оролцогчид шүүх хуралдааны өмнө эрх, үүргийг нь тайлбарлах ажиллагаа бүрэн хийгдэхгүй байгаа нөгөө талаас зохигчдын эрх зүйн боловсрол дутмаг байгааг харуулж байна.

Шүүх хуралдааныг хамгийн ихээр хойшлуулж байгаа субъект хэн бэ гэсэн асуултад хариулсан байдлыг нэгтгэн харвал:⁵⁰



Шүүх хуралдаан хойшилж буй шалтгаан ямар үндэслэлээр ихэнх тохиолдолд гарч байна гэсэн асуултад хариулсан дүнг нэгтгэн харвал:⁵¹

/Өмгөөлөгчдөөс авсан судалгаа/ Хүснэгт 8

№	Шүүх хуралдаан хойшлох үндэслэл	Тоо	Сонголтын хувь	Тохиолдлын хувь
1	Хүндэтгэн үзэх шалтгаан	50	18.3%	94.3%
2	Нотлох баримт гаргуулах	51	18.7%	96.2%
3	Өмгөөлөгч авах, солих	47	17.2%	88.7%
4	Хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдээгүй	48	17.6%	90.6%
5	Шүүгчээс татгалзах	44	16.1%	83.0%
6	Зөрчлийн улмаас хэргийн оролцогч, гэрч, шинжээчийг шүүх хуралдааны танхимаас гаргасан	33	12.1%	62.3%
	Нийт	273	100.0%	515.1%

⁵⁰ Нийслэлийн 9 дүүрэг, орон нутаг дахь 20 аймгийн Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн 180 шүүгчээс авсан анкетын судалгаа. /2018 он/

⁵¹ 53 өмгөөлөгчөөс авсан анкетын судалгаа.

Иргэний хэргийн шүүх хуралдаан ихэвчлэн аль субъектээс шалтгаалан хойшилдог вэ? гэсэн асуултад нийт судалгаанд оролцогчдын 57% нь нэхэмжлэгч ба хариуцагч, тэдгээрийн өмгөөлөгчөөс шалтгаалан хойшилдог гэсэн бол өмгөөлөгчдөөс авсан анкетын судалгаагаар 17.2 хувийг өмгөөлөгч авах, өмгөөлөгчөө солих үндэслэлээр шүүх хуралдаан хойшилдог гэж үзжээ.

Дүгнэлт

Хэргийн оролцогчдын зүгээс шүүх хуралдааныг хойшлуулж буй зонхилох шалтгаанаас өмгөөлөгч авах, өмгөөлөгчөө солих хүсэлтээр шүүх хуралдаан хойшлох нь 20 хувийг эзэлж байгаа нь нэн тэргүүний шийдвэрлэх ёстой асуудал болсон нь тодорхой байна.



Практик дээр зохигчдоос шалтгаалан ихэнх тохиолдолд шүүх хуралдаан хойшилдог нь нэгэнт тодорхой болсон. Тэр дундаа хариуцагч, түүний төлөөлөгч нь хэргийг түргэн шуурхай шийдвэрлүүлэх сонирхолгүй байдаг тул шүүх хуралдааны өмнө өмгөөлөгч авалгүй шүүх хуралдаанд оролцдог ба шүүх хуралдааны явцад эрх зүйн туслалцаа авах хүсэлтийг гаргаж шүүх хуралдааныг эхний удаа хойшлуулдаг, дараагийн хуралд шүүхээс тогтоосон хугацаанд өмгөөлөгч авч чадаагүй, авсан боловч тухайн өмгөөлөгчөө солих гэх зэргээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах тактикийг түгээмэл хэрэглэдэг.

Ийнхүү хүсэлт гаргах бүрд хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх нь шүүх хуралдаан удаашрах, хойшлох шалтгаан болж байгаа хэдий ч хүсэлтийг хүлээн авалгүй хэргийг шийдвэрлэх нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмыг зөрчсөн үйлдэл болохоор байна.

Санал

- Өмгөөлөгч бол иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогчид мэргэжлийн туслалцаа үзүүлэх, тэдгээрийн хууль ёсны эрхийг хамгаалж байгаа гэдэг утгаар нь эрх үүргийг нь тусдаа зохицуулах;
- Өмгөөлөгчийн ёс зүйг дээшлүүлэх, тэдэнтэй хариуцлага тооцох асуудлыг нарийвчлан хуульд тусгаж өгөх;
- Хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа дууссан тохиолдолд өмгөөлөгч авах гэсэн хүсэлтийг хүлээж авахгүй байхаар зохицуулалт хуульд тусгаж өгөх;

- Шүүх хуралдаан зарлагдахаас өмнө хэргийн материалтай танилцуулж, өмгөөлөгч авах эрхтэй гэдгийг тайлбарлан, өмгөөлөгч авах эсэхийг тодруулан гарын үсэг зуруулах хэлбэрээр баталгаажуулах.

2.2. Шүүхээс шалтгаалан шүүх хуралдаан хойшилж буй үндэслэл

2.2.1. Хэргийн оролцогчид эрх, үүргийг тайлбарлаагүй

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрхийг бүрэн хангаж чадсанаар шүүх эрх зүйн маргааны талаар хууль ёсны шийдвэр гаргах үндэслэл бүрддэг учир хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэний хэргийн оролцогчдын эдлэх эрх, хүлээх үүргийг зөв тодорхойлох, тэдэнд хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд нь шүүхийн зүгээс шаардлагатай нөхцөл, боломжийг хангаж ажиллах нь зүйтэй юм.

Шүүхээс хэргийн оролцогчдын эдлэх эрх, хүлээх үүргийг анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлэх үед буюу иргэний хэрэг үүсгэх үеэс зохигчдод эрх, үүргийг нь танилцуулж, хуульд зааснаар хангах асуудал нь шүүхийн нэн тэргүүний зорилго мөн. Учир нь хэргийн оролцогч өөрт хуулиар олгогдсон эрхийг эдлэхгүй байх эрхтэй хэдий ч шүүх эдгээр эрхийг эдлэх бүхий л боломжоор хангасан байх нь шүүхийн шийдвэрийн хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг баталгаажуулна.

Шүүх энэ зорилгодоо хүрэхийн тулд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тодорхой үе шатуудыг дамжин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулна. Дээрх ажиллагаа нь хэргийг анхан шатны шүүх хуралдаанд бэлтгэх үе шатаар эхлэх ба энэ үе шат нь хэргийг үнэн зөв, түргэн шуурхай шийдвэрлэх, маргаантай эрх зүйн харилцааны шинж чанарыг тодруулах, материаллаг эрх зүйн хэм хэмжээг зөв хэрэглэж талуудын эрх үүргийг зөвөөр тодорхойлох ач холбогдолтой.

Гэхдээ энэ үе шат нь хуулийн шаардлагад нийцэх хэмжээнд хүрээгүй, зарим талаар дутагдалтай буюу ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлд заасан хэргийн оролцогчдын эрх үүргийг бүрэн тайлбарлаж, танилцуулдаггүй дутагдалтай байгаа нь шүүхийн практикаас ажиглагдаж байна.

Шүүгч энэхүү ажиллагааг хэрхэн үр дүнтэй явуулснаас шалтгаалан талуудын мэтгэлцээн хуульд заасны дагуу явагдах, хууль зүйн үндэслэл бүхий нотлох баримт бүрдүүлж цуглуулах, улмаар шүүх хэрэгт авагдсан нотлох баримтын хүрээнд хэргийг хуульд нийцүүлэн шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой байдаг. Эрх үүргийг огт тайлбарлаагүй гэсэн тохиолдол гараагүй ч “тайлбар” нь учир дутагдалтай байх тохиолдол байгааг анхаарах нь зүйтэй.⁵²

ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлд заасан хэргийн оролцогчдын эдлэх эрх, хүлээх үүргийн утга, учрыг шүүх бүрэн тайлбарлахгүйгээр хуулийн зүйл, заалтыг уншуулах, ойлгож танилцсан гэж гарын үсэг зуруулах зэргээр хэлбэрийн төдий ажиллагааг зарим тохиолдолд явуулж байна. Энэ нь хэдийгээр ажлын ачаалалтай

⁵² Улсын дээд шүүхийн зөвлөмж, 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдөр.

холбоотой хэдий ч байнга явагддаг процесс тул шүүхийн туслах ажилтны хувийн зохион байгуулалт ажлын туршлага, цаг ашиглалтаас шууд хамааралтай байж болох юм.

Хэргийн оролцогчдын эрх, үүргийн зааг ялгааг тайлбарлан ойлгуулдаггүй. Тухайлбал, үүргийг нь танилцуулсан боловч, эрхийг нь бүрэн тайлбарлахгүй байх. Аливаа харилцаа эрх, үүргийн нэгдлээс үүсдэг тул аль нэг бүрдэл хэсгийг нь орхигдуулсан нь доголдол үүсэх гол шалтгаан болдог.

ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлд хэргийн оролцогчдын нийтлэг эрх, үүргийг тусгасан ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа тус бүрт тухайн эрхээ хэрхэн хэрэгжүүлэхийг чиглүүлэн тайлбарлах ёстой. Тухайлбал, үе шат бүрийн онцлог байдлаас хамааран тухайн тохиолдол бүрт эдлэх эрх, хүлээх үүргийг танилцуулах мөн ИХШХШТХ-ийн 25.1.7-д заасан “хуульд заасан бусад эрх” гэдгийг товч байдлаар тайлбарлах шаардлагатай.

Мөн бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд эсхүл бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээд, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс оролцож байгаа прокурор, төлөөллөөр оролцож байгаа субъект тус бүрт эрх зүйн байдлыг нь тайлбарлан өгч чиглүүлж ойлгосон эсэхийг нь лавлаж асууж байх нь иргэний хэрэг хуульд заасан зарчим, зорилгын дагуу түргэн шуурхай шийдвэрлэгдэх ач холбогдолтой байна.

Дүгнэлт

ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлд заасан эрх, үүргийг танилцуулсан, тайлбарласан боловч зөв ойлгосон эсэхийг тодруулах шаардлагатай. Тухайлбал, нарийн мэргэжил эзэмшээгүй, хуулийн тодорхой мэдлэг ойлголт багатай иргэн нь шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог, зарчим, агуулга зэргийг нарийн нэг мөр ойлгож хүлээн авах боломжгүй байх талтай ба ойлгосон эсэхийг лавлаж асууж байх нь ач холбогдолтой бөгөөд нэн шаардлагатай ажиллагаа юм.

Дээр дурдсанчлан хэргийн оролцогчдын эрх, үүргийг шүүх хангалттай тайлбарлаж танилцуулах нь зайлшгүй хэдий ч эсрэгээрээ хэргийн оролцогчид нь ойлгомжгүй, тодорхойгүй асуудлыг лавлаж байх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа түргэн шуурхай явагдах нэг үндэслэл болох юм. Учир нь шүүхийн эрх, үүрэг, бусад оролцогчдын эрх үүрэгтэй харилцан уялдаа холбоотой хэрэгжинэ. Ийнхүү нэг субъектийн эрх, нөгөө субъектийн үүргээр хангагдаж иргэний хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн харилцааны агуулгыг бүрдүүлэх учиртай.⁵³

Санал

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хэргийн оролцогчдод эрх, үүргийг нь тайлбарлах ажиллагаанд холбогдох дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

⁵³ З.Мөнхжаргал, Монгол Улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, УБ., 2009 он, 119 дэх тал.

- Иргэний хэргийн оролцогч бүрт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх, үүргийг тайлбарлах, ойлгосон эсэхийг лавлан асууж гарын үсэг зуруулах хэлбэрээр баталгаажуулах;
- Хэргийн оролцогчдын эрх, үүргийг нэг дор бүгдийг нь танилцуулах бус иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрд юу хийх хэрхэн идэвхтэй үйлдлээр эрх, үүргээ хэрэгжүүлэх ёстойг тайлбарладаг байх;
- Хэргийн зохигчдоос гадна тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчдөд эрх, үүргийг нь заавал тайлбарлан ойлгосон эсэхийг лавлан гарын үсэг зуруулах хэлбэрээр баталгаажуулах /энэ нь эрх, үүргээ ойлгоогүйгээс гэх үндэслэлийг багасгах боломжтой/;
- Хэргийн оролцогчдын эрх, үүргийг зөвхөн зохигчдод танилцуулдаг, зарим тохиолдолд ИХШХШТХ-ийн 22 дугаар зүйлд заасан бүх субъектийг хамруулан ажиллагаа явуулдаггүй сул талтай. Тухайлбал, зохигч болон гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, бусдын эрх ашгийг хамгаалах бүрэн эрх хуулиар олгогдсон этгээдэд эрх, үүргийг зааг ялгаатай танилцуулж, тайлбарладаг байх;⁵⁴
- Шүүгч, шүүгчийн туслахын ажиллах арга барилыг өөрчлөх, ур чадварыг нэмэгдүүлэх зэрэг болно.

2.2.2. Хэргийн оролцогчид шүүх хуралдааны тов хүрээгүй

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлд “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна” гэж заасан. Шүүхийн мэдэгдэх хуудсыг зохигч, түүнчлэн шүүх хуралдаанд ирвэл зохих бусад оролцогчдод мэдэгдэх нь мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх, хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх боломжийг олгож байгаа чухал ажиллагаа юм.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь иргэн, хуулийн этгээдээс зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд нэхэмжлэл, гомдол хүсэлт гаргах, шүүх түүнийг хүлээн авч хянан шийдвэрлэх цаг хугацаа, үйл явцыг хамарсан ойлголт юм.⁵⁵

Шүүхэд болон шүүх хуралдаанд хүрэлцэн ирснээр хэргийн оролцогч аливаа этгээдийн ИХШХШТХ-ийн дагуу эрх зүйн маргаанд шүүхэд мэдүүлэх, нээлттэй байх үндсэн зарчмын тулгуур эрхүүдийг хангаж ажиллах нь шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чиглэл байх учиртай.⁵⁶

Иргэний хэрэг үүсгэн нэхэмжлэлийг хүлээн авсан тохиолдолд шүүх хуралдаанд бэлтгэх бөгөөд энэ нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг чухал үе шат байдаг. Тухайлбал, анхан шатны шүүх буюу шүүгч хэргийг зохигч,

⁵⁴ Улсын дээд шүүхийн зөвлөмж, 2010 оны 06 дугаар сарын 2-ны өдөр.

⁵⁵ “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй” гарын авлага, УБ., 2007 он, 31 дэх тал.

⁵⁶ Х.Ганболд, Хэргийн оролцогч болон шүүх хуралдааны оролцогчдыг шүүхэд болон шүүх хуралдаанд дуудах ажиллагааны талаар, Монголын төр, эрх зүй сэтгүүл, УБ., 2015 он, Дугаар 2, 28 дахь тал.

гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн нэмж гаргаж өгсөн нотлох баримтыг хүлээн авах, зохигчийн хүсэлтээр нотлох баримтыг бүрдүүлэх, шинжээч, орчуулагчийг томилох, шүүх хурлын товыг хэргийн зохигч болон оролцогчдод мэдэгдэх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг томилох зэрэг шүүх хуралдаанаар хэргийг хэлэлцэхэд урьдчилан бэлтгэх ажиллагааг явуулна.

Дээрх ажиллагааг бүрэн хийсэн гэж үзсэн тохиолдолд зохигч, түүнчлэн шүүх хуралдаанд ирвэл зохих бусад оролцогчдод шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг шүүхийн мэдэгдэх хуудсаар тэдгээрийн оршин суугаа буюу ажлын газрын хаягаар шүүхэд хүрэлцэн ирэх, шүүх хуралдаанд бэлтгэх боломжтой хугацааг харгалзан мэдэгдэх нь зарчмын асуудал юм.

Сүүлийн жилүүдэд хэргийн оролцогчид нь өөрсдийн нэрийн өмнөөс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд аливаа этгээдийг оролцуулах тохиолдол ихэссэнтэй холбогдуулан тэднийг шүүхэд дуудахад төлөөлөгчийн хаяг тодорхойгүй, өмгөөлөгчийн хаяг албан ёсны бус байдлаас хамааран шүүхэд ирүүлж нотлох баримтуудтай танилцах, шүүх хуралдаанд оролцуулж мэтгэлцүүлэх зарчмыг хангуулах ажиллагаа тодорхой бус хугацаагаар саатдаг байдал орон нутгийн шүүхүүдэд их гарах болсон.⁵⁷

Шүүгч болон шүүхийн захиргааны ажилтнууд ИХШХШТХ-ийн 77 дугаар зүйлд заасныг баримтлан бичиг хүргэгч, шүүгчийн туслахын ажлын чиг үүрэгт нь хамааруулан зохигч болон бусад этгээд /гэрч, шинжээч/ -ийг шүүхэд мэдэгдэх хуудсаар дууддаг байна.

Бусад орны зохицуулалтыг авч үзвэл, Тухайлбал, ОХУ-ын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шүүх хуралдааныг хойшлуулсан бол тухайн үед дараагийн хурлын товыг гаргаж хэргийн оролцогчдод мэдэгдэх ба шаардлагатай нотлох баримт шүүх хуралд гаргаж өгөх болон өмнөх шүүх хуралд ирээгүй хэргийн оролцогчдод шүүхийн зарлан дуудах хуудсаар мэдэгдэнэ. Шүүн таслах ажиллагаанд оролцож чадаагүй болон шинээр илэрсэн хэргийн оролцогчдод хойшилсон хуралдааны товыг мэдэгдэнэ гэж хуульчилжээ.⁵⁸

Харин Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хэргийн оролцогчид шүүх хуралдааны товтой шүүх хуралдаан эхлэхээс 7 хоногийн өмнө танилцсан байхаар зохицуулалттай байна.⁵⁹

Энэхүү процесс ажиллагааг ИХШХШТХ болон Улсын дээд шүүхээс гаргасан тайлбарт дараах байдлаар тусгажээ.

Хүснэгт 9

Хуулийн зүйл заалт	Тайлбарт
--------------------	----------

⁵⁷ Х.Ганболд Хэргийн оролцогч болон шүүх хуралдааны оролцогчдыг шүүхэд болон шүүх хуралдаанд дуудах ажиллагааны талаар, Монголын төр, эрх зүй сэтгүүл, УБ., 2015 он, Дугаар 2, 28 дахь тал.

⁵⁸ Гражданский процессуальный кодекс Российской Федерации, Статья 169.2.

⁵⁹ Code of Civil Procedure of Germany, Section 217.

<p>76.1.2.хэргийн болон шүүх хуралдааны оролцогчдод шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг шүүхийн мэдэгдэх хуудсаар мэдэгдэх.</p>	<p>Хэргийн оролцогчид нь хэргийн нөхцөл байдлын талаар өөрийн тайлбараа өгөх боломжоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хангагдах ёстой. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэтгэлцэх зарчимтай холбоотой юм.</p> <p>Шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг хэргийн оролцогчдод шүүхийн мэдэгдэх хуудсаар мэдэгдэх бөгөөд энэ үүргийг шүүх хүлээнэ. Шүүхийн мэдэгдэх хуудсыг ИХШХШТХ-ийн 77 дугаар зүйлд заасан журмын дагуу хүргүүлэхдээ шүүх хуралдаанд биечлэн ирж оролцох боломжтой хугацааны өмнө мэдэгдэнэ.</p>
---	---

Нийслэлийн 9 дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хэмжээнд дээрх шалтгаанаар шүүх хуралдаан хойшилсон шүүгчийн захирамжийг 2013-2017 оны байдлаар шүүхийн статистик мэдээллээс нэгтгэн харвал /давхардсан




тоогоор/:

- Нийслэлийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2013-2014 оны шүүх хуралдаан хойшилсон шүүгчийн 1000 захирамжтай танилцахад 2013 онд 20, 2014 онд 24 хэрэг маргаан шүүх хуралдааны тов мэдэгдээгүй гэсэн үндэслэлээр;⁶⁰
- 2015 онд нийт 13166 хэрэг, маргаан хойшилсноос 43 буюу 0.3 хувь нь шүүх хуралдааны тов мэдэгдээгүй гэсэн үндэслэлээр;
- 2016 онд нийт 11298 хэрэг, маргаан хойшилсноос 130 буюу 1.7 хувь нь шүүх хуралдааны тов мэдэгдээгүй гэсэн үндэслэлээр;
- 2017 онд нийт 13751 хэрэг, маргаан хойшилсноос 71 буюу 0.7 хувь нь шүүх хуралдааны тов мэдэгдээгүй гэсэн үндэслэлээр тус тус хойшилсон байна.

Орон нутаг дахь 20 аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хэмжээнд дээрх шалтгаанаар шүүх хуралдаан хойшилсон шүүгчийн захирамжийг 2013-2017 оны эхний хагас жилийн байдлаар шүүхийн статистик мэдээллээс нэгтгэн харвал /давхардсан тоогоор/

⁶⁰ 2013-2014 оны дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн статистик мэдээллийг "Шүүхийн төрөлжсөн" архиваас шүүх хуралдаан хойшлуулсан 1000 шүүгчийн захирамжийг түүвэрлэн гаргасан болно.



- 2013 онд нийт 1652 хэрэг, маргаан хойшилсноос 20 буюу 1.2 хувь нь шүүх хуралдааны тов хүрээгүй гэсэн үндэслэлээр;
- 2014 онд нийт 1950 хэрэг, маргаан хойшилсноос 34 буюу 1.7 хувь нь шүүх хуралдааны тов мэдэгдээгүй гэсэн үндэслэлээр;
- 2015 онд нийт 2917 хэрэг, маргаан хойшилсноос 37 буюу 1.2 хувь нь шүүх хуралдааны тов мэдэгдээгүй гэсэн үндэслэлээр;
- 2016 онд нийт 3351 хэрэг, маргаан хойшилсноос 38 буюу 1.1 хувь нь шүүх хуралдааны тов мэдэгдээгүй гэсэн үндэслэлээр
- 2017 оны эхний хагаст нийт 1715 хэрэг, маргаан хойшилсноос 19 буюу 1.1 хувь нь шүүх хуралдааны тов мэдэгдээгүй гэсэн үндэслэлээр хойшилсон байна.

Энэхүү статистик дүнгээс харахад 2013-2017 оны хооронд шүүх хуралдаан хойшилж буй тоон үзүүлэлт аймаг, нийслэлд өссөн дүнтэй байна. Мөн шүүх хуралдааны тов хүрээгүй гэсэн үндэслэлээр шүүх хуралдаан хойшилж буй тоо ч жилд сум, сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2-4 байхад, нийслэлийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд маш их хэлбэлзэлтэй тоон үзүүлэлт харагдаж байна. Харин нийслэлийн болон аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн хувьд шүүх хуралдааны тов хүрээгүйгээс шалтгаалан шүүх хуралдаан хойшилсон дүн алга байна.

Дээрх тоон үзүүлэлтээс дүгнэхэд шүүх хуралдааны тов хүрээгүй гэсэн шалтгаанаар шүүх хуралдаан хойшилж буй нь орон нутагт 1.27 хувь, нийслэлд 0.6 хувь байгаа нь орон нутагт илүү гарч байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Хэрэв энэхүү шалтгааныг шүүхийн зүгээс шүүх хуралдаан хойшилж байна гэсэн үндэслэлд оруулбал давтамжийн тоогоороо өндөр байгаа 4 шалтгаанаас 23 хувийг эзэлж байгаа нь 180 шүүгчээс авсан судалгаанаас⁶¹ харагдаж байна.

⁶¹Нийслэлийн 9 дүүрэг, орон нутаг дахь 20 аймгийн Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн 180 шүүгчээс авсан анкетын судалгаа. /2018 он/



53 өмгөөлөгчөөс авсан анкетын судалгаанаас үзвэл хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов хүрээгүйгээс шалтгаалан шүүх хуралдаан хойшилж буй нь 24.6 хувийг эзэлж байна.

Хүснэгт 10

№	Үндэслэл	Тоо	Сонголтын хувь	Тохиолдлын хувь
1.	Шүүх хуралдааны явцад шинээр нотлох баримт шаардагдвал	49	25.7%	92.5%
2.	Хүндэтгэн үзэх шалтгаан	49	25.7%	92.5%
3.	Хэргийн оролцогчид шүүх хуралдааны тов хүрээгүй	47	24.6%	88.7%
4.	Шүүх хуралдааны танхимын хүрэлцээгүй байдал	46	24.1%	86.8%
Нийт		191	100.0%	360.4%

Дүгнэлт

Шүүхэд болон шүүх хуралдаанд дуудах үйл ажиллагааг хуульд нийцүүлж хэрэгжүүлэх талаар Улсын дээд шүүхээс хууль тайлбарласан тогтоол, зөвлөмж болон Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс шүүхийн захиргааны ажлын дүрэм, журмыг шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байгаа боловч зарим асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлага гарч байна. Энэхүү хуулийн зохицуулалтаас үзэхэд шүүх нь шүүхийн захиргааны ажилтнаас бусад шүүх хуралдааны оролцогч нарт бүгдэд нь шүүх хуралдааны товыг нэг ижил мэдэгдэх хуудсаар хүргүүлж байгаа нь эрх зүйн этгээдийн эрх үүрэгт нь уялдуулах ажиллагаа орхигдон хэрэгжүүлж ирсэн харагдаж байна.

Зарим тохиолдолд шинээр орсон шүүгчийн туслах ажилдаа дадаагүйгээс болж зохигчдод хурлын товыг мэдэгдэж чадаагүй тохиолдол гардаг бөгөөд энэ нь мөн л шүүх шаардлагатай гэж үзэж шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болдог. Гэтэл хуульд шүүх хуралдааны товыг шүүхийн зүгээс хүргэж чадаагүй бол хурлыг хэрхэх талаар ямар нэгэн зохицуулалтгүй байна. Энэ тохиолдолд шүүх шаардлагатай гэж үзэж шүүх хуралдааныг хойшлуулах зохицуулалтыг тус зүйлд нарийвчлан зохицуулах шаардлага бий гэж үзэж байна.⁶²

Хэргийн болон шүүх хуралдаанд биечлэн оролцох шаардлагатай байтал ирэхгүй байх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг мухардалд оруулах, хугацаа алдахад хүргэдэг тохиолдол мөн практикт нэлээдгүй байна.

Санал

Дээрх нөхцөл байдлыг харгалзан дараах саналыг гаргаж байна.

- Шүүх хуралдааны товыг шүүхээс лавлах үүргийг сайн тайлбарлан, танилцуулж түүнийгээ баталгаажуулан авах, энэхүү үүргээ биелүүлээгүй тохиолдолд хэргийн оролцогчдод хариуцлага тооцдог байх;
- Шүүх хуралдааны оролцогчдыг шүүх хуралдаанд оролцуулах товыг гар утсаар нь дамжуулан шүүхийн утаснаас мессеж хүргүүлэх арга хэлбэрийг нэвтрүүлэх боломжтой. Энэ үйл ажиллагааг нэвтрүүлснээр шүүх хуралдааны тов мессежээр шүүх хуралдааны оролцогчдод хүргэгдсэн тохиолдолд өмнө нь шүүх хуралдааны оролцогчид унших, уншихгүйгээс үл хамаарч мэдэгдсэнд тооцох талаар эрх үүрэг тайлбарлахдаа танилцуулж баримтжуулсан үндэслэлээр хуулийн дагуу мэдэгдсэнд тооцох боломжтой гэж үзэж болно,⁶³
- Шүүх хуралдааны мэдэгдлийг боломжит хугацаанд хүргүүлэх, шүүх хуралдаанаас өмнө хэргийн баримттай сайтар танилцах боломжийг хангах гэсэн 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн дугаар 01 Улсын дээд шүүхийн зөвлөмжийг чанд сахин ажиллах шаардлагатай байна.

3. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны онолын ойлголт, судалгаа, статистик тоо баримтад тулгуурлан иргэний хэргийг хуульд заасан хугацааны дотор хянан шийдвэрлэхэд юуг анхаарах, хугацаа тогтоосон зохицуулалтыг хуулийн бусад зохицуулалттай хэрхэн уялдуулах зөв зүйтэй тайлбарлаж хэрэглэх талаар судалж тогтоосноор хэрэг маргааныг түргэн шуурхай шийдвэрлэх, зохигчид тэгш боломжийг бий болгох, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа эрх тэгш байх зарчимд үндэслэх тухай ИХШХШТХ-ийн 4

⁶² Т.Энхтуяа, "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шүүх хуралдааныг хойшлуулахтай холбоотой зохицуулалт", Монголын төр, эрх зүй сэтгүүл. УБ., 2013 он, Дугаар 2, 37 дахь тал.

⁶³ Х.Ганболд, Хэргийн оролцогч болон шүүх хуралдааны оролцогчдыг шүүхэд болон шүүх хуралдаанд дуудах ажиллагааны талаар, Монголын төр, эрх зүй сэтгүүл, УБ., 2015 он, Дугаар 2, 29 дэх тал.

дүгээр зүйлийн 4.1-д заасан зарчмыг шүүхийн практикт хэрэгжүүлэхэд ач холбогдолтой юм.

Шүүхийн ажлын ачаалал, хэргийн нөхцөл байдлаас шалтгаалж нэхэмжлэлийг хүлээн авч, иргэний хэрэг үүсгэсэн шүүгч ИХШХШТХ-ийн 67 дугаар зүйлд заасан ажиллагааг бүрэн гүйцэд хийдэггүй тухайлбал, хэргийн оролцогчдод эрх үүргийг нь бүрэн дүүрэн тайлбарлан ойлгуулж чаддаггүйгээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиар тогтоосон хугацаа хэтрэх, удаашрах төлөв ихээхэн ажиглагддаг нь ИХШХШТХ-ийн 25, 26 дугаар зүйлд заасныг буруу тайлбарлан хэрэглэх практик тогтжээ.⁶⁴

Шүүхийн нэгдсэн системд хэргийн оролцогчдоос шалтгаалан шүүх хуралдаан хойшлогдож байгаа үндэслэлийг тус бүрээр нь ялган нэгдсэн мэдээлэл гаргадаг хэдий ч бусад гэсэн үндэслэлийг нарийн тодорхойлдоггүй байна. Бусад гэсэн үндэслэл нь нийт шүүх хуралдаан хойшилж байгаа шалтгааны ихэнх хувийг эзэлж байгаа хэдий ч тодорхой үндэслэл заахгүйгээр бүртгэсэн байгаа нь практикийн хувьд ач холбогдолгүй юм. Мөн асуудал хаана үүсч байгааг ерөнхий байдлаар тодорхойлох боломжгүй нөхцөлийг бий болгож байна.


Бусад шалтгаан дотор хэргийн оролцогчдод эрх, үүргийг танилцуулаагүй, хариуцагч сөрөг нэхэмжлэл гаргасан, эвлэрэх хүсэлт гаргасан, төлөөлөх бүрэн эрхгүй этгээд оролцсон, хариуцагч түүний төлөөлөгч, өмгөөлөгчийг шүүх хуралдаанд биечлэн оролцуулах хүсэлт гаргасан, хамтран хариуцагчаар татах, зэрэг асуудлууд хамаарч байна.

Гарын авлагыг бэлтгэхэд нийслэлийн болон орон нутгийн шүүхээс статистик дүн мэдээллийг нэгдсэн системээс нь гаргуулан авсан хэдий ч зарим талаараа хэт хэлбэлзэлтэй /зөрүү ихтэй/ тоон мэдээлэл цөөнгүй байсан. Энэ нь шүүхүүд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой гардаг шүүгчийн захирамжаа системдээ бүртгэн оруулахдаа нэгдсэн ойлголтгүй байдаг болов уу гэсэн ойлголт төрүүлэхээр байна. Учир нь хэргийн оролцогчийн зүгээс гаргасан хүсэлтийг шийдвэрлэсэн захирамжийг системдээ оруулахдаа 3-4 хүсэлтийн нэгийг нь сонгон авч оруулдаг бах жишээтэй. Иймээс шүүхийн нэгдсэн системд мэдээлэл оруулах талаар нэгдсэн ойлголттой болох, мөн хүсэлт болгоныг нэрээр нь оруулахгүй бол бусад гэсэн ангилал руу нэлээд олон тооны захирамж бүртгэгддэг байх юм.

Шүүх хуралдааныг хойшлуулж буй шалтгааныг бууруулах арга зам нь урьдчилсан хэлэлцүүлэг байж болох юм гэж үзсэний үндсэн дээрээс “Урьдчилсан хэлэлцүүлэг”-ийг ИХШХШТХ-д тусгах нь оновчтой юу ? гэх асуултыг 180 шүүгч, 53 өмгөөлөгчид тавихад 51.3 хувь нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлд заасан “Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг” Иргэний хэргийн шүүхэд хэрэгжүүлэх боломжтой гэж хариулсан байна.

⁶⁴ Б.Хишигбаатар, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа, практик хэрэглээ, Шүүх эрх мэдэл эмхэтгэл, УБ., 2017 он, Дугаар 3, 119 дэх тал.

Тиймээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан урьдчилсан хэлэлцүүлгийг тусгах боломжтой эсэхийг судлах шаардлага үүсч байна.



Дээрх судалгаанаас үзэхэд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах боломжтой хэдий ч өмгөөлөгчдийн ёс зүй, хариуцлагыг сайжруулахгүйгээр энэ асуудлыг шийдэх боломжгүй юм.

4. НЭГДСЭН САНАЛ

Хэрэг хянан шийдвэрлэж буюу шүүгч батлагдсан хууль тогтоомжийг чанд мөрдөж, эрх зүйн онолын үүднээс үндэслэл бүхий тайлбарлан, нэг мөр, зөв хэрэглэх шаардлагатай ба ингэснээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдод тэгш боломжийг олгох, шүүхийн өмнө эрх тэгш байх хуулиар тогтоосон зарчмын хэрэгжилтийг хангах үндэс болох юм.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шүүх хуралдаан хойшлох буюу удааширч буй шалтгаан нөхцөлийг багасгах зорилгоор хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, шүүгчийн ажлын зохион байгуулалт, хууль хэрэглээний хүрээнд болон бусад арга замаар хэрхэн шийдвэрлэж болох талаар бүлэг тус бүрээр дараах саналыг гаргаж байна. Үүнд:

Нэг. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хүрээнд:

1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “Шүүх хуралдаанд оролцож мэдүүлэг өгөөгүй тал нь үүнээс үүссэн зардлыг хариуцна, үүнд: мэдүүлэг өгөөгүйгээс шалтгаалан шүүх хуралдаан хойшлогдох, эсхүл аман мэдүүлгээс шалтгаалан хойшлогдох, мөн түүнчлэн аман мэдүүлэг өөрчлөгдөх зэргээс шалтгаалсан бол” гэж хуульчилж өгсөн байна.⁶⁵ Энэхүү зохицуулалтыг өөрийн орны онцлогт нийцүүлэн тусгаж өгөх. Тухайлбал, хойшлуулах хүсэлт гаргасан талаас эсрэг талд гарах тодорхой зардлыг төлүүлдэг байх;

⁶⁵ Code of Civil Procedure of Germany, Section 95.

2. Урьдчилсан хэлэлцүүлгийг иргэний хэргийн шүүхэд хэрэгжүүлснээр нотлох баримт гаргаж өгөх, эрх үүргээ дутуу ойлгосон гэсэн шалтгаан нөхцөлөөр шүүх хуралдаан хойшлуулах үндэслэлүүд буурах сайн талтай байж болох юм. Тиймээс урьдчилсан хэлэлцүүлгийг маргааны төрөл, хэргийн зохигчдын тоо зэргийг харгалзан зохион байгуулах /ИХШШТХ-н 105.2-т урьдчилсан хэлэлцүүлгийн талаар заалт оруулж өгөх/;
3. Америкийн Нэгдсэн Улсын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүх хуралдааны өмнөх зөвлөгөөнийг явуулдаг. Шүүх хуралдааны өмнөх зөвлөгөөн гэдэг нь шүүх хуралдаанаас өмнө шүүгч талуудын өмгөөлөгчтэй хэргийн нөхцөл байдлын талаар зөвлөлдөх ба практик ёсоор зөвхөн шүүгчид болон талуудын өмгөөлөгчид л зөвлөлдөх эрхтэй байдаг. Энэхүү зөвлөлдөх хуралдаан дээр талуудын хооронд маргааны зүйл болоогүй хэргийн нөхцөл байдлыг тогтоож, зөвшилцөлд хүрэхийг хичээдэг. Энэ ажиллагаа хийгдсэнээр шүүх хуралдааны явцад хэлэлцэгдэх олон асуудал цөөрөх бөгөөд шүүх хуралдаан үр дүнтэй явагдах нөхцөл бүрдэнэ.⁶⁶ Энэ зохицуулалтыг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгах боломжтой эсэхийг судлах;
4. Нотлох баримтыг ИХШШТХ-ийн 38.7, 25.1.3-д заасан хүсэлтийг хэлэлцүүлэх захирамж гаргахын өмнө гаргах, захирамж гарснаас хойш хүсэлт хүлээж авахгүй гэсэн өөрчлөлт оруулах;
5. ИХШШТХ-ийн 87 дугаар зүйлд шүүх хуралдааны нарийн бичгийн хийх ажлыг хуульчилсан байна. Энэхүү заалтаар шүүгчийн туслахын ажил үүргийн хуваарийг шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хийхээр хуульчилсан байгаа нь бодит амьдралд нийцэхгүй байна. Иймд шүүгчийн туслахын эрх зүйн байдлыг тодорхойлон хуулийн заалтыг нэмж оруулах шаардлагатай;
6. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Иргэний процессын хуулийн 356 дугаар зүйлд⁶⁷ заасны адил шүүхээс нотлох баримтыг гаргаж өгөх хугацааг тогтоож өгөх ба хугацаа өнгөрсөн тохиолдолд зөвхөн шүүхийн шийдвэрээр тухайн нотлох баримтыг ашиглах эсэхийг шийдэх, энэ нь шүүх хуралдаан хойшлогдох шалтгаан болохгүй хэмээн хуульд тусгах;
7. Хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа дууссан тохиолдолд өмгөөлөгч авах гэсэн хүсэлтийг хүлээж авахгүй байхаар зохицуулалт хуульд тусгаж өгөх;
8. Шүүх хуралдааныг 2 удаа хойшлуулсан тохиолдолд дахин хойшлуулахгүйгээр үргэлжлүүлдэг зохицуулалтыг ИХШШТХ-д оруулж өгөх.

Хоёр. Шүүгчийн ажлын зохион байгуулалт, хууль хэрэглээний хүрээнд:

1. ИХШШТХ-ийн 67 дугаар зүйлийн 67.1.1.-д заасан зохицуулалтаар шүүгч, зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчид шаардлага ба татгалзлаа үндэслэж буй нотлох баримтаа өөрөө гаргаж нотлох үүрэгтэйг танилцуулж, эдлэх эрхийг нь тайлбарлан өгөх үүрэгтэй.

⁶⁶ АНУ-ын эрх зүйн зохицуулалтын товчоон, 177 дахь тал.

⁶⁷ Germany Code of Civil procedure. Section 356.

Харин шүүгчийн туслах ажилтан хэргийн оролцогчид эрх, үүргийг нь танилцуулж байгаа нь хэлбэр төдий бөгөөд зөвхөн танилцуулсан гэдэг утгаар ойлгогдож байна. Иймд шүүгч хэргийн оролцогчид эрх, үүргийг нь тайлбарлаж өгөх шүүгчийн ажиллагааг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэг бус удаа хийх учиртай. Тухайлбал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрд онцлог зохицуулалт болоод агуулгыг нь тодорхой тайлбарлаж өгөх, эсхүл шүүгчийн туслахын эрх, үүргийг нэг бүрчлэн ИХШШТХ-д тодорхойлон хуульчилж, хэргийн оролцогчид эрх, үүргийг нь танилцуулах, тайлбарлах болон бусад ажиллагааг хуульд заасан арга, хугацаанд гүйцэтгэх ёстойг тодорхойлон, гүйцэтгэвэл зохих ажлыг хийгээгүй тохиолдолд хариуцлага тооцдог байх;

2. Шүүгч, шүүгчийн туслахын ажил үүргийн хуваарийг зөв хуваарилж, хяналт тавих, арга барилыг сайжруулах зорилгоор дараах хэлбэрээр ажиллах. Үүнд:
 - хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх хуулийн зохицуулалтыг зөв тайлбарлан хэрэглэх;
 - иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын дагуу ажиллах, шүүгч нь шүүгчийн туслахын ажилд хяналт тавих, мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй шүүхийн албан тушаалтан бүр өөрөө өөрийн ажилдаа хариуцлагатай хандах;
 - Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс баталсан “Иргэний хэргийн хөдөлгөөний стандарт”-ыг мөрдөж ажиллах;
 - шүүгчийн туслахаар ажиллахаар шинээр томилогдож буй ажилтан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг урьдчилан судалж, тухайн ажлыг гардан хийх хэмжээнд бэлтгэгдсэн байх асуудлыг шүүхийн Тамгын хэлтэс, албад анхаарч ажиллах шаардлагатай. Тамгын хэлтэс шүүхийн туслах ажилтныг зөвхөн томилж, ажлыг нь хүлээлгэж өгснөөр хязгаарлан, ажлын арга барилд сургаж дадлагажуулах үүргийг шүүгчид хүлээлгэдэг практикийг халж, шинээр ажилд орж буй шүүхийн туслах ажилтнуудтай дадлагын ажил, сургалтыг зохион байгуулж байх нь зүйтэй юм.
3. Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд мэтгэлцэх зарчмыг дараах хэлбэрээр ханган ажиллах. Үүнд:
 - зохигч шүүх хуралдаанд биечлэн оролцож үг хэлэх болон нотлох баримтыг шинжлэн судлах бүх нөхцөлийг бүрдүүлэх;
 - практикт туслах ажилтан шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг шүүхийн мэдэгдэх хуудсаар тэдгээрийн оршин суугаа буюу ажлын газрын хаягаар ИХШШТХ-ийн 76 дугаар зүйлийн 76.1.2 болон 77 дугаар зүйлд заасан журмын дагуу мэдэгдэж байгаа. Мөн шаардлагатай тохиолдолд шүүхийн мэдэгдэх хуудсыг утас, факс, цахилгаан буюу олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдэгдэж байгаа ийнхүү мэдэгдсэнээ баримтжуулж байгаа эсэхэд хяналт тавих;
 - шүүхийн мэдэгдэх хуудсыг зохих этгээдэд хүргүүлэх, мэдэгдэхийг зохих журмын дагуу хийгээгүй нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа хэтрүүлэх, үндэслэлгүйгээр шүүх хуралдаан хойшлуулах, шүүхийн шийдвэр,

магадлал хүчингүй болох үр дагаврын талаар шүүгч шүүхийн ажилтан болон нарийн бичгийн дарга нарт сайтар урьдчилан танилцуулж байх;

- шүүхийн мэдэгдэх хуудас нь шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг өөртөө агуулдгаас гадна хүрэлцэн ирээгүйгээс гарах үр дагавар болон ИХШХШтХ-ийн 100 дугаар зүйлд зааснаар хэргийг хянан шийдвэрлэх боломжийг тусгасан байдаг тул мэдэгдэх хуудсыг зохигч талын ажлын газрын хаягаар шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар хүргүүлэх ажиллагаанд хяналт тавих. Шаардлагатай тохиолдолд л утсаар мэдэгдэх боломжтойг ойлгуулах;
 - шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрд нотлох баримтын үнэлгээг хийх ба талуудын үндэслэл болон шаардлага нотолж байгаа баримтын хамаарах хэсгийг тодорхойлох нь зүйтэй юм. Энэ нь мэтгэлцээнийг зөв горимоор явуулахад чиглүүлэх шүүгчийн үүрэг болно. Өөрөөр хэлбэл, шүүх хэрэгт цугларч буй нотлох баримтыг хүлээн авсан цаг тухайд нь үнэлж чадвал маргааны зүйлийг тодорхой болгоход хэргийн оролцогчдыг чиглүүлэх, хэрэгт хамааралгүй болон хуулиар зөвшөөрөгдөөгүй баримтыг нотлох баримтаас хасах, хэргийн оролцогчдыг өөр нотлох баримт цуглуулах, гаргаж өгөх боломжоор хангах нөхцөл үүсэх сайн талтай.
4. Хүндэтгэн үзэх зайлшгүй нөхцөл байдал аль ч үед тохиолдож болох хэдий ч шүүх хуралдаан хойшлуулах үндэслэл болохын хувьд шүүгч дараах урьдчилсан нөхцөлийг шалгаж хүсэлтийг шийдвэрлэж байх. Үүнд:
- тухайн иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдод зайлшгүй нөхцөл байдал үүссэн байх;
 - шүүх хуралдаан эхлэхээс өмнө мэдэгдсэн байх;
 - хүндэтгэн үзэх шалтгаанаа нотлох баримтыг шүүхэд гаргаж өгсөн байх.
5. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчим нь хуулийн зохицуулалттай зөрчилдөж байна. Тухайлбал, ИХШХШтХ-ийн 71 дүгээр зүйлд заасан хугацааны дотор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах ёстой хэдий ч хангалттай нотлох баримт бүрдээгүй эсхүл хэргийн оролцогчдын хүсэлт үндэслэлтэй болоод заавал шийдвэрлэх нөхцөлд хүсэлтийг хангалгүйгээр хуульд заасан хугацааны дотор хэргийг шийдвэрлэхэд тодорхой зарчмыг⁶⁸ баримтлаагүй гэх үндэслэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах, дээд шатны шүүхээс хэрэг буцах зэрэг хүндрэлтэй нөхцөл байдал практикт байна. Иймд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчимд хэргийг түргэн шуурхай, үнэн зөв шийдвэрлэх /хуульд заасан боломжоор бүрэн хангасан гэж үзсэн тохиолдолд/ гэх зарчмыг тусгаж өгөх шаардлагатай.
6. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй шүүх нь дараах ажиллагааг уялдаа холбоотой, харилцан шүтэлцэлтэй, шат дараалан явуулснаар эрх зүйн маргааныг хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий

⁶⁸ Мэтгэлцэх зарчим, Хэргийн бодит үнэнийг тогтоох зарчим, Диспозитив зарчим гэх мэт.

байдлаар хянан шийдвэрлэх үндсэн нөхцөл бүрдэхийг анхаарах шаардлагатай.⁶⁹

- нэхэмжлэлийн шаардлага болон үндэслэл ойлгомжтой томъёологдсон эсэхийг тогтоох, эсхүл тодорхой болгох арга хэмжээ авах;
 - нэхэмжлэлд тусгагдсан үндэслэл, түүний үндсэн дээр гаргасан шаардлагын талаар маргаан байгаа эсэхийг тогтоох;
 - зохигчдын хооронд үүссэн эрх зүйн харилцааг тогтоож, маргаантай хэсгийг нь илрүүлэх;
 - хэргийн нөхцөл байдал бүрэн тогтоогдсон эсэхийг шалгах;
 - иргэний хэргийн маргааны зүйлийг тодорхойлж, талуудын мэтгэлцээнийг чиглүүлэх;
 - хэргийн талаарх талуудын байр суурийг тодорхой болгох;
 - маргаантай харилцааг зохицуулж буй хууль, хуулийн зүйл, заалтыг оновчтой сонгох;
 - сонгосон хуулийн зохицуулалтыг эрх зүйн тухайн хэм хэмжээний агуулгад нийцүүлэн зөв тайлбарлан хэрэглэх.
7. Шүүх хуульд заасан журмаар шинжээч томилохдоо дараах хэд хэдэн үндэслэлд анхаарлаа хандуулах шаардлагатай. Үүнд:
- Шинжээч томилуулах тухай хэргийн оролцогчийн хүсэлт нь хууль зүйн үндэслэлтэй, хэрэгт ач холбогдолтой эсэхийг сайн нягтлан үзсэний үндсэн дээр хүсэлтийг хангах асуудлыг шийдвэрлэж байх;
 - Шинжилгээний дүгнэлт гаргуулах хугацааг шинжилгээ хийлгэх объектын онцлогийг харгалзан маш нарийн тогтоож өгөх;
 - Шүүхээс тогтоосон хугацааны дотор шинжилгээний хариуг ирүүлж байх, хугацаандаа ирүүлээгүй тохиолдолд хэрхэн зохицуулах талаар хуульд тодорхой тусгаж өгөх шаардлагатай.
8. Шүүх хуралдаан зарлагдахаас өмнө хэргийн материалтай танилцуулж, өмгөөлөгч авах эрхтэй гэдгийг тайлбарлан, өмгөөлөгч авах эсэхийг тодруулан гарын үсэг зуруулах хэлбэрээр баталгаажуулах;
9. Хэргийн зохигчдоос гадна тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчдөд эрх, үүргийг нь заавал тайлбарлан ойлгосон эсэхийг лавлан гарын үсэг зуруулах хэлбэрээр баталгаажуулах /энэ нь эрх, үүргээ ойлгоогүйгээс гэх үндэслэлийг багасгах боломжтой/;
10. Шүүх хуралдааны товыг шүүхээс лавлах үүргийг сайн тайлбарлан, танилцуулж түүнийгээ баталгаажуулан авах, энэхүү үүргээ биелүүлээгүй тохиолдолд хэргийн оролцогчдод хариуцлага тооцдог байх.

Гурав. Бусад саналын хүрээнд:

1. Шүүхийн цахим хуудсыг боловсронгуй болгох;
2. Өмгөөлөгчийн ёс зүйг дээшлүүлэх, тэдэнтэй хариуцлага тооцох асуудлыг нарийвчлан хуульд тусгаж өгөх;

⁶⁹ Монгол Улсын дээд шүүхийн зөвлөмж, 2016 оны 5 дугаар сарын 10-ны өдөр.

3. Өмгөөлөгч бол иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогчид мэргэжлийн туслалцаа үзүүлэх, тэдгээрийн хууль ёсны эрхийг хамгаалж байгаа гэдэг утгаар нь эрх үүргийг нь тусдаа зохицуулах;
4. Шүүхийн ерөнхий зөвлөл, Өмгөөлөгчдийн холбооны хамтын ажиллагааг өргөжүүлэх;
5. Бодит байдал, ажлын ачааллыг харгалзан шүүгчийн тоог нэмэгдүүлэх боломжтой эсэхийг судлан шийдвэрлэх;
6. Хэргийн оролцогчоос шүүх хуралдааныг удаа дараа хойшлуулах хугацаа хожих гэсэн байдал практикт ихээр байгаа учраас шүүх хуралдааныг хойшлуулах хуулийн заалтыг нарийн тодорхой болгож өгөх, ингэснээр шүүх тухай бүр хойшлох хүсэлтийг хүлээн авахгүй байх боломж бүрдэх юм.



ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭР ШҮҮХИЙН ХЯНАЛТАД БАЙХ НЬ: ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ БОЛОН ЕРДИЙН ШҮҮХИЙН ХАРЬЯАЛЛЫН АСУУДАЛ⁷⁰

НЭГ. ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭР ШҮҮХИЙН ХЯНАЛТАД БАЙХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

Монгол Улсын олон улсын гэрээ болох Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт Пактын оролцогч гишүүн улсад дараах үүргийг хүлээлгэсэн. Үүнд:

- а) Энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн аливаа хүнийг, ийм зөрчлийг албаны үүргээ гүйцэтгэж байсан этгээд үйлдсэн байсан ч үр нөлөөтэй эрх зүйн хамгаалалтаар хангах;
- б) Энэхүү Пактад оролцогч улс бүр эрх зүйн хамгаалалт хүссэн аливаа этгээдийн тийм эрхийг эрх бүхий шүүх, захиргааны байгууллага, хууль тогтоох байгууллага, эсхүл тухайн улсын эрх зүйн тогтолцоонд заасан эрх бүхий бусад байгууллагаас тогтоож байх явдлыг хангах, түүнчлэн шүүхээр хамгаалуулах боломжийг нь хөгжүүлэх үүрэг хүлээнэ;
- в) Эрх зүйн хамгаалалт олгож байгаа бол түүнийг эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлэх явдлыг хангах.⁷¹

Энэ ёсоор Засгийн газрын зүгээс Пактаар хүлээн зөвшөөрсөн хүний эрх, эрх чөлөөг зөрчихөөс хамгаалах, бүхий л нөхцөлд шүүхээр хамгаалуулах боломжийг хөгжүүлэх явдлыг Монгол Улс олон улсын гэрээний дагуу хүлээсэн. Түүнчлэн, НҮБ-ын Хүний эрхийн хорооны 13 дугаар чуулганаас 1981.07.29-ний өдөр баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 2 дугаар зүйлийн талаар тайлбарласан.⁷² Энэхүү тайлбарын 1 дэх хэсэгт дурдсанаар, Пактын гишүүн улсууд бүх хувь хүний эрхийг тухайн улсын шүүхийн хамгаалалтад байлгахад шаардлагатай арга хэмжээ авах ёстой.

Иймд Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагаа нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт болон Монгол Улсын Үндсэн хуульд баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хөндөх, зөрчих эсэхийг шүүхээс тухай бүр хянах нь зайлшгүй байна. Энэ нь Засгийн газрын ямар шийдвэр, үйл ажиллагаа хүний эрх, эрх чөлөөг хөндөх буюу зөрчих эрсдэлтэйг тодорхойлох нь зүйтэй болохыг харуулж байна.

1.1. Засгийн газрын шийдвэрийг Засгийн газар өөрөө болон Улсын Их Хурлаас хянаж буй байдал

Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн бөгөөд 2

⁷⁰ Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судлаач Л.Галбаатар тус судалгааг гүйцэтгэв.

⁷¹ International Covenant on Civil and Political Rights <http://www.ohchr.org/Documents/ProfessionalInterest/ccpr.pdf>

⁷² UN Human Rights Committee (HRC), *CCPR General Comment No. 3: Article 2 (Implementation at the National Level)*, 29 July 1981, available at: <http://www.refworld.org/docid/453883fe0.html> [accessed 9 May 2018]

дахь хэсэгт зааснаар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу дараах 9 чиглэлээр үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.⁷³ Үүнд:

1. Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах;
2. Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх;
3. Салбарын ба салбар хоорондын, түүнчлэн бүс нутгийн хөгжлийн асуудлаар арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх;
4. Хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах;
5. Төрийн захиргааны төв байгууллагыг шуурхай удирдаж, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;
6. Улсыг батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангах;
7. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
8. Төрийн гадаад бодлого хэрэгжүүлэх;
9. Улсын Их Хуралтай зөвшилцөж дараа соёрхон батлуулахаар Монгол Улсын олон улсын гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, түүнчлэн Засгийн газар хоорондын гэрээ байгуулах, цуцлах.

Мөн Үндсэн хуулийн 45 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарын үсэг зурна. Энэхүү зохицуулалт ёсоор Засгийн газрын шийдвэр нь тогтоол, захирамж хэлбэртэй байх юм. Үүнээс гадна Үндсэн хуулийн 45 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно.

Эндээс харахад, дээр дурдсан 9 чиглэлээр гарсан Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжтой заавал нийцэх шаардлагатай байна. Профессор Б.Чимид багшийн дурдсанаар “Засгийн газраас гаргаж буй акт нь зөвхөн Үндсэн хуулийн холбогдолтой асуудлыг биш хүний болон тэдгээрийн хамтлаг (хуулийн этгээд)-ийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын асуудлыг ямар нэг байдлаар хөндөхүйц үр дагавартай, үүгээрээ эрх зүйн бүх салбарт холбогдолтой байдаг”.⁷⁴ Мөн тэрхүү тогтоол, захирамж хууль тогтоомжтой нийцээгүй бол залруулах үүрэг нь Засгийн газарт өөрт нь болон Улсын Их Хуралд байна. Харин ямар хугацаанд, аль үе шатанд Засгийн газрын тогтоол, захирамжийг хууль тогтоомжид нийцүүлэх талаар Үндсэн хуульд тодорхойлоогүй байна.

⁷³ Монгол Улсын Үндсэн хууль. “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 1992 он, №1

⁷⁴ Ярилцлага. Б.Чимид: Цэцийн шийдвэр бурууг нь мэдсээр атлаа дуугүй байгааг нь гайхаж сууна. “Өнөөдөр” сонин. 2005.09.05 <https://ikon.mn/n/19xu>

Эрх зүйн мэдээллийн цахим санд 2018 оны 5 дугаар сар 09-ний өдрийн байдлаар Засгийн газрын нийт 5707 шийдвэр байна. Үүнээс Засгийн газрын хүчин төгөлдөр 4487 шийдвэр, хүчингүй болгосон 1220 шийдвэр байна.⁷⁵



1 дүгээр графикт Засгийн газар нийт шийдвэрийнхээ 21 хувийг өөрөө хүчингүй болгосон бол, Улсын Их Хурлаас 0.03 хувьд нь хүчингүй болгожээ.⁷⁶ Эндээс харахад, Засгийн газрын нийт шийдвэрийн ойролцоогоор 80 хувь нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, энэ талаарх Засгийн газрын өөрийнх нь хяналт зөв эсэх, хүний эрх, эрх чөлөөг зүй бусаар хөндсөн, зөрчсөн эсэх нь тодорхойгүй байна. Энэ байдал нь Засгийн газрын шийдвэрийн талаарх хяналтыг зөвхөн Засгийн газар, Улсын Их Хуралд үлдээх нь зохимжгүй болохыг харуулж байна.

1.2. Засгийн газрын шийдвэр гаргах үйл явц ба хууль дээдлэх, шударга ёсыг бэхжүүлэх

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Засгийн газар асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол шийдвэр гараагүйд тооцно.⁷⁷ Мөн тус хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын Засгийн газар Ерөнхий сайд, 15 гишүүнээс бүрдэж байна.⁷⁸

Энэ ёсоор, Монгол Улсын Засгийн газрын хувьд асуудлыг Ерөнхий сайд, Засгийн газрын 15 гишүүн буюу нийт 16 хүний олонх буюу 9 хүний саналаар шийдвэрлэж тогтоол, захирамж гаргаж байна. Мөн Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-т зааснаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь Засгийн газрын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, энэ талаар яам, Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааг зохицуулна.

⁷⁵ Засгийн газрын хүчин төгөлдөр шийдвэрийн жагсаалт: <http://legalinfo.mn/law/?cat=33>; Засгийн газрын хүчингүй болсон шийдвэрийн жагсаалт: <http://legalinfo.mn/law/?cat=33>

⁷⁶ Тодруулбал, Улсын Их Хурлын 1998.08.14-ний өдрийн "Засгийн газрын зарим тогтоолыг хүчингүй болгох тухай" 92 дугаар тогтоолоор Засгийн газрын 1998.05.27-ны өдрийн 80 дугаар тогтоол, 1998.07.10-ны өдрийн 114 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болгожээ.

⁷⁷ Монгол Улсын Засгийн газрын тухай хууль. "Төрийн мэдээлэл" эмхтгэл. 1993 он, №3

⁷⁸ Монгол Улсын Шадар сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Батлан хамгаалахын сайд, Гадаад харилцааны сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Барилга, хот байгуулалтын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрчим хүчний сайд, Эрүүл мэндийн сайд

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заасан. Үүний дагуу Засгийн газрын шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэх нь шударга ёс, эрх чөлөө, тэгш байдлыг хангах, хууль дээдлэх зарчимд нийцсэн байх шаардлагатай.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.1-4.1.4-т шүүхийн эрхэм зорилгыг дараах байдлаар тусгасан байна.⁷⁹ Үүнд:

1. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох;
2. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, Үндсэн хуульд байгууллыг хамгаалах;
3. Хууль дээдлэх, шударга ёс, ардчилсан ёсыг бэхжүүлэх;
4. Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, иргэний эрх зүйн ухамсар, соёлыг дээшлүүлэх.

Эндээс харахад, дараах шинжээр Засгийн газрын шийдвэр нь шүүхийн хяналтад байх шаардлагатай болж байна. Үүнд:

- Засгийн газрын шийдвэрийг олонхийн саналаар гаргадаг,
- Засгийн газрын шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэх нь шударга ёс, эрх чөлөө, тэгш байдлыг хангах, хууль дээдлэх зарчимд нийцсэн байх шаардлагатай,
- Засгийн газрын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дэмжлэг үзүүлэх хэдий ч энэ нь хууль дээдлэх, шударга ёсыг бэхжүүлэхэд шууд нөлөө үзүүлэх эсэх нь тодорхойгүй,
- Хууль дээдлэх, шударга ёс, ардчилсан ёсыг бэхжүүлэх нь шүүхийн эрхэм зорилго мөн,
- Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.

ХОЁР.ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ХҮРЭЭ БА ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭР

Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт шүүн таслах ажлын төрлийн хувьд эрүү, иргэн, захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулж болох тухай заасан. Шүүх байгуулах тухай хуулийн дагуу байгуулагдсан эрүүгийн хэргийн шүүх, иргэний хэргийн шүүх, захиргааны хэргийн шүүх нь анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн тогтолцоогоор шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байна.⁸⁰ Мөн Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-т зааснаар Засгийн газрын шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх маргаантай асуудлаар Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна. Үүний дагуу Засгийн газрын шийдвэрийг хянах байдлаар нь шүүх, Үндсэн хуулийн цэцийн харьяаллыг дараах хүснэгтээр илэрхийлэх боломжтой байна.

⁷⁹ Монгол Улсын Шүүхийн тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 2012 он, №11

⁸⁰ Шүүх байгуулах тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 2015 он, №25




Хүснэгт 1. Засгийн газрын шийдвэрийг хянах Үндсэн хуулийн цэц болон шүүхийн харьяалал

	Үндсэн хуулийн цэц ⁸¹	Захиргааны хэргийн шүүх ⁸²	Иргэний хэргийн шүүх ⁸³
Хянах маргаан/зүйл	Засгийн газрын шийдвэр	Үндсэн хуулийн цэц болон өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн маргаан	иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн иргэний эрх зүйн маргаан
Хяналтын агуулга	Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх	Засгийн газрын хууль бус үйл ажиллагааны улмаас хүн, хуулийн этгээдийн эрх зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эсэх	иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын шаардах эрхийг хангах эсэх
Шийдвэрийн агуулга	Засгийн газрын шийдвэр хүчингүй болно	1. Засгийн газрын шийдвэрийг хүчингүй болгох; 2. Засгийн газрын шийдвэр гаргахыг Засгийн газарт даалгах; 3. Засгийн газрын хууль бус үйл ажиллагааны улмаас хүн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг гаргуулах; 4. Засгийн газрын шийдвэрийг 6 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх	1. нэхэмжлэлийн шаардлагыг хангах; 2. нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг нь хэрэгсэхгүй болгох; 3. нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох.
Хамаарахгүй маргаан	Үндсэн хуулиас бусад хуулийг зөрчсөн эсэх тухай маргаан	1. Үндсэн хуулийн цэц, бусад шүүхийн гэмт хэрэг, эрх зүйн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа; 2. Улс төрийн шийдвэр гаргах ажиллагаа.	Иргэний хэргээс бусад хэрэг, маргаан

1.3. Үндсэн хуулийн цэцээс хянасан Засгийн газрын шийдвэрийн талаарх дүгнэлт, тогтоолын тойм

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд 2018.04.25-ны байдлаар Үндсэн хуулийн цэцийн нийт 255 шийдвэр байна.⁸⁴ Үүнээс 12 шийдвэр нь Засгийн газрын холбогдох шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянасан шийдвэр байна. Энэ нь Үндсэн хуулийн цэцийн нийт шийдвэрийн 4.7%-ийг эзэлж байна.



⁸¹ Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль. 1997 он, №6

⁸² Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. "Төрийн мэдээлэл" эмхтгэл. 2016 он, №9

⁸³ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. "Төрийн мэдээлэл" эмхтгэл. 2002 он, №8

⁸⁴ Үндсэн хуулийн цэцийн нийт 255 шийдвэрийг энэ холбоосоор үзэх боломжтой: <http://legalinfo.mn/law/?cat=31>

Дээр дурдсан Засгийн газрын 12 шийдвэрийг Үндсэн хуулийн цэцээс хянасан байдлыг дараах хүснэгтээр харуулж байна. Энэхүү хүснэгтээс харахад Засгийн газрын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар Үндсэн хуулийн цэцээс 10 дүгнэлт, 3 тогтоол гаргажээ.

Хүснэгт 2. Үндсэн хуулийн цэцээс Засгийн газрын шийдвэрийг хянасан байдал /хугацааны дарааллаар/

Д/д	Огноо	Дугаар	Шийдвэрийн төрөл	Агуулга
1	1995.12.07	07	Дүгнэлт	Монгол Улсын Засгийн газраас Айбекс групптэй 1993.04.17-нд байгуулсан түншлэлийн гэрээ Үндсэн хууль зөрчсөнтэй холбогдуулан Ерөнхий Сайд П.Жасрайг огцруулах эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай
2	1996.12.12	10	Дүгнэлт	Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхсайхан Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай
3	1997.03.29	02	Тогтоол	Монгол Улсын Ерөнхий сайдын 1996 оны 132 дугаар захирамж Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн зарим заалтыг зөрчсөн тухай
4	1998.04.27	04	Дүгнэлт	Монгол Улсын Засгийн газрын 1997.12.03-ны өдрийн 235 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн 45 дугаар зүйлийн заалтуудыг зөрчсөн эсэх тухай
5	2000.05.11	04	Дүгнэлт	Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 176, 2000 оны 22, 23 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байгаа эсэхийг хянан хэлэлцсэн тухай
6	2005.12.14	02	Тогтоол	Монгол Улсын Засгийн газрын 2005.02.02-ны өдрийн 22 дугаар тогтоолын зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай
7	2006.02.22	02	Дүгнэлт	Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 209 дүгээр тогтоолын 3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай
8	2006.12.20	13	Дүгнэлт	Засгийн газрын "Журам батлах тухай" 2005 оны 208 дугаар тогтоолын зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай
9	2007.03.07	01	Тогтоол	Засгийн газрын "Журам батлах тухай" 2005 оны 208 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн хянан шийдвэрлэсэн тухай
10	2010.07.07	04	Дүгнэлт	Засгийн газрын 2009 оны 86 дугаар тогтоолын заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

11	2011.12.27	05	Дүгнэлт	Засгийн газрын 2010 оны 299 дүгээр тогтоолын 3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай
12	2014.01.22	02	Дүгнэлт	Монгол Улсын Засгийн газрын 1998.06.10-ны өдрийн 92 дугаар тогтоол, 2012.05.02-ны өдрийн 153 дугаар тогтоолын холбогдох заалт Үндсэн хуулийн зарим заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай
13	2018.04.06	04	Дүгнэлт	Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 12 дугаар захирамж Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Энд анхаарах нэг зүйл бол, 2002.12.26-ны өдөр батлагдаж, 2004.06.01-ний өдрөөс 2016.07.01-ний өдөр хүртэл үйлчилсэн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т Монгол Улсын Засгийн газраас гаргасан захиргааны актад холбогдох маргааныг Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэнэ гэж зохицуулсан.⁸⁵

Харин Үндсэн хуулийн цэцийн 2005.03.31-ний өдрийн “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 02 дугаар дүгнэлтээр дээрх заалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн”, 45 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна гэж дүгнэжээ.⁸⁶ Энэхүү дүгнэлтийн үндэслэлээ “Монгол Улсын Засгийн газар төрийн гүйцэтгэх дээд байгууллага болохынх нь хувьд түүний шийдвэр хуульд нийцээгүй тохиолдолд хүчингүй болгох эрх бүхий субъектийг Үндсэн хуулиар тусгайлан тогтоосон байна. Улсын Их Хурал, Засгийн газар Үндсэн хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд Үндсэн хуулийн цэцэд хандаж шийдвэрлүүлж болох нь нээлттэй байна. Хууль тогтоогчоос Засгийн газрын шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх хянаж байхаар хуульчилсан нь Үндсэн хуулиар тусгайлан тогтоосон Засгийн газар, Улсын Их Хурлын эрх хэмжээнд халдсан гэх үндэслэл тогтоогдож байна. Захиргааны хэргийн шүүхэд төрийн гүйцэтгэх дээд байгууллагын шийдвэрийг хянах эрх хэмжээ Үндсэн хуулиар олгогдоогүй байна” гэж тайлбарлажээ.

Үүний дагуу 2005.04.28-ны өдөр батлагдсан “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай” хуулийн 1 дүгээр зүйлээр Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр

⁸⁵ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 2003 он, №3

⁸⁶ Үндсэн хуулийн цэцийн 2005.03.31-ний өдрийн “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 02 дугаар дүгнэлт <http://legalinfo.mn/law/details/997?lawid=997>

зүйлийн “4.1.1.Монгол Улсын Засгийн газар” гэсэн заалтыг хүчингүй болсонд тооцсон.⁸⁷

Энэ нөхцөл байдлыг профессор Б.Чимид багш “... Цэц маань захиргааны процессын урьдчилан шийдвэрлэх хэсгийг нь шүүхийн ажиллагаатай хутгаж орхисон бололтой” гэж тодотгож, дараах байдлаар дүгнэжээ.

“Хураангуйлж дүгнэвэл Үндсэн хуулийн цэц, УИХ-ын эл шийдвэр нь:

Нэгдүгээрт, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага болох Засгийн газар, түүний гишүүд, яам болон Засгийн газрын гишүүний тэргүүлсэн агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын хийгээд сонгуулийн хууль биелүүлэх үүрэгтэй гүйцэтгэх байгууллагын засаг захиргааны үйл ажиллагааг шүүхийн хяналтаас гаргаж дархаллаа.

Хоёрдугаарт, аливаа хэрэг, эрх зүйн маргааныг эцсийн дүнд гагцхүү шүүх хянан төгс шийдвэрлэнэ гэсэн агуулга бүхий Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хөсөрдүүлж, шүүхийн хараат бус байдалд халдан нэг шүүх (Цэц) нь нөгөө шүүхийнхээ Үндсэн хуульчлагдсан бүрэн эрхийг хасч хязгаарлалаа.

Гуравдугаарт, Цэц, УИХ хоёрын шийдвэрийн хамгийн ноцтой бөгөөд нэлээд далд мэт гажуудал нь “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх”, “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах”, “шударга шүүхээр хэргээ шүүлгэх” эерэг Үндсэн хуулиар олгогдсон улс төрийн эрхүүдээ иргэд Захиргааны хэргийн шүүхээр хамгаалуулах эрх, боломжоо хэрэг дээр хасууллаа.”⁸⁸

Харин 2016.02.04-ний өдөр батлагдаж, 2016.07.01-ний өдрөөс эхлэн үйлчилж буй Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1.1-т “захиргааны байгууллага” гэж Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд заасан байгууллагыг ойлгоно гэж заасан. 2015.06.19-ний өдөр батлагдаж, 2016.07.01-ний өдрөөс эхлэн үйлчилж буй Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 5.1.1-т нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллагыг захиргааны байгууллага гэж ойлгоно гэж хуульчилсан байна.⁸⁹ Үүгээр захиргааны байгууллагын тодорхойлолтыг өргөжүүлж, шинжээр нь тодорхойлсон бөгөөд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч төв байгууллагад Засгийн газар хамаарч байна.⁹⁰

Эндээс үзэхэд, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.1 дэх заалт 2004.06.01-ний өдрөөс 2005.03.31-ний өдөр хүртэл хугацаанд үйлчлэх үед

⁸⁷ “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай” 2005.04.28-ны өдрийн хууль <http://legalinfo.mn/additional/details/464?lawid=284>

⁸⁸ Ярилцлага. Б.Чимид: Цэцийн шийдвэр бурууг нь мэдсээр атлаа дуугүй байгааг нь гайхаж сууна. “Өнөөдөр” сонин. 2005.09.05 <https://ikon.mn/n/19xu>

⁸⁹ Захиргааны ерөнхий хууль. “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 2015 он, №28

⁹⁰ - Д.Сүнжид. “Захиргааны ерөнхий хууль: Үзэл баримтлал, хэрэглээ”. Улаанбаатар. 2017 он. 33 дахь тал; - ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан, “Эрх зүйн боловсрол” академи. “Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар /судалгаа, хэрэглээний/. Улаанбаатар. 2017 он. 79 дэх тал

Үндсэн хуулийн цэцээс Засгийн газрын шийдвэрийг хянаагүй байна. Харин Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2016.07.01-ний өдрөөс эхлэн үйлчилж буй хугацаанд Үндсэн хуулийн цэцээс Засгийн газрын 1 шийдвэрийг хянасан байна.

Үүнд үндэслэн Үндсэн хуулийн цэцийн хувьд захиргааны хэргийн шүүхийн харьяаллын маргааныг хянасан эсэхэд дүн шинжилгээ хийж болох юм. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулиас бусад хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг Цэц харьяалан шийдвэрлэхгүй” гэж заасан. Харин Үндсэн хуулийн цэцээс 2018.04.06-ны өдрийн “Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 12 дугаар захирамж Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 04 дүгээр дүгнэлтдээ Монгол Улсын Ерөнхий сайд асан Ж.Эрдэнэбат 2016.07.20-ны өдөр “Засаг даргаар томилох, ажлаас чөлөөлөх тухай” 12 дугаар захирамжаар иргэн Л.Ганболдыг Хөвсгөл аймгийн Засаг даргаар томилохдоо Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5.2-т заасан “аймгийн Засаг даргад нэр дэвшигч нь “төрийн албанд гурваас доошгүй жил ажилласан байх шаардлагыг хангасан байна” гэх зохицуулалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэжээ.⁹¹

Энэ нь Үндсэн хуулийн цэцийн хувьд Үндсэн хуулиас бусад хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэж, улмаар захиргааны хэргийн шүүхийн харьяаллын маргааныг харьяалал зөрчин шийдвэрлэсэн болохыг харуулж байна.

Түүнчлэн, Үндсэн хуулийн цэцийн даргаас Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид хандсан 2018.04.02-ны өдрийн “Шүүхийн үйл ажиллагааг Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт нийцүүлэх тухай” албан бичигт “...2015 онд Захиргааны ерөнхий хууль, 2016 онд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль батлагдан, хүчин төгөлдөр болж үйлчилсэн өдрөөс хойш Захиргааны хэргийн шүүхээс Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 2/02 дугаар дүгнэлттэй уялдуулан холбогдох хуулийг хэрэглэх ёстой атал Засгийн газрын шийдвэрийн талаарх маргааныг хянан шийдвэрлэж байгаа нь Монгол Улсын Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэцийн дээр дурдсан шийдвэрт нийцэхгүй үйл ажиллагаа болж байна” гэжээ.⁹² Энэ байдлыг МУИС-ийн Хууль зүйн сургуулийн дэд профессор, хууль зүйн доктор О.Мөнхсайхан холбогдох нийтлэлдээ “...Засгийн газар өөрийн үйл ажиллагааг захиргааны хэргийн шүүхээр хянуулахгүй байхын тулд энэ тухай мэдээлэл гаргахыг иргэнд захиалж, Цэцийн дарга Д.Одбаяр уг захиалгыг нь хууль бусаар биелүүлж Дээд шүүхийн ерөнхий шүүгч рүү албан бичиг явуулжээ гэж ойлгогдож байна. Иргэнд захиалга өгч өргөдөл, мэдээлэл гаргуулах замаар Цэцийг

⁹¹ Үндсэн хуулийн цэцийн 2018.04.06-ны өдрийн “Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 12 дугаар захирамж Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 04 дүгээр дүгнэлт <http://legalinfo.mn/law/details/13289?lawid=13289>

⁹² Үндсэн хуулийн цэцийн даргын 2018.04.02-ны өдрийн “Шүүхийн үйл ажиллагааг Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт нийцүүлэх тухай” 1/142 тоот албан бичиг <https://ikon.mn/n/19a6>

улс төрийн арга хэрэгсэл болгон ашигладаг, Цэц түүнд нь үйлчилдэг гэсэн хардлага ортойг харуулсан жишээ ийнхүү нэгээр нэмэгдлээ” гэж дүгнэжээ.⁹³

Улсын Дээд шүүхийн хувьд Үндсэн хуулийн цэцийн даргын дээр дурдсан хүсэлтийг хүлээн аваагүй бөгөөд Үндсэн хуулийн цэцээс өөрт нь хамаарах, Улсын Дээд шүүхийн хуулиар тогтоосон бүрэн эрх, эрхлэн шийдвэрлэх асуудалд харьяалагдахгүй маргааныг харьяалан шийдвэрлэхгүй, шүүхэд шилжүүлж буй асуудал гарч буй талаар Улсын Дээд шүүхийн цахим хуудаст мэдээлсэн байна.⁹⁴

Зарим судлаачийн хувьд Засгийн газрыг бүхэлд нь Үндсэн хуулийн цэц, эсхүл захиргааны хэргийн шүүх хянах тухай асуудлыг дэмжихгүй байна. Харин Засгийн газрын ямар шийдвэр буюу тэрхүү шийдвэртэй холбоотой ямар төрлийн хэрэг, маргаан гэдгийг ялгаж, Үндсэн хуулийн цэц, захиргааны шүүхийн харьяаллыг тогтоох тухай хэлэлцэх болжээ.⁹⁵ Үүнийг “Засгийн газрын шийдвэрийг хянах Үндсэн хуулийн цэц болон шүүхийн харьяалал”-ыг харуулсан 1 дэх хүснэгтээс харж болохоор байна.

2.2. Захиргааны хэргийн шүүхээс гаргасан Засгийн газартай холбоотой шийдвэрийн тойм

Энэ судалгааны 2.1 дэх хэсэгт дурдсан ёсоор, Засгийн газрын захиргааны актад холбогдох маргааныг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэх зохицуулалт болох Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.1 дэх заалт 2004.06.01-ний өдрөөс 2005.03.31-ний өдөр хүртэл хугацаанд үйлчилсэн. Мөн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2016.07.01-ний өдрөөс эхлэн үйлчилж, Засгийн газрын гаргасан нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэртэй холбоотой маргааныг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэж байна. Тодруулбал, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд харьяалан шийдвэрлэсэн Засгийн газар хариуцагчаар татагдсан маргаан 2015-2017 оны байдлаар 34 байна.⁹⁶



Дээрх графикт харуулснаар, 2015 онд 4, 2016 онд 11, 2017 онд 19 нийт 34 нэхэмжлэлд холбогдуулан Засгийн газрыг хариуцагчаар татсан байна. Эндээс

⁹³ О.Мөнхсайхан. "Засгийн газрыг захиргааны хэргийн шүүхийн хяналтаас гаргавал хууль дээдлэх ёс хоосон тунхаг болно" нийтлэл. 2018.04.27 <http://time.mn/r/mAF>

⁹⁴ Улсын Дээд шүүхийн цахим хуудас. "Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаярын ирүүлсэн хүсэлтийг хангахаас татгалзлаа". 2018.05.04 <http://supremecourt.mn/news/381>

⁹⁵ Монгол ТВ. "Нүүдэл Шийдэл: Захиргааны шүүх ба Засгийн газрын шийдвэр" нэвтрүүлэг. 2018.05.07 <http://mongol.tv/news/archives/4529>

⁹⁶ Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн. "Засгийн газрыг хариуцагчаар татсан хэрэг маргааны судалгаа: Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх". 2018.05.07

харахад захиргааны хэргийн маргаанд Засгийн газар хариуцагчаар татагдах байдал нэмэгдсээр байна. Үүнийг дараах хүснэгтэд дэлгэрүүлэн үзүүлэв.

Хүснэгт 3. Нийслэл дэх захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэсэн маргаанд Засгийн газрыг хариуцагчаар татсан байдал, 2015-2017

Нийт нэхэмжлэл /Маргааны төрөл	Огноо			Нийт
	2015	2016	2017	
		4	11	19
Нөхөн олговор	1	-	-	1
Сонгууль	3	-	-	3
Төрийн алба	-	5	3	8
Газар	-	3	4	7
Төрийн өмч	-	1	-	1
Хувьцаа, ногдол ашиг	-	-	4	4
Тусгай зөвшөөрөл	-	-	2	2
Ашигт малтмал	-	-	1	1
Өргөдөл шийдвэрлээгүй эс үйлдэхүй	-	-	3	3
Бусад	-	2	2	4



Дээрх 3 дугаар хүснэгт болон 4 дүгээр графикаас харахад, Засгийн газрын хувьд захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэж буй төрийн алба, газар, хувьцаа, ногдол ашиг, өргөдөл шийдвэрлээгүй эс үйлдэхүй, сонгууль, тусгай зөвшөөрөл, ашигт малтмал, төрийн өмч, нөхөн олговортой холбоотой маргаанд хариуцагчаар татагдаж байна.

2.3. Иргэний хэргийн шүүхээс гаргасан Засгийн газартай холбоотой шийдвэрийн тойм

Иргэний хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.-т “Төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болох аймаг, нийслэл, сум, дүүрэг нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцоно” гэж заасан.⁹⁷ Энэ ёсоор Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхүүд 2015-2017 онд Монгол Улсын Засгийн газартай холбоотой 60 хэрэг шийдвэрлэжээ. Тодруулбал, дээрх шүүхүүдээс 2015 онд 49 нэхэмжлэл, гомдол хүлээн авснаас 39-ийг, 2016 онд 34 нэхэмжлэл, гомдол хүлээн авснаас 15-ыг, 2017 онд 15 нэхэмжлэл, гомдол хүлээн авснаас 6-аг тус тус хянан шийдвэрлэсэн байна.⁹⁸



Дээрх графикаас харахад шүүхээс хянан шийдвэрлэж буй иргэний хэрэгт Засгийн газар хариуцагчаар татагдах байдал буурах хандлагатай байна. Иргэний хэргийн шүүхийн шийдвэрлэж буй ямар төрлийн хэрэг, маргаанд Засгийн газар холбогдож буйг дараах хүснэгт харуулав.

Хүснэгт 4. Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээс шийдвэрлэсэн Засгийн газарт холбогдох хэргийн төрөл

Хэргийн төрөл	Огноо			Нийт
	2015	2016	2017	
Хөдөлмөрийн хуулиар буюу ажлаас үндэслэлгүй халагдсан, цалин хөлсний маргаан	18	3	2	23
Тогтоол шийдвэр болон түүний зарим заалтыг хүчингүй болгуулах, түүнээс учирсан хохирол гаргуулах тухай	5	4	2	11
Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирол гаргуулах тухай	10	3	2	15
Хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн чадвар алдалт, эмчилгээний төлбөр нөхөн гаргуулах тухай	-	3	-	3
Бусад	6	2	-	8

Дээрх 4 дүгээр хүснэгт болон 6 дугаар графикаас харахад, Засгийн газрын хувьд иргэний хэргийн шүүхийн шийдвэрлэж буй 1/ Хөдөлмөрийн тухай хуулиар

⁹⁷ Иргэний хууль. “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 2002 он, №7

⁹⁸ Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн. “Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхүүд 2015-2017 онд Монгол Улсын Засгийн газартай холбоотой хэргийг шийдвэрлэсэн байдал”. 2018.05.07

буюу ажлаас үндэслэлгүй халагдсан, цалин хөлсний маргаан, 2/ Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирол гаргуулах тухай маргаан, 3/ Тогтоол шийдвэр болон түүний зарим заалтыг хүчингүй болгуулах, түүнээс учирсан хохирол гаргуулах тухай маргаан, 4/ Хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн чадвар алдалт, эмчилгээний төлбөр нөхөн гаргуулах тухай маргаанд хариуцагчаар татагдаж байна.



ГУРАВ.ДҮГНЭЛТ

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт болон Монгол Улсын Үндсэн хуульд баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг Засгийн газрын шийдвэр хөндөх, зөрчих эсэхийг шүүхээс тухай бүр хянах нь нэгэнт олон улсын эрх зүйн болон үндэсний эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээ болжээ.

Холбогдох статистик мэдээнд хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд, Засгийн газрын шийдвэрийн талаарх бүх хяналтыг зөвхөн Засгийн газарт өөрт нь буюу Улсын Их Хуралд үлдээх нь оновчгүй байна. Өнөөгийн Засгийн газрын шийдвэрийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны туршлагаас харахад Засгийн газрын шийдвэр шүүхийн хяналтад зайлшгүй байх шаардлагатай болж байна.

Үүнтэй холбоотойгоор Засгийн газрын шийдвэрийг ямар шүүх буюу Үндсэн хуулийн цэц, Захиргааны хэргийн шүүх, Иргэний хэргийн шүүх хянах асуудлыг тодорхойлохдоо ерөнхий байдлаар хандах бус, 1/ хянах маргааны агуулга, 2/ хяналтын хүрээ, 3/ холбогдох шүүхээс гарах шийдвэрийн агуулга, үр дагавар, 4/ тухайн шүүхийн хянан шийдвэрлэх маргааны харьяалал гэсэн хүчин зүйлсийг бүхэлд нь шалгаж байх нь зүйтэй байна.

Өнөөгийн практикаас харахад, Үндсэн хуулийн цэцээс Засгийн газрын шийдвэрийг хянах байдал хангалтгүй байх бөгөөд энэ нь Үндсэн хуулийн цэцийн хувьд Үндсэн хуулиас бусад хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэж, улмаар захиргааны хэргийн шүүхийн харьяаллын маргааныг харьяалал зөрчин шийдвэрлэсэн зэргээр илэрч байна.

Судлаачдын хувьд шүүхийн харьяаллыг тогтоохдоо Засгийн газар гэх субъектээр нь бус, Засгийн газрын шийдвэрийн төрөл буюу тэрхүү шийдвэртэй холбоотой хэрэг, маргааныг ялгаж, Үндсэн хуулийн цэц, захиргааны шүүхийн харьяаллыг тогтоох тухай санал гаргаж буй нь зүйтэй байна.

Практикт захиргааны хэргийн маргаанд Засгийн газар хариуцагчаар татагдах байдал нэмэгдсээр байна. Ингэхдээ Засгийн газрын хувьд захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэж буй төрийн алба, газар, хувьцаа, ногдол ашиг, өргөдөл шийдвэрлээгүй эс үйлдэхүй, сонгууль, тусгай зөвшөөрөл, ашигт малтмал, төрийн өмч, нөхөн олговортой холбоотой маргаанд хариуцагчаар татагдаж байна. Харин шүүхээс шийдвэрлэж буй иргэний хэрэгт Засгийн газар хариуцагчаар татагдах байдал буурах хандлагатай байна.

Дээр дурдсан нөхцөл байдлаас харахад, Засгийн газрын шийдвэр шүүхийн хяналтад байх бөгөөд түүний ямар шийдвэр Үндсэн хуулийн цэц, ердийн шүүхийн харьяаллын асуудал болохыг холбогдох хуульд нэгэнт эргэлзээгүйгээр зохицуулжээ. Гэвч энэ талаар маргаан мэтгэлцээн гарч, эргэлзээтэй байдал үүсч буй нь талуудын онолын болон хууль тогтоомжийн хэрэглээний мэдлэг, ур чадвараас шууд хамаарч байна.

ДӨРӨВ.САНАЛ

Дээрх дүгнэлттэй уялдуулан судлаачийн зүгээс дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Засгийн газрын шийдвэр Үндсэн хуулийн цэц болон ердийн шүүхийн хяналтад байх тухай өнөөгийн багц хууль /Монгол Улсын Үндсэн хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны ерөнхий хууль/-ийн агуулга, зохицуулалтыг өөрчлөхгүй байх.
- Дээр дурдсан Засгийн газрын шийдвэр Үндсэн хуулийн цэц болон ердийн шүүхийн хяналтад байх тухай өнөөгийн багц хуулийг түүний үзэл баримтлалын үүднээс ойлгож хэрэглэх мэдлэг, ур чадвар олгох хэлэлцүүлэг, сургалтыг бүх хуульч, судлаачдын дунд тогтмол зохион байгуулах.
- Үндсэн хуулийн цэц болон Захиргааны хэргийн шүүх, Иргэний хэргийн шүүхээс Засгийн газрын шийдвэрийг хянах эсэх талаар зохих шийдвэр гаргах, эдгээр шүүхэд Засгийн газрын шийдвэрийг хянуулах этгээдийн зүгээс асуудалд ерөнхий байдлаар хандахгүйгээр 1/ хянах маргааны агуулга, 2/ хяналтын хүрээ, 3/ холбогдох шүүхээс гарах шийдвэрийн агуулга, үр дагавар, 4/ тухайн шүүхийн хянан шийдвэрлэх маргааны харьяалал гэсэн хүчин зүйлсийг бүхэлд нь шинжлэн дүгнэж байх.



**ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ
ЗӨРЧСӨН ГЭХ ҮНДЭСЛЭЛЭЭР УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН
ШҮҮХ ХУРАЛДААНААР ШИЙДВЭР, МАГАДЛАЛЫГ ХҮЧИНГҮЙ БОЛГОЖ,
ХЭРГИЙГ ДАХИН ХЭЛЭЛЦҮҮЛЭХЭЭР АНХАН, ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ
ШҮҮХЭД 2015-2017 ОНД БУЦААСАН ИРГЭНИЙ ХЭРГИЙН СУДАЛГАА⁹⁹**

**НЭГ.УЛСЫН ХЭМЖЭЭНД ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ИРГЭНИЙ ХЭРГИЙН
ЕРӨНХИЙ ТООН ҮЗҮҮЛЭЛТ**

2015 онд улсын хэмжээнд анхан шатны журмаар нийт 56607 нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авснаас 71.9 хувь буюу 40674 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн ба үүнээс 6.9 хувь буюу 2800 хэрэгт давж заалдах журмаар, 3.5 хувь буюу 1435 хэрэгт хяналтын журмаар тус тус гомдол гаргаж байжээ.

2016 онд улсын хэмжээнд анхан шатны журмаар нийт 64030 нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авснаас, 72.1 хувь буюу 46173 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн ба үүнээс 7.5 хувь буюу 3475 хэрэгт давж заалдах журмаар, 3.7 хувь буюу 1711 хэрэгт хяналтын журмаар тус тус гомдол гаргажээ.

2017 онд улсын хэмжээнд анхан шатны журмаар нийт 63220 нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авснаас, 71,5 хувь буюу 45233 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн ба үүнээс 9,2 хувь буюу 4167 хэрэгт давж заалдах журмаар, 4,4 хувь буюу 1991 хэрэгт хяналтын журмаар тус тус гомдол гаргажээ.

Он	Анхан шат			Давж заалдах шат				Хяналтын шат					
	Хүлээн авсан	Шийдвэрлэсэн		Хүлээн авсан		Шийдвэрлэсэн		Хүлээн авсан		Шийдвэрлэсэн			
		Хэрэг	Хэрэг	Хувь	Хэрэг	Хувь	Хэрэг	Хувь	Хэрэг	Хувь	Бүгд		Шүүх хуралдаанаар
										Хэрэг	Хувь	Хэрэг	Хувь
2015	56607	40674	71,9	2800	6,9	2540	90,7	1435	56,5	1376	95,9	1155	80,5
2016	64030	46173	72,1	3475	7,5	3108	89,4	1711	55,1	1655	96,7	1469	85,9
2017	63220	45233	71,5	4167	9,2	3721	89,3	1991	53,5	1829	91,7	1704	85,6

Улсын Дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргасан хэргийн тоо сүүлийн 3 жилд өмнөх онтой харьцуулахад 2016 онд 276 хэргээр буюу 19,2 хувь, 2017 онд 280 хэргээр буюу 16,4 хувь өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэргийн тоо өмнөх онтой харьцуулахад 2016 онд 314 хэргээр буюу 27,2 хувь, 2017 онд 235 хэргээр буюу 20 хувиар тус тус өссөн нь Улсын Дээд шүүхийн иргэний хэргийн танхимын шүүгчдийн ачаалал сүүлийн 2 жилд нэмэгдсэн байдал харагдаж байна.

⁹⁹Тус судалгааг Шүүхийн ерөнхий зөвлөлийн захиалгаар УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР гүйцэтгэв.

Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэргийг харуулбал:

№	Шийдвэрлэсэн байдал	2015		2016		2017	
		Хэрэг	Хувь	Хэрэг	Хувь	Хэрэг	Хувь
1	Шийдвэр, магадлал хэвээр	643	55.7	793	53.9	915	53.7
2	Шийдвэр, магадлалд нэмэлт өөрчлөлт	250	21.7	303	20.6	307	18.0
3	Шийдвэр, магадлал, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилсөн	123	10.6	158	10.7	191	11.2
4	Шийдвэр магадлалыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон	36	3.1	38	2.6	95	5.6
5	Шийдвэр магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан	103	8.9	177	12	196	11.5
Нийт		1155		1469		1704	

2015 онд хяналтын шатны шүүх хуралдаанаар 1155 хэрэг хянан шийдвэрлэсэнээс 643, 2016 онд 1469 хэргээс 793, 2017 онд 1704 хэргээс 915 хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээсэн байна. Шийдвэр, магадлалыг хэвээр үлдээсэн нь 2016 онд өмнөх онтой харьцуулбал 1.8 хувь, 2017 онд 0,0 хувиар буурсан үзүүлэлттэй бол 2015 онд 1155 хэрэг хянан шийдвэрлэсэнээс 103, 2016 онд 1469 хэргээс 177, 2017 онд 1704 хэргээс 196 хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин шийдвэрлүүлэхээр шүүхэд буцаасан байна. Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин шийдвэрлүүлэхээр шүүхэд буцаасан нь 2016 онд өмнөх онтой харьцуулбал 3.1 хувиар өссөн бол 2017 онд 0,5 хувиар буурсан байна.

ХОЁР.ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХЭЭС ШИЙДВЭР, МАГАДЛАЛЫГ ХҮЧИНГҮЙ БОЛГОЖ, ХЭРГИЙГ ДАХИН ХЯНАН ШИЙДВЭРЛҮҮЛЭХЭЭР БУЦААСАН ХЭРЭГ

Гарсан алдаа зөрчлүүд	2015		2016 он		2017 он	
	хэргийн тоо	эзлэх хувь	хэргийн тоо	эзлэх хувь	хэргийн тоо	эзлэх хувь
Шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон үндэслэл						
1 Шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй	59	57.3	68	38.4	93	47.4
2 Зохигч, тэдгэрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангалгүй хэргийг хянан шийдвэрлэсэн	1	1.0	14	7.9	19	9.7
3 Хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсөн	10	9.7	24	13.5	18	9.2

4	Хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн	3	2.9	-	-		
5	Шийдвэрт шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч гарын үсэг зураагүй, эсхүл шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан	-	-	-	-		
6	Хуурамч нотлох баримтын үндсэн дээр хэргийг хянан шийдвэрлэсэн нь илэрсэн	1	1.0	4	2.3	2	1.0
7	ИХШХШТХ-ийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлсэн	29	28.1	67	37.9	64	32.7
Нийт		103	100	177	100	196	100

Хяналтын журмаар хянан хэлэлцэж шийдвэр, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэсэн 291 хэргийн 67.4 хувь буюу 196 хэргийг шүүхээр дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцаасан бол 32.6 хувь буюу 95 хэргийн нэхэмжлэлийг буюу хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

2017 онд хяналтын журмаар хянан хэлэлцэж шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаасан 196 хэргийн үндэслэлийг өмнөх онтой харьцуулахад:

2017 онд өмнөх онтой харьцуулахад шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй гэсэн үндэслэлээр буцаасан хэрэг 25 хэргээр буюу 36,8 хувиар, зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангалгүй хэргийг хянан шийдвэрлэсэн гэсэн үндэслэлээр 5 хэргээр буюу 35.7 хувиар тус тус өссөн бол хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсөн гэсэн үндэслэлээр 6 хэргээр буюу 25.0 хувиар, хуурамч нотлох баримтын үндсэн дээр хэргийг хянан шийдвэрлэсэн нь илэрсэн үндэслэлээр 2 хэргээр буюу 50.0 хувиар, ИХШХШТХ-ийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлсэн гэсэн үндэслэлээр 3 хэргээр буюу 4.5 хувиар тус тус буурсан байна.

2016-2017 онуудад шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй, зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангалгүй хэргийг хянан шийдвэрлэсэн, хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсөн, ИХШХШТХ-ийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлсэн зэрэг үндэслэлээр буцаасан хэрэг 2015 онд харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна.

ГУРАВ.ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХЭЭС ШИЙДВЭР, МАГАДЛАЛЫГ ХҮЧИНГҮЙ БОЛГОЖ, ХЭРГИЙГ ДАХИН ХЯНАН ШИЙДВЭРЛҮҮЛЭХЭЭР БУЦААСАН ҮНДЭСЛЭЛ:

		Гарсан алдаа зөрчлүүд	2015		2016		2017	
			Хэрэг	Хувь	Хэрэг	Хувь	Хэрэг	Хувь
Шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон үндэслэлүүд	1	Нэхэмжлэл, сөрөг нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл тодорхой бус байснаас эрх зүйн харилцаа тодорхой бус болсон, улмаар нотлох баримтын бодит үндэслэл тогтоогдоогүй, талуудын мэтгэлцэх эрх бүрэн хэрэгжээгүй /ИХШШТХ-ийн 6, 61, 62, 65, 66, 67/	20	19.4	37	21	61	31,1
	2	Хэргийн оролцогчийн эрх зүйн байдал тодорхойгүй, зохигчдод эрх үүргийг тайлбарлан таниулаагүй, нэхэмжлэл, сөрөг нэхэмжлэлийг гардуулаагүй, хэргийн материалтай танилцуулаагүй, шүүх хуралдааны товыг хуульд заасан журмын дагуу хүргүүлээгүйгээс мэтгэлцэх эрхээр хангагдаагүй /ИХШШТХ-ийн 6, 25, 73, 76, 77/	17	16.5	21	11.9	30	15,3
	3	Гуравдагч этгээдийн эрх ашиг сонирхол зөрчигдсөн /ИХШШТХ-ийн 29/	2	1.9	2	1.1	2	1,0
	4	Нотлох баримт гаргах, цуглуулах, бүрдүүлэх, түүнийг үнэлэх журам зөрчсөн /ИХШШТХ-ийн 37, 40/	21	20.4	48	27.1	47	24,0
	5	Нотлох баримт цуглуулах журмыг зөрчсөн, хэргийн оролцогчдын нотлох баримтыг шүүхийн журмаар гаргуулах тухай хүсэлт зөрчигдсөн /ИХШШТХ-ийн 38.6, 38.9, 44, 47, 48/	15	14.6	22	12.4	25	12,8
	6	Эрх зүйн харилцаа тодорхой бус /Эрх зүйн харилцааг буруу тодорхойлсон, хууль буруу хэрэглэсэн, нотлох баримт үнэлэх журам зөрчигдсэн/	19	18.4	30	17	17	8,7
	7	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гаргасан бусад зөрчил	9	8.7	17	9.6	14	7,1
Нийт			103		177		196	

Нэхэмжлэл, сөрөг нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл тодорхой бус байснаас эрх зүйн харилцаа тодорхой бус болсон, улмаар нотлох баримтын бодит үндэслэл тогтоогдоогүй, талуудын мэтгэлцэх эрх бүрэн хэрэгжээгүй үндэслэлээр буцаасан хэрэг шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцаасан нийт хэргийн 19,4-31,1 хувийг эзэлж байгаа бөгөөд буюу 2017 онд өмнөх онтой харьцуулахад 10,1 хувь өссөн үзүүлэлттэй байна.

Хэргийн оролцогчийн эрх зүйн байдал тодорхойгүй, зохигчдод эрх үүргийг тайлбарлан таниулаагүй, нэхэмжлэл, сөрөг нэхэмжлэлийг гардуулаагүй, хэргийн материалтай танилцуулаагүй, шүүх хуралдааны товыг хуульд заасан журмын дагуу хүргүүлээгүйгээс мэтгэлцэх эрхээр хангагдаагүй үндэслэлээр буцаасан хэрэг 2016 онд 4,6 хувиар буурсан боловч 2017 онд 3,4 хувиар өссөн байна.

Харин нотлох баримт гаргах, цуглуулах, бүрдүүлэх, түүнийг үнэлэх журам зөрчсөн үндэслэлээр 2016 онд 6,7 хувиар өссөн бол 2017 онд 3,1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Эрх зүйн харилцаа тодорхой бус /эрх зүйн харилцааг буруу

тодорхойлсон, хууль буруу хэрэглэсэн, нотлох баримт үнэлэх журам зөрчигдсөн үндэслэлээр буцаасан хэрэг 2017 онд 8,3 хувиар буурсан харагдаж байна.

ДҮГНЭЛТ

Иргэний эрх зүйн харилцаа талуудын тэгш эрхийн зарчимд үндэслэгдсэн тул энэ харилцаанаас аливаа маргааныг шийдвэрлэх шүүхийн ажиллагаа нь талуудын тэгш эрхийн болон мэтгэлцээний зарчимд тулгуурлан явагддаг билээ. Тэгш эрхийн буюу тэгш байдлын зарчим нь Үндсэн хуулийн “хууль шүүхийн өмнө эрх тэгш байх” зарчмаас иш үндэстэй ба Шүүхийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т “шүүх шүүх таслах ажиллагааны мэтгэлцэх зарчмыг хангахдаа шүүх хуралдаанд талууд, тэдгээрийн өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч болон улсын яллагчид асуулт асуух, хариулах, нотлох баримтыг танилцуулах, өөрсдийн тайлбар өгөх, үндэслэлээ хамгаалах, үгүйсгэх боломжийг тэгш олгоно” гэж талуудын тэгш эрхийн үндсэн дээр мэтгэлцэх зарчимд шүүхийн эзлэх байр суурийг тодорхойлсон билээ.

Мэтгэлцэх зарчмаар иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны мэтгэлцэх ёс, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талуудын тэгш эрхийг бэхжүүлсэн байна. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын тэгш эрх нь маргааны оролцогч талууд шүүхийн ажиллагаанд нэг гараанаас, ижил эрх зүйн байдалтайгаар, адилхан эрх, үүрэгтэйгээр оролцох хэлбэрээр илэрхийлэгддэг бол мэтгэлцэх ёс нь төвийг сахисан шүүх, шүүгчийн өмнө харилцан эсрэг ашиг сонирхол бүхий талууд өөр өөрсдийн байр суурийг нотлох хэлбэрээр илэрдэг байна.

Шүүх, шүүгч нь хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ хуульд заасан хөндлөнгийн байх зарчмыг баримтална. Маргааны үйл явц талуудын санаачилгаар явагдах боловч энэхүү ажиллагаа нь хуулиар тогтоосон журмын дагуу явагдаж буй эсэхэд шүүгч хяналт тавьж, талууд шүүхийн өмнө эрх тэгш байх эрхийг хангаж, маргааныг хуульд нийцүүлэн шийдвэрлэх үүрэгтэй байна.

Нэхэмжлэгч, хариуцагчийг хэн байхыг тодорхойлсноос мэтгэлцэх зарчим хэрэгжиж эхэлдэг байна. Гэтэл нэхэмжлэгч, хариуцагчийг зөв тогтоож чадаагүйгээс шийдвэр, магадлал хүчингүй болсон хэвээр байна.

Нэхэмжлэгч гэдэг нь өөрийн болон бусдын нэрийн өмнөөс зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар маргааныг үүсгэсэн этгээдийг хэлнэ. Харин хариуцагч гэдэг нь нэхэмжлэлийг холбогдуулан гаргасан этгээд юм. Нэхэмжлэл гаргахын тулд уг этгээдийн өөрийнх нь эрх зөрчигдсөн, эсхүл тэрээр бусдыг төлөөлөх эрх бүхий байх ёстой.

Хэнийг хариуцагчаар татах нь нэхэмжлэгчийн эрхийн асуудал боловч түүний нэхэмжлэлд хамааралтай этгээд мөн эсэхийг шүүх тодруулж хэргийн нэхэмжлэгч, хариуцагчийг зөв тогтоох шаардлагатай байна. Үүний тулд дараах зүйлийг анхаарах нь зүйтэй.

1. Хэргийн оролцогчийн эрх зүйн байдлыг тогтоох; Нэхэмжлэгч, хариуцагчийн эрх зүйн байдлыг Иргэний хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 26 дугаар зүйлийн 26.1-д зохицуулсан байна. Эрх зүйн чадамжтай эсэхээс холбогдох этгээд эрх үүргээ хэрэгжүүлэх боломжтой эсэх хамаарна;

2. Нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд мөн эсэх;
3. Нэхэмжлэлийн шаардлагад хамааралтай этгээд мөн эсэх;
4. Төлөөлөх тохиолдолд хуульд нийцсэн итгэмжлэл байгаа эсэхийг тогтооно.

Ийнхүү Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар нэхэмжлэлийг хүлээн авсан шүүгч нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангагдсан гэж үзвэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 66 дугаар зүйлд зааснаар иргэний хэрэг үүсгэнэ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 66 дугаар зүйлд зааснаар шүүгч нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор иргэний хэрэг үүсгэх боловч иргэний хэрэг үүсгэсний дараа шаардлага тодорхой бус тохиолдолд нэхэмжлэгчээс “хэнд холбогдуулан юу хүсэж байгааг нь” тодруулж энэ шаардлагыг нь хариуцагчид мэдэгдэхийг хуулиар хориглоогүй, энэ нь шүүх хөндлөнгийн байх зарчимд нөлөөлөхгүй юм.

Харин нэхэмжлэлийн шаардлага нь тодорхой бус байхад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэн явуулах нь шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байх зарчимд нийцэхгүйг анхаарвал зохино.

Нэхэмжлэлийн шаардлага тодорхой, ойлгомжтой байх нь маргааны эрх зүйн харилцааг зөв тогтоох, улмаар хууль зүйн бодит үндэслэлтэй нотлох баримт бүрдэх нөхцөл болно. Ингэснээр давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийн баримтыг үндэслэн шийдвэр, магадлал хуулийн үндэслэл бүхий болсон эсэхэд дүгнэлт хийж маргааныг эцэслэн шийдвэрлэх боломж бүрдэнэ.

Нэхэмжлэлийн шаардлага нь тухайн этгээдийн зөрчигдсөн эрхэд хамааралтай бөгөөд нэхэмжлэгч шүүхэд юу хүсэж буйг тодорхойлдог бол нэхэмжлэлийн үндэслэл нь тухайн шаардлагын боломж нөхцөлийг тодорхойлдог. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэлийн шаардлагад тухайн этгээд өөрийнхөө ямар эрх, юуны улмаас, яаж зөрчигдөж байгааг болон шаардлагаа зөвтгөж буй үндэслэл тусгагдсан байх ёстой.

Нэхэмжлэлийн үндэслэл, шаардлагаас шүүх шийдвэрлэх гэж буй маргааны эрх зүйн харилцааг тодорхойлдог. Нэхэмжлэлийн шаардлага тодорхой бус эсхүл ойлгомжгүй байгаа тохиолдолд шүүх ямар материаллаг эрх зүйн харилцаанаас үүдэлтэй маргаан болохыг тодорхойлж хэрэглэгдэх хууль түүний хэм хэмжээг зөв олж тайлбарлах боломжгүй юм.

Иймд нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл тодорхой бус хэргийг шийдвэрлэснээр маргааны талаар талуудын мэтгэлцэх эрх бүрэн бодитойгоор хэрэгжээгүй, хэрэгт цугларсан нотлох баримтын хууль зүйн бодит үндэслэл тогтоогдоогүй, шүүхийн шийдвэр, магадлал Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.2-дахь хэсэгт заасан “Шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна” гэсэн шаардлагыг хангаагүй гэж хяналтын шатны шүүх дүгнэн, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаадаг байна.

Шүүгч хэргийн оролцогчдыг эрх, үүргээ хэрэгжүүлж мэтгэлцэх боломжоор хангахын тулд хуульд заасан дараах ажиллагааг заавал явуулна. Үүнд:

- Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлд зааснаар нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулах, сөрөг нэхэмжлэл гаргасан тохиолдолд нэхэмжлэгчид мөн гардуулах;
- хэргийн оролцогчдод эрх үүргийг тайлбарлан таниулах;
- хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2-т зааснаар хэргийн оролцогчдод хэргийн материалыг танилцуулах;
- хуулийн 76, 77 дугаар зүйлд зааснаар шүүх хуралдааныг товлож хуралдаан хэзээ хаана болохыг хэргийн оролцогчдод мэдэгдэх зэрэг болно. Эдгээр ажиллагааг гүйцэтгэхдээ тухайн хэргийн оролцогч болох этгээдэд өөрт нь эсвэл тэднээс хуулийн дагуу итгэмжлэл олгосон этгээдэд хандана. Ийнхүү хуульд заасны дагуу хийгээгүйн улмаас шүүхийн шийдвэр, магадлал хүчингүй болох явдал байсаар байна.

Эрх, үүрэг тайлбарлах өгөх гэдэг нь хэргийн оролцогчид хуулийн хүрээнд ямар эрхтэй, ямар үүрэгтэйг нь тэдэнд мэдүүлэх гэсэн ойлголт юм. Шүүгч энэхүү ажиллагааг хэрхэн үр дүнтэй явуулснаас шалтгаалан маргааны талаарх талуудын мэтгэлцээн хуульд заасны дагуу явагдах, хууль зүйн үндэслэл бүхий нотлох баримт бүрдүүлж цуглуулах, улмаар хэрэгт авагдсан нотлох баримтын хүрээнд шүүхээс хэргийг хуульд нийцүүлэн шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой болно.

Хэрэг маргааныг хянан шийдвэрлэж буй шүүх зохигчдод нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл юу болохыг, шаардлагыг хэрхэн нотлох, үндэслэлийг хэрхэн тодорхойлох талаар танилцуулснаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.1.-д зааснаар эрх, үүргийг нь тайлбарлан өгөх үүргээ хангалттай биелүүлнэ. Зохигчид мэргэжлийн өмгөөлөгчийн туслалцаа авч байгаа явдал нь шүүхийн хэргийн оролцогчдод эрх, үүргийг хуульд нийцүүлэн тайлбарлах, маргааны болон нотолгооны зүйлийг тодорхойлох үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй юм.

Хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1-д “хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримт хангалттай бүрдсэн гэж шүүгч үзсэн, эсхүл 71.1-д заасан хугацаа дууссан, түүнчлэн шаардлагатай гэж үзсэн бусад тохиолдолд шүүгч хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамж гаргаж, шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг товлоно” гэж, хуулийн 25.1.2-т хэргийн оролцогч “хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх захирамж гарсны дараа хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох” эрхтэй гэж заажээ.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн оролцогчид өөрсдөө хэргийн материалтай хэдэн ч удаа танилцахыг хориглоогүй боловч шүүх хуралдаанаас өмнө хэргийн материалыг тэдэнд танилцуулах нь шүүгчийн хуулиар хүлээсэн үүрэг болно. Иймд шүүгч шүүх хуралдааныг товлосны дараа хуралдаан болохоос өмнө боломжит хугацаанд хэргийн материал танилцуулна. Харин шүүх хуралдаан болох өдөр, эсхүл өмнөх өдөр танилцуулж байгаа нь зохигчдын мэтгэлцэх эрхээр бүрэн хангагдсан гэж үзэх боломжгүй байдаг.

Түүнчлэн хуулийн 76, 77 дугаар зүйлд зааснаар шүүгч, шүүх хуралдааны товыг хэргийн болон шүүх хуралдааны оролцогчид мэдэгдэх үүрэгтэй бөгөөд

ингэхдээ хуулийн 77 дугаар зүйлд заасан журмыг баримтлах ба энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд хуралдааны тов мэдэгдээгүй гэж үзнэ.

Нотлох баримт бүрдүүлэх, цуглуулах түүнийг үнэлэх талаарх хуульд заасан журам зөрчсөн, хэргийн оролцогчдын нотлох баримтыг шүүхийн журмаар гаргуулах тухай хүсэлтийг шийдвэрлээгүй гэсэн үндэслэлээр буюу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37, 40, 38.6, 38.9, 44, 47, 48 дугаар зүйлд заасныг зөрчсөнөөс шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан байна.

Дээрх төрлийн алдаа зөрчлийг хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн хэргээс түүвэрлэн дурдвал:

- а. нотлох баримт үнэлэх талаар хуулиар тогтоосон журам зөрчсөн буюу хэрэгт авагдаагүй, байхгүй баримтад үндэслэн хэргийг шийдвэрлэсэн, хэрэгт авагдсан нотлох баримтыг үнэлээгүй, шүүх хуралдаанаар хэлэлцсэн эсэх нь тодорхой бус, энэ талаар тэмдэглэлд тусгагдаагүй, нотлох баримтын хууль зүйн үндэслэл тогтоогдоогүй.
- б. нотлох баримт цуглуулах журам зөрчсөн, нотлох баримт гаргуулах талаар зохигчдын хүсэлтийг шийдвэрлээгүй буюу хүсэлтийг хангахаас үндэслэлгүйгээр татгалзсан,
- в. нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болсон хэрэгт ач холбогдол бүхий баримт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2, 44.4, 38 дугаар зүйлийн 38.6-д заасан шаардлагыг хангаагүй, хэрэг хянан шийдвэрлэхэд шаардлагатай нотлох баримт ирүүлэхийг холбогдох байгууллагад даалгасан захирамж гаргасан боловч уг захирамжийн заалт биелэгдээгүй, захирамжид заасан баримт хэрэгт авагдаагүй байхад шүүх хэргийг шийдвэрлэсэн, бичмэл нотлох баримт хуульд заасан хэлбэрийн шаардлага хангаагүй байхад уг баримтыг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгожээ.

Хэргийн оролцогчид шүүхэд бодит байдалд нийцсэн тайлбар өгөхийн зэрэгцээ тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримт гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй ба шүүх өөрийн санаачилгаар нотлох баримт бүрдүүлэхгүй, зөвхөн зохигч өөрөө бүрдүүлэх үүрэгтэй ба тэдгээрийн шүүхэд ирүүлсэн нотлох баримт шүүхийн шийдвэр гаргахад үндэслэл болж чадахуйц байх шаардлагатай.

Энэ нь нэг талаас үүрэг мэт боловч нөгөө талаас түүний мэтгэлцэх эрхээ хэрэгжүүлж байгаа нэг хэлбэр болно. Ингэснээр хэргийн оролцогч шаардлагатай гэсэн нотлох баримтыг шүүхэд бүрэн хангалттай гаргаж өгснөөр хэргийг зөв шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой болно.

Хэргийн оролцогчдоос шүүхэд ирүүлсэн нотлох баримт нь хуульд заасан арга хэлбэрээр олж авсан байхыг шаардана. Харин хууль бус аргаар цуглуулсан нотлох баримтыг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгохыг хуульд хориглосон байна.

Түүнээс гадна хэргийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй ач холбогдолтой нотлох баримтыг зохигч өөрөө олж авах боломжгүй тохиолдолд шүүхэд хүсэлт гаргах ба шүүх түүний хүсэлтийг үндэслэн уг нотлох баримтыг бүрдүүлж болно.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч хуулиар өөрт нь үүрэг болгосон ажиллагаанаас бусдыг хэргийн оролцогчдын хүсэлтээр хуульд нийцүүлэн явуулах бөгөөд өөрөөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд санаачилгаараа оролцох нь шүүх хөндлөнгийн байх хуульд заасан зарчимд нийцэхгүй болно.

Ийнхүү Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа мэтгэлцэх буюу талуудын тэгш эрхийн зарчимд үндэслэн явагдах бөгөөд аливаа маргаан, түүнийг шүүхээр шийдвэрлэх ажиллагаа нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар тогтоосон журмын дагуу явагдах ёстой. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчих нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.2-т зааснаар хяналтын гомдол гаргах улмаар шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгох үндэслэл болоод зогсохгүй шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаа, хариуцлагатай холбоотой гэж үзнэ. Шүүгчийн мэдлэг, чадварт эргэлзээ төрүүлэхээс гадна шүүхийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх үр дагавартай юм.

Эцэст нь Улсын Дээд шүүхийн шүүгч Ц.Амарсайхан шүүгчийн хэлсэнчлэн: “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн хэм хэмжээг зөрчих явдал нь иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчихөд хүргэдэг төдийгүй, иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилго бүхий шүүх өөрийн буруугаас шүүхээр хамгаалуулах иргэдийн эрхийг хязгаарладаг билээ. Энэ хортой үр дагаврыг бий болгохгүй байхын тулд шүүгч бүр хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож, хуульд заасан процессын үйлдэл тус бүрийг нарийвчлан зөв гүйцэтгэхийг эрхэмлэх нь чухал юм.” гэдгийг дурдахад илүүдэхгүй юм.

ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ НЭВТРҮҮЛЭХ НЬ¹⁰⁰

УДИРТГАЛ

Энэхүү судалгааг Монгол Улсын шүүн таслах ажиллагааны дийлэнх хувийг эзэлдэг иргэний хэргийн шүүхийн тоо баримтад тулгуурлан давж заалдах болон хяналтын шатны шүүх хэргийг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцаасан үндэслэл, мөн шүүх хуралдаан хойшлох буюу удааширч буй шалтгаан нөхцөл зэргийг тодруулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай, зардал чирэгдэл багатайгаар явуулах, цаашлаад шүүхийн шийдвэрийн чанар, тогтвортой байдлыг хангахад гарц шийдэл хайх зорилготойгоор боловсруулав.

Түүнчлэн энэхүү судалгаагаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгарч буй асуудал, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа болон шүүх хуралдаан хойшлох буюу удааширч буй шалтгаан нөхцөлийг тодорхойлж, гадаад орнуудын холбогдох хуулийн зохицуулалтыг судалж, санал, дүгнэлтийг дэвшүүлэв.

НЭГ. ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ТУЛГАРЧ БУЙ АСУУДАЛ

1.1. Шүүхийн шийдвэр, магадлал хүчингүй болж, дахин хэлэлцүүлэхээр буцаагдаж буй байдал

Шүүн таслах ажиллагааны сүүлийн 5 жилийн тоо баримтаас үзэхэд анхан шатны шүүх 2013 онд 35314 хэрэг, 2014 онд 33996 хэрэг, 2015 онд 40674 хэрэг, 2016 онд 46173, 2017 онд 45233 иргэний хэргийг тус тус хянан шийдвэрлэсэн. Үүнээс харахад иргэний хэрэг шүүн таслах ажиллагаанд хамгийн өндөр хувийг эзэлдэг бөгөөд жил бүр өсөх хандлагатай байна.

Хүснэгт №1¹⁰¹ Давж заалдах шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэсэн байдал

№	Хянан шийдвэрлэсэн байдал	2013	2014	2015	2016	2017
1	Хэвээр үлдээсэн	821	742	879	1080	1501
2	Өөрчлөлт оруулсан	492	593	944	1237	1411
3	Хүчингүй болгосон	493	612	696	791	809
	Нийт дүн	1806	1947	2519	3108	3721

Шүүхийн шийдвэрийн тогтвортой байдлын тухайд гэвэл давж заалдах шатанд анхан шатны шүүхийн шийдвэрийн ойролцоогоор 50-60 хувьд өөрчлөлт орох эсхүл хүчингүй болж байгаагаас 25-30 хувийг хүчингүй болсон шийдвэр эзэлж

¹⁰⁰ Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судлаач Б.Хонгорзул /LL.M/

¹⁰¹ Шүүхийн ерөнхий зөвлөл "Монгол Улсын шүүхийн тайлан", 2013, 2014, 2015, 2016, 2017

байна. Харин хяналтын шатны шүүхийн шийдвэрийн 8-17 орчим хувьд шийдвэр, магадлал хүчингүй болж, дахин хэлэлцүүлэхээр буцаагдсан байна.

Хүснэгт №2¹⁰² Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон үндэслэл

№	Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон үндэслэл	2013	2014	2015	2016	2017
1	Шүүх өөр хуулийг, эсвэл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй	75	114	208	128	161
2	Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангалгүй хэргийг хянан шийдвэрлэсэн	14	31	27	35	50
3	Хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсөн	72	47	108	145	150
4	Хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн	9	11	21	20	8
5	Шүүхийн шийдвэрт шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч гарын үсэг зураагүй, эсвэл шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан	0	1	2	-	2
6	Хуурамч нотлох баримтын үндсэн дээр хэргийг хянан шийдвэрлэсэн	0	0	-	3	0
7	ИХШШТХ-ийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлж хэргийг хянан шийдвэрлэсэн	171	100	96	158	188
8	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн	139	295	211	263	211
9	ИХШШТХ-ийн 168.2-т зааснаар шийдвэрлэсэн	13	13	23	39	39
	Нийт дүн	493	612	696	791	809

Хүснэгт №3¹⁰³ Хяналтын шатны шүүх хэргийг хүчингүй болгосон байдал

	Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг	Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан
2013	749	127
2014	841	102

¹⁰² Шүүхийн ерөнхий зөвлөл "Монгол Улсын шүүхийн тайлан", 2013, 2014, 2015, 2016, 2017

¹⁰³ Шүүхийн ерөнхий зөвлөл "Монгол Улсын шүүхийн тайлан", 2013, 2014, 2015, 2016, 2017

2015	1155	103
2016	1469	177
2017	1704	196

Хүснэгт №4¹⁰⁴ Хяналтын шатны шүүх шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон үндэслэл

№	Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан үндэслэл	2013	2014	2015	2016	2017
1	Шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй	64	33	59	68	93
2	Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангалгүй хэргийг хянан шийдвэрлэсэн	1	1	1	14	19
3	Хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсөн	17	19	10	24	18
4	Хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн	4	0	3	-	0
5	Шийдвэрт шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч гарын үсэг зураагүй, эсхүл шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан	0	-	-	-	0
6	Хуурамч нотлох баримтын үндсэн дээр хэргийг хянан шийдвэрлэсэн нь илэрсэн	0	0	1	4	2
7	ИХШХШТХ-ийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлсэн	41	49	29	67	64
	Нийт	127	102	103	177	196

Буцаагдсан хэргийн үндэслэлийг харвал дийлэнхдээ шүүх өөр хуулийг эсвэл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй гэх хуулийн хэрэглээтэй холбоотой, хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсөн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчигдсөнтэй холбоотой, мөн ИХШХШТХ-ийн 38.6-д заасан тохиолдолд нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлж хэргийг хянан шийдвэрлэсэн гэх нотлох баримттай холбоотой зөрчлүүд эзэлж байна.

Энэ нь анхан шатны шүүх хэргийн үйл баримтыг нарийвчлан тогтоож, түүнд тулгуурласан нотлох баримт шинжлэн судлах, процесс ажиллагаан дахь талуудын хүсэлтийг хангах тал дээр учир дутагдалтай ажиллаж байгааг харуулж байна.

Үүнээс болж шийдвэрүүд олноороо хүчингүй болж, дахин хэлэлцэгдэхээр буцаагддаг нь шүүхийн шийдвэрийн чанар тогтвортой байдал, талуудын болон

¹⁰⁴ Шүүхийн ерөнхий зөвлөл "Монгол Улсын шүүхийн тайлан", 2013, 2014, 2015, 2016, 2017

шүүн таслах ажиллагааны зардлыг ихэсгэх, хэрэг шийдвэрлэлтийг удаашруулах, цаашлаад талуудын шүүхэд итгэх итгэлд сөргөөр нөлөөлж байна.

1.2. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа

ИХШХШ тухай хуулийн 71.1-д хэрэг хянан шийдвэрлэх хугацааг 60 хоног гээд мөн хуулийн 71.2-т тус хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгах боломжтой бөгөөд иргэний хэргийг үүсгэх 7 хоногийн хугацааг оруулан тооцоход нийт 97 хоногт иргэний хэргийг шийдвэрлэхээр байна.

Гэвч өнөөгийн шүүхийн практикт иргэний хэргийг хуулиар тогтоосон дээрх хугацаанд шийдвэрлэх нь хүндрэлтэй бөгөөд тулгамдсан асуудлын нэг болжээ. Учир нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашралтай явагддаг, шүүхээс хугацаанд анхаарал хандуулдаггүй, хэргийн оролцогчид нь хүссэн үедээ хүсэлт гаргаж шүүх хуралдааныг хойшлуулдаг, шүүхээс шаардсан баримтуудыг иргэн, хуулийн этгээд хугацаанд нь гаргаж ирүүлдэггүй зэргээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хугацаандаа явагддаггүй байна¹⁰⁵.

1.3. Шүүх хуралдаан хойшлох үндэслэл, ангилал

Шүүх хуралдаан дунджаар 3-4 удаа тогмол хойшилдог. Практикт шүүх хуралдааныг хойшлуулж байгаа үндэслэлийг нэгдүгээрт хэргийн оролцогчийн хүсэлтээр, хоёрдугаарт шүүхийн санаачилгаар гэж 2 хувааж болох юм. Шүүх хуралдаан хойшилж байгаа дараах нийтлэг үндэслэлүүд байна. Үүнд нэгдүгээрт хэргийн оролцогчийн хүсэлтээр буюу нэхэмжлэлийн шаардлага нэмсэн эсхүл өөрчилсөн, хэргийн материалтай танилцах, гэрч, гуравдагч этгээд оролцуулах, өмгөөлөгч авах, солих, хүндэтгэн үзэх шалтгаан, шинжээч томилуулах, нотлох баримт гаргуулах, шүүгчээс татгалзах хүсэлт гаргасан¹⁰⁶.

Хоёрдугаарт шүүхийн санаачилгаар буюу шүүх хуралдааны явцад шинээр нотлох баримт шаардагдвал шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулах/ИХШХШТХ-ийн 38.9/, ИХШХШТХ-ийн 90.5, хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой нэмэлт тайлбар, нотлох баримтыг урьд нь гаргах буюу санал болгох бололцоотой байсан боловч шүүх хуралдааны үед гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаантай гэж шүүх үзвэл түүнийг хүлээн авч, шинжлэн судлах шаардлагатай гэж үзвэл шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулах/ИХШХШТХ-ийн 105.2/, гэрлэгчдийн хэн нэг нь хүндэтгэн үзэх шалтгаанаар ирээгүй бол шүүх хуралдааныг хойшлуулах/ИХШХШТХ-ийн 131.2/, хэргийн оролцогчид шүүх хуралдааны тов хүрээгүй тохиолдлоор шүүх хуралдаан хойшлох/ИХШХШТХ-ийн 76.1.2/ зэрэг байна¹⁰⁷.

Эдгээрээс түгээмэл тохиолддог үндэслэлд хэргийн оролцогчдын талаас хүндэтгэн үзэх шалтгаан, шинжээч томилуулах хүсэлт, нотлох баримт гаргуулах, өмгөөлөгч авах болон солих хүсэлтүүд байна. Харин шүүхийн талаас хэргийн

¹⁰⁵ "Орчин үеийн эрх зүйн тулгамдсан асуудлууд" эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, 2015 он, 33-р тал

¹⁰⁶ Хууль зүйн үндэсний хүрээлэн "Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шүүх хуралдаан хойшлох буюу удааширч буй шалтгаан нөхцөл", 2018 он, 10-р тал

¹⁰⁷ Мөн тэнд

оролцогчид эрх, үүргийг тайлбарлаагүй, хэргийн оролцогчид шүүх хуралдааны тов хүрээгүй гэх үндэслэлүүд байна.


Дээрхийг нэгтгэн дүгнэвэл анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал олноор хүчингүй болж, дахин хэлэлцүүлэгдэхээр буцаагддаг. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хугацаандаа явагддаггүй. Шүүх хуралдаан талуудын болон шүүхийн санаачилгаар тогтмол хойшилдог асуудлууд байна.

Иймд дээрх асуудлуудыг цогцоор нь шийдэх нэг арга зам нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд урьдчилсан хэлэлцүүлгийг явуулах явдал байж болох юм. Дараагийн хэсэгт гадаад орнуудын урьдчилсан хэлэлцүүлгийн талаарх зохицуулалтыг авч үзье.

ХОЁР. ГАДААД ОРНУУДЫН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.1. АНУ

Тус улсын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь 2 үе шатанд хуваагддаг. Нэхэмжлэгч анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргаснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлэх бөгөөд шүүх нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулна. Үүний дараа шүүх урьдчилсан хэлэлцүүлгийн товйг талуудад мэдэгдэнэ. Урьдчилсан хэлэлцүүлгийн үе шатанд талууд эвлэрэх нь элбэг байдаг байна. Урьдчилсан хэлэлцүүлэг дууссаны дараа шүүх хуралдааны үе шатанд шилждэг. Хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг тоймлон үзүүлбэл¹⁰⁸:



¹⁰⁸ 東京弁護士会民事訴訟問
Токиогийн Өмгөөлөгчдийн
дахь төлөөлөгчийн практик 2 урьдчилсан хэлэлцүүлэг” 2011 он

務Ⅱ争点整理』(青林書院、2011年)
дах тусгай комисс “Иргэний процесс

Pretrial conference нь хэргийн үйл баримтыг тогтоох зорилготойгоор зохигчид болон тэдний төлөөлөгч, өмгөөлөгч, шүүгч нарын хооронд явагддаг. Эхний Pretrial conference нь хэрэг шийдэх төлөвлөгөөг гаргахын тулд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлмэгц нээгдэж, түүний дараа хэд хэдэн хурал явагдаж, маргаантай асуудал болон шаардлагатай нотлох баримтуудыг аван, хамгийн сүүлийн Pretrial conference-н хурлын тэмдэглэлд(pretrial order) тусгадаг. Тус хурлын тэмдэглэл нь илтэд алдаатай байхаас бусад тохиолдолд засвар хийхийг зөвшөөрдөггүй(Нэгдсэн Улсын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам 16-р зүйл).

Урьдчилсан хуралдааны хурлын тэмдэглэлийн гол зорилго нь шүүх хуралдааныг үр дүнтэйгээр явуулах, хурлын тэмдэглэлд тусгаагүй нотлох баримт, гэрчийг нэмэхийг зарчмын хувьд зөвшөөрдөггүй бөгөөд энэ нь хэргийн үл ойлгогдох байдлаас сэргийлэхийн зэрэгцээ шүүх хуралд хэлэлцэгдэх маргаантай асуудлыг тогтоох, хумих ач холбогдолтой байдаг байна¹⁰⁹.

2.2. Англи

Англид иргэний хэргийн шүүхийн бэлтгэл ажиллагаа нь pleading гэх талууд хоорондоо хэргийн үйл баримтын талаар тайлбараа бичгээр солилцох ажиллагааг хэлдэг. Энэ ажиллагаанд шүүгч оролцдоггүйгээрээ онцлогтой. Ийм учраас тус баримтыг хэргийн бэлтгэл ажиллагааны шатанд шүүхэд гаргадаггүй, харин шүүхийн шатанд шүүхэд гаргадаг. Бэлтгэл ажиллагаа нь зөвхөн талуудын хооронд явагддаг гэдгээрээ шүүх ажиллагаа удаашрах талтай байдаг байна¹¹⁰.

Иймд талуудын хооронд солилцдог баримтын тоог хязгаарлах, засвар хийхийг хязгаарлах, баримтыг хүргүүлэх, засварлахад хугацаа тогтоох зэрэг заалтууд байдаг. Өөрөөр хэлбэл нэхэмжлэгч хугацаа баримтлаагүй бол нэхэмжлэл хэрэгсэхгүй болдог бол хариуцагч хугацаа баримтлаагүй бол нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсөнд тооцдог байна¹¹¹.

Бэлтгэл ажиллагаа нь талуудын хооронд явагддаг хэдий ч талууд хоорондоо шийдэж чадахгүй асуудал гарах үед шүүгч оролцдог хэдий ч тус шүүгч нь шүүх хуралдааныг удирдан явуулах шүүгч бус шүүх хуралдаанаас гадуурх ажиллагааг удирдан явуулдаг туслах шүүгч оролцдог. Тус шүүгч нь талуудын баримт гаргах хугацааг сунгах, засвар оруулахыг зөвшөөрөх, засвар хийхийг захирамжлах, хэргийн үйл баримтын талаар тайлбар хийхийг захирамжлах, баримтыг эс хүлээн авах гэх мэт эрх хэмжээтэй байдаг¹¹².

2.3. Герман

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тайлбар болон нотлох баримт гаргах үе шат болон түүнийг шинжлэн судлах гэсэн 2 үе шаттай явагддаг. Шүүхэд хандахаас өмнө заавал эвлэрэх гэж оролдож үзсэн байхыг шаарддаг. Тайлбар болон нотлох баримт гаргах буюу шүүхийн бэлтгэл ажиллагаа 2

¹⁰⁹ 8-р ишлэл дэх номын 122-р тал

¹¹⁰ 8-р ишлэл дэх номын 125-р тал

¹¹¹ 8-р ишлэл дэх номын 125-р тал

¹¹² 8-р ишлэл дэх номын 126-р тал

хэлбэрээр явагддаг¹¹³. Үүнд нэгдүгээрт хэрэг үүсгэснээс хойш аль болох түргэн хугацаанд эхний шүүх хуралдааныг зарлан, зохигчид болон шүүгчид хэргийн үйл баримтыг тогтоосны дараа нотлох баримтыг шинжлэн судлах үе шат эхэлдэг.

Харин хоёр дахь хэлбэр нь хэрэг үүсгэсний дараа шүүх хуралдаан зарлалгүйгээр талууд тайлбар болон нотлох баримтаа бичгээр гарган маргааны үйл баримтыг тогтоосны дараа нотлох баримт шинжлэн судлах үе шат эхэлдэг.

Түүнчлэн шүүгч талуудаас нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл, хэргийн үйл баримтын талаар асууж тодруулах замаар хэргийг хөтлөн явуулах эрх 2001 оны Иргэний процессын хуулийн шинэчлэсэн найруулгаар нэмэгдсэн¹¹⁴. Хэргийн үйл баримтыг тодруулахтай холбоотой асуулт нь шүүх хуралдааны өмнө эсхүл шүүх хуралдаан хооронд бичгээр эсхүл амаар өргөн хүрээнд явагддаг. Бичгээр хийгдсэн тодруулга нь хавтаст хэрэгт авагдан, шүүх хуралдаан дээр амаар явагдсан тодруулга нь шүүх хуралдааны тэмдэглэлд тусгагддаг.

2.4. Япон

Японы иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа тайлбар болон нотлох баримт цуглуулах, бүрдүүлэх, гаргах буюу бэлтгэл ажиллагаа (урьдчилсан хэлэлцүүлгийн шат), нотлох баримт шинжлэн судлах буюу шүүхийн шат гэсэн 2 үе шаттайгаар явагддаг.

Урьдчилсан хэлэлцүүлэг 3 хэлбэрээр явагддаг. Үүнд нээлттэй хэлэлцүүлэг, хаалттай хэлэлцүүлэг, бичгээр явагдах хэлэлцүүлэг гэсэн төрөлтэй. Олон хэргийн оролцогчтой, нээлттэй хуралдах шаардлагатай(захиргааны хэрэг, хөдөлмөрийн хэрэг, нийгмийн анхаарлыг татсан хэрэг) хэрэгт нээлттэй хэлэлцүүлгийн аргыг хэрэглэдэг бол зохигч талууд хоорондоо маш хол зайд амьдардаг, зохигчид өвчтэй зэрэг шалтгаанаар урьдчилсан хэлэлцүүлэгт ирэхэд хүндрэлтэй бол хэлэлцүүлгийг бичгээр явуулах аргыг хэрэглэдэг. Харин үүнээс бусад хэрэгт практикт хаалттай хэлэлцүүлгийн аргыг өргөнөөр хэрэглэдэг байна.

Урьдчилсан хэлэлцүүлэг дээр талууд тайлбар болон бүх бичмэл нотлох баримтыг гарган мэтгэлцдэг. Ийнхүү хэргийн үйл баримт, маргаантай асуудал тодорхой болж, шаардлагатай нотлох баримт (ямар ямар этгээдүүдийг гэрчээр дуудах, гэрчээс ямар агуулгатай мэдүүлэг авах, хэр хугацаанд асуулт тавих зэргийг мөн хэлэлцдэг) цугларсаны дараа урьдчилсан хэлэлцүүлгийг дуусгавар болгодог. Үүний дараа шүүхийн шатанд урьдчилсан хэлэлцүүлгийн үр дүнг бичгээр бэлдэн танилцуулсаны дараа талуудын болон гэрчийн мэдүүлгийг авснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болж, шүүх шийдвэрээ гаргадаг.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Шүүхийн жил бүрийн статистикаас харахад анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал олноор хүчингүй болсон бөгөөд шүүхийн шийдвэрийн

¹¹³ 8-р ишлэл дэх номын 134-р тал

¹¹⁴ 8-р ишлэл дэх номын 135-р тал

чанар, тогтвортой байдал суларчээ. Үүний үндэслэл, шалтгаанд хуулийн хэрэглээ, хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрх ноцтой зөрчигдсөн, ИХШХШТХ-ийн 38.6-д зааснаар нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлж хэргийг хянан шийдвэрлэсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн зэрэг үндэслэлүүд зонхилж байна. Энэ нь шүүхийн ачаалал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа эсхүл талууд болон шүүхийн хайхрамжгүй байдлаас шалтгаалан үүсч буй асуудал байж болох юм.

Хуулиар хэрэг хянан шийдвэрлэх хугацааг сунгалт ороод 90 хоногт багтаан шийдвэрлүүлэхээр заасан хэдий ч талуудын хариуцлагагүй байдал, хариуцагч талын хэрэг маргааныг нэн даруй шийдвэрлүүлэх санаагүй байдал, мөн хэргийн ээдрээ төвөгтэй байдал зэргээс шалтгаалан дээрх хугацааг баримтлах боломжгүй байдаг байна. Үүнээс болж хэдий нотлох баримт, тайлбарыг шүүх хуралдааны өмнө гаргах ёстой ч тус заалт практикт хэрэгждэггүй бөгөөд шүүх хуралдаан талуудын хүсэлтээр тогтмол хойшилж буй асуудлууд байна.

Иймд дээрх гадаад орнуудын хуулийн зохицуулалтын адил хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тайлбар, нотлох баримт гаргах, хэргийн үйл баримт, маргаантай асуудлыг тодруулах урьдчилсан хэлэлцүүлгийн үе шат болон нотлох баримтыг шинжлэх судлах шүүхийн шат гэж 2 хуваах нь зүйтэй гэж үзээд доорх саналыг дэвшүүлж байна.

Эдгээр саналыг практикт хэрэгжүүлснээр талуудын болон шүүхийн хүсэлтээр шүүх хуралдаан хойшлох явдал багасч, зохигч талууд болон тэдний өмгөөлөгч нарын шүүх хуралдаанд урьдчилан бэлтгэх ухамсар дээшилж, мэргэшсэнээр талууд өмгөөлөгчөө олон дахин солих байдал арилж, шүүхийн шийдвэрийн чанар, тогтвортой байдал сайжрах талтай юм.

ДӨРӨВ. САНАЛ

- Талууд зөвхөн урьдчилсан хэлэлцүүлгийн үе шатанд хүсэлт гаргадаг байх (нэхэмжлэлийн шаардлагаа нэмэх буюу өөрчлөх, хэргийн материалтай танилцах, гэрч, гуравдагч этгээдийг оролцуулах, шинжээч томилуулах, нотлох баримт гаргуулах хүсэлт гаргах).
- Шүүгч хэргийн үйл баримт, шаардлагатай нотлох баримтуудыг тогтоохын тулд талуудаас тайлбар шаардах, тодруулга асуулт идэвхтэйгээр асуух замаар шүүн таслах ажиллагааг хөтлөн явуулах.
- Шүүгч урьдчилсан хэлэлцүүлгийн зохистой үе шатанд эвлэрэл болон эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэхийг талуудад санал болгох нь эдгээр арга хэмжээ амжилттай болох үр дүнтэй.
- Зөвхөн урьдчилсан хэлэлцүүлгийн үе шатанд шаардлагатай тайлбар, нотлох баримтыг гаргадаг байх. Хэрэв шүүхийн шатанд шинээр тайлбар, нотлох баримт гаргах шаардлагатай бол урьд өмнө гаргаж чадахааргүй хүндэтгэн үзэх шалтгаантай байсныг шүүхэд нотолдог болох. Хэрэв эс чадваас тайлбар, нотлох баримтыг үнэлэхгүй байх.
- Хэрэг хянан шийдвэрлэх ерөнхий хугацаа (90 хоног) гэсэн ойлголтыг хуулиас хасч, хэрэг хянан шийдвэрлэх хугацааг шүүх талуудтай хэрэг бүр дээр тусад нь тогтоодог болох.

- Талууд тайлбар, үндэслэлээ бичгээр гаргадаг болох. Энэ нь талуудын бүх тайлбар, үндэслэл хавтас хэрэгт гээгдэлгүй тэмдэглэгдэх, мөн шүүхийн нарийн бичгийн ажлыг хөнгөвчилж, шүүхэд шийдвэрээ гаргахад нь ч тустай билээ.



УДИРТГАЛ

1992 оны шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш шүүхийг шинэ Үндсэн хуулийн зарчим, агуулгад нийцүүлж байгуулахдаа харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтрал, аж ахуйн нэгж, байгууллагын тоо, хэрэг, маргааны гаралтын түвшин зэргийг харгалзан байгуулж байжээ.

Ийнхүү байгуулахдаа 1993 оны Шүүхийн тухай болон Шүүх байгуулах тухай хуулиудад шүүгчийн ажлын ачааллын норм, стандарт ямар байх тухай, мөн шүүгчийн ажлын ачааллыг хэрхэн зохистойгоор тэнцвэржүүлэх тухай зохицуулалтыг тусгаагүй байна.

Үүнтэй холбогдуулан Улсын Их Хурлын 2000 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн чуулганаар хэлэлцүүлж, УИХ-ын 2000 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”-ний 2.3.1-т “шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтны ажлын ачаалалд хамаарагдах үйл ажиллагааны хүрээг тодорхойлж, тэдэнд ногдох ачааллын хамгийн их хязгаарыг тогтоох” арга хэмжээ авна гэж тусгажээ.

Энэ хүрээнд хууль тогтоогчийн зүгээс шүүгчийн ачааллыг тэнцвэржүүлэх талаарх зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлсэн байна.

Тухайлбал, 2002 онд батлагдсан Шүүхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгчийг шүүн таслах ажлын дадлага эзэмшүүлэх, туршлага судлуулах, шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, шүүхийн боловсон хүчнийг оновчтой байршуулах зорилгоор адил шатны шүүхэд өөрийнх нь зөвшөөрснөөр сэлгэн ажиллуулж болно”, 42.2-т “Улсын дээд шүүхийн шүүгчийг танхим хооронд нь Ерөнхий шүүгчийн шийдвэрээр сэлгэн ажиллуулж болно.”, 42.3-т “Энэ хуулийн 42.1-д зааснаар шүүгчийг сэлгэн ажиллуулах шийдвэрийг Ерөнхийлөгч гаргана.” гэж тусгасан байна.

Түүнчлэн 2012 онд батлагдсан Шүүхийн захиргааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5-д “Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүгч болон шүүхийн захиргааны ажилтны ажлын ачааллыг судалж, холбогдох арга хэмжээ авах, тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг энэ хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу хамгаалах” бүрэн эрхтэй гэж тусгасан.

¹¹⁵ Шүүхийн ерөнхий зөвлөлийн захиалгаар “Хөгжлийн санаачилга, бодлого судлалын төв” нийслэлийн 6 дүүргийн эрүү, иргэний хэргийн анхан шатны шүүх, нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх, сум дундын эрүү, иргэний анхан шатны шүүхүүдэд шүүгчийн ажлын ачааллыг тооцох судалгааг анх удаа хийсэн бөгөөд энэхүү “Шүүгчийн ажлын ачаалал тодорхойлох судалгааны тайлан”-г бүрэн эхээр нь эмхэтгэв.

Хэдийгээр дээр дурдсанчлан шүүгчийн ажлын ачааллыг тооцох талаарх зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгаж байсан боловч өнөөг хүртэл шүүгчийн ажлын ачааллыг тодорхойлсон норм, стандартыг батлаагүй байна. Энэ нь шүүгчийн ажлын ачааллыг тодорхойлоход шалгуур үзүүлэлт тодорхойгүй, энэ талаарх цогц судалгаа хийгдээгүй байсантай холбоотой.

Монгол Улсын хувьд 1993 оны Шүүх байгуулах тухай болон Шүүхийн тухай хууль батлагдсанаас хойш өнөөг хүртэл шүүгчийн ажлын ачааллыг тооцохдоо тухайн жилд нийт шийдвэрлэсэн хэргийн тоогоор ажлын ачааллыг тооцож хэвшсэн байна. Энэ нь дараах сул талтай болохыг иргэний хэргийн шүүхэд хянан шийдвэрлэсэн практикаар жишээ болгон авч үзье.

Улсын хэмжээгээр 2015-2017 оны хооронд буюу сүүлийн 3 жилийн дунджаар авч үзвэл нийт шийдвэрлэгдсэн хэргийн 33.2 хувийг ИХШХШТХ-ийн 74 дүгээр зүйл /талууд эвлэрэх, нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх/, 53.6 хувийг ИХШХШТХ-ийн 115-р зүйл /талуудыг мэтгэлцүүлэн шийдвэрлэсэн хэрэг/, 13.2 хувийг ИХШХШТХ-ийн 117 дугаар зүйлээр /Хэргийг хэрэгсэхгүй болгосон/ тус тус хэргийг шийдвэрлэсэн байна.

Үүнээс үзэхэд ИХШХШТХ-ийн 115-р зүйлийн дагуу талуудыг мэтгэлцүүлэн шийдвэрлэсэн хэрэг хянан шийдвэрлэх хугацаа 69 хоног, талууд эвлэрэх, хялбаршуулсан журмаар шийдвэрлэх хэрэг 42.7 хоног, онцгой ажиллагааны журмаар 27.4 хоногийн хугацаа дунджаар зарцуулагддаг байна. Эдгээр ачааллыг адилтган тооцож ирсэн нь арга зүйн хувьд алдаатай болсон нь харагдаж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсээс хийсэн судалгаагаар өнөөгийн байдлаар Монгол Улсад “шүүгчдийн шүүн таслах ажлын үзүүлэлтийг бүрэн гүйцэд гаргаж чаддаггүй, зөвхөн шийдсэн хэргээр ажлын үзүүлэлтийг гаргаж хэвшсэн нь учир дутагдалтай болсон” гэжээ.

Дээрхээс үзэхэд шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй хүчин зүйлийг бодитой гаргаж ирэх үүднээс хэрэг маргааны төрөл, хэргийн онцлог шинж, мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлөх бусад хувьсах хүчин зүйлийг харгалзан шүүгчийн ажлын ачааллыг тооцсон цогц судалгаа хийх шаардлагатай болох нь харагдаж байна.

Тус судалгаа нь дөрвөн бүлэгтэй бөгөөд нэгдүгээр бүлэгт Эрүүгийн хэргийн шүүхийн ажлын ачаалал, хоёрдугаар бүлэгт Иргэний хэргийн шүүхийн ажлын ачаалал, гуравдугаар бүлэгт Захиргааны хэргийн шүүхийн ажлын ачааллыг тус тус тооцож, судалгааг гүйцэтгэлээ.

Судалгааны зорилго

Монгол Улсын шүүх институцийн үйл ажиллагааны өнөөгийн байдал болон шүүгчдийн хуульд заасан бүрэн эрх, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг судалгааны ажлын даалгаварт тусгасан шүүгчийн ажлын ачаалал тодорхойлох

үзүүлэлтэд тулгуурлан шинжлэн судалж, тэдний ажлын ачааллыг бодитой тодорхойлох, тайлан, санал зөвлөмж боловсруулахад чиглэсэн. Энэ зорилгод хүрэхийн тулд судалгааны багийн зүгээс шүүгчдээс ярилцлага, шүүгчийн ажлын байрны зураг авалт болон ажиглалт, хавтаст хэргийн шинжилгээний хүрээнд ажлын ачаалалд шууд болон дам байдлаар нөлөөлж буй асуудлуудыг судалсан болно.

Судалгааны зорилт

- Шүүгчийн ажлын ачааллыг тодорхойлох үзүүлэлтийг тооцох аргачлалыг судалж бодлогын хувилбар боловсруулах;
- Эрүүгийн, иргэний болон захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүн таслах ажиллагаатай холбогдох үеийн/ шүүх ажиллагааны өмнөх, шүүх хуралдааны үеийн, шүүх хуралдааны дараа/ ачааллыг судалж тодорхойлох;
- Шүүгчийн гүйцэтгэх ажил, чиг үүргээс бусад ажлууд болох багшлах, эрдэм шинжилгээ, сургалт хэлэлцүүлэг зэргийг судалж, өнөөгийн байдлыг харьцуулан дүгнэсний үндсэн дээр шүүгчийн ажлын ачааллыг хэрхэн тооцох талаар санал, зөвлөмж боловсруулна.


Сэдвийн судлагдсан байдал

Энэхүү судалгаанд шүүгчийн ажлын ачааллыг тооцох талаар хийгдэж байсан хэд хэдэн судалгааны тайлан, статистик мэдээ, мэдээлэл зэрэг эх сурвалжуудыг ашигласан. Тухайлбал, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсийн гаргасан статистик мэдээлэл, мөн энэ хэлтсээс хийсэн “Нийслэл дэх дүүргийн иргэний хэргийн анхан шатны зарим шүүх, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, шүүхийн захиргааны ажилтны ажлын ачаалал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс” судалгааны тайлан, мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн 2015 онд гүйцэтгэсэн “Гадаадын зарим улсын шүүгчдийн тоо ба 100.000 хүн амд ногдох шүүгчдийн тоон харьцуулалт” сэдэвт судалгааг эх сурвалж болгон ашигласан.

Судалгааны арга зүй

Энэхүү үнэлгээ судалгааг тоон ба чанарын арга зүй болон шинжлэх ухааны үндсэн арга болох харьцуулах, түүхчлэх, задлан шинжилгээ (анализ)-ний аргыг ашигласан. Түүнчлэн, шүүгчийн ажлын ачааллыг тодорхойлохын тулд социологийн судалгааны үндсэн аргууд болох ажиглалт, ярилцлага, контент анализын аргуудыг ашигласан болно.

Судалгааны мэдээлэл цуглуулж, боловсруулсан байдал



Судалгаанд ганцаарчилсан ярилцлага, ажиглалтын аргуудыг хослуулан хэрэглэсэн бөгөөд хууль эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийхдээ бичиг баримтын судалгааг ашиглав.

Түүнчлэн дэлхийн улсууд шүүх, шүүгчийн ажлын ачааллыг тооцохдоо тухайн улсын шүүхийн байгууллага, хууль эрх зүйн тогтолцоо, шүүхийн байршил, онцлог, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр өөрийн орны нөхцөлд тохируулан дараах гурван уламжлалт аргачлалыг дангаар нь эсхүл тус гурван аргачлал дээр тулгуурласан дөрөв дэх аргачлалыг хэрэглэж байдаг.¹¹⁶ Үүнд:

- Тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулж буй цаг, минутаар нь ачааллыг тооцох буюу “хэргийн жингийн ачааллаар үнэлэх аргачлал”
- Дельфи аргачлал
- Норматив аргачлал
- Холимог аргачлал

Судалгааны багийн зүгээс эдгээр аргачлалд тулгуурлан холимог хэлбэрийн аргачлалын дагуу шүүгчийн ажлын ачааллыг бодитой гаргаж ирэхийг зорьсон бөгөөд шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь стандарт үйл ажиллагаанд зарцуулж буй хугацааг тооцоолох, судлах зорилго тавьж ажилласан болно.

¹¹⁶ Шүүгчийн ажлын ачааллыг тооцох гадаадын зарим улсын аргачлалын талаарх лавлагаа, 2015 он, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судалгааны тайлангийн эмхтгэл, 212 дугаар тал.

Хэргийн жингийн ачааллаар үнэлэх аргачлал нь хэргийг маргааны төрөл, ээдрээ төвөгтэй байдлаар нь ялгаж, шүүгчийн ижил төсөөтэй хэрэг шийдвэрлэсэн давтамж, тухайн хэрэгт хийгдэж буй ажиллагаа бүрт зарцуулсан хугацааг тодорхойлсны үндсэн дээр шүүгч тодорхой хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд зарцуулсан нийт хугацааг тооцон гаргадаг¹¹⁷. Хэргийн жингийн ачаалал нь шүүхэд ирсэн нэг тодорхой хэргийг хүлээн авснаас хойш хэргийг шийдвэрлэж дуусах хүртэлх хугацаанд хийсэн ажиллагаа тус бүрт зарцуулж буй дундаж хугацааг илэрхийлдэг байна.

Дельфи аргачлал бол хууль зүйн салбарын шинжээч, мэргэжилтнүүдээс санал асуулга авсны үндсэн дээр шүүгчийн төрөл бүрийн хэрэг, маргаанд зарцуулж буй дундаж хугацааг тооцсоноор шүүгчийн ажлын ачааллыг тооцох аргачлал юм. Дельфи аргачлал нь хэргийн жингийн ачааллаар үнэлэх аргачлалтай төстэй аргачлал юм¹¹⁸.

Норматив аргачлал нь шүүгчийн ажлын ачааллыг тооцоход эдийн засгийн хувьд хамгийн хэмнэлттэй, энгийн аргад тооцогддог. Энэ аргачлалаар нэг тойрогт байрших шүүхүүдийн хэргийн ачааллыг харьцуулах замаар /үүнд тухайн тойрог дахь нийт хэргийн тоог нийт шүүгчдийн тоонд хувааж тооцно/ шүүгчийн ажлын ачааллыг гаргана. Энэ байдлаар нэг хэрэгт ногдох шүүгчийн тоог ойролцоогоор тооцдог¹¹⁹.

Холимог аргачлалын хувьд дээрх 3 аргачлалд тулгуурлан шүүгчийн ажлын ачааллыг тооцох аргачлал юм. Судалгааны багийн зүгээс дээрх 3 аргачлалд тулгуурлан холимог хэлбэрийн аргачлалаар шүүгчийн ажлын ачааллыг тооцохыг зорьсон болно. Ингэхдээ эрүүгийн хэрэг, иргэний хэрэг, захиргааны хэргийн нэг шүүгчийн тухайн хэргийг шийдвэрлэхэд хийж буй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нэг бүрт зарцуулах хугацааг шүүгч нартай ярилцлага хийх аргаар авч тооцсон.

Улмаар ярилцлага хийсэн шүүгчээс шийдвэрлэсэн нэг хөнгөн хэрэг, нэг хүнд хэргийг сонгон авч хавтаст хэрэгт дүн шинжилгээ хийсэн болно. Хавтаст хэргийг шинжлэхдээ хэрэг үүсгэсэн, шүүгчид хэрэг ирснээс хойш ямар ямар ажиллагаа хийгдсэн болох, түүний давтамжийн тоог гаргасан. Тухайлбал хавтаст хэргийн хуудасны тоо, нотлох баримтын хуудасны тоо, шүүгчээс гаргасан захирамжийн тоо, шүүх хуралдаан хойшилсон тоо, гэрчийн тоо, үзлэгийн тоо, шинжээчийн дүгнэлтийн тоо зэргийг судалсан болно.

Хавтаст хэргийн агуулгад дүн шинжилгээ хийж судалснаар тухайлбал, иргэний хэргийн онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх нэг маргаанд ямар ямар ажиллагаа хийгддэг болох, ИХШХШТХ-ийн 115 дугаар зүйлд зааснаар

¹¹⁷ Шүүгчийн ажлын ачааллыг тооцох гадаадын зарим улсын аргачлалын талаарх лавлагаа, 2015 он, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судалгааны тайлангийн эмхтгэл, 212 дугаар тал.

¹¹⁸ Мөн тэнд.

¹¹⁹ Мөн тэнд.

шийдвэрлэдэг нэг маргаанд ямар ажиллагаа ямар давтамжтай хийгддэг болохыг тооцсон болно.

Улмаар эрүү, иргэн, захиргааны хэргийн нэг шүүгчид жилдээ ногдож буй хэргийн тоог гарган ирснээр нэг шүүгч жилдээ хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд зарцуулж буй нийт хугацааг тооцон гаргалаа.

НЭГ.ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХИЙН АЖЛЫН АЧААЛАЛ

1.1. Эрүүгийн хэргийн шүүхийн ажлын ачааллын ерөнхий төлөв байдал

Эрүүгийн хэргийн шүүхийн ажлын ачааллын ерөнхий төлөв байдлыг гаргахдаа Шүүхийн ерөнхий зөвлөлийн Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсээс сар бүр гаргадаг “Хэргийн хөдөлгөөний мэдээлэл”, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс хагас жил, бүтэн жилээр гаргадаг “Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны тайлан”-д тулгуурлаж тооцлоо.

Хүснэгт №1 Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн хэргийн хөдөлгөөн, 2017 он

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Хүлээн авсан	Хянан шийдвэрлэсэн	ХХША-д	Хугацаа хэтэрсэн
Нийслэл дэх Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд	632	582	453	1
Орон нутаг дахь эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд	588	554	320	10
Нийт	1220	1136	773	11

Өнгөрсөн 2017 онд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх шинээр 1220 хэрэг хүлээн авч, 1136 хэрэг хянан шийдвэрлэж, 773 хэргийн шүүх хуралдаан хойшилсон байна. Харин 11 хэрэг хугацаа хэтэрсэн үзүүлэлттэй байна.

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ачаалал: Шүүгчийн хэргийн ачааллыг тооцохдоо тухайн шүүхийн хянан шийдвэрлэсэн нийт хэргийг тайлант хугацаанд ажилласан^{120*} шүүгчийн тоонд харьцуулж ерөнхий байдлаар гаргав. 2017 онд эдгээр шүүхэд нийт 54.5 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүгчид дунджаар 68.3 хэрэг ногдож байна. Баянзүрх

¹²⁰Тайлбар* Тайлант хугацаанд ажилласан шүүгчдийн тоог тооцохдоо Шүүхийн хүний нөөцийн газраас гаргасан 1-12 саруудын тоон судалгаан дээр үндэслэн гаргасан болно. Тухайлбал Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 1-11 дүгээр саруудад 9 шүүгчтэй, 12 дугаар сард 10 шүүгчтэй ажилласан байна. Эндээс 9 шүүгч нь тайлант хугацаанд бүтэн 12 сар, шинээр томилогдсон 1 шүүгч нь 1 сар ажилласан гэж тооцвол тайлант хугацаанд ажилласан шүүгчдийн дундаж тоо 9.1 байна. Өөрөөр хэлбэл, 1 шүүгч тайлант хугацааны 12 сар бүтэн ажилласан бол “1 бүхэл” гэж тооцогдох бөгөөд шинэ шүүгч томилогдсон тохиолдолд 1/12*ажилласан сар гэсэн аргачлалаар тооцсон болно.

дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нарын ачаалал дунджаас харьцангуй өндөр байгаа бол Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн хэргийн ачаалал харьцангуй бага¹²¹ байна. /Хүснэгт №2/

Хүснэгт №2 Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн хэргийн ачаалал

Шүүх	Эрүүгийн хэрэг	Шүүгчийн тоо	Нэг шүүгчид ногдох хэргийн тоо
Нийт дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн дундаж	3725	54.5	68.3
Судалгааны түүвэрт орсон шүүхүүд			
Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	841	9.1	92.4
Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	495	7.0	70.7
Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	612	7.1	86.2
Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	594	8.0	74.3
Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	382	7.7	49.6
Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	569	8.7	65.4
Нийт/дундаж	3496	47.6	73.4

Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ачаалал: 2017 онд сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 68.2 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүгч дунджаар 63.8 хэрэг шийдвэрлэсэн байна. Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгчид 115.1 хэрэг, Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгчид 91.2 хэрэг, Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгчид 87 хэрэг ногдож байгаа бөгөөд дунджаас харьцангуй их ачаалалтай ажилласан байна. Харин Говь-Алтай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгчид дунджаар 31.7 хэрэг, Завхан аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгчид дунджаар 29.3 хэрэг ногдож байгаа нь дунджаас харьцангуй бага байсан байна. /Хүснэгт №3/


¹²¹ Монгол Улсын шүүхийн тайлан 2017 он, Шүүхийн ерөнхий зөвлөл, 2018 он, 269 дахь тал.

Хүснэгт №3 Сум дундын эрүүгийн анхан шатны шүүхийн шүүгчийн хэргийн ачаалал

Шүүх	Эрүүгийн хэрэг	Шүүгчийн тоо	Нэг шүүгчид ногдох хэргийн тоо
Нийт Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн дундаж	4349	68.2	63.8
Судалгааны түүвэрт орсон шүүхүүд			
Өвөрхангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	174	3	58.0
Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	447	4.9	91.2
Нийт/ дундаж	621	7.9	78.6

Шүүхийн захиргааны тухай хуулийн 7 дугаар зүйлд шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах талаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэн эрхийг тусгаж өгсөн байх бөгөөд үүний 7.1.5-т “шүүгч болон шүүхийн захиргааны ажилтны ажлын ачааллыг судалж, холбогдох арга хэмжээ авах” гэж хуульчилж өгсөн байна. Энэ хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн захиалгаар Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх, Хан-Уул, Баянгол, Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдэд, орон нутагт Өвөрхангай, Төв аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн шүүгч нарын ажлын ачааллыг судаллаа.

Зураг №1 Судалгаанд хамрагдсан эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн ажиллаж буй шүүх



Судалгаанд хамрагдсан шүүхүүдээс захиалагч байгууллагаас тогтоосон түүврийн дагуу шүүгч нарыг хамруулсан бөгөөд судалгаанд хамрагдсан шүүгч нарын хүйсийн харьцаа, насны бүтцийг (зураг №2)-оос харна уу.

Зураг №2 Судалгаанд хамрагдсан эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн хүн ам зүйн байдал



Гүйцэтгэгчийн зүгээс судалгааг хийхдээ шүүгчээр ажилласан жилийг 5 хүртэл жил ажилласан, 6-10 жил ажилласан, 11-ээс дээш жил ажилласан туршлагатай шүүгч байхаар тооцоолж судалгааг авахыг зорьсон болно. Ганцаарчилсан ярилцлагад нийт 25 эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч оролцсон бол ажлын байрны зураг авалт 13 шүүгч хамрагдсан байна.

Судалгаанд оролцсон шүүгч нараас эрүүгийн хэргийн шүүхийн шүүгчээр ажиллахад ачаалалтай санагддаг эсэх талаар асуухад нийслэлд 55.6 хувь нь, орон нутагт 85.7 хувь нь ачаалалтай гэсэн хариултыг өгсөн. Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны 2017 дүн мэдээнээс үзвэл дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгчид жилд 73 хэрэг ногдож байхад судалгаанд хамрагдсан сум дундын эрүүгийн хэргийн нэг шүүгчид 65 хэрэг ногдож байгааг үзвэл дүүргийн шүүгч даруй 8 хэргээр илүү ачаалалтай байтал орон нутгийн шүүгч илүү ачаалалтай гэж хариулсан байна. Энэ нь шүүгч шийдвэрлэж буй хэргийн тооноос үл хамааралтайгаар шүүгчийн ажлыг ачаалалтай гэж үзэх хандлага буйг харуулж байна.

Зураг №3 Эрүүгийн хэргийн шүүхийн шүүгчээр ажиллах ачаалалтай санагддаг эсэх



Монгол улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны 2017 оны дүн мэдээнээс үзвэл “эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд 2017 онд нийт 14079 хүнд холбогдох 10412 эрүүгийн хэрэг хүлээн авснаас 887 хүнд холбогдох 491 хэргийг хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтад, 418 хүнд холбогдох 283 хэргийг прокурорт буцааж, 13 хүнд холбогдох 11 хэргийг түдгэлзүүлж, 149 хүнд холбогдох 47 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 1222 хүнд холбогдох 865 хэргийг хэрэгсэхгүй болгож, нийт 8839 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэж, 10040 хүнийг гэм буруутайд тооцож, үүнээс 962 хүнийг хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, 59 хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, 9019 хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, ял шийтгэл оногдуулсан бөгөөд тайлант хугацааны эцэст 741 хэргийн үлдэгдэлтэй байна” гэжээ.

Үүнээс судалгаанд хамрагдсан нийслэлийн 6 дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2017 онд нийт 3496 хэрэг шийдвэрлэсэн байх бөгөөд Баянзүрх дүүргийн шүүх хамгийн олон хэрэг шийдвэрлэж, нэг шүүгчид ногдох хэргийн тоо нь 92.4 хэрэг байсан бол, Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 382 хэрэг шийдвэрлэж, нэг шүүгч жилд 49.6 хэрэг шийдвэрлэсэн¹²² байна. Нийслэлийн хэмжээнд авч үзвэл нэг шүүгчид дунджаар 73.4 эрүүгийн хэрэг ногдож шийдвэрлэсэн байна. (Хүснэгт №1-ээс дэлгэрэнгүй үзнэ үү). Харин орон нутаг дахь судалгаанд хамрагдсан гурван сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 2017 оны байдлаар 709 хэргийг 10.9 шүүгч шийдвэрлэсэн байх бөгөөд нэг шүүгчид 65 эрүүгийн хэрэг ногдсон байна.

Хүснэгт №4 Нийслэлийн 6 дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн хэргийн ачаалал 2017 он

Шүүх	Эрүүгийн хэргийн тоо	Шүүгчийн тоо ¹²³	Нэг шүүгчид ногдох хэргийн тоо	Өсөлт бууралт
Баянзүрх	841	9.1	92.4	+19
Сүхбаатар	495	7.0	70.7	-3.4
Чингэлтэй	612	7.1	86.2	+12.8
Баянгол	594	8.0	74.3	+0.9
Хан-Уул	382	7.7	49.6	-23.8

¹²² Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны дүн мэдээ 2017 он, 66-р тал.

¹²³ Тайлбар: Тайлант хугацаанд ажилласан шүүгчдийн тоог тооцохдоо Шүүхийн хүний нөөцийн газраас гаргасан 1-12 саруудын тоон судалгаан дээр үндэслэн гаргасан болно. Тухайлбал Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 1-11 дүгээр саруудад 9 шүүгчтэй, 12 дугаар сард 10 шүүгчтэй ажилласан байна. Эндээс 9 шүүгч нь тайлант хугацаанд бүтэн 12 сар, шинээр томилогдсон 1 шүүгч нь 1 сар ажилласан гэж тооцвол тайлант хугацаанд ажилласан шүүгчдийн дундаж тоо 9.1 байна. Өөрөөр хэлбэл, 1 шүүгч тайлант хугацааны 12 сар бүтэн ажилласан бол “1 бүхэл” гэж тооцогдох бөгөөд шинэ шүүгч томилогдсон тохиолдолд 1/12*ажилласан сар гэсэн аргачлалаар тооцсон болно.

Сонгинохайрхан	569	8.7	65.4	-8
Нийт/дундаж	3496	47.6	73.4	
Төв аймаг дахь сум дундын шүүх	447	4.9	91.2	+12.6
Өвөрхангай аймаг дахь сум дундын шүүх	174	3	58	-20.6
Нийт/дундаж	621	7.9	78.6	
Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх	33	3.4	9.7	
Нийт/дундаж	33	3.4	9.7	

Судалгаанд хамрагдсан шүүгч нарын гар дээр дунджаар 11 хэрэг ажиллагаанд байна. Мөн шүүгч нараас дээд тал нь хэдэн хэрэг ажиллагаанд байсан талаар асуухад дунджаар 25 хэрэг гэж хариулсан бол ер нь хэдэн хэрэг ажиллагаанд байхад таны ачаалал хэвийн гэж үзэх вэ гэсэн асуултад дунджаар 10 хэрэг гэж хариулсан байна. Үүнээс дүгнэж үзвэл шүүгчид өөрсдийн ачааллыг төдийлөн өндөр байна гэж харахгүй байгааг харуулж байгаа бөгөөд одоо гар дээр ажиллагаанд байгаа хэрэг 11 байх бөгөөд нэг хэргээр цөөрүүлэхэд ачаалал хэвийн байна гэж хариулсан байна. (Хүснэгт №5-аас үзнэ үү)

Хүснэгт №5 Шүүгчийн ажиллагаанд байгаа гар дээрх хэргийн тоо, болон байвал зохих хэргийн тоо

	Одоо ажиллагаанд байгаа хэргийн тоо	Нэгэн зэрэг ажиллагаанд байсан хамгийн их хэргийн тоо	Нэгэн зэрэг ажиллагаанд байвал зохих хэргийн тоо
Дундаж /Mean	13.75	23.91	10.30
Голч /Median	11.00	25.00	10.00

Судалгаанд хамрагдсан шүүгч нар долоо хоногт дунджаар 5 хэрэг, сардаа 16 хэрэг, жилд 80 хэрэг шийддэг гэж хариулжээ. Хэдийгээр шүүгч нар долоо хоногт 5 хэрэг шийддэг гэж өндөр үзүүлэлт хэлж байгаа боловч жилдээ дунджаар 80 хэрэг шийдвэрлэдэг гэж хариулсан нь 7 хоногт байнга таван хэрэг шийддэггүй болохыг харуулж байна.

Хүснэгт №6 Та дараах асуултад ойролцоогоор дунджийг тооцож хариулна уу. 7 хоногт, сард, жилдээ хэдэн хэрэг дээр ажиллаж шийдвэрлэдэг вэ?

	7 хоногт	Сард	Жилд
Дундаж /Mean	5.79	17.18	103.96
Голч /Median	5.00	16.00	80.00


Шүүгч нараас та жилдээ хэдэн хэрэг шийдвэрлэвэл ажлын ачаалал хэвийн гэж үзэх вэ гэсэн асуултад шүүгч нар дунджаар 75 хэрэг байвал ажлын ачаалал хэвийн, боломжийн гэж хариулсан байна. Үүнээс үзвэл шүүгч нарын хариулт Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны 2017 оны дүн мэдээгээр нэг шүүгчид 74 хэрэг ногдож байсан дундажтай ойролцоо байна. Гэхдээ анхаарч үзэх асуудал нь дүүргүүдийн шийдвэрлэж буй эрүүгийн хэргийн тоо нь харилцан адилгүй байгаатай холбоотой байж болох юм. Тухайлбал Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 1 шүүгч жилд 92.4 хэрэг шийдвэрлэсэн статистик байгаа бол Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн шүүгчид жилд 49.6 хэрэг ногдож байгаа нь харилцан адилгүй ачаалалтай байсныг харуулж байна.

Хүснэгт №7 Та нэг шүүгч жилдээ хэдэн хэрэгтэй ажиллавал үндэслэл бүхий, чанартай шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна вэ?

	Нэг шүүгч жилд шийдвэрлэвэл ачаалал хэвийн байх тоо
Дундаж/Mean	87.62
Голч/Median	75.00


Шүүгч нар ачаалалтай ажилладаг эсэхийг хэмжих нэг хэмжүүр нь ажлын цаг бөгөөд шүүгч хуульд заасан чиг үүргээ гүйцэтгэхдээ ажлын 8 цагтаа амжиж байгаа эсэх, аль эсвэл илүү цагаар сууж ажилладаг эсэхийг шүүгч нараас асуухад орон нутаг дахь шүүгч нарын 86.8 хувь нь ажлын өдөр болон амралтын өдөр илүү цагаар ажилладаг гэж хариулсан бол нийслэл дэх шүүгч нарын 83.3 хувь нь ажлын өдөр болон амралтын өдөр илүү цагаар ажилладаг гэж хариулсан байна. Гэтэл бодит байдал дээр орон нутгийн шүүгч нар дүүргийн шүүгч нараас цөөн тооны хэргийг шийдвэрлэдэг байтал орон нутгийн шүүгчид илүү сууж ажилладаг гэж хариулсан байна.

Зураг №4 Та ажлын цагаас гадна амралтын өдрөөр болон ажлын бус цагаар ажилладаг уу?



Шүүгч нараас ажлын ачааллаас үүдэн стресс, ядаргаанд орж байсан эсэх талаар асуухад орон нутаг дахь шүүгчдийн 57.1 хувь нь стресст ордог гэж хариулсан бол нийслэл дэх шүүгчдийн 33.3 хувь нь стресстдэг гэж хариулсан байна.

Зураг №5 Та ажлын ачааллаас үүдэн ямар нэг стресст орж байсан уу?



1.2. Эрүүгийн хэргийн шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй хүчин зүйл

Судалгааны өмнөх хэсэгт шүүгчийн ажлын ерөнхий төлөв байдал, одоо байгаа ажлын ачаалал, байх ёстой норматив ачааллыг шүүгч нараас тодруулж ажлын ачааллыг тандах зорилготой асуулт, судалгааг явуулсан бол энэ хэсэгт шүүгчийн ажлын ачаалал яагаад өндөр байгаа, үүнд нөлөөлөх учир шалтгаан нь юу болох зэрэг хүчин зүйлсийг авч үзсэн болно. 2017 оны байдлаар нийслэлийн 6 дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд 47.6 шүүгчийн орон тоотойгоор, нэг шүүгчид 73.4 хэрэг ногдож ажилласан байх бөгөөд 3496 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэсэн байна. Үүнийг 6 дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нарын 55.6 хувь нь ачаалалтай гэж дүгнэсэн байгаа тул ажлын ачааллыг нэмэгдүүлж байгаа хүчин зүйлсийг авч үзье.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалал жилийн турш ачаалалтай байдаг эсэх, жилийн аль сард өндөр ачаалалтай байдаг талаар асуухад нийт шүүгчдийн 76-80 хувь нь 7 болон 8 дугаар сард ачаалал өндөр байдаг гэж хариулсан байна. Үүний шалтгааныг асуухад 7,8 дугаар сард шүүгч нар амралтаа авдаг, шүүгч нарын тоо цөөрч ажлын ачаалал нэмэгддэг байна.

Зураг №6 Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн ачаалал ихэсдэг сарууд



Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй гол хүчин зүйлд 1-т шүүгчийн орон тооны хүрэлцээгүй байдал гэж нийт судалгаанд оролцсон шүүгчдийн 56 хувь нь хариулсан бөгөөд 2-т шинэ эрүү, зөрчлийн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ажлын ачаалал өндөр байна гэж 44 хувь нь үзсэн байна. 3-т шүүх хурал хойшлох болон шүүхийн тойргийн тогтолцоо хүчингүй болсонтой холбогдон ачаалал нэмэгдсэн, ажлын ачаалалд нөлөөлж байна гэж судалгаанд оролцсон шүүгчдийн 24 хувь нь үзсэн байна. Харин бусад хувьд нь хурлын заалны хүрэлцээ муу, шийтгэх тогтоол бичих хугацаа бага, захиргааны ажилтны орон тоо цөөн, ур чадвар муу, ирж байгаа хэрэг маргааны тоо их зэргээр хариулсан байна.

Шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй хамгийн гол хүчин зүйлийг шүүгчийн орон тоо гэж үзсэн байх бөгөөд шүүгчийн орон тоо өсөх нь өөрт ирэх хэргийн ачааллыг хуваалцдаг учраас хамгийн өндөр хүчин зүйл байх нь тодорхой. Мөн шүүгчийн батлагдсан орон тоондоо хүрч ажиллахгүй байгаа шүүхүүд байна. Тухайлбал шүүгчийн ярилцлагаар:

Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн батлагдсан орон тоо нь 7 байгаа боловч Ерөнхий шүүгч нэг, жирэмсний амралттай нэг шүүгч, нэг шүүгч цагдан хорионы хэргийг шийдвэрлэдэг учраас үндсэн ачаалал 4 шүүгчид л ногдож байгаа юм гэжээ.

2017 оны 7 дугаар сарын 1-ээс эхлэн шинэ Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор шүүхэд хууль хэрэглээний асуудал үүссэн байхыг үгүйсгэхгүй бөгөөд үүнтэй холбоотойгоор шинэ материаллаг болон процессын хуулиа судлах, ойлгох, хэрэглэх хугацаа их шаардагдсанаас ачаалалд нөлөөлсөн хүчин зүйлд орсон байна.

Мөн түүнчлэн анхан шатны шүүхийн эрүүгийн хэргийн шүүх хуралдаан хэд хэдэн үе шаттай болж шүүх хуралдааны тоо өссөн байна. Үүнд: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан урьдчилсан хэлэлцүүлэг явуулах, 34.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Гэм буруугийн талаар маргасан шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцох шүүх хуралдаан хийж зөвлөлдөх тасалгаанд орж гэм буруутай эсэхийг тооцсоны дараа гэм буруутай бол Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэх, гэм буруугүй бол

цагаатгах асуудлыг шийдвэрлэх 2 үе шаттай шүүх хуралдаан хийх, 34 дүгээр зүйлийн 3,4,5 дахь хэсэгт заасныг үндэслэн хохирол төлөх хүсэлтийг үндэслэн шүүх хурлыг 5 хоногоор хойшлуулж хуралдах, цагдан хорио таслан сэргийлэх арга хэмжээний шүүх хуралдаан, шүүхийн өмнөх шатанд шүүхээс авах арга хэмжээг хэрэгжүүлэх шүүх хуралдаан, хялбаршуулсан журмаар хэргийг 72 цагийн дотор шийдвэрлэх шүүх хуралдаан, зөрчил шалган шийдвэрлэх шүүх хуралдаан¹²⁴ гэж хурлын төрөл олширсон нь шүүх хуралдааны тоог нэмэх, үүний улмаас шүүгч, шүүгчийн туслах, нарийн бичгийн ажлын ачаалал нэмэгдэх, шүүх хурлын давтамж олширсноор шүүх хурлын танхимын хүрэлцээ муудах асуудал үүссэн байж болох юм.

Зураг №7 Ажлын ачаалалд нөлөөлж байгаа хүчин зүйлс




Мөн шүүгч нар шүүх хуралдаан хойшлох нь ажлын ачаалалд нөлөөлж байна гэж 24 хувь нь хариулсан бөгөөд шүүх хурал хойшлох нь хурал хойшилсон захирамж гаргах, хурлын тов зарлах, талуудад мэдэгдэх, шүүх хуралдааныг нээхээс хэрэг хэлэлцэж эхлэх хүртэл хурлын процесс ажиллагааг дахин хийх учир ажлын ачааллыг нэмэгдүүлдэг байна.

Улмаар шүүгчийн ажлын ачааллыг бууруулах зорилгоор шүүгчийн туслах руу шилжүүлэх боломжтой техник ажиллагаа байдаг эсэх, хэрэв байдаг бол ямар төрлийн ажиллагааг шүүгчийн туслахаар хийлгэж болох талаар асуухад судалгаанд хамрагдсан шүүгч нарын 33.3 хувь нь шүүгчийн туслахад шилжүүлэх ажил байхгүй гэж хариулсан нь хамгийн өндөр хувь байна. Хоёрдугаарт, шүүгч нарын 13.9 хувь нь эрх зүйн актын төсөл бичих ажлыг шүүгчийн туслахаар

¹²⁴ “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль ба шүүхийн ачаалал, хүндрэл”, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2017 №4, 111 дахь тал.

гүйцэтгүүлэх боломжтой гэж үзсэн бол 8.3 хувь нь хохирлын тооцоолол, эрх үүрэг тайлбарлах ажлыг шүүгчийн туслахаар хийж гүйцэтгүүлэх боломжтой гэж үзэж байна.

Зураг №8 Шүүгчийн өдөр тутмын үйл ажиллагаанаас шүүгчийн туслах руу шилжүүлж болох ажил байдаг уу? хэрэв байдаг бол дурдана уу?



Шүүхийн ерөнхий зөвлөл Шүүхийн захиргааны тухай хуульд заасан чиг үүргийн дагуу шүүгчийн ажлын ачааллыг бууруулах арга хэмжээ авч байгаа эсэх талаар асуухад судалгаанд хамрагдсан эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн 32 хувь нь ажлын ачаалал бууруулах арга хэмжээ авч байгаа гэж хариулсан бол 64 хувь нь ажлын ачаалал бууруулах арга хэмжээ авахгүй байна гэж хариулсан байна.


Зураг №9 ШЕЗ болон тамгын газраас ажлын ачааллыг бууруулах ямар нэг ажлыг зохион байгуулж байсан уу?



Шүүгчийн ажлын ачааллыг бууруулах ямар арга хэмжээ авах шаардлагатай байна вэ? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан шүүгчдийн 47.8 хувь нь буюу хамгийн түрүүнд хийх ёстой ажил бол шүүгчийн орон тоог нэмэх, батлагдсан орон тоондоо хүрч ажиллах гэж үзсэн бол 17.4 хувь нь шүүгчийн туслах, нарийн бичгийн тоог нэмэх, мөн 17.4 хувь нь шүүх хуралдааны танхимын тоог нэмэх гэж хариулсан байна. Бусад саналд шүүгчийн захиргааны ажилтныг чадавхижуулах, ажиллах орчин нөхцөл, цалин хангамжийг сайжруулж тогтвортой ажиллуулах, цагдан хорио

болон зөрчлийн хэрэг шийдвэрлэх шүүгч нарт хэрэг хуваарилах, зарим хэргийг шүүх хурал хийлгүйгээр шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх зэрэг багтаж байна.

Зураг №10 Ажлын ачааллыг бууруулах талаар ямар үйл ажиллагааг явуулах шаардлагатай вэ?



1.3. Эрүүгийн хэрэг шийдвэрлэхэд зарцуулж буй хугацаа

Судалгааны багийн зүгээс шүүгчээс авах судалгааны хэрэглэгдэхүүнийг боловсруулахдаа эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид ирсэн нэг хэрэг шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиар шүүгч ямар ямар ажиллагаануудыг хийж гүйцэтгэх ёстой болохыг шүүх хуралдаанаас өмнө хийгдэх ажиллагаа, шүүх хуралдааны үеэр хийгдэх ажиллагаа болон шүүхийн шийтгэх тогтоол гарсны дараах ажиллагаа гэж гурван бүлэг болгон хуулиар хийж гүйцэтгэх ажиллагаанд зарцуулагдах хугацааг асуусан болно. Ингэхдээ шүүгч нараас эдрээ төвөгтэй хэрэг дээр зарцуулах хугацаа болон хөнгөн, ажиллагаа багатай хэрэг дээр ажиллахад зарцуулах хугацааг тус тусад нь асуусан болно.

Хүснэгт №8 Шүүгчийн ажлын ачаалал тодорхойлох үзүүлэлт /Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх/

Шүүгчийн үйл ажиллагаа	Эдрээ төвөгтэй хэрэг	Хөнгөн хэрэг	Ерөнхий дундаж
	Голч	Голч	
Шүүх хуралдаанаас өмнөх шүүгчийн ажиллагаа			
Таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг шийдвэрлэх	120	30	75
Хэргийн материалтай танилцах, эрүүгийн хэргийг шүүгч хүлээн авах	480	120	300

	Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх/урьдчилсан хэлэлцүүлэг хийх	90	30	60
	Хэргийг прокурорт буцаах	180	60	120
	Хэргийг түдгэлзүүлэх	80	30	55
	Хэргийг харьяалах шүүхэд шилжүүлэх	60	30	45
	Шүүхээс гаргах эрх зүйн акт боловсруулах, хянах, албажуулах	60	60	60
	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хүсэлт, гомдол шийдвэрлэх	180	40	110
	Хэргийн хөдөлгөөний нэгдсэн систем дэх шүүгчийн ажиллагаа	20	10	15
	Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх	60	60	60
	Хэргийн материалтай дахин танилцах, /хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой нотлох баримт хангалттай цугласан эсэхийг шалгах, дүгнэх/	240	120	180
Шүүх хуралдааны үеийн шүүгчийн ажиллагаа				
	Шүүх хуралдааныг даргалах	480	60	270
	Гэрч асуух	40	25	32.5
	Үзлэг хийх	60	30	45
	Шинжээч томилох, шинжээчийн дүгнэлттэй танилцах	60	30	45
	Таньж олуулах ажиллагаа хийх	60	30	45
	Туршилт хийх	45	20	32.5
	Хэргийг шүүх бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэхэд оролцох	300	60	180
	Шүүхийн шийдвэр гаргахаар зөвлөлдөх	180	30	105
	Гэм буруугийн талаар дүгнэлт гаргах	120	30	75
	Эрүүгийн хариуцлага гаргахаар зөвлөлдөх	75	30	52.5
	Шүүх хуралдааныг хойшлуулах	30	15	22.5
	Шүүх хуралдааны шийдвэрийг талуудад танилцуулах	30	18	24
Шүүх хуралдааны дараах шүүгчийн ажиллагаа				
	Шүүх шийтгэх тогтоолыг хянах, албажуулах	480	120	300

Шүүх хуралдааны тэмдэглэлийг хянах, баталгаажуулах	60	30	45
Хэргийн хөдөлгөөний нэгдсэн систем дэх шүүгчийн ажиллагаа	30	30	30
Давж заалдах, хяналтын гомдол хүлээн авах, хэргийн бүрдлийг хянах, холбогдох шүүхэд хэргийг хүргүүлэх	30	30	30
Шүүхийн тогтоол хүчин төгөлдөр болсны дараах ажиллагаа	28	20	24
Ял шийтгэлийн тэмдэглэл хянах	30	20	25
Эд мөрийн баримтыг хянах	30	25	27.5
Мөрдөн шалгах ажиллагааны үе дахь шүүгчийн ажиллагаа	60	45	52.5
Эд хөрөнгө хураах, битүүмжлэх, орлого эд мөрийн баримтыг шийдвэрлэхтэй холбоотой арга хэмжээ	40	30	35
Цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ	60	30	45
Эд мөрийн баримтын талаарх арга хэмжээ	40	30	35
Бусад			
Шүүхийн шийдвэрт гүйцэтгэх хуудас бичих	30	20	25
Шүүгчдийн зөвлөгөөнд орох	90	30	60
Сургалт, хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох	480	60	270
Шүүхийн Ёс зүйн хороонд тайлбар гаргах, хуралдаанд оролцох	120	120	120

Судалгаанд хамрагдсан шүүхүүдийн ажлын байрны зураг авалтад хамрагдсан шүүгч нараас шийдвэрлэсэн нэг хөнгөн хэрэг болон нэг хүнд хэргийг сонгон авч тухайн хэрэг анхан шатны шүүхээр шийдвэрлэгдэх хүртэлх хугацаанд хавтаст хэрэгт цугларсан нотлох баримт, шүүгчийн хийсэн ажиллагаанд дүн шинжилгээ хийсэн болно. Ингэхдээ доорх хүснэгтэд заасан үзүүлэлтээр хавтаст хэргийг задалж дүн шинжилгээ хийсэн бөгөөд үүнээс хөнгөн гэж үзсэн хавтаст хэрэгт дунджаар ямар үзүүлэлтүүд голчилж байгаа, хүнд хэрэгт ямар үзүүлэлтүүд голчилж байгааг судалж, үүний үндсэн дээр нэг дундаж хэрэгт ямар шалгуур үзүүлэлтүүд орж байгаа, тэдгээрийн давтамжийн тоог гаргасан болно.

Дээрх аргачлалын дагуу судалгаа хийхэд нэг эрүүгийн дундаж хэргийн хавтасны тоо 1, эрүүгийн хэрэг үүсгэснээс хойш шүүхийн шийтгэх тогтоол гартал хавтаст хэргийн хуудасны тоо 178, анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол гартал 75 хоног, эзэн холбогдогчдын тоо 1, нотлох баримтын хуудасны тоо 123, оролцсон гэрчийн тоо 4.5, шинжээчийн дүгнэлтийн тоо 2.5, хийгдсэн үзлэгийн тоо 1.5, шүүгчийн гаргасан захирамжийн тоо 4 гэсэн үзүүлэлт гарсан байна.

Хүснэгт №9 Хавтаст хэрэгт хийсэн дүн шинжилгээ

	Хавтасны тоо	Хавтас хэргийн хуудас	Шийдвэрлэсэн хонор	эзэн холбогдогчдын тоо	Сөрөг нэхэмжлэл гаргасан эсэх	Нотлох баримтын хуудасны тоо	Гэрч оролцсон эсэх тоо	Шинжээчийн дүгнэлтийн тоо	Үзлэгийн тоо	Туршилт хийгдсэн тоо	Хойшлогдсон тоо	Хурал	Шүүгчийн захирамжийн тоо
Ээдрээ төвөгтэй	5.5	1141.0	150.0	4.0	0.0	893.0	18.5	21.5	12.0	0.0	2.5		11.5
Хөнгөн	1.0	112.0	52.0	1.0	0.0	95.0	4.0	2.0	2.0	0.0	0.0		4.0
Санамсаргүй	1.0	178.0	115.0	1.0	0.0	142.0	4.0	3.0	2.0	0.0	0.0		4.0
Нийслэл	1.0	178.0	75.0	1.0	0.0	123.0	4.5	2.5	1.5	0.0	0.0		3.0
Орон нутаг	2.0	516.0	147.0	1.0	0.0	373.0	19.0	24.0	8.0	0.0	1.0		26.0
Дундаж	2.0	250.0	77.5	1.0	0.0	186.0	6.0	4.0	2.0	0.0	0.0		3.0

Дээрх аргачлалын дагуу нэг хэргийг шийдэхэд эрүүгийн хэргийн шүүгчийн гүйцэтгэх ажил үүргийн дундаж хугацааг тогтоосон, мөн нэг эрүүгийн дундаж хэрэгт ямар ямар ажиллагааг хийж гүйцэтгэх талаарх хэмжигдэхүүнийг тодорхой болгосон тул эрүүгийн хэргийн 1 шүүгч жилдээ өөрт ногдсон хэргийг шийдвэрлэхэд хэдий хэмжээний хугацаа зарцуулж байгааг тооцоолох боломжтой болж байна.

Судалгаанаас үзвэл 2017 оны байдлаар нийслэлд эрүүгийн хэргийн шүүхийн нэг шүүгчид 73.4 хэрэг ногдож байгаа бөгөөд үүнд зарцуулсан хугацааг тооцоолж гаргалаа. (Хүснэгт №10)

Хүснэгт №10 Нэг дундаж эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд зарцуулах хугацаа

Шүүгчийн хэргийг шийдвэрлэхэд хийх ажиллагаа	Нэг стандарт үйл ажиллагааг гүйцэтгэхэд зарцуулах хугацаа /минутаар/	Давтамжийн тоо	Хугацаа /минутаар/
Хэргийн материалтай танилцах, эрүүгийн хэргийг шүүгч хүлээн авах	300	1	300
Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх/урьдчилсан хэлэлцүүлэг	60	1	60
Шүүхээс гаргах эрх зүйн акт боловсруулах, хянах, албажуулах	60	3	180
Хэргийн материалтай дахин танилцах, /хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой нотлох баримт хангалттай цугласан	180	1	180

	эсэхийг шалгах, дүгнэх/			
	Шүүх хуралдааныг даргалах	270	1	270
	Шүүх шийтгэх тогтоолыг хянах, албажуулах	300	1	300
	Шүүх хуралдааны тэмдэглэлийг хянах, баталгаажуулах	45	1	45
	НИЙТ			1335

Нийслэл дэх 6 дүүргийн нэг эрүүгийн хэргийн шүүгч нэг жилд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулж буй хугацаа=1335 минут (нэг хэргийг шийдвэрлэхэд зарцуулах хугацаа) × 73.4 (нэг эрүүгийн шүүгчид бүтэн жилд ногдож буй эрүүгийн хэрэг) хэрэг =97989 минут:60минут=1633цаг:8 цаг=204 өдөр болж байна. Өөрөөр хэлбэл дүүргийн эрүүгийн хэргийн нэг шүүгч 73.4 хэргийг ажлын 204 өдөрт шийдвэрлэнэ гэсэн тооцоолол гарч байна.

Харин орон нутгийн буюу сум дундын эрүүгийн хэргийн шүүгч нэг жилд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулж буй хугацааг тооцоолбол =1335 минут (нэг хэргийг шийдвэрлэхэд зарцуулах хугацаа) × 65 хэрэг (нэг эрүүгийн шүүгчид бүтэн жилд ногдож буй эрүүгийн хэрэг) хэрэг =86775 минут:60минут=1446 цаг:8 цаг=180.7 өдөр болж байна. Өөрөөр хэлбэл сум дундын эрүүгийн хэргийн нэг шүүгч 65 хэргийг ажлын 180.7 өдөрт шийдвэрлэнэ гэсэн тооцоолол гарч байна.

Сум дундын шүүхийн (Завхан аймгийн Тосонцэнгэл сумын) нэг шүүгч нэг жилд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулж буй хугацаа= 1335 минут (нэг хэргийг шийдвэрлэхэд зарцуулах хугацаа) × 9.7 хэрэг (нэг эрүүгийн шүүгчид бүтэн жилд ногдож буй эрүүгийн хэрэг) =12949минут : 60минут=215.8цаг:8 цаг=26.9 өдөр зарцуулсан байна.

Дээр тооцоолсон хугацаа нь шүүгч өөрт хуваарилагдсан хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой ажлын ачаалал, түүний хугацааг тооцоолсон бол шүүгчийн бусад үйл ажиллагаанд зарцуулах хугацааг мөн тооцоолох шаардлагатай. Тухайлбал: хамтын зарчмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоход зарцуулж буй хугацаа, шүүгчдийн зөвлөгөөнд зарцуулж буй хугацаа, ёс зүйн хороонд гомдлын хэрэг үүссэн бол тайлбар өгөх, хуралдаанд оролцох, шүүгчийн давтан сургалтад зарцуулж буй хугацаа зэргийг нэмж тооцоолох нь зохистой юм.

Бүрэлдэхүүнтэй хэрэг шийдвэрлэхэд зарцуулж буй хугацаа

Улсын хэмжээнд анхан шатны шүүхэд шүүх бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэсэн нийт 2609 шүүх хуралдаанд 2649 иргэдийн төлөөлөгч оролцжээ. Нийт бүрэлдэхүүнтэй шүүх хуралдааны 1506 буюу 57.7 хувь нь эрүүгийн хэргийн шүүхийн шүүх хуралдаан байна. 2017 оны байдлаар улсын хэмжээнд 8839

эрүүгийн хэргийг шийдвэрлэсэн байх бөгөөд үүнээс 3493 хэрэг буюу 39 хувийг судалгаанд хамрагдсан 6 дүүргийн шүүх шийдвэрлэсэн байна. Улсын хэмжээнд анхан шатны шүүхээр 1506 хэрэг шийдвэрлэсний 39 хувь буюу 587 хэргийг нийслэлийн 6 дүүргийн шүүхэд бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэсэн байна. 587 хэргийг бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэхэд нэг шүүгчид ногдож буй хугацааг тооцоолбол : $587(\text{хэрэг}) \times 3 (\text{бүрэлдэхүүн}) \times 180(\text{нэг бүрэлдэхүүнтэй хэрэг шийдвэрлэхэд зарцуулах хугацаа}) = 316980 \text{ минут} : 73.4 (6 \text{ дүүргийн нийт шүүгчдийн тоо}) = 4318 \text{ минут}$ (нэг шүүгч бүрэлдэхүүнтэй хуралд зарцуулах хугацаа): $60 \text{ минут} = 72 \text{ цаг} : 8 \text{ цаг} = 9 \text{ ажлын өдөр}$. Өөрөөр хэлбэл нэг эрүүгийн хэргийн шүүгч жилдээ 9 ажлын өдрийг бүрэлдэхүүнтэй хурал шийдэхэд зарцуулж байна.

Шүүгчдийн зөвлөгөөнд орох: шүүгчдийн зөвлөгөөн долоо хоногт нэг удаа болох бөгөөд жилд 50 долоо хоног байна. Үүнээс шүүгчийн ээлжийн амралттай байх 1 сарын хугацааны зөвлөгөөний тоог хасвал шүүгч жилдээ 46 удаа шүүгчийн зөвлөгөөнд оролцохоор байна. Дүүргийн эрүүгийн хэргийн нэг шүүгч жилдээ зөвлөгөөнд зарцуулж буй цагийг тооцвол $= 60 \text{ минут} \times 46 \text{ удаа} = 2760 \text{ минут} : 60 \text{ минут} = 46 \text{ цаг} : 8 \text{ цаг} = 5.75 \text{ өдөр}$ зарцуулж байна.

Шүүгчийн давтан сургалт, хуульчдын холбооны багц цагт зарцуулж буй хугацааг ажлын 10 өдөр гэж тооцлоо.

Хүснэгт №11 Нийслэлийн 6 дүүргийн эрүүгийн хэргийн нэг шүүгчийн ажлын ачаалал

Шүүгчийн үндсэн үйл ажиллагаа	Дүүргийн эрүүгийн хэргийн шүүгч
73.4 эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд	204 өдөр
Шүүгч бүрэлдэхүүнтэй хуралд ороход	9 өдөр
Шүүгчдийн зөвлөгөөнд ороход	5.75 өдөр
Шүүгч сургалтад хамрагдахад	10 өдөр
Шүүгч ёс зүйн хороонд тайлбар гаргахад	0.5 өдөр
Нийт	229.5 өдөр


Үүнээс үзвэл судалгаанд хамрагдсан 6 зургаан дүүргийн нэг эрүүгийн хэргийн шүүгч 73.4 хэргийг шийдвэрлэхдээ 229.5 өдрийн ачаалалтай ажиллаж байна.

1.4. Эрүүгийн хэргийн шүүгчийн ажлын байрны зураглал

Ажлын байрны зураглалын судалгаа нь тухайн албан тушаалтны ажлын цагийн ашиглалт, үр ашигтай зарцуулалт, ажлын ачаалал, ажлын цагийн алдагдлыг илрүүлэн түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох, хөдөлмөрийн

зохион байгуулалтыг судалж дүгнэх зорилгоор хийгддэг.¹²⁵ Судалгааны хүрээнд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нарын ажлын байран дээрээ гүйцэтгэж буй үндсэн үйл ажиллагаа тус бүр дээр ажлын өдрүүдэд зарцуулж буй хугацааг бүртгэж, үүнд шинжилгээ хийлээ.

Зураг №11 Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн нэг өдрийн ажлын цагийн задаргаа



Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч ажлын 5 өдрийн дунджаар өдрийн ажлын цагийн 22% буюу 120.7 минутыг (2 цаг) хэргийн материалтай танилцах, хавтаст хэрэгт түүвэр хийх, урьдчилсан хэлэлцүүлэг хийх зэрэг ажилд, 36% буюу 199.3 минутыг (3 цаг 19 минут) шүүх хуралдаан даргалах болон шүүх хуралдааны бүрэлдэхүүнд ороход зарцуулдаг бол үүний дараагаар өдрийн ажлын цагийн 34% буюу 190.3 минутыг (3 цаг 10 минут) шийтгэх тогтоол бичих, шүүх хуралдааны тэмдэглэл хянах ажлуудад зарцуулдаг байна. Эндээс Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч шүүх хуралдаанаас өмнөх болон шүүх хуралдааны үеийн үйл ажиллагаанд зарцуулах цаг өдөр тутам өндөр байгааг харж болно.

Хүснэгт №12 Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын байрны зураглал, гарагаар

Шүүгчийн гүйцэтгэх ажил, чиг үүрэг	Даваа гараг	Мягмар гараг	Лхагва гараг	Пүрэв гараг	Баасан гараг	Нийт цаг	1 өдрийн дундаж цаг
Шүүх хуралдаанаас өмнөх шүүгчийн ажиллагаа	197.0	237.0	193.3	129.0	195.3	951.7	190.3
Шүүх хуралдааны үеийн шүүгчийн ажиллагаа	240.7	210.0	241.0	134.7	171.3	997.7	199.5
Шүүх хуралдааны дараах шүүгчийн ажиллагаа	126.3	129.3	113.0	117.0	117.7	603.3	120.7
Бусад	29.3	4.0	17.3	148.0	26.0	224.7	44.9
Нийт /минутаар/	593.3	580.3	564.7	528.7	510.3	2777.3	555.5

¹²⁵ Ажлын байрны зураг авалт хийх зааварчилгаа.

Нийт /цагаар/	9.9	9.7	9.4	8.8	8.5	46.3	9.3
---------------	-----	-----	-----	-----	-----	------	-----

Ажлын байрны зураглал хийгдсэн эхний 7 хоногт Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нар пүрэв гарагт Дээд шүүх дээр хэлэлцүүлэгт хамрагдсан бөгөөд энэ нь пүрэв гарагт бусад ажилд зарцуулсан хугацааг 148 минут (1 цаг 28 минут) зарцуулахад нөлөөлсөн байна.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч долоо хоногийн эхний өдрүүдэд ачаалалтай байгаад долоо хоногийн төгсгөлд хэвийн ачаалалтай болж байна. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч долоо хоногт дунджаар 2400 минут (40 цаг) ажиллах ёстойгоос 2773.3 минут (46.3 цаг) буюу 373.3 минутаар (6.3 цаг) илүү ажиллаж байна. Энэ нь ажлын өдрөөр хийгдсэн ажлын байрны зураг авалтын үр дүн бөгөөд зарим шүүгч нар амралтын өдрийн аль нэгэнд тогтмол ажилладаг талаараа ярилцлагын судалгааны үед онцолж байв. Нэг өдөрт 480 минут (8 цаг) ажиллах ёстойгоос 555.3 минут (9.3 цаг) буюу 175.3 минутаар (1.3 цаг) илүү ажиллаж байна.

ХОЁР.ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН АЖЛЫН АЧААЛАЛ

2.1. Иргэний хэргийн шүүхийн ажлын ачааллын ерөнхий төлөв байдал

Иргэний хэргийн шүүхийн ажлын ачааллын ерөнхий төлөв байдлыг гаргахдаа Шүүхийн ерөнхий зөвлөлийн Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсээс сар бүр гаргадаг “Хэргийн хөдөлгөөний мэдээлэл”, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс хагас жил, бүтэн жилээр гаргадаг “Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны тайлан”-д тулгуурлаж тооцлоо.



Хүснэгт №13 Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хэргийн хөдөлгөөн, 2017 он

Иргэний хэргийн анхан шатны шүүх	Хүлээн авсан	Хянан шийдвэрлэсэн	ХХША-д	Хугацаа хэтэрсэн
Нийслэл дэх Иргэний хэргийн анхан шатны шүүхүүд	2542	1638	3877	667
Орон нутаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүхүүд	2149	1980	2514	67
Нийт	4691	3618	6391	734

Өнгөрсөн 2017 онд Иргэний хэргийн анхан шатны шүүх шинээр 4691 нэхэмжлэл хүлээн авч, 3618 хэргийг хянан шийдвэрлэж, 6391 хэргийн шүүх хуралдаан хойшилсон байна. Харин 734 хэрэг хугацаа хэтэрсэн үзүүлэлттэй байна.

Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 12 дугаар сарын нэгдсэн тайлан мэдээнээс үзвэл Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх 525 нэхэмжлэл хүлээн авсан нь хамгийн өндөр үзүүлэлттэй гарсан байна. Харин Багануур дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх 51 нэхэмжлэл хүлээн авсан нь бусад дүүргүүдтэй харьцуулахад бага үзүүлэлттэй байна. Орон нутаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүхүүдийн хувьд: Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх 249 нэхэмжлэл хүлээн авсан нь хамгийн өндөр үзүүлэлт байна.¹²⁶

Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ачаалал: 2017 онд иргэний хэргийн анхан шатны шүүхэд нийт 87 шүүгч ажилласан бол нэг шүүгчид дунджаар 294.4 хэрэг ногдож байна. /Хүснэгт №2/

Хүснэгт №14 Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн хэргийн ачаалал

Шүүх	Иргэний хэрэг	Шүүгчийн тоо	Нэг шүүгчид ногдох хэргийн тоо
Нийт дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн дундаж	25609	87	294.4
Судалгааны түүвэрт орсон шүүхүүд			
Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	5678	16.8	338.0
Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	4148	12	345.7
Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	3197	12.8	249.8
Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	4346	14.3	303.9
Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	3495	11.5	303.9
Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	3775	11.9	317.2
	24639	79.3	310.7

Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ачаалал: 2017 онд сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд 71.2 шүүгч

¹²⁶ <http://www.judcouncil.mn/main/6777--12-11.html> ШЕЗ-ийн цахим хаяг, 2018.06.01-ний өдөр нэвтрэв.

ажилласан бол нэг шүүгчид дунджаар 244.3 хэрэг ногдож байна. Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгчид 340 хэрэг, Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгчид 301.9 хэрэг ногдож байгаа нь дунджаас харьцангуй их ачаалалтай байна. Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгч дунджаар 104.8 хэрэг, Говь-Алтай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгч дунджаар 167 хэрэг шийдвэрлэсэн нь харьцангуй бага ачаалалтай байгааг харуулж байна.¹²⁷ /Хүснэгт №3/

Хүснэгт №15 Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн хэргийн ачаалал

Шүүх	Иргэний хэрэг	Шүүгчдийн тоо	Нэг шүүгчид ногдох хэргийн тоо
Нийт Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн дундаж	17391	71.2	244.3
Судалгааны түүвэрт орсон шүүхүүд			
Өвөрхангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	761	2.7	281.9
Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1357	4.6	295.0
	2118	7.3	290

Сум дундын шүүх: Сум дундын шүүхийн хувьд 2017 оны байдлаар нийт 26.9 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүгчид дунджаар 111.4 хэрэг ногдож байна. Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүхийн нэг шүүгч дунджаар 160.8 хэрэг, Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн нэг шүүгч дунджаар 134.3 хэрэг шийдвэрлэсэн нь дунджаас дээгүүр байна. Харин Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүхийн нэг шүүгч дунджаар 89.1 хэрэг, Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүхийн нэг шүүгч дунджаар 68.2 хэрэг шийдвэрлэсэн нь дунджаас доогуур¹²⁸ байгааг харуулж байна. /Хүснэгт №4/

Хүснэгт №16 Сум дундын шүүхийн шүүгчийн хэргийн ачаалал

Шүүх	Эрүүгийн хэрэг	Иргэний хэрэг	Нийт хэрэг	Шүүгийн тоо	Нэг шүүгчид ногдох хэргийн тоо
Нийт Сум дундын шүүхийн дундаж	765	2233	2998	26.9	111.4


¹²⁷ Монгол Улсын шүүхийн тайлан 2017 он, Шүүхийн ерөнхий зөвлөл, 2018 он, 271 дахь тал

¹²⁸ Монгол Улсын шүүхийн тайлан 2017 он, Шүүхийн ерөнхий зөвлөл, 2018 он, 272 дахь тал

Судалгааны түүвэрт орсон шүүхүүд					
Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх	33	274	307	3.4	9.7/80.5


Шүүхийн захиргааны тухай хуулийн 7 дугаар зүйлд шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах талаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэн эрхийг тусгаж өгсөн байх бөгөөд үүний 7.1.5-т “шүүгч болон шүүхийн захиргааны захиргааны ажилтны ажлын ачааллыг судалж, холбогдох арга хэмжээ авах” гэж хуульчилж өгсөн байна. Энэ хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн захиалгаар Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх, Хан-Уул, Баянгол, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхүүдэд, орон нутагт Өвөрхангай, Төв аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх, Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхийн шүүгч нарын ажлын ачааллыг судаллаа.

Зураг №12 Судалгаанд хамрагдсан иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн ажиллаж буй шүүх



Судалгаанд хамрагдсан шүүхүүдээс захиалагч байгууллагаас тогтоосон түүврийн дагуу шүүгч нарыг хамруулсан бөгөөд судалгаанд хамрагдсан шүүгч нарын хүйсийн харьцаа, насны бүтцийг (график №2)-оос харна уу.


Зураг №13 Судалгаанд хамрагдсан иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн хүн ам зүйн байдал



Гүйцэтгэгчийн зүгээс судалгааг хийхдээ шүүгч нарын шүүгчээр ажилласан жилийг 5 хүртэл жил ажилласан, 6-10 жил ажилласан, 11-ээс дээш жил ажилласан туршлагатай шүүгч байхаар тооцоолж судалгааг авахыг зорьсон болно. Судалгаанд нийт 25 иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч ганцаарчилсан ярилцлага өгч оролцсон бол 14 шүүгчийн ажлын байрны зураг авалтыг хийсэн байна.

Судалгаанд хамрагдсан шүүгч нараас иргэний хэргийн шүүгчээр ажиллахад ачаалалтай санагддаг эсэх талаар асуухад нийслэлд 95.2 хувь нь, орон нутагт 85.7 хувь нь ачаалалтай гэсэн хариултыг өгсөн байна. Нийслэлийн 6 дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч жилдээ 310 хэрэг шийдвэрлэдэг бол судалгаанд хамрагдсан Өвөрхангай, Төв аймаг дахь сум дундын шүүхийн иргэний хэргийн шүүгч жилд 290 хэрэг шийдвэрлэж байгаа нь дүүргийн шүүгчээс даруй 20 хэргээр цөөн хэрэг шийдвэрлэж байна. Харин Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын нэг шүүгч жилд 80 иргэний хэрэг, 10 эрүүгийн хэрэг шийдвэрлэж байгаа нь дүүргийн шүүгч болон аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээс бага ачаалалтай байгааг харуулж байна. /Хүснэгт №2, 3, 4-ийг үзнэ үү/

Зураг №14 Иргэний хэргийн шүүхийн шүүгчээр ажиллах ачаалалтай санагддаг эсэх



Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдээс Нийслэлийн 6 дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх тайлант хугацаанд нийт 24639 хэрэг шийдвэрлэсэн нь улсын хэмжээнд шийдвэрлэсэн нийт иргэний хэргийн 54.5 хувийг эзэлж байгаа бөгөөд Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 5678 хэрэг

шийдвэрлэсэн нь улсын хэмжээнд шийдвэрлэсэн нийт иргэний хэргийн 12.6 хувийг, Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 4346 хэрэг шийдвэрлэсэн нь улсын хэмжээнд шийдвэрлэсэн нийт иргэний хэргийн 9.6 хувийг тус тус эзэлж байна.¹²⁹

Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх: Тайлант хугацаанд Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд нийт 79.3 шүүгч ажилласан бол нэг шүүгчид дунджаар 310.7 хэрэг ногдож байна.

Хүснэгт №17 Нийслэлийн 6 дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн хэргийн ачаалал 2017 он

Шүүх	Иргэний хэргийн тоо	Шүүгчийн тоо ¹³⁰	Нэг шүүгчид ногдох хэргийн тоо	Өсөлт бууралт
Баянзүрх	5678	16.8	338.0	+28
Сүхбаатар	4148	12	345.7	+35
Чингэлтэй	3197	12.8	249.8	-61
Баянгол	4346	14.3	303.9	-7
Хан-Уул	3495	11.5	303.9	-7
Сонгинохайрхан	3775	11.9	317.2	+7
	24639	79.3	310.7	

Судалгаанд хамрагдсан шүүгч нараас таны гар дээр хэдэн хэрэг ажиллагаанд байгаа талаар асуухад дунджаар 58 хэрэг байлаа. Харин шүүгч нараас дээд тал нь хэдэн хэрэг ажиллагаанд байсан талаар асуухад дунджаар 81 хэрэг гэж хариулсан бол ер нь хэдэн хэрэг ажиллагаанд байхад таны ачаалал хэвийн гэж үзэх вэ гэсэн асуултад дунджаар 35 хэрэг гэж хариулсан байна. Үүнээс дүгнэж үзвэл шүүгчид өөрсдийн ачааллыг өндөр байна гэж үнэлж байгаа нь харагдах бөгөөд одоо ажиллаж байгаа хэргээсээ даруй 23 хэргээр бага байвал ачаалал нь хэвийн болно гэж үзсэн байна.

¹²⁹ Монгол Улсын Шүүхийн шүүн таслах ажиллагааны дүн мэдээ 2017 он, 30 дахь тал

¹³⁰ Тайлбар:Тайлант хугацаанд ажилласан шүүгчдийн тоог тооцохдоо Шүүхийн хүний нөөцийн газраас гаргасан 1-12 саруудын тоон судалгаан дээр үндэслэн гаргасан болно. Тухайлбал Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 1-11 дүгээр саруудад 9 шүүгчтэй, 12 дугаар сард 10 шүүгчтэй ажилласан байна. Эндээс 9 шүүгч нь тайлант хугацаанд бүтэн 12 сар, шинээр томилогдсон 1 шүүгч нь 1 сар ажилласан гэж тооцвол тайлант хугацаанд ажилласан шүүгчдийн дундаж тоо 9.1 байна. Өөрөөр хэлбэл, 1 шүүгч тайлант хугацааны 12 сар бүтэн ажилласан бол "1 бүхэл" гэж тооцогдох бөгөөд шинэ шүүгч томилогдсон тохиолдолд 1/12*ажилласан сар гэсэн аргачлалаар тооцсон болно.

“Гар дээр 20-25 хэрэг байвал хангалттай. Сэтгэл ханамжтай, урам зоригтой ажиллаж болно доо.”

Шүүгчтэй хийсэн ярилцлагаас

Хүснэгт №18 Шүүгчийн ажиллагаанд байгаа гар дээрх хэргийн тоо, болон байвал зохих хэргийн тоо

	Одоо ажиллагаанд байгаа хэргийн тоо	Нэгэн зэрэг ажиллагаанд байсан хамгийн их хэргийн тоо	Нэгэн зэрэг ажиллагаанд байвал зохих хэргийн тоо
Дундаж/Mean	53.30	94.58	36.30
Голч/Median	58.00	81.00	35.00

Судалгаанд хамрагдсан шүүгч нараас та долоо хоногт дунджаар хэдэн хэрэг шийдвэрлэдэг вэ гэсэн асуултад дунджаар 10 хэрэг шийдвэрлэдэг, сардаа 35 хэрэг, жилд 307 хэрэг шийддэг гэж хариулсан байна. Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2 шүүгчийн дунд 1 нарийн бичгийн орон тоо батлагдсан бөгөөд нэг шүүгч ажлын таван өдрийн 2.5 өдөр шүүх хурал хийдэг бол үлдсэн 2.5 өдөрт нь шүүхийн шийдвэр, захирамж бичих, хэргийн материалтай танилцах, шүүх хуралдааны тэмдэглэл хянах зэрэг шүүх хуралдаанаас бусад ажиллагааг хийдэг байна. Үүнээс үзвэл шүүгч 2.5 өдөрт 10 шүүхийн шийдвэр бичих ёстой болж байгаа бөгөөд үүний хажуугаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой бүх ажиллагааг зэрэг хийнэ гэсэн үг юм.

Хүснэгт №19 Та дараах асуултад ойролцоогоор дунджийг тооцож хариулна уу. 7 хоногт, сард, жилдээ хэдэн хэрэг дээр ажиллаж шийдвэрлэдэг вэ?

	7 хоногт	Сард	Жилд
Дундаж/Mean	10.76	39.00	308.00
Голч/Median	10.00	35.00	307.00

Шүүгч нараас та жилдээ хэдэн хэрэг шийдвэрлэвэл ажлын ачаалал хэвийн гэж үзэх вэ гэсэн асуултад шүүгч нар дунджаар 200 хэрэг байвал ажлын ачаалал хэвийн, боломжийн гэж хариулсан байна. Үүнээс Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны 2017 оны дүн мэдээгээр нэг шүүгчид 310 хэрэг ногдож байсан дунджаас даруй 110 хэргээр бага байна. Өөрөөр хэлбэл иргэний шүүгч нар ачаалал их байна гэдгийг үүгээр хэлж байгаа бөгөөд тухайлбал иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч дараах байдлаар өөрсдийн ачааллыг үнэлж байна:

“7 хоногт 3-4 шийдвэр гарч байвал их чанартай гарна. Жилд 150 шийдвэр гэсэн үг.” Шүүгчтэй хийсэн ярилцлагаас

“7 хоногт 3-5 хэрэг шийдвэрлэвэл боломжийн. Ажлын таван өдрийн 2 өдөрт нь өөрийн хурлаа тавьж байна, Шийдвэр бичихэд зарцуулах хугацаа бага байна.” Шүүгчтэй хийсэн ярилцлагаас

Хүснэгт №20 Та нэг шүүгч жилдээ хэдэн хэрэгтэй ажиллавал үндэслэл бүхий, чанартай шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна вэ?


	Нэг шүүгч жилд шийдвэрлэвэл ачаалал хэвийн байх тоо
Хамгийн их давтагдсан утга/Mode	200

Шүүгч нар ачаалалтай ажилладаг эсэхийг хэмжих нэг хэмжүүр нь ажлын цаг бөгөөд шүүгч хуульд заасан чиг үүргээ гүйцэтгэхдээ ажлын 8 цагтаа амжиж байгаа эсэх, аль эсвэл илүү цагаар сууж ажилладаг эсэхийг шүүгч нараас асуухад орон нутаг дахь шүүгч нарын 85.7 хувь нь ажлын өдөр болон амралтын өдөр илүү цагаар ажилладаг гэж хариулсан бол нийслэл дэх шүүгч нарын 95.2 хувь нь ажлын өдөр болон амралтын өдөр илүү цагаар ажилладаг гэж хариулсан байна.

“Ажлын бус цагаар ажилладаг. Олон шалтгаан бий. Өдөржин шүүх хуралд орохоор орой ажил тардаг. Тэгэхээр хэрэгтэй танилцаж амждаггүй учир оройн цагаар суухаас өөр арга байхгүй. Уулзах хүмүүсээ ажлын цагаар дууддаг. Эрх үүргээ тайлбарласаар байтал ихэнх цаг өнгөрдөг. Ард нь хуралд орсон шүүхийн шийдвэр 7 хоногийн дотор гаргаж өгөх ёстой байтал хоцорчихдог. Мөн сургалт семинарт явдаг. Сургалтад явахаас өмнө, сургалтаас ирсний дараа ажил ихэсдэг. Тэрхүү ажлаа ажлын бус цагаар амжуулна. Ээдрээ төвөгтэй хэргийн шүүх хурлыг өмнө нь сууж бэлтгэдэг. Баримтуудаа дахин нягталдаг. Шийдвэр болон бичих ажлаа ихэнхдээ ажлын бус цагаар гүйцэтгэж байна.”

Шүүгчтэй хийсэн ярилцлагаас


Зураг №15 Та ажлын цагаас гадна амралтын өдрөөр болон ажлын бус цагаар ажилладаг уу?



Шүүгч нараас ажлын ачааллаас үүдэн стресс, ядаргаанд орж байсан эсэх талаар асуухад орон нутаг дахь шүүгчдийн 57.1 хувь нь стресст ордог гэж

хариулсан бол нийслэл дэх шүүгчдийн 90.5 хувь нь стресстдэг гэж хариулсан байна.

Зураг №16 Та ажлын ачааллаас үүдэн ямар нэг стресст орж байсан уу?



2.2. Иргэний хэргийн шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй хүчин зүйл

2017 оны байдлаар нийслэлийн 6 дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхүүд 79.3 шүүгчийн орон тоотойгоор, нэг шүүгчид 310.4 хэрэг ногдож ажилласан байх бөгөөд 24639 иргэний хэргийг хянан шийдвэрлэсэн байна. Үүнийг 6 дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нарын 95.2 хувь /График №4/ нь ачаалалтай гэж дүгнэсэн байгаа тул ажлын ачааллыг нэмэгдүүлж байгаа хүчин зүйлсийг авч үзье.

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалал жилийн турш ачаалалтай байдаг эсэх, жилийн аль сард өндөр ачаалалтай байдаг талаар асуухад нийт шүүгчдийн 46-50 хувь нь 5,6,7 дугаар сард, 61-65 хувь нь 9 болон 10 дугаар сард ачаалал өндөр байдаг гэж хариулсан байна. Үүний шалтгааныг асуухад 5 дугаар сараас эхлэн шүүхэд гаргах нэхэмжлэлийн тоо өсдөг, зуны амралт эхэлсэнтэй холбоотойгоор 7 болон 8 дугаар сард нэхэмжлэлийн тоо буурдаг хэдий ч амралт дуусаад 9,10 сард ажлын ачаалал нэмэгддэг гэж хариулсан байна. Мөн 7 болон 8 дугаар сард ажлын ачаалал төдийлөн буурдаггүй өндөр гэж 42-46 хувь нь үзсэн байгаа нь шүүгч нар ээлжийн амралтаа авахад үлдэж байгаа шүүгч нарт нэхэмжлэл хуваарилагддаг учраас ачаалал ихтэй байдаг гэж хариулсан байна.

Зураг №17 Иргэний хэргийн анхан шатны шүүхийн ачаалал ихэсдэг сарууд



Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй гол хүчин зүйлд шүүгчийн орон тоо хүрэлцээгүй, дутуу мөн шүүх хуралдаан их хойшилдог гэж нийт судалгаанд оролцсон шүүгчдийн 42.9 хувь нь хариулсан бөгөөд хоёрдугаарт, шүүгчийн туслах, нарийн бичгийн ур чадвар, тогтворгүй байдал гэж 17.9 хувь нь үзсэн байна. Гуравдугаарт, шүүх хуралдаан хийх заал, танхимын хүрэлцээ муу байна гэж судалгаанд оролцсон шүүгчдийн 14.3 хувь нь үзжээ.

Нийслэлийн 6 дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нийт 78 шүүгч, 6 ерөнхий шүүгчийн орон тоо, нийт 84 шүүгчийн орон тоо батлагдсан байх бөгөөд 2017 оны байдлаар 6 дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд 79 шүүгчийн орон тоотойгоор хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Үүнээс үзвэл шүүгчийн батлагдсан орон тоондоо хүрч ажиллаж чадаагүй, мөн түүнчлэн одоо байгаа орон тоог нэмж батлуулах шаардлагатай гэсэн саналыг гаргасан байна.

Шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй томоохон хүчин зүйл нь шүүх хуралдаан хойшлох бөгөөд анхан шатны шүүхүүдэд 2015 оны 6 дугаар сарын 22-ны байдлаар нийт 22877 шүүх хуралдаан товлогдсоноос 8632 буюу 37.8 хувь нь хойшилсон байна. Үүнээс хэргийн оролцогчийн хүсэлтээр буюу хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хойшилсон шүүх хуралдаан 84 хувийг эзэлж байна¹³¹. Шүүх хуралдаан хойшилж байгаа үндсэн шалтгаан нь хэргийн оролцогчдоос гаргасан хүсэлт байх бөгөөд шүүхээс шалтгаалан хурал хойшлох явдал төдийлөн өндөр хувь эзлэхгүй байна. Хэргийн оролцогчийн хүсэлтэд шинжээч томилуулах, нотлох баримт гаргуулах, өмгөөлөгч авах, өмгөөлөгчийн шүүх хурал давхардсан, нэхэмжлэлийн шаардлага нэмсэн, өөрчилсөн, өмгөөлөгч өвчтэй болон томиллолтоор явсан ирээгүй байгаа гэх шалтгаанууд багтаж байна. Мөн дийлэнх шүүх хурлыг дээрх шалтгаанаар хойшлуулжээ. Шүүх хурлыг хойшлуулах хүсэлт гаргах нь ИХШХШТХ-д заасан зохигч болон хэргийн оролцогчийн эрх боловч нөгөө талаараа эрхийг хангах үүднээс шүүх хурал хойшлох нь шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж байдаг үндсэн шалтгаан болдог байна.

Шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй хоёр дахь том хүчин зүйл нь шүүгчийн туслах, нарийн бичгийн орон тоо болон ур чадвар хангалтгүй байдал гэж шүүгчид хариулжээ. Шүүх эрх мэдлийн байгууллагад өмнө хийгдсэн судалгааны дүнд шүүхийн захиргааны ажилтнууд тогтвор суурьшилгүй байгаа нь ажлын ачаалал нэмэгдүүлэх, ажлын уялдаа холбоог алдагдуулах хандлагатай байгаа ажлын ачаалал нэмэгдүүлэх, ажлын уялдаа холбоог алдагдуулах хандлагатай байна. Шүүхийн захиргааны ажилтнуудын 65 орчим хувь нь 0-3 жил хүртэл ажилладаг гэсэн судалгаа байх бөгөөд үүнээс үзвэл шүүхийн туслах, нарийн бичиг нь тогтвор суурьшилтай ажилладаггүй нь харагдаж байна. Үүний шалтгаан нь ажиллах орчин хангалтгүй түүнчлэн ажлын ачаалалтай дүйцэх хэмжээний цалин хөлс, албан ажилдаа үлдэх хангалттай шалтгаан болохуйц нийгмийн халамж, хангамжийн асуудал юм.

¹³¹ "Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хэргийн хөдөлгөөний төлөв байдал", Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2015 оны №4, 115 дахь тал

Шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй гурав дахь том хүчин зүйл нь шүүх хуралдааны танхимын хүрэлцээний асуудал байна. Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхүүд нь нэг газар байрлаж байгаа бөгөөд 39 шүүгчид 9 хурлын заал ногдож байгаа нь байх ёстой тооноос 4-өөр цөөн байна. Энэ нь хурлын цаг болоход өмнөх хурал тарахгүй байх, хурлын заал олдохгүй байх үндсэн шалтгаан болж байна. Харин Хан-Уул, Сонгинохайрхан, Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд 35 шүүгчид 7 хурлын танхим ногдож байгаа нэг таван шүүгчийн дунд 1 хурлын танхим ногдоно гэсэн үг юм. Харин Шүүхийн ерөнхий зөвлөлийн хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсээс 3 шүүгчийн дунд 1 хурлын танхим байх, 1 хурлын танхимд 2 нарийн бичиг ажиллахаар¹³² зохицуулбал шүүгчийн болон шүүх хуралдааны нарийн бичгийн ажлын ачаалал буурч хэвийн ажиллах боломжтой гэж үзсэн байна.

1-рт. Орон тоог нэмэх.

2-рт. 2 туслахтай болмоор байна. Ядаж 1 туслах, 1 нарийн бичигтэй.

Тухайлбал би 3 жил 10 сар шүүгчээр ажиллахдаа 2231 нэхэмжлэл хүлээн авсан 1356 хэрэг шийдсэн байна.

3-рт. Өрөөндөө ганцаараа суудаг болмоор байна." Шүүгчтэй хийсэн ярилцлагаас

"1-рт. Шүүгчийн орон тоог нэмэх.

2-рт. Туслах нарийн бичгийг чадваржуулах. 1 шүүгчид 1 нарийн

бичигтэй байх хэрэгтэй байна. Мөн хурлын танхим хүрэлцээ

муутай. 40 шүүгчид 9-н заалтай байна.

3-рт. Туслах, нарийн бичгийн ажиллах орчин нөхцөлийг

сайжруулах хэрэгтэй." Шүүгчтэй хийсэн ярилцлагаас

¹³² "Нийслэл дэх дүүргийн иргэний хэргийн анхан шатны зарим шүүх, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, шүүхийн захиргааны ажилтны ажлын ачаалал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс" судалгаа, Шүүх эрх мэдэл сэтгүүл 2015№4, 123 дахь тал.

Зураг №18 Ажлын ачаалалд нөлөөлж байгаа хүчин зүйлс



Улмаар шүүгчийн ажлын ачааллыг бууруулах зорилгоор шүүгчийн туслах руу шилжүүлэх боломжтой техник ажиллагаа байдаг эсэх, хэрэв байдаг бол ямар төрлийн ажиллагааг шүүгчийн туслахаар хийлгэж болох талаар асуухад судалгаанд хамрагдсан шүүгч нарын 24.3 хувь нь шүүгчийн туслахад шилжүүлэх ажил байхгүй гэж хариулсан нь хамгийн өндөр хувь байна. Мөн 24.3 хувь нь эрх зүйн актын төсөл бичих ажлыг шилжүүлэх гэсэн бол Хоёрдугаарт, шүүгч нарын 10.8 хувь нь талуудад эрх үүрэг тайлбарлах ажлыг шилжүүлэх гэсэн бол 8.1 хувь нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан захирамж, 74 дүгээр зүйлд заасан захирамж, мөн хэрэг үүсгэх болон хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх захирамжийг шүүгчийн туслахаар бичүүлэх ажлыг шүүгчийн туслахаар хийж гүйцэтгүүлэх гэж хариулсан байна.

Зураг №19 Шүүгчийн өдөр тутмын үйл ажиллагаанаас шүүгчийн туслах руу шилжүүлж болох ажил байдаг уу? хэрэв байдаг бол дурдана уу?




Шүүхийн ерөнхий зөвлөл Шүүхийн захиргааны тухай хуульд заасан чиг үүргийн дагуу шүүгчийн ажлын ачааллыг бууруулах арга хэмжээ авч байгаа эсэх талаар асуухад эрүүгийн хэргийн анхан шатны судалгаанд хамрагдсан нийт шүүгчдийн 82.3 хувь нь ажлын ачаалал бууруулах арга хэмжээ авч байгаа гэж хариулсан байна.

Зураг №20 Хэрэв тийм бол ШЕЗ болон тамгын газраас ажлын ачааллыг бууруулах ямар нэг ажлыг зохион байгуулж байсан уу?



Шүүгчийн ажлын ачааллыг бууруулах ямар арга хэмжээ авах шаардлагатай байна вэ? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан шүүгчдийн 38.2 хувь нь буюу хамгийн түрүүнд хийх ёстой ажил бол шүүгчийн орон тоог нэмэх, батлагдсан орон тоондоо хүрч ажиллах гэж үзсэн бол 14.5 хувь нь шүүгчийн туслах, нарийн бичгийн тоог нэмэх, тогтвортой ажиллуулах гэсэн бол 10.9 хувь нь шүүх хуралдааны танхимын тоог нэмэх гэж хариулсан байна. Бусад хариултад иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, бүрэлдэхүүнтэй орох хэргийг цөөлөх, туслахуудын ур чадварыг дээшлүүлэх саналууд багтаж байна.

Зураг №21 Ажлын ачааллыг бууруулах талаар ямар үйл ажиллагааг явуулах шаардлагатай вэ?



2.3. Иргэний хэрэг шийдвэрлэхэд зарцуулж буй хугацаа

Судалгааны багийн зүгээс шүүгчээс авах судалгааны хэрэглэгдэхүүнийг боловсруулахдаа эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид ирсэн нэг хэрэг шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл шүүгч ямар ямар ажиллагаануудыг хийж гүйцэтгэх ёстой болохыг шүүх хуралдаанаас өмнө хийгдэх ажиллагаа, шүүх хуралдааны үеэр хийгдэх ажиллагаа болон шүүхийн шийтгэх тогтоол гарсны дараах ажиллагаа гэж гурван бүлэг болгон хуулиар хийж гүйцэтгэх ажиллагаануудыг хийж гүйцэтгэхэд зарцуулагдах хугацааг асуусан болно. Ингэхдээ шүүгч нараас ээдрээ төвөгтэй хэрэг дээр зарцуулах хугацаа болон хөнгөн, ээдрээ төвөг ажиллагаа багатай хэрэг дээр ажиллахад зарцуулах хугацааг тус тусад нь асуусан болно.

Хүснэгт №21 Шүүгчийн ажлын ачаалал тодорхойлох үзүүлэлт /Иргэний хэргийн анхан шатны шүүх/

№	Шүүгчийн гүйцэтгэх ажил, чиг үүрэг	Ачаалал тооцох нэгж /минут/		
		Ээдрээ төвөгтэй хэрэг	Хөнгөн хэрэг	Ерөнхий дундаж
		Голч	Голч	
Шүүх хуралдаанаас өмнөх шүүгчийн ажиллагаа				
1	Хэрэг, нэхэмжлэлтэй танилцах, иргэний хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэх	30	10	20
2	Шүүх хуралдааны бэлтгэл хангах: /хэргийн материалтай танилцах, нотлох баримт судлах/	120	60	90

3	Шүүхээс гаргах эрх зүйн акт боловсруулах, хянах, албажуулах	120	30	75
4	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хүсэлт, гомдол шийдвэрлэх	60	30	45
5	Гэрч асуух	60	30	45
6	Үзлэг хийх	150	50	100
7	Шинжээч томилох, шинжээчийн дүгнэлттэй танилцах	60	30	45
8	Таньж олуулах ажиллагаа хийх,	60	30	45
9	Туршилт хийх	30	30	30
10	Хэргийн хөдөлгөөний нэгдсэн систем дэх шүүгчийн ажиллагаа	55	30	42.5
11	Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх	60	30	45
12	Хэргийн материалтай дахин танилцах, /хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой нотлох баримт хангалттай цугласан эсэхийг шалгах, дүгнэх/	120	60	90
Шүүх хуралдааны үеийн шүүгчийн ажиллагаа				
1	Шүүх хуралдааныг даргалах	240	60	150
2	Шүүх хурлын өмнө гаргасан хүсэлт хэлэлцэх, хүсэлтийг шийдвэрлэх	60	20	40
3	Хэргийг шүүх бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэхэд оролцох	180	60	120
4	Шүүгчийн захирамжид гаргасан гомдлыг хэлэлцэхэд оролцох	60	30	45
5	Шүүхийн шийдвэр гаргахаар зөвлөлдөх	75	30	52.5
6	Шүүх хуралдааныг хойшлуулах	55	23	39
7	Шүүх хуралдааны шийдвэрийг талуудад танилцуулах	25	15	20
Шүүх хуралдааны дараах шүүгчийн ажиллагаа				
1	Шүүхийн шийдвэр боловсруулах, хянах, албажуулах	330	60	195
2	Шүүх хуралдааны тэмдэглэлийг хянах, баталгаажуулах	60	30	45
3	Хэргийн хөдөлгөөний нэгдсэн систем дэх шүүгчийн ажиллагаа	60	33	46.5
4	Давж заалдах, хяналтын гомдол хүлээн авах, холбогдох шүүхэд хэргийг хүргүүлэх	30	30	30
5	Шүүхийн шийдвэрт гүйцэтгэх хуудас бичих	53	23	38
Бусад				

1	Шүүгчдийн зөвлөгөөнд орох	120	60	90
2	Багшлах болон эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх	60	30	
3	Сургалт, хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох	60	0	
4	Шүүхийн Ёс зүйн хороонд тайлбар гаргах, хуралдаанд оролцох	120	60	90

Судалгаанд хамрагдсан шүүхүүдийн ажлын байрны зураг авалтад хамрагдсан шүүгч нараас шийдвэрлэсэн нэг хөнгөн хэрэг болон нэг хүнд хэргийг сонгон авч тухайн хэрэг анхан шатны шүүхээр шийдвэрлэгдэх хүртэлх хугацаанд хавтаст хэрэгт цугларсан нотлох баримт, шүүгчийн хийсэн ажиллагаанд дүн шинжилгээ хийсэн болно. Ингэхдээ доорх хүснэгтэд заасан үзүүлэлтээр хавтаст хэргийг задалж дүн шинжилгээ хийсэн бөгөөд үүнээс хөнгөн гэж үзсэн хавтаст хэрэгт дунджаар ямар үзүүлэлтүүд голчилж байгаа, хүнд хэрэгт ямар үзүүлэлтүүд голчилж байгааг судалж, үүний үндсэн дээр нэг дундаж хэрэгт ямар ямар шалгуур үзүүлэлтүүд орж байгаа, тэдгээрийн давтамжийн тоог гарган ирсэн болно.

Дээрх аргачлалын дагуу судалгаа хийхэд Нийслэлд нэг дундаж иргэний хэргийн хавтасны тоо 1, иргэний хэрэг үүсгэснээс хойш шүүхийн шийдвэр гартал хавтаст хэргийн хуудасны тоо 54, анхан шатны шүүхийн шийдвэр гартал 67 хоног, хэргийн оролцогчдын тоо 2, нотлох баримтын хуудасны тоо 24, хурал хойшилсон тоо 1, шүүгчийн гаргасан захирамжийн тоо 4 гэсэн үзүүлэлт гарсан байна.

Хүснэгт №22 Нэг дундаж иргэний хэргийг шийдвэрлэхэд зарцуулах хугацаа

	Хавтасны тоо	Хавтас хэргийн хуудас	Шийдвэрлэсэн хоног	Эзэн холбогдогчдын тоо	Сөрөг нэхэмжлэл гаргасан эсэх	Нотлох баримтын хуудасны тоо	Гэрч оролцсон эсэх тоо	Шинжээчийн дүгнэлтийн тоо	Үзлэгийн тоо	Туршилт хийгдсэн тоо	Хурал хойшилсон тоо	Шүүгчийн захирамжийн тоо
Ээдрээ төвөгтэй	2.0	304.0	300.0	3.5	0.5	221.0	2.0	0.0	0.0	0.0	6.5	17.0
Хөнгөн	1.0	35.0	43.0	2.0	0.0	13.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	2.0
Санамсаргүй	1.0	129.5	57.5	2.0	0.0	70.0	0.0	0.0	0.0	0.0	0.5	11.5
Нийслэл	1.0	54.0	67.0	2.0	0.0	24.0	0.0	0.0	0.0	0.0	1.0	3.0
Орон нутаг	1.0	229.0	162.5	4.0	0.0	191.0	3.0	0.0	0.0	0.0	0.0	19.0
Дундаж	1.0	126.5	67.0	2.0	0.0	37.0	0.0	0.0	0.0	0.0	1.0	5.0

Дээрх аргачлалын дагуу нэг хэргийг шийдэхэд иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн гүйцэтгэх ажил үүргийн дундаж хугацааг тогтоосон, мөн нэг дундаж иргэний хэрэг маргаанд ямар ямар ажиллагааг хийж гүйцэтгэх талаарх хэмжигдэхүүнийг тодорхой болгосон тул иргэний хэргийн 1 шүүгч жилдээ өөрт ногдсон хэргийг шийдвэрлэхэд хэдий хэмжээний хугацаа зарцуулж байгааг тооцоолох боломжтой болж байна.

Судалгаанаас үзвэл 2017 оны байдлаар нийслэлд иргэний хэргийн шүүхийн нэг шүүгчид 310 хэрэг ногдож байгаа бөгөөд үүнд зарцуулсан хугацааг тооцоолж гаргах боломжтой. Гэхдээ нэг шүүгчид ногдож байгаа 310 хэрэг нь хэргийн жингээрээ ямар төрлийн хэргүүдэд хуваагдаж байгааг ялгаатай тооцох шаардлагатай бөгөөд судалгаа үнэн бодитой гарах нөхцөл бүрдэх юм.

Үүний тулд шүүхээс гарч байгаа шийдвэрийн хэдэн хувь нь хялбаршуулсан журмаар шийдвэрлэдэг, хэдийн хувийг нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэдэг, хэдэн хувьд нь талууд мэтгэлцэж шийдвэр гардаг талаарх статистик судалж үзэхэд 2015, 2016, 2017 оны Монгол Улсын хэмжээнд иргэний хэргийн анхан шатны шүүхээс нийт шийдвэрлэсэн хэрэг маргааны 33.2 хувийг хялбаршуулсан журмаар буюу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн /ИХШХШТХ/ 74 дүгээр зүйлээр, 53.6 хувьд нь талууд мэтгэлцэж буюу ИХШХШ тухай хуулийн 115 дугаар зүйлээр шийдвэрлэсэн байх бол нийт хэргийн 13.2 хувьд нь иргэний хэргийг хэрэгсэхгүй болгож буюу ИХШХШ тухай хуулийн 117 дугаар зүйлээр шийдвэрлэсэн байна.

Хүснэгт №23 Монгол Улсын хэмжээнд иргэний хэргийг шийдвэрлэсэн байдал

Шийдвэрлэсэн бүх иргэний хэрэг	2015 он		2016 он		2017 он		3 жилийн дунджаар		
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь			
	40674	100.0%	46173	100.0%	45233	100.0%		100.0%	
Үүнээс	Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэрэг /ИХШХШТХуулийн 74-р зүйл/		13972	34.4%	16204	35.1%	13612	30.1%	33.2%
	ИХШХШТХ-ийн 115-р зүйлээр шийдвэрлэсэн		21521	52.9%	23569	51.1%	25659	56.7%	53.6%
	Хэргийг хэрэгсэхгүй болгосон /ИХШХШТ хуулийн 117-р зүйл/		5181	12.7%	6400	13.8%	5962	13.2%	13.2%

Дээр дурдсан статистикаас үзвэл нийслэлийн 6 дүүргийн 1 иргэний шүүгч жилд дунджаар 310 хэрэг шийдвэрлэж байгаагийн 33.2 хувь буюу 102.9 хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн, 53.6 хувь буюу 166.1 хэргийг ИХШХШТХ-ийн 115 дугаар зүйлээр, 13.2 хувь буюу 40.9 хэргийг ИХШХШТХ-ийн 117 дугаар зүйлээр шийдвэрлэсэн гэж үзвэл дараах аргачлалын дагуу тооцоолол хийхээр байна.

Нийслэлд нэг дундаж иргэний хэргийн хавтасны тоо 1, иргэний хэрэг үүсгэснээс хойш шүүхийн шийдвэр гартал хавтаст хэргийн хуудасны тоо 54, анхан шатны шүүхийн шийдвэр гартал 67 хоног, хэргийн оролцогчдын тоо 2, нотлох баримтын хуудасны тоо 24, хурал хойшилсон тоо 1, шүүгчийн гаргасан захирамжийн тоо 4 гэсэн үзүүлэлтээр тооцож байгаа бөгөөд 116.1 хэргийг энэ үзүүлэлтээр тооцоолох юм. (Хүснэгт№23)

Хүснэгт №24 Нэг дундаж иргэний хэргийг шийдвэрлэхэд зарцуулах хугацаа буюу ИХШХШТХ-ийн 115 дугаар зүйлээр шийдвэрлэх хэрэг

	Шүүгчийн хэргийг шийдвэрлэхэд хийх ажиллагаа	Нэг стандарт үйл ажиллагааг гүйцэтгэхэд зарцуулах хугацаа /минутаар/	Давтамжийн тоо	Хугацаа /минутаар/
1	Хэрэг, нэхэмжлэлтэй танилцах, иргэний хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэх	20	1	20
2	Шүүхээс гаргах эрх зүйн акт боловсруулах, хянах, албажуулах	10/75	2/1	20+75
3	Хэргийн материалтай дахин танилцах, /хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой нотлох баримт хангалттай цугласан эсэхийг шалгах, дүгнэх/	90	1	90
4	Шүүх хуралдааныг даргалах	150	1	150
5	Шүүх хуралдааныг хойшлуулах	39	1	39
6	Шүүхийн шийдвэр боловсруулах, хянах, албажуулах	195	1	195
7	Шүүх хуралдааны тэмдэглэлийг хянах, баталгаажуулах	45	1	45
				634 минут

Дүүргийн нэг иргэний хэргийн шүүгч нэг жилд ИХШХШТХ-ийн 115 дугаар зүйлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулж буй хугацаа= 634 минут (ИХШХШТХ-ийн 115-аар нэг хэргийг шийдэхэд зарцуулах хугацаа) × 166.1 хэрэг (нэг жилд нийт ИХШХШТХ-ийн 115-аар шийдвэрлэсэн хэргийн тоо) =105307 минут:60минут=1755 цаг:8 цаг=219 өдөр зарцуулсан байна.

Дээрх тооцоолол нь 166 хэргийг шүүгч ИХШХШТХ-ийн 115 дугаар зүйлээр шийдвэрлэхэд зарцуулсан ажлын өдрийг тооцоолсон бол ИХШХШТХ-ийн 74 дүгээр зүйл болон 117 дугаар зүйлээр шийдвэрлэсэн нийт 144 хэргийг шийдвэрлэхэд зарцуулах хугацааг тооцоолох шаардлагатай байна. Үүний тулд эдгээр хэргийг шүүгч шийдвэрлэхэд харьцангуй хугацаа бага зарцуулна гэж тооцоод хөнгөн

хэргийг шийдвэрлэхэд шүүгчийн хийгдэх ажиллагааны дундаж болон түүнд зарцуулах дундаж хугацааг тооцоолох замаар хугацааг тооцно.

Нийслэлд нэг хөнгөн иргэний хэргийн хавтасны тоо 1, иргэний хэрэг үүсгэснээс хойш шүүхийн шийдвэр гартал хавтаст хэргийн хуудасны тоо 35, анхан шатны шүүхийн шийдвэр гартал 43 хоног, хэргийн оролцогчдын тоо 2, нотлох баримтын хуудасны тоо 13, шүүгчийн гаргасан захирамжийн тоо 2 гэсэн үзүүлэлт гарч байна.

Хүснэгт №25 ИХШХШТХ-ийн 74, 117 дугаар зүйлээр шийдвэрлэх хэрэг

	Шүүгчийн хэргийг шийдвэрлэхэд хийх ажиллагаа	Нэг стандарт үйл ажиллагааг гүйцэтгэхэд зарцуулах хугацаа /минутаар/	Давтамжийн тоо	Хугацаа /минутаар/
1	Хэрэг, нэхэмжлэлтэй танилцах, иргэний хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэх	10	1	10
2	Шүүхээс гаргах эрх зүйн акт боловсруулах, хянах, албажуулах	10/	2	20
3	Хэргийн материалтай дахин танилцах, /хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой нотлох баримт хангалттай цугласан эсэхийг шалгах, дүгнэх/	60	1	60
4	Шүүх хуралдааныг даргалах	30	1	30
5	Шүүхийн шийдвэр боловсруулах, хянах, албажуулах	60	1	60
6	Шүүх хуралдааны тэмдэглэлийг хянах, баталгаажуулах	30	1	30
				210 минут

Дүүргийн нэг иргэний хэргийн шүүгч нэг жилд ИХШХШТХ-ийн 74,117 дугаар зүйлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулж буй хугацаа= 210 минут (ИХШХШТХ-ийн 74 болон 117 дугаар зүйлээр нэг хэргийг шийдэхэд зарцуулах хугацаа) × 144 хэрэг (нэг жилд нийт ИХШХШТХ-ийн 74,117-аар шийдвэрлэсэн хэргийн тоо) =30240 минут:60минут=504 цаг:8 цаг=63 өдөр зарцуулсан байна. Нийслэлийн 6 дүүрэг дэх нэг иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч өөрт ногдож байгаа 310 хэргийг нийт 282 (219 өдөр +63 өдөр) ажлын өдөр хянан шийдвэрлэх тооцоо гарч байна.

Дээрх аргачлалын дагуу орон нутаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачааллыг тооцвол нэг шүүгч жилдээ 290 иргэний хэрэг шийдвэрлэсэн байх бөгөөд үүнээс 155.4 хэрэг буюу 53.6 хувийг нь

ИХШХШТХ-ийн 115 дугаар зүйлээр мэтгэлцүүлж, 134.4 хэргийг буюу 46.4 хувийг нь ИХШХШТХ-ийн 74, 117 дугаар зүйлээр хянан шийдвэрлэдэг байна.

Орон нутгийн нэг иргэний хэргийн шүүгч нэг жилд ИХШХШТХ-ийн 115 дугаар зүйлээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулж буй хугацаа= 634 минут (ИХШХШТХ-ийн 115-аар нэг хэргийг шийдэхэд зарцуулах хугацаа) \times 155.4 хэрэг (нэг жилд нийт ИХШХШТХ-ийн 115-аар шийдвэрлэсэн хэргийн тоо) =98253минут : 60минут=1642 цаг:8 цаг=208 өдөр зарцуулсан байна.

Орон нутгийн нэг иргэний хэргийн шүүгч нэг жилд ИХШХШТХ-ийн 74,117 дугаар зүйлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулж буй хугацаа= 210 минут (ИХШХШТХ-ийн 74 болон 117 дугаар зүйлээр нэг хэргийг шийдэхэд зарцуулах хугацаа) \times 134.4 хэрэг (нэг жилд нийт ИХШХШТХ-ийн 74,117-аар шийдвэрлэсэн хэргийн тоо) =28224 минут:60минут=470.4 цаг:8 цаг=58.8 өдөр зарцуулсан байна. Үүнээс дүгнэж үзвэл орон нутаг дах сум дундын иргэний хэргийн анхан шатны нэг шүүгч өөрт ногдож буй 290 хэргийг 266 (208 өдөр + 58 өдөр) ажлын өдөр шийдвэрлэж байна гэсэн үг юм.

Харин Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын нэг шүүгчийн ажлын ачааллыг тооцвол нэг шүүгч жилд 80.5 иргэний хэрэг ногдож байгаа бөгөөд үүнийг өмнө бодсон аргачлалын дагуу бодож үзье.

Сум дундын шүүхийн нэг шүүгч нэг жилд ИХШХШТХ-ийн 115 дугаар зүйлээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулж буй хугацаа= 634 минут (ИХШХШТХ-ийн 115-аар нэг хэргийг шийдэхэд зарцуулах хугацаа) \times 43.1 хэрэг (нэг жилд нийт ИХШХШТХ-ийн 115-аар шийдвэрлэсэн хэргийн тоо) =27325минут : 60минут=455.4 цаг:8 цаг=56.9 өдөр зарцуулсан байна.

Сум дундын шүүхийн нэг шүүгч нэг жилд ИХШХШТХ-ийн 74,117 дугаар зүйлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулж буй хугацаа= 210 минут (ИХШХШТХ-ийн 74 болон 117 дугаар зүйлээр нэг хэргийг шийдэхэд зарцуулах хугацаа) \times 37.4 хэрэг (нэг жилд нийт ИХШХШТХ-ийн 74,117-аар шийдвэрлэсэн хэргийн тоо)=7854 минут:60минут=130.9 цаг:8 цаг=16.3 өдөр зарцуулсан байна. Үүнээс дүгнэж үзвэл сум дундын нэг шүүгч өөрт ногдож буй 80.5 иргэний хэргийг 73 (56.9 өдөр + 16.3 өдөр) ажлын өдөр шийдвэрлэж байна гэсэн үг юм. Гэхдээ сум дундын шүүхийн шүүгч нь иргэний хэргийг шийдвэрлэхээс гадна эрүүгийн хэрэг шийдвэрлэдэг тул эрүүгийн хэрэг шийдвэрлэхэд зарцуулж буй хугацааг нэмж тооцоолох шаардлагатай.

Дээр тооцоолсон хугацаа нь шүүгч өөрт хуваарилагдсан хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой ажлын ачаалал, түүний хугацааг тооцоолсон бол шүүгчийн бусад үйл ажиллагаанд зарцуулах хугацааг мөн тооцоолох шаардлагатай. Тухайлбал: хамтын зарчмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоход зарцуулж буй хугацаа, шүүгчдийн зөвлөгөөнд зарцуулж буй хугацаа, ёс зүйн хороонд гомдлын хэрэг үүссэн бол тайлбар өгөх, хуралдаанд оролцох, шүүгчийн давтан сургалтад зарцуулж буй хугацаа,

Бүрэлдэхүүнтэй хэрэг шийдвэрлэхэд зарцуулж буй хугацаа: Шүүгчтэй хийсэн ярилцлагаас үзвэл нэг шүүгч сард 9 бүрэлдэхүүнтэй хэрэгт ордог байна. Жилийн 12 сараас шүүгчийн ээлжийн амралттай байх хугацааны 1 сар, нийтээр амрах баяр ёслолын өдөр, сургалттай байх, чөлөөтэй байх хугацааны 1сарын хугацаанд бүрэлдэхүүнтэй хуралд оролцохгүй гэж үзвэл шүүгч жилдээ 9 хэрэг×10сар буюу 90 удаа бүрэлдэхүүнтэй хуралд ордог байна. Үүнээс 66 хувь¹³³ буюу 60 хэргийн шүүх хуралдаан нь хойшилдог бөгөөд үлдсэн 30 хэргийг нь эцэслэн шийдвэрлэдэг гэж үзвэл. Нэг шүүгчид ногдож буй хугацааг тооцоолбол: 60(хэрэг)×39(хойшилж буй бүрэлдэхүүнтэй хэрэг шийдвэрлэхэд зарцуулах хугацаа)+30(хэрэг)×150минут=6840 минут:60минут=114 цаг:8цаг=14 ажлын өдөр. Өөрөөр хэлбэл нэг иргэний хэргийн шүүгч жилдээ 14 ажлын өдрийг бүрэлдэхүүнтэй хурал шийдэхэд зарцуулж байна.

Гомдлын хуралд ороход зарцуулж буй хугацаа: Шүүгчтэй хийсэн ярилцлагаас үзвэл нэг шүүгч сард 9 удаа ИХШХШТХ-ийн 170 дугаар зүйлд заасан гомдлын хуралд бүрэлдэхүүнтэй оролцдог байна. Жилийн 12 сараас шүүгчийн ээлжийн амралттай байх хугацааны 1 сар, нийтээр амрах баяр ёслолын өдөр, сургалттай байх, чөлөөтэй байх хугацааны 1сарын хугацаанд бүрэлдэхүүнтэй хуралд оролцохгүй гэж үзвэл шүүгч жилдээ 9 гомдлын хурал×10сар буюу 90 удаа гомдлын хуралд ордог байна. Нэг шүүгчид ногдож буй хугацааг тооцоолбол: 90(гомдлын хурал)×45(гомдол шийдвэрлэхэд зарцуулах хугацаа)=4050 минут:60минут=67.5цаг:8цаг=8ажлын өдөр. Өөрөөр хэлбэл нэг иргэний хэргийн шүүгч жилдээ 8 ажлын өдрийг бүрэлдэхүүнтэй хурал шийдэхэд зарцуулж байна.

Шүүгчдийн зөвлөгөөнд орох: шүүгчдийн зөвлөгөөн долоо хоногт нэг удаа болох бөгөөд жилд 50 долоо хоног байна. Үүнээс шүүгчийн ээлжийн амралттай байх 1, нийтээр амрах баяр ёслолын өдөр, сургалттай байх, чөлөөтэй байх хугацааны 1сарын хугацаанд зөвлөгөөнд оролцохгүй гэж үзвэл шүүгч жилдээ 42 удаа шүүгчийн зөвлөгөөнд оролцохоор байна. Дүүргийн иргэний хэргийн нэг шүүгч жилдээ зөвлөгөөнд зарцуулж буй цагийг тооцвол=90 минут ×42 удаа=3780 минут :60 минут=63 цаг:8 цаг =7.8 өдөр зарцуулж байна.

Шүүгчийн давтан сургалт, хуульчдын холбооны багц цагт зарцуулж буй хугацааг ажлын 10 өдөр гэж тооцлоо.

Хүснэгт №26 Нийслэлийн 6 дүүргийн иргэний хэргийн нэг шүүгчийн ажлын ачаалал

Шүүгчийн хийх ажил	Дүүргийн эрүүгийн хэргийн шүүгч
310 иргэний хэргийг	282 өдөр
Шүүгч бүрэлдэхүүнтэй хуралд	14 өдөр
Гомдлын хуралд	8 өдөр

¹³³ Иргэний хэргийн шүүх хурал 66 хувьтай хойшилдог


Шүүгчдийн зөвлөгөөнд	7.8 өдөр
Шүүгч сургалтад	10 өдөр
Шүүгч ёс зүйн хороонд	1.2 өдөр
Нийт	323 өдөр

Үүнээс үзвэл судалгаанд хамрагдсан 6 дүүргийн нэг иргэний хэргийн шүүгч 310 хэргийг шийдвэрлэхдээ 315 өдрийн ачаалалтай ажиллаж байна.

Нэг шүүгч жилд 230 өдөр ажилладаг гэж тооцвол: $323\text{өдөр} - 230\text{өдөр} = 93$ өдөр илүү ажилладаг гэсэн тооцоолол гарч байна. Судалгааны хүрээнд хийгдсэн ажлын байрны зураг авалтаар нийслэлийн 6 дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нэг ажлын өдөрт 90 минутаар сунаж ажилладаг гэсэн үр дүн гарсан байх бөгөөд $230\text{ ажлын өдөр} \times 90\text{ минут} = 20700\text{ минут}$; $60\text{ минут} = 345$ цаг; $8 = 43$ өдөр болж байна. Энэ нь шүүгч нэг жилд илүү цагаар ажилласан хугацаа нь 43 ажлын өдөр болж байна.

$93\text{ өдөр} - 43\text{ өдөр} = 50$ өдөр үлдэж байгаа бөгөөд нийслэлийн 6 дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн 95.2 хувь нь амралтын аль нэг өдөр сууж ажилладаг гэж хариулсанаас үзвэл жилд 52 долоо хоног байгаа бөгөөд үүнээс аль нэг амралтын өдөр нь сууж ажилладаг гэж үзвэл илүү гарч буй 50 өдөр нь амралтын өдөр ажилладаг байж болохоор байна.


Зураг №22 Шүүгчийн ажлын ачаалал, шүүхийн шийдвэрийн чанарт нөлөөлөх эсэх



2.4. Иргэний хэргийн шүүгчийн ажлын байрны зураглал

Судалгааны хүрээнд Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нарын ажлын байран дээрээ гүйцэтгэж буй үндсэн үйл ажиллагаа тус бүр дээр ажлын өдрүүдэд зарцуулж буй хугацааг бүртгэж, үүнд шинжилгээ хийлээ.

Зураг №23 Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн нэг өдрийн ажлын цагийн задаргаа



Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч ажлын 5 өдрийн дунджаар өдрийн ажлын цагийн 24% буюу 134.9 минутыг (2 цаг 14 минут) хавтаст хэрэгтэй танилцах, шүүхээс гарах эрх зүйн акт боловсруулах зэрэг ажилд, 33% буюу 188.2 минутыг (3 цаг 8 минут) шүүх хуралдаан даргалах болон шүүх хуралдааны бүрэлдэхүүнд ороход зарцуулдаг бол үүний дараагаар өдрийн ажлын цагийн 18% буюу 100.9 минутыг (1 цаг 40 минут) шүүхийн шийдвэр боловсруулах, хянах, албажуулах, шүүх хуралдааны тэмдэглэл хянах, баталгаажуулах ажлуудад зарцуулдаг байна. Эндээс Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч шүүх хуралдаанаас өмнөх болон шүүх хуралдааны үеийн үйл ажиллагаанд цаг хугацаа их зарцуулж буйг харж болно.

Хүснэгт №27 Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын байрны зураглал, гарагаар

Шүүгчийн гүйцэтгэх ажил, чиг үүрэг	Даваа гараг	Мягмар гараг	Лхагва гараг	Пүрэв гараг	Баасан гараг	Нийт цаг	1 өдрийн дундаж цаг
Шүүх хуралдаанаас өмнөх шүүгчийн ажиллагаа	219.6	179.6	97.1	84.6	93.6	674.6	134.9
Шүүх хуралдааны үеийн шүүгчийн ажиллагаа	115.4	148.2	440.1	153.6	83.6	940.8	188.2
Шүүх хуралдааны дараах шүүгчийн ажиллагаа	171.8	123.9	65.7	66.8	76.1	504.3	100.9
Бусад	132.1	108.6	170.4	102.9	212.1	726.1	145.2
Нийт /минутаар/	638.9	560.4	773.3	407.9	465.4	2845.8	569.2
Нийт /цагаар/	10.6	9.3	12.9	6.8	7.8	47.4	9.5

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч шүүгч долоо хоногт дунджаар 2400 минут (40 цаг) ажиллах ёстойгоос 2845.8 минут (47.4 цаг) буюу 445.8 минутаар (7.4 цаг) илүү ажиллаж байна. Энэ нь ажлын өдрөөр хийгдсэн ажлын байрны зураг авалтын үр дүн бөгөөд зарим шүүгч нар амралтын өдрийн аль

нэгэнд тогтмол ажиллаж шийдвэр бичих, хавтаст хэрэгтэй танилцах ажлуудыг хийдэг талаараа ганцаарчилсан ярилцлагын үеэр дурдаж байсан. Шүүгч өдөрт 480 минут (8 цаг) ажиллахаас 569.2 минут (9.5 цаг) буюу 89.2 минутаар (1 цаг 29 минут) илүү ажиллаж байна.

ГУРАВ.ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН АЖЛЫН АЧААЛАЛ

3.1. Захиргааны хэргийн шүүхийн ажлын ачааллын ерөнхий төлөв байдал

Захиргааны хэргийн шүүхийн ажлын ачааллын ерөнхий төлөв байдлыг гаргахдаа Шүүхийн ерөнхий зөвлөлийн Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсээс сар бүр гаргадаг “Хэргийн хөдөлгөөний мэдээлэл”, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс хагас жил, бүтэн жилээр гаргадаг “Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны тайлан”-г голлох эх сурвалж болгон судалгаанд ашиглалаа.

Хүснэгт №28 Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хэргийн хөдөлгөөн, 2017 он

Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Хүлээн авсан	Хянан шийдвэрлэсэн	ХХША-д	Хугацаа хэтэрсэн
Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх	151	101	399	85
Орон нутаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхүүд	66	69	171	13
Нийт	217	170	570	98

Өнгөрсөн 2017 онд Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд шинээр 217 нэхэмжлэл хүлээн авч, 170 хэргийн хянан шийдвэрлэж, 570 хэрэгт шүүх хуралдаан хойшилсон байна. Харин 98 хэрэгт хугацаа хэтэрсэн гэсэн үзүүлэлттэй байна. Хугацаа хэтэрсэн хэргийн 85 буюу 86,7%-нь Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт байна.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ачаалал: Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 2017 онд нийт 75.5 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүгчид 25.3 хэрэг ногдож байна. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд (Улаанбаатар) нэг шүүгчид 50.5 хэрэг ногдож байгаа нь дунджаас 2 дахин их хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 28 хэрэг ногдож байгаа нь захиргааны хэргийн орон нутгийн шүүхүүдээс хамгийн өндөр нь байгаа бол Хэнтий аймаг дахь


Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгчид 7.8 хэрэг ногдож байгаа нь хамгийн бага байна.¹³⁴ /Хүснэгт №2/

Хүснэгт №29 Судалгаанд хамрагдсан захиргааны хэргийн анхан шатны шүүх шүүгчийн хэргийн ачаалал

Шүүх	Шүүгчдийн тоо	Захиргааны хэрэг	Нэг шүүгчид ногдох хэргийн тоо
Нийт захиргааны хэргийн анхан шатны шүүхийн дундаж	75.5	1908	25.3
Судалгааны түүвэрт орсон шүүхүүд			
Өвөрхангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	3	27	9.0
Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	3	47	15.7
Нийслэл Захиргааны хэргийн анхан шатны шүүх	21	1060	50.5

Дээрх хүснэгтээс үзэхэд Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид улсын дунджаас 1 дахин их хэрэг шийдвэрлэдэг ба судалгааны түүврийн дагуу сонгосон шүүхийн шүүгчдээс 3 дахин олон тооны хэрэг шийддэг болох нь харагдаж байна. Ингээд судалгаанд хамрагдсан шүүхийн шүүгчдээс авсан санал асуулгын үр дүнг дор товч хүргэе.

Зураг №24 Судалгаанд хамрагдсан захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн ажиллаж буй шүүх



¹³⁴ Монгол Улсын шүүхийн тайлан 2017 он, Шүүхийн ерөнхий зөвлөл, 2018 он, 273 дахь тал

Судалгаанд хамрагдсан шүүхүүдээс захиалагч байгууллагаас тогтоосон түүврийн дагуу шүүгч нарыг хамруулсан бөгөөд судалгаанд хамрагдсан шүүгч нарын хүйсийн харьцаа, насны бүтцийг (график №2)-оос харна уу.


Зураг №25 Судалгаанд хамрагдсан захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн хүн ам зүйн байдал



Судалгааны багийн зүгээс судалгааг гүйцэтгэхдээ шүүгч нарын ажилласан жилийн түүврийг авахдаа 5 хүртэл жил ажилласан, 6-10 жил ажилласан, 11-ээс дээш жил ажилласан туршлагатай гэсэн шалгуур үзүүлэлтийг баримтлан судалгааг авсан болно. Судалгаанд захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нийт 10 шүүгчээс ганцаарчилсан ярилцлага авсан бол 5 шүүгчид ажлын байрны зураг авалтыг ажлын 5 өдрийн турш хийсэн байна.

Судалгаанд хамрагдсан шүүгч нараас шүүгчээр ажиллахад ачаалалтай санагддаг эсэх талаар асуухад нийслэлд 83.3 хувь нь, орон нутагт 50 хувь нь ачаалалтай гэсэн хариултыг өгсөн байна. Үүнээс үзэхэд орон нутгийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн 50 хувь нь ачаалалтай ажилладаг гэж хариулсан боловч улсын дундаж хэргийн ачаалалтай харьцуулахад 2 дахин бага хэрэг шийдэж байгаа нь харагдаж байна.

Зураг №26 Захиргааны хэргийн шүүхийн шүүгчээр ажиллах ачаалалтай санагддаг эсэх



Монгол улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны 2017 оны дүн мэдээнээс үзвэл Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх 1060 хэрэг

шийдвэрлэсэн нь нийт шийдвэрлэсэн хэргийн 55.6 хувь бөгөөд нэг шүүгчид 50.5 хэрэг ногдохоор байна.

Харин судалгаанд хамрагдсан орон нутаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхүүд болох Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 47 хэрэг буюу нэг шүүгч 15.6 хэрэг дунджаар шийдвэрлэсэн бол Өвөрхангай аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 27 хэрэг буюу нэг шүүгч 9 хэрэг шийдвэрлэсэн үзүүлэлттэй байна.¹³⁵

Үүнээс үзэхэд судалгаанд хамрагдсан орон нутгийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн ажлын ачааллыг Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхтэй харьцуулахад 3 дахин ачаалал багатай ажилладаг болох нь харагдаж байна.

Хүснэгт №30 Судалгаанд хамрагдсан Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн хэргийн ачаалал, 2017 он¹³⁶

Шүүхийн нэр	Захиргааны хэргийн тоо	Шүүгчийн тоо	Нэг шүүгчид ногдох хэргийн тоо
Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх	1060	21	50.5
Төв аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүх	47	3	15.66
Өвөрхангай аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүх	27	3	9

Судалгааны багийн зүгээс судалгаанд хамрагдсан шүүгчдээс нэгж хугацаанд хэдэн хэрэг дээр зэрэг ажиллаж байгааг тодруулах зорилгоор “таны гар дээр хэдэн хэрэг ажиллагаанд байгаа вэ ?” гэсэн асуултад шүүгчид дунджаар 20 (20.30) хэрэг байна гэж хариулсан. Харин шүүгч нараас дээд тал нь хэдэн хэрэг дээр зэрэг ажиллаж байсан талаар асуухад дунджаар 49 (49.67) хэрэг гэж хариулсан.

Харин шүүгчийн ажиллагаанд байх хэргийн зохистой хэмжээг тодруулах зорилгоор “таны хувьд хэдэн хэрэг ажиллагаанд байвал таны ачаалал хэвийн гэж үзэх вэ? гэсэн асуултад дунджаар 15 (15.44) хэрэг гэж хариулсан байна. Үүнээс дүгнэж үзвэл шүүгчид өөрсдийн ачааллыг өндөр байна гэж үнэлж байгаа ба одоо гар дээр байгаа хэргээсээ 5 хэргээр бага байвал ачаалал хэвийн болох боломжтой гэж үзсэн байна.

¹³⁵ Шүүхийн Ерөнхий зөвлөл, *Монгол Улсын шүүхийн тайлан (2017 он)*, 242 дахь тал.

¹³⁶ Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсийн өгсөн мэдээлэл.

Харин шүүгчдээс жилд хэдэн хэрэг шийдэх нь зохистой болохыг тодруулахад жилдээ 42 шийдэх нь зохистой гэж хариулсан байна.


Хүснэгт №31 Шүүгчийн ажиллагаанд байгаа гар дээрх хэргийн тоо болон байвал зохих хэргийн тоо

	Одоо ажиллагаанд байгаа хэргийн тоо	Нэгэн зэрэг ажиллагаанд байсан хамгийн их хэргийн тоо	Нэгэн зэрэг ажиллагаанд байвал зохих хэргийн тоо	Жилд шийдэх хэргийн зохистой тоо
Дундаж/Mean	20.30	49.67	15.44	39
Голч/Median	19.00	53.50	15.00	42

Шүүгч нар ачаалалтай ажилладаг эсэхийг хэмжих өөр нэг хэмжүүр нь хуульд заагдсан ажлын цаг юм. Өөрөөр хэлбэл шүүгч хуульд заасан чиг үүргээ гүйцэтгэхдээ ажлын 8 цагтаа амжиж ажиллаж байгаа эсэх, мөн илүү цагаар сууж ажилладаг эсэхийг шүүгч нараас тодруулах нь шүүгчийн ажлын ачааллыг тодорхойлоход чухал ач холбогдолтой.

Үүнтэй холбогдуулан шүүгчийн ажлын цагийн тооцоог ажлын байрны зураг авалтын дагуу судлахад орон нутаг дахь шүүгч нарын 75 хувь нь ажлын өдөр болон амралтын өдөр илүү цагаар ажилладаггүй гэж хариулсан бол нийслэл дэх шүүгч нарын 66.7 хувь нь ажлын өдөр илүү цагаар сууж ажилладаг ба 16.7 хувь нь амралтын өдрийн аль нэг өдөр ирж илүү цагаар ажилладаг гэж хариулсан байна.


Зураг №27 Та ажлын цагаас гадна амралтын өдрөөр болон ажлын бус цагаар ажилладаг уу?



Үүнээс үзэхэд Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн 66.7 хувь нь ажлын өдрүүдээр илүү цагаар ажилладаг ба 16.7 хувь нь амралтын өдрүүдийн аль нэг өдөр ирж ажилладаг гэж хариулсан байна. Харин орон нутаг дахь захиргааны шүүхийн шүүгчид жилд шийдвэрлэх хэргийн тоо бага байгаатай холбоотойгоор ажлын өдөр болон амралтын өдөр сууж ажиллах нь ховор байна.

Шүүгч нараас ажлын ачааллаас үүдэн стресс, ядаргаанд орж байсан эсэх талаар асуухад орон нутаг дахь шүүгчдийн 75 хувь нь стресст ордог гэж хариулсан бол нийслэл дэх шүүгчдийн 83.3 хувь нь стресстдэг гэж хариулсан байна.

Зураг №28 Та ажлын ачааллаас үүдэн ямар нэг дарамт, стресст орж байсан уу?



Үүнээс үзэхэд шүүгч нарын ажлын ачаалал өндөр байх нь тухайн шүүгчид дарамт, стресст оруулдаг байна. Үүнээс үүдэн судалгааны багийн зүгээс стресст нөлөөлдөг гол хүчин зүйлүүдийг илүү нарийвчлан тодруулахад санал асуулгад хамрагдсан шүүгчид дараахь хариултыг өгч байсан.

1/ Нэгэн зэрэг олон хэрэг дээр давхар ажиллахад заримдаа шийдвэр бичих хугацаа гардаггүй. Үүнээс үүдэн хэргийн оролцогчид гомдол гаргадаг.

2/ Улс төрийн шинжтэй хэрэг дээр ажиллахад заримдаа стресст өртдөг. Тухайлбал, захиргааны хэрэг нь нэг талаас төрийн эрх бүхий албан тушаалтан нөгөө талаас иргэн хуулийн этгээд оролцдог учраас тодорхой улс төрчдөөс нөлөөлөх оролдлого гаргадаг. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэр хоч өгөх, шийдсэн хэрэгтэй нь холбогдуулж тухайн гаргасан шийдвэрийг үнэлэх зэргээр илэрдэг.

3/ Захиргааны зарим хэрэг дээр хэргийн оролцогчид олон учраас тухайн хэрэг ээдрээ төвөгтэй болдог. Үүнээс үүдэн ажлын ачаалал автоматаар нэмэгддэг гэж хариулсан байна. Ингээд захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй бусад хүчин зүйлийг дор дэлгэрүүлэн авч үзье.


3.2. Захиргааны хэргийн шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй хүчин зүйл

Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 2017 онд нийт 75.5 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүгчид 25.3 хэрэг ногдож байна. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд (Улаанбаатар) нэг шүүгчид 50.5 хэрэг ногдож байгаа нь улсын дунджаас 2 дахин их хэрэг хянан шийдвэрлэсэн байна.¹³⁷ Үүнтэй холбогдуулан нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдээс ачаалал ямар байгаа талаар асуухад шүүгч нарын 83.3 хувь ачаалалтай гэж үзсэн. Иймээс шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж байгаа хүчин зүйлсийг дор товч авч үзье.

¹³⁷ Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны тайлан, 70 дахь тал.

Судалгааны багийн зүгээс шүүгчийн ажлын ачаалалд улирлаас шалтгаалсан ачаалал байгаа эсэх талаар асууж тодруулахад нийт шүүгчдийн 75-80 хувь нь 9-12 дугаар сард ачаалал өндөр байдаг гэж хариулсан байна. Үүний шалтгааныг асуухад 7, 8 дугаар сард шүүгч нар амралтаа авдаг, үүнтэй холбоотойгоор бусад шүүгчийн хэргийг өөр дээрээ давхар авсны улмаас ажлын ачаалал нэмэгддэг гэж хариулж байна.

Зураг №29 Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн ачаалал ихэсдэг сарууд



Дээрхээс үзэхэд шүүгчийн ажлын ачаалалд улирлаас хамаарсан ачаалал байгаа болох нь харагдаж байна. Ингээд шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж байгаа хүчин зүйлийг хэрхэн үзэж байгаа талаар дор авч үзье.

Зураг №30 Ажлын ачаалалд нөлөөлж байгаа хүчин зүйлс



Дээрхээс үзэхэд захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй гол хүчин зүйлд 1/ шүүгчийн орон тооны хүрэлцээгүй байдал гэж нийт судалгаанд оролцсон шүүгчдийн 50 хувь 2/ захиргааны шүүхийн өөрийн онцлог болох мөрдөн шалгах зарчмын дагуу нотлох баримт цуглуулах ажиллагаа ачааллыг нэмэгдүүлдэг гэж 20 хувь, 3/ хэрэг маргааны төрөл, ээдрээ

төвөгтэй хэрэг ачаалалд нөлөө үзүүлдэг гэж 20 хувь, 4/ талууд шүүх хуралдааныг хойшлуулснаар шүүхийн ачаалал нэмэгддэг гэж 20 хувь хариулжээ.

Улсын Их Хурлын 2016 оны 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар анхан шатны шүүхийн шүүгчийн орон тоог баталсан.¹³⁸ Энэхүү тогтоолоор Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 20 орон тооны шүүгч ажиллах ёстой боловч өнөөг хүртэл 5 шүүгчийн орон тоо дутуу ажиллаж байна. Үүнээс үүдэн шүүгчийн ажлын ачаалал өндөр болсныг харгалзан Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор томилолтын 6 шүүгчийг ажиллуулж, одоогоор нийтдээ 21 шүүгч ажиллаж байна.

Үүнээс дүгнэж үзэхэд Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан шүүгчийн тоогоор бүрэн ажиллуулах нь Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ачааллыг бууруулахад чухал ач холбогдолтой болох нь харагдаж байна.

Шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж байгаа өөр нэгэн хүчин зүйлд талуудаас нотлох баримт цуглуулах ажиллагаа болох нь харагдаж байна. Шүүгч нараас авсан ярилцлагаар дараахь саналыг шүүгчид дэвшүүлсэн байна. Тухайлбал, нэгэн шүүгч ярилцлагадаа:

Миний бодлоор шүүх хуралдаан хойшлох, хэрэг хянан шийдвэрлэх хугацаандаа хэргийг шийдэж чадахгүй байх гол хүчин зүйл бол талуудаас нотлох баримт цуглуулах ажиллагаа юм. Захиргааны хэргийн шүүх нь өөрийн онцлог чиг үүрэг болох мөрдөн шалгах чиг үүргийн хүрээнд талуудаас нотлох баримт цуглуулдаг. Шүүгчид гол тулгардаг бэрхшээлийн нэг бол талуудаас нотлох баримтыг хуульд заасан хугацаанд цуглуулж чаддаггүй байна.

Жишээлбэл, 1990-ээд оны өмч хувьчлалтай холбоотой маргааныг шийдвэрлэхэд тухайн өмч хувьчлалтай холбоотой материалууд архиваас олддоггүй. Түүнчлэн уг хэрэг дээр үзлэг хийхэд хэд хэдэн байгууллагын архивт хайлт хийх зэргээр маш их хугацаа ордог. Энэ нь үндсэн хэргээ хянан шийдвэрлэхэд хүндрэлтэй болгодог гэсэн.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ярилцлагаас ...

Шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлдэг өөр нэгэн хүчин зүйл бол талууд шүүх хуралдааныг хойшлуулдаг явдал юм. Шүүгч нараас авсан ярилцлагаар шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлдэг нэг хүчин зүйл бол талуудын хүсэлтээр шүүх хуралдааныг хойшлуулах явдал юм гэж хариулжээ. Тухайлбал, Шүүхийн ерөнхий зөвлөлийн хэргийн хөдөлгөөний хэлтсээс авсан мэдээллээр Захиргааны

¹³⁸ <http://www.legalinfo.mn/annex/details/7304?lawid=11941>


хэргийн анхан шатны шүүхүүдийн хувьд 2016 оны 09 дүгээр сарын 05-наас 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 225 нэхэмжлэл хүлээн авсан байна. Нийт хүлээн авсан нэхэмжлэлийн 128 буюу 56.8 хувь нь Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд ногдож байна. Шүүх хуралдаан хойшилж байгаа тоон мэдээллээс үзэхэд 7 хоногт тогтмол 100-с дээш хурал хойшилж байгаа нь энэ асуудалд анхаарал хандуулах шаардлагатай болохыг харуулж байна.¹³⁹

Миний хувьд тулгардаг гол бэрхшээлийн нэг бол төрийн захиргааны төв, гүйцэтгэх, орон нутгийн байгууллагуудаас нотлох баримт гаргуулах явдал байдаг. Тухайлбал, нэг газрын маргаан гарсан гэж үзэхэд хэргийг шийдэхэд шаардлагатай нотлох баримтуудыг байгаль орчин аялал, жуулчлалын яамнаас гаргуулах болдог. Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь нотлох баримтыг явуулахгүй байсаар хугацаа алддаг. Үүнээс болж хэрэг хянан шийдвэрлэх хугацаа хойшилж, улмаар шүүх хуралдаан хойшлох асуудал гардаг. Энэ нь шүүгч нарт давхар ачаалал нэмэгдүүлдэг гэж үзэж байна.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ярилцлагаас ...

Улмаар шүүгчийн ажлын ачааллыг бууруулах зорилгоор шүүгчийн туслахруу шилжүүлэх боломжтой ажил байдаг эсэх, хэрэв байдаг бол ямар төрлийн ажиллагааг шүүгчийн туслахаар хийлгэж болох талаар асуухад судалгаанд хамрагдсан шүүгч нарын 30 хувь нь шүүгчийн туслахад шилжүүлэх ажил байхгүй гэж хариулсан бол нотлох баримт цуглуулах эрх хэмжээтэй болгох гэж 30 хувь нь хариулсан байна.

Зураг №31 Шүүгчийн өдөр тутмын үйл ажиллагаанаас шүүгчийн туслах руу шилжүүлж болох ажил байдаг уу? хэрэв байдаг бол дурдана уу?



Дээрхээс үзэхэд шүүгчдийн зүгээс шүүгчийн туслахыг нотлох баримт цуглуулах эрх хэмжээтэй болгох гэж нийт шүүгчдийн 30 хувь нь хариулсан боловч шүүгчийн туслах болон шүүгчийн ажил үүргийн хуваарийг процессын хуульд

¹³⁹ ШЕЗ, Анхан шатны шүүхүүдийн хэргийн хөдөлгөөний мэдээ, 2016 он, Дугаар 3, 105 дахь тал.


нарийвчлан тусгасан буюу шүүгчийн туслахад нэмж хариуцуулах ажил үүрэг байхгүй гэж 30 хувь үзсэн байна.

Ингээд судалгааны багийн шүүгчийн ачааллыг бууруулахад голлох үүрэгтэй шүүгчийн туслахын чиг үүрэг, ажлын чадавхи, тогтвор суурьшил, цалин нийгмийн баталгааны талаар асууж тодруулахад зарим шүүгчдийн зүгээс дараахь саналыг хэлж байсан. Тухайлбал нэгэн шүүгч ярилцлагадаа дараах тайлбарыг хийж байсан:

Шүүгчийн ажлын ачааллыг хөнгөвчилж өгдөг гол хүн бол шүүгчийн туслах юм. Шүүгчийн нийт хийх ёстой ажлын бараг тал хувийг туслах маань хийж гүйцэтгэдэг. Хэдийгээр ийм их ачаалалтай ажилладаг боловч цалин нь маш бага буюу 500 орчим мянган төгрөг байдаг ба өглөө 8:30-аас ажилдаа ирээд орой 9, 10 гэж гэртээ харьдаг. Ажил оройтох тусам хоол, унааны мөнгө гэх мэт урсгал зардлууд нэмэгддэг. Үүнээс болж цалин хангалтгүй зарим туслахууд тогтвор суурьшилтай ажиллаж чаддаггүй байна.

Шүүхийн шийдвэр тогтвортой байх нь иргэдийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл байдаг. Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн “Монгол Улсын шүүхийн 2015 оны 1 дүгээр улирлын шүүн таслах ажиллагааны тойм” судалгаагаар 2015 оны байдлаар нийт иргэний хэргийг шийдвэрлэсэн шийдвэрийн 67 хувь, эрүүгийн хэргийг шийдвэрлэсэн тогтоолын 59.3 хувь, захиргааны хэргийг шийдвэрлэсэн шийдвэрийн 54 хувь нь давж заалдах шатанд өөрчлөгдөж, хүчингүй болсон байна.¹⁴⁰ Үүнээс үзэхэд шүүгч үндэслэл муутай шийдвэр гаргавал дээд шатны шүүхээс тодорхой хэмжээгээр өөрчлөлт ордог байна. Үүнтэй холбогдуулан судалгааны багийн зүгээс шүүгчийн ажлын ачаалал өндөр байх нь гаргаж буй шийдвэрийн чанарт нөлөөлөх эсэх талаар тодруулахад нийт судалгаанд хамрагдсан шүүгчдийн 90 хувь нь шийдвэрийн чанарт нөлөөлнө гэж үзсэн байна.

Зураг №32 Шүүгчийн ажлын ачаалал, шүүхийн шийдвэрийн чанарт нөлөөлөх эсэх



¹⁴⁰ Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, “Монгол Улсын шүүхийн 2015 оны 1 дүгээр улирлын шүүн таслах ажиллагааны тойм”, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2015 он, дугаар 1, 96 дахь тал.

Үүнээс үзэхэд шүүгчийн ажлын ачаалал өндөр байх нь шүүгчийн гаргаж буй шийдвэрийн чанарт нөлөөлөх боломжтой болох нь харагдаж байна. Улмаар шүүгчдээс жилдээ хэдэн хэрэг шийдвэр үндэслэл бүхий, чанартай шийдвэр гаргах боломжтой талаар асууж тодруулахад дунджаар 42 хэрэг шийдэх нь зохистой гэж үзсэн байна.

Үүнээс үзэхэд Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны 2017 оны дүн мэдээгээр нэг шүүгчид 25.3 хэрэг ногдож байгаа гэсэн статистик мэдээлэлтэй харьцуулахад Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид дээр дурдсан ачаалалтай харьцуулахад өндөр ачаалалтай ажилладаг болох нь харагдаж байна. Харин хөдөө орон нутаг дахь захиргааны хэргийн шүүхийн шүүгчид ачаалал харьцангуй бага байгаа болох нь харагдаж байна.

Ингээд Захиргааны хэргийн шүүхийн шүүгчдийн ачааллыг бууруулахад Шүүхийн ерөнхий зөвлөл болон тамгын газраас ямар ажил гүйцэтгэж байгаа талаар асуухад нийт судалгаанд хамрагдсан шүүгчдийн 40 хувь нь томилолтын шүүгч ажиллуулж байгаа, 30 хувь нь зохион байгуулсан тодорхой ажил байхгүй, 20 хувь нь нарийн бичгийн дарга, шүүгчийн туслахын чиг үүргийг салгасан зэргээр дэвшилттэй ажил зохион байгуулсан гэж хариулсан байна. Үүнийг зургаар харуулбал:

Зураг №33 ШЕЗ болон тамгын газраас ажлын ачааллыг бууруулах ямар нэг ажлыг зохион байгуулж байсан уу?



Ингээд цаашид шүүгчийн ажлын ачааллыг бууруулах талаар ямар үйл ажиллагааг явуулах шаардлагатай талаар асуухад судалгаанд оролцсон шүүгчдийн 40 хувь нь шүүгчийн орон тоог нэмэх, 20 хувь нь шүүхийн захиргааны ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарах, үлдсэн 20 хувьд нь шүүгчийн туслах, нарийн бичгийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай гэж хариулжээ.

Зураг №34 Шүүгчийн ажлын ачааллыг бууруулах талаар ямар үйл ажиллагааг явуулах шаардлагатай вэ?



Дээрх графикаас үзэхэд шүүгчийн ажлын ачааллыг бууруулах үндсэн нөхцөл нь шүүгчийн орон тоог нэмэх болох нь харагдаж байна. Үүнээс гадна шүүгчийн ажлын ачааллыг бууруулах өөр нэгэн хүчин зүйл бол шүүгчийн туслах, нарийн бичгийн даргын цалин, нийгмийн баталгааг хангах мөн, эдгээрийн орон тоог нэмэх явдал болох нь дээрх графикаас харагдаж байна.

3.3. Захиргааны хэрэг шийдвэрлэхэд зарцуулж буй хугацаа

Хүснэгт №32 Шүүгчийн ажлын ачаалал тодорхойлох үзүүлэлт

№	Шүүгчийн гүйцэтгэх ажил, чиг үүрэг	Ээдрээ төвөгтэй хэрэг	Хөнгөн хэрэг	Ерөнхий дундаж
		Голч	Голч	
Шүүх хуралдаанаас өмнөх шүүгчийн ажиллагаа				
1	Нэхэмжлэлтэй танилцах	60	30	45
2	Захиргааны хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэх /захирамж гаргах, хянах/	55	30	43
3	Шүүх хуралдааны бэлтгэл хангах: /хэргийн материалтай танилцах, нотлох баримт судлах/	120	60	90
4	Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах	105	30	68
5	Нотлох баримт цуглуулах, албан тоот төлөвлөх	180	30	105
6	Гэрчээс мэдүүлэг авах	120	60	90

7	Үзлэг хийх	180	60	120
8	Туршилт хийлгэх	120	60	90
9	Таньж олуулах ажиллагаа хийх	30	10	20
10	Шинжээч томилох, дүгнэлттэй танилцах	120	60	90
11	Шүүхээс гаргах эрх зүйн акт боловсруулах, хянах, албажуулах	240	60	150
12	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хүсэлт, гомдол шийдвэрлэх	250	90	170
13	Хэргийн хөдөлгөөний нэгдсэн систем дэх ажиллагаа	60	0	45
Шүүх хуралдааны үеийн шүүгчийн ажиллагаа				
1	Шүүх хуралдааныг даргалах	240	60	150
2	Шүүх хурлын өмнө гаргасан хүсэлт хэлэлцэх, хүсэлтийг шийдвэрлэх	120	60	90
3	Хэргийг шүүх бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэхэд оролцох	240	60	150
4	Шүүхийн шийдвэр гаргахаар зөвлөлдөх	120	35	78
5	Шүүх хуралдааныг хойшлуулах	75	30	53
6	Шүүх хуралдааны шийдвэрийг талуудад танилцуулах	30	20	25
Шүүх хуралдааны дараах шүүгчийн ажиллагаа				
1	Шүүхийн шийдвэр боловсруулах, хянах, албажуулах	1440	440	940
2	Шүүх хуралдааны тэмдэглэлийг хянах, баталгаажуулах	120	60	90
3	Хэргийн хөдөлгөөний нэгдсэн систем дэх шүүгчийн ажиллагаа	60	30	45
4	Давж заалдах, хяналтын гомдол хүлээн авах, холбогдох шүүхэд хэргийг хүргүүлэх	360	50	205
5	Шүүхийн шийдвэрт гүйцэтгэх хуудас бичих	120	60	90
Бусад				
1	Шүүгчдийн зөвлөгөөнд орох	120	60	90
2	Багшлах болон эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх	30	60	45
3	Сургалт, хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох	120	120	120
4	Шүүхийн Ёс зүйн хороонд тайлбар гаргах, хуралдаанд оролцох	180	120	150

Судалгаанд хамрагдсан шүүхүүдийн ажлын байрны зураг авалтад хамрагдсан шүүгч нараас шийдвэрлэсэн нэг хөнгөн хэрэг болон нэг ээдрээ төвөгтэй хэргийг сонгон авч тухайн хэрэг анхан шатны шүүхээр шийдвэрлэгдэх хүртэлх хугацаанд хавтаст хэрэгт цугларсан нотлох баримт, шүүгчийн хийсэн ажиллагаанд дүн шинжилгээ хийсэн болно. Ингэхдээ доорх хүснэгтэд заасан үзүүлэлтээр хавтаст хэргийг задалж дүн шинжилгээ хийсэн. Мөн үүнээс гадна хөнгөн гэж үзсэн хавтаст хэрэгт дунджаар ямар ажиллагаа хийгдсэн, ээдрээ төвөгтэй хэрэгт ямар ажиллагаа явагдсан талаар судалсан. Үүний үндсэн дээр нэг дундаж хэрэгт ямар ямар шалгуур үзүүлэлтүүд орж байгаа, тэдгээрийн давтамжийн тоог гарган ирсэн болно.

Дээрх аргачлалын дагуу судалгаа хийхэд Нийслэлд нэг дундаж захиргааны хэргийн хавтасны тоо 2, захиргааны хэрэг үүсгэснээс хойш шүүхийн шийдвэр гартал хавтаст хэргийн хуудасны тоо 365, анхан шатны шүүхийн шийдвэр гартал 227 хоног, хэргийн оролцогчдын тоо 3, нотлох баримтын хуудасны тоо 324, хурал хойшилсон тоо 3, шүүгчийн гаргасан захирамжийн тоо 7.5 /тогтоол, захирамжийн тоо/ гэсэн үзүүлэлт гарсан байна.

Хүснэгт №33 Нэг дундаж захиргааны хэргийг шийдвэрлэхэд зарцуулах хугацаа

	Хавтасны тоо	Хавтаст хэргийн хуудас	Шийдвэрлэсэн хоног	Холбогдогчдын тоо эзэн	Сөрөг нэхэмжлэл гаргасан эсэх	Нотлох баримтын хуудасны тоо	Гэрч оролцсон эсэх тоо	Шинжээчийн дүгнэлтийн тоо	Узлагийн тоо	Туршилт хийгдсэн тоо	Хурал хойшлогдсон тоо	Шүүгчийн захирамжийн тоо
Ээдрээ төвөгтэй	2.0	380.0	140.0	5.0	0.0	137.0	2.0	0.0	1.0	0.0	0.0	13.0
Хөнгөн	1.0	38.0	69.0	1.0	0.0	25.0	2.0	0.0	0.0	0.0	1.0	6.0
Санамсаргүй	1.0	70.0	25.0	1.0	0.0	65.0	4.0	1.0	0.0	0.0	0.0	5.0
Нийслэл	2.0	365.0	227.5	3.0	0.0	324.0	0.0	0.0	0.5	0.0	3.0	7.5
Орон нутаг	1.0	70.0	57.5	3.0	0.0	65.0	4.0	0.0	0.0	0.0	0.0	6.0
Дундаж	2.0	252.0	120.0	3.0	0.0	25.0	2.0	0.0	0.0	0.0	0.0	6.0

Дээрх аргачлалын дагуу нэг хэргийг шийдвэрлэхэд захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн гүйцэтгэх ажил үүргийн дундаж хугацаа, мөн нэг дундаж иргэний хэрэг маргаанд ямар ямар ажиллагааг хийж гүйцэтгэх талаарх хэмжигдэхүүнийг тодорхой болгосон тул захиргааны хэргийн 1 шүүгч жилдээ өөрт ногдсон хэргийг шийдвэрлэхэд хэдий хэмжээний хугацаа зарцуулж байгааг тооцоолох боломжтой болж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан судалгаанаас үзвэл 2017 оны байдлаар нийслэлд захиргааны хэргийн шүүхийн нэг шүүгчид 50.5 хэрэг ногдож байгаа бөгөөд үүнд зарцуулсан хугацааг тооцоолж гаргах боломжтой. Гэхдээ нэг шүүгчид ногдож байгаа 50.5 хэрэг нь хэргийн онцлог шинжээрээ ямар төрөлд хуваагдаж байгааг судлах шаардлагатай бөгөөд ачаалал үнэн бодитой гарах нөхцөл бүрдэх юм.

Үүний тулд шүүхээс гарч байгаа шийдвэрийн хэдэн хувь нь хялбаршуулсан журмаар шийдвэрлэдэг, хэдийн хувийг нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэдэг, хэдэн хувьд нь талууд мэтгэлцэж шийдвэр гардаг талаарх статистик судалж үзэхэд 2015-2017 оны хооронд улсын хэмжээнд захиргааны хэргийн анхан шатны шүүхээс нийт шийдвэрлэсэн хэрэг маргааны 23.4 хувийг хялбаршуулсан журмаар буюу Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн ЗХШХШТ хуулийн 66-68 дугаар зүйлээр, 56.7 хувьд нь талууд мэтгэлцэж буюу ЗХШХШТ хуулийн 106 дугаар зүйлээр шийдвэрлэсэн байх бол нийт хэргийн 19.9 хувьд нь захиргааны хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Хүснэгт №34 Монгол Улсын хэмжээнд захиргааны хэргийг шийдвэрлэсэн байдал

Шийдвэрлэсэн бүх захиргааны хэрэг		2015 он		2016 он		2017 он		3 жилийн дунджаар
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	
		1439	100.0%	1780	100.0%	1577	100.0%	100.0%
Үүнээс	Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэрэг	348	24.2%	412	23.1%	359	22.8%	23.4%
	ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлээр шийдвэрлэсэн хэрэг-бүгд	694	48.2%	893	50.2%	1129	71.6%	56.7%
	Хэргийг хэрэгсэхгүй болгосон-Бүгд	397	27.6%	475	26.7%	89	5.6%	19.9%

Дээр дурдсан статистикаас үзвэл улсын дунджаар захиргааны хэргийн анхан шатны шүүхээс нийт шийдвэрлэсэн хэрэг маргааны 23.4 хувийг хялбаршуулсан журмаар, 56.7 хувьд нь талууд мэтгэлцэж шийдвэрлэсэн, нийт хэргийн 19.9 хувьд нь захиргааны хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Энэхүү аргачлалыг харгалзан дор тооцооллыг хийж үзье.

Нийслэлд нэг дундаж захиргааны хэргийн хавтасны тоо 2, захиргааны хэрэг үүсгэснээс хойш шүүхийн шийдвэр гартал хавтаст хэргийн хуудасны тоо 365, анхан шатны шүүхийн шийдвэр гартал 227 хоног, хэргийн оролцогчдын тоо 3, нотлох баримтын хуудасны тоо 324, хурал хойшилсон тоо 3, шүүгчийн гаргасан захирамжийн тоо 7.5 /тогтоол, захирамжийн тоо/ гэсэн үзүүлэлт гарсан байна. Энэхүү үзүүлэлт дээр тулгуурлан дундаж хугацааг тооцож үзье. (Хүснэгт№ ...)

Хүснэгт №35 Нэг дундаж захиргааны хэргийг шийдвэрлэхэд зарцуулах хугацаа буюу ЗХШШТХ хуулийн 106 дугаар зүйлээр шийдвэрлэх хэрэг

	Шүүгчийн хэргийг шийдвэрлэхэд хийх ажиллагаа	Нэг стандарт үйл ажиллагааг гүйцэтгэхэд зарцуулах хугацаа /минутаар/	Давтамжийн тоо	Хугацаа /минутаар/
1	Нэхэмжлэлтэй танилцах	45	1	45
2	Захиргааны хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэх /захирамж гаргах, хянах/	43	1	43
3	Шүүх хуралдааны бэлтгэл хангах: /хэргийн материалтай танилцах, нотлох баримт судлах/	90	1	90
4	Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах	68	1	68
5	Нотлох баримт цуглуулах, албан тоот төлөвлөх	105	1	105
6	Үзлэг хийх	120	0.5	60
7	Шүүхээс гаргах эрх зүйн акт боловсруулах, хянах, албажуулах	150	5	750
8	Шүүх хуралдааныг даргалах	150	1	150
9	Шүүх хуралдааныг хойшлуулах	53	3	159
10	Шүүхийн шийдвэр боловсруулах, хянах, албажуулах	940	1	940
11	Шүүх хуралдааны тэмдэглэлийг хянах, баталгаажуулах	90	1	90
	Нийт			2500 минут

Нэг захиргааны хэргийг шүүгч нэг жилд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулж буй хугацаа= 2500 минут (ЗХШШТХ-ийн 106 дугаар зүйлээр нэг хэргийг шийдэхэд зарцуулах хугацаа) × 28.6 хэрэг¹⁴¹ =71500 минут: 60минут=1191 цаг: 8 цаг=148 өдөр зарцуулсан байна. **Энэ нь 28.6 хэргийг шүүгч ЗХШШТХ-ийн 106 дугаар зүйлээр шийдвэрлэхэд зарцуулсан ажлын өдрийг тооцоолсон болно.**

¹⁴¹ 2017 оны байдлаар Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч дунджаар жилд 50.5 хэрэг шийдвэрлэдэг гэж үзвэл үүний 56.7 хувийг тооцсон болно.

ЗХШХШТ хуулийн 66-68 дугаар зүйлийн дагуу хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэрэг /23.4 хувь/ болон захиргааны хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хэрэг /19.9 хувь/ байна. Үүнийг хугацаагаар тооцож үзвэл эдгээр нь харьцангуй хөнгөн шийдвэрлэгдэх хэрэг учраас хөнгөн хэргийг голчоор тооцсон болно.

Нийслэлд нэг дундаж захиргааны хэргийн хавтасны тоо 1, захиргааны хэрэг үүсгэснээс хойш шүүхийн шийдвэр гартал хавтаст хэргийн хуудасны тоо 38, анхан шатны шүүхийн шийдвэр гартал 69 хоног, хэргийн оролцогчдын тоо 2, нотлох баримтын хуудасны тоо 25, гэрч оролцсон тоо 2, хурал хойшлогдсон эсэх 1, шүүгчийн гаргасан захирамжийн тоо 5 тус тус байна.

Хүснэгт №36 ЗХШХШТХ-ийн 66-68 дугаар зүйлээр шийдвэрлэх хэрэг болон хэргийн хэрэгсэхгүй болгосон хэрэг

	Шүүгчийн хэргийг шийдвэрлэхэд хийх ажиллагаа	Нэг стандарт үйл ажиллагааг гүйцэтгэхэд зарцуулах хугацаа /минутаар/	Давтамжийн тоо	Хугацаа /минутаар/
1	Нэхэмжлэлтэй танилцах	30	1	30
2	Захиргааны хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэх /захирамж гаргах, хянах/	30	1	30
3	Шүүх хуралдааны бэлтгэл хангах: /хэргийн материалтай танилцах, нотлох баримт судлах/	60	1	60
4	Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах	30	1	30
5	Нотлох баримт цуглуулах, албан тоот төлөвлөх	30	1	30
7	Шүүхээс гаргах эрх зүйн акт боловсруулах, хянах, албажуулах	60	4	240
8	Шүүх хуралдааныг даргалах	60	1	60
9	Шүүх хуралдааныг хойшлуулах	30	3	30
10	Шүүхийн шийдвэр боловсруулах, хянах, албажуулах	440	1	440
11	Шүүх хуралдааны тэмдэглэлийг хянах, баталгаажуулах	60	1	60
	Нийт			1010 минут

Нэг захиргааны хэргийн шүүгч нэг жилд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулж буй хугацаа= 1010 минут (ЗХШШТХ-ийн 66-68 дугаар зүйлээр шийдвэрлэх хэрэг болон хэргийн хэрэгсэхгүй болгон шийдэхэд зарцуулах хугацаа) × 21.9 хэрэг =22119 минут: 60минут=368.6 цаг: 8 цаг=46 өдөр зарцуулсан байна.

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч жилдээ 50.5 хэрэг шийдвэрлэж байгаа бөгөөд үүнд **194** ажлын өдрийг зарцуулж байгаа тооцоо гарч байна. Нэг шүүгч жилд 230 өдөр ажилладаг гэж тооцвол: 230 өдөр-194 өдөр=36 өдөр дутуу байгаа нь харагдаж байна.

Харин орон нутгийн тухайд судалгаанд сонгож авсан Төв аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хувьд 2017 онд 47 хэрэг шийдсэн ба үүнээс нэг шүүгчид 15.66 хэрэг, Өвөрхангай аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 27 хэрэг буюу нэг шүүгч 9 хэрэг шийдсэн үзүүлэлттэй байна. Ингээд Төв аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн ажлын ачааллыг дор тооцож үзье.

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч жилдээ 50.5 хэргийг дунджаар 194 өдөр шийдвэрлэдэг гэсэн дундаж үзүүлэлтийг харгалзан үзвэл Төв аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 15.66 хэргийг 60.2 ажлын өдөр шийдвэрлэдэг байна. $15.66 \text{ хэрэг} \times 194 \text{ өдөр} : 50.5 = 60.2 \text{ өдөр}$

Харин дээрх аргачлалаар Өвөрхангай аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэж байгаа хэргийг тооцож үзэхэд тус аймаг 2017 оны байдлаар нийтдээ 9 хэрэг шийдвэрлэсэн гэж үзвэл жилдээ дунджаар 34.6 ажлын өдөр ажилладаг байна. $9 \text{ хэрэг} \times 194 \text{ өдөр} : 50.5 = 34.6 \text{ өдөр}$

Дээрхээс үзэхэд Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч дунджаар 194 ажлын өдөр, Төв аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч жилдээ 60.2 ажлын өдөр, Өвөрхангай аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч 34.6 ажлын өдрийг тухайн жилдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулдаг болох нь харагдаж байна.

Бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн хэрэг

Мөн үүнээс гадна шүүгч ЗХШШТХ-ийн 74 дүгээр зүйлд заасны дагуу тухайн шүүгчийн бусад шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэрэгт оролцох хувь хэмжээг дор цухас авч үзье.

Монгол Улсын шүүн таслах ажиллагааны 2014 онд гаргасан тайлангаас үзвэл Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2014 онд шийдвэрлэсэн 634 хэргийн 471 буюу 74.2 хувийг ЗХШШТХ-ийн 70 дугаар зүйлээр талуудыг мэтгэлцүүлэн шүүсэн бол 163 буюу 25.7 хувийг ЗХШШТХ-ийн 41, 42, 43 дугаар зүйлээр хялбаршуулсан журмаар шийдвэрлэжээ. 2014 онд нийт шийдсэн

хэргийнхээ 103 буюу 16.2 хувийг бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн, 531 буюу 83.7 хувийг дангаар шийдвэрлэжээ.¹⁴²

Харин Шүүхийн ерөнхий зөвлөлийн Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсийн 2017 оны мэдээллээс үзвэл нийт 1777 хэрэг шийдвэрлэснээс 131 хэрэг буюу 7.4 хувийг бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн байна. Үүнийг дор хүснэгтээр үзүүлбэл,

Хүснэгт №37 Бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн хэрэг, 2017 он

№	Бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн байдал	Захиргааны хэрэг
1	Шүүгч дангаар шийдвэрлэсэн хэрэг	1777
2	Бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн хэрэгт оролцсон байдал	131

Дээрх мэдээлэлтэй холбоотойгоор шүүгчийн ажлын ачааллыг тооцож үзвэл дараах тооцоо гарч байна.

Хүснэгт №38 Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч бүрэлдэхүүнтэй хэрэг шийдвэрлэхэд зарцуулж буй хугацаа

№		Нэгж хугацаа	Давтамжийн тоо	Хугацаа /минутаар/	Өдөр
1	Хэргийг шүүх бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэхэд оролцох	150	5.24	786	1.63 өдөр
2	Хэргийг шүүх бүрэлдэхүүнээр шийдвэрлэх хэрэг хойшлох	53	12.68	672	1.4 өдөр
Нийт					3 өдөр

Ингээд судалгааны багийн зүгээс шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлөх бусад зүйлийг тодруулж үзэхэд шүүгчдээс авсан чанарын судалгаагаар дараахь хүчин зүйлүүд ажлын ачааллыг нэмэгдүүлдэг гэж үзсэн байна. Тухайлбал, 1/ Шүүгчийн орон тоо, 2/ Нотлох баримт цуглуулахад хүндрэлтэй байдал 3/ хэрэг маргааны ээдрээ төвөгтэй байдал, 4/ шүүх хуралдаан хойшлолт, 5/ Шинжээчээс шалтгаалах, 6/ Шүүхийн ёс зүйн хороонд тайлбар гаргах, 7/ Шүүхийн ерөнхий зөвлөл өөрөө ачааллыг нэмэгдүүлэх 8/ Улсын Их Хурал, аймаг, нийслэл сум, орон нутгийн сонгуультай холбоотой ачаалал нэмэгдэх, 9/ Захиргааны ажилтнууд болох шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүгчийн туслахын ур чадваргүй байдал, ажлын тогтвор суурьшил, мөн эдгээр ажилтнуудын орон тоо хүрэлцээгүй байдал,

¹⁴² ШЕЗ, Нийслэл дэх дүүргийн иргэний хэргийн анхан шатны зарим шүүх, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, шүүхийн захиргааны ажилтны ажлын ачаалал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, 2015 он, Дугаар 4, 111 дэх тал.

10/ шүүх хуралдааны танхимын хүрэлцээгүй байдал зэрэг хүчин зүйлүүд ажлын ачаалалд нөлөөлдөг гэж үзсэн байна.

Эдгээр хүчин зүйл нь шүүгчийн ажлын ачаалалд их бага хэмжээгээр нөлөөлж байгаа боловч судалгааны багийн зүгээс эдгээр үзүүлэлтийн зарим ачааллыг тооцоход хүндрэлтэй байдлыг харгалзан нарийвчлан хугацааг тооцоогүй болно. Харин эдгээрээс шүүгчийн ёс зүйн хороонд тайлбар гаргах, сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох, шүүгчдийн зөвлөгөөнд орох хугацааг тооцож үзэхэд дараах тооцоолол гарч байна.

Хүснэгт №39 Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн шүүх хуралдаанаас бусад үйл ажиллагаанд зарцуулж буй хугацаа

№		Нэгж хугацаа	Давтамжийн тоо	Хугацаа /минутаар/	Нэг шүүгчид ногдох бусад ажлын хугацаа
1	Шүүгчийн ёс зүйн хороонд тайлбар гаргах	150	3.5 ^ш	525	1.09 өдөр
2	Сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох	480	10	4800	10 өдөр
3	Шүүгчдийн зөвлөгөөнд орох	90	42	3780	7.8 өдөр
Нийт				9105 минут	18.8 өдөр

Дээрхээс дүгнэж үзэхэд Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид дангаар шийдвэрлэсэн хэрэг 194 өдөр, бүрэлдэхүүнтэй хэрэгт орж шийдвэрлэсэн хугацаа 3 өдөр, бусад ажиллагаанд 18.8 өдөр зарцуулдаг байна. Энэ нь нийтдээ 215.8 ажлын өдөр болж байна.


Харин судалгаанд хамрагдсан Төв аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн дангаар шийдвэрлэсэн хэрэг 60.2 өдөр, бүрэлдэхүүнтэй хэрэгт орж шийдвэрлэсэн хугацаа 0.93 өдөр /15.66 хэрэг × 3 өдөр : 50.5 = 0.93 өдөр/, бусад ажиллагаанд 5.8 өдөр /15.66 хэрэг × 18.8 өдөр : 50.5 = 5.8 өдөр / нийтдээ 67 ажлын өдөр зарцуулдаг байна.

Өвөрхангай аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажилласан ачааллын тухайд нэг шүүгчийн дангаар шийдвэрлэсэн хэрэг 34.57 өдөр, бүрэлдэхүүнтэй хэрэгт орж шийдвэрлэсэн хугацаа 0.53 өдөр /9 хэрэг × 3 өдөр : 50.5 = 0.533 өдөр/, бусад ажиллагаанд 3.35 /9 хэрэг × 18.8 өдөр : 50.5 = 3.35 өдөр/ өдөр нийтдээ 38.45 ажлын өдөр зарцуулдаг байна.

3.4. Захиргааны хэргийн шүүгчийн ажлын байрны зураглал

Судалгааны хүрээнд Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нарын ажлын байран дээрээ гүйцэтгэж буй ажиллагаанууд тус бүр дээр ажлын өдрүүдэд зарцуулж буй хугацааг бүртгэж, үүнд шинжилгээ хийлээ.

Зураг №35 Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн нэг өдрийн ажлын цагийн задаргаа



Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч ажлын 5 өдрийн дунджаар 1 өдөрт ажлын цагийн 55% буюу 245.4 минутыг (4 цаг 5 минут) хавтаст хэрэгтэй танилцах, шүүхээс гарах эрх зүйн акт боловсруулах, нотлох баримт цуглуулах зэрэг ажилд, 9% буюу 39.4 минутыг (39 минут) шүүх хуралдаан даргалах болон шүүх хуралдааны бүрэлдэхүүнд ороход зарцуулдаг бол үүний дараагаар өдрийн ажлын цагийн 5% буюу 22.8 минутыг (22 минут) шүүхийн шийдвэр боловсруулах, хянах, албажуулах, шүүх хуралдааны тэмдэглэл хянах, баталгаажуулах ажлуудад зарцуулдаг байна. Эндээс Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч шүүх хуралдаанаас өмнөх үеийн үйл ажиллагаанд цаг хугацаа их зарцуулж буйг харж болно.

Хүснэгт №40 Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын байрны зураглал

№	Шүүгчийн гүйцэтгэх ажил, чиг үүрэг	Даваа гараг	Мягмар гараг	Лхагва гараг	Пүрэв гараг	Баасан гараг	Нийт цаг	1 өдрийн дундаж цаг
1	Шүүх хуралдаанаас өмнөх шүүгчийн ажиллагаа	320	246	282	271	108	1227	245.4
2	Шүүх хуралдааны үеийн шүүгчийн ажиллагаа	12	107	30	0	48	197	39.4
3	Шүүх хуралдааны дараах шүүгчийн ажиллагаа	12	0	36	0	66	114	22.8
4	Бусад	120	120	100	142	216	698	139.6
5	Нийт /минутаар/	464.0	473.0	448.0	413.0	438.0	2236.0	447.2
6	Нийт /цагаар/	7.7	7.9	7.5	6.9	7.3	37.3	7.5

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч долоо хоногт дунджаар 2400 минут (40 цаг) ажиллах ёстойгоос 2236.0 минут (37.3 цаг) буюу 164.0 минутаар (2 цаг 44 минут) дутуу ажилласан байна. Шүүгч өдөрт 480 минут (8 цаг) ажиллахаас 447.2 минут (7.5 цаг) буюу 32.8 минутаар (32 минут) дутуу ажилласан байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

1. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН АЖЛЫН АЧААЛАЛ

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачааллын ерөнхий төлөв байдал

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 2017 онд нийт 47.6 шүүгч ажилласан байх бөгөөд судалгаанд хамрагдсан 6 дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгчид 73.4 хэрэг ногдож байна. *Улмаар шүүгчдээс жилд хэдэн хэрэг шийдэх нь ажлын ачаалал хэвийн байх талаар асуухад нэг шүүгч дунджаар 75 хэрэг жилдээ шийдэх нь шүүхийн шийдвэр чанартай бөгөөд үндэслэл бүхий гарна гэж хариулсан бөгөөд 6 дүүргийн эрүүгийн хэргийн нэг шүүгчид 73.4 хэрэг ногдож, үүнийг шийдвэрлэхэд ажлын 229.5 өдөр зарцуулж байгаа нь ажлын ачаалал хэвийн гэж үзэж болохоор байна.*

Дараах хүснэгтээс ажлын ачааллын задаргааг үзнэ үү.

Хүснэгт №41 Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалал

	Шүүгчийн хийх ажил	Дүүргийн эрүүгийн хэргийн шүүгч
1	73.4 эрүүгийн хэргийг	204 өдөр
2	Шүүгч бүрэлдэхүүнтэй хуралд	9 өдөр
3	Шүүгчдийн зөвлөгөөнд	5.75 өдөр
4	Шүүгч сургалтад	10 өдөр
5	Шүүгч ёс зүйн хороонд	0.5 өдөр
	Нийт	229.5 өдөр

Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн нэг шүүгч 91 хэрэг шийдвэрлэсэн бол Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн шүүгч 49 хэрэг шийдвэрлэсэн байгаа нь ачаалал дүүргүүдийн дунд харилцан адилгүй байгааг харуулж байна. Иймд нийслэлийн 6 дүүргийн эрүүгийн хэргийн шүүгчдийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн шүүхээс Баянзүрх дүүргийн эрүүгийн шүүхэд шүүгчийг томилолтоор ажиллуулах байдлаар ачааллыг тэнцвэржүүлэх боломжтой байна.

Судалгаанд хамрагдсан Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 447 хэрэг буюу нэг шүүгчид 91.2 хэрэг шийдвэрлэсэн бол Өвөрхангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 147 хэрэг буюу нэг шүүгчид 58 хэрэг шийдвэрлэсэн үзүүлэлттэй байна. Үүнээс үзвэл сум дундын шүүхийн шүүгчдийн ажлын ачаалал харилцан адилгүй байгаа тул ажлын ачааллыг тэнцвэржүүлэх шаардлагатай.

Үүнээс үзэхэд судалгаанд хамрагдсан орон нутгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх дүүргийн шүүхтэй адилхан ачаалалтай байгаа бөгөөд харин Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхэд нэг шүүгчид жилдээ 9 эрүүгийн хэрэг, 80 иргэний хэрэг ногдож байгаа нь харьцангуй ачаалал багатайг харуулж байна. Ингээд дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй хүчин зүйлийг дор авч үзье.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй хүчин зүйл

Судалгааны багийн зүгээс шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж буй хүчин зүйлсийг тодруулах зорилгоор шүүгчдээс ганцаарчилсан ярилцлага авсан. Уг ярилцлагаар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн 55 хувь нь ачаалалтай гэж үзсэн.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй гол хүчин зүйлд 1-т шүүгчийн орон тооны хүрэлцээгүй байдал гэж нийт судалгаанд оролцсон шүүгчдийн 56 хувь нь хариулсан бөгөөд 2-т шинэ эрүү, зөрчлийн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ажлын ачаалал өндөр байна гэж 44 хувь нь үзсэн байна. 3-т шүүх хурал хойшлох болон шүүхийн тойргийн тогтолцоо хүчингүй болсонтой холбогдон ачаалал нэмэгдсэн, ажлын ачаалалд нөлөөлж байна гэж судалгаанд оролцсон шүүгчдийн 24 хувь нь үзсэн байна. Харин бусад хувьд нь хурлын заалны хүрэлцээ муу, шийтгэх тогтоол бичих хугацаа бага, захиргааны ажилтны орон тоо цөөн, ур чадвар муу, ирж байгаа хэрэг маргааны тоо их зэрэг хүчин зүйлүүд ажлын ачаалалд нөлөөлдөг гэж үзсэн байна.

Эдгээр хүчин зүйл нь шүүгчийн ажлын ачаалалд их бага хэмжээгээр нөлөөлж байгаа боловч судалгааны багийн зүгээс эдгээр үзүүлэлтээс дараахь хүчин зүйлүүдийг онцолж байна.

Шүүгчийн орон тоо: Монгол Улсын Их Хурлын 2016 оны 42 дугаар тогтоолын 2 дугаар хэвсрэлтээр анхан шатны шүүхийн шүүгчийн орон тоог баталсан.¹⁴³ Энэхүү тогтоолоор нийслэлийн 6 дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 70 орон тооны шүүгч ажиллах ёстой бөгөөд 2017 оны байдлаар 47 шүүгчийн бүрэлдэхүүнтэй ажилласан байна. Шүүгчийн ажлын ачааллыг бууруулахад шүүгчийн орон тоог нэмэх нь өөрт ногдох хэргийн ачааллыг шууд хуваалцах учраас ажлын ачааллыг бууруулах үндсэн хүчин зүйл гэж үзэж байна.

¹⁴³ <http://www.legalinfo.mn/annex/details/7304?lawid=11941>

Шинэ эрүүгийн болон процессын хуулийн хэрэгжилт: 2017 оны 7 дугаар сарын 1-ээс шинэ эрүүгийн болон процессын хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж байна. Тухайлбал шинэ процессын хуулиар шүүх хуралдааны тоо нэмэгдэж байгаа бөгөөд урьдчилсан хэлэлцүүлэг хийх, гэм буруугийн болон ял оногдуулах хурлыг 2 үе шаттайгаар хийх, хохирол нөхөн төлөх хүсэлттэй холбоотойгоор шүүх хуралдааныг хойшлуулж дахин хурал зарлах зэргээр нэг хэрэгт хийх шүүх хуралдааны тоо өссөн байна.

Шүүхийн захиргааны ажилтан, албан хаагч: Шүүгч нарын зүгээс шүүгчийн ажлын ачааллыг бууруулахад гол үүрэг гүйцэтгэдэг хүн бол шүүгчийн туслах, шүүхийн нарийн бичгийн дарга учраас эдгээр ажилтны орон тоог нэмэх, цалин, нийгмийн баталгааг хангахад анхаарах, тогтвор суурьшилтай ажиллуулах шаардлагатай байна.

Санал, зөвлөмж

- Судалгаанд хамрагдсан 6 дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны нэг шүүгчид 73.4 хэргийг шийдвэрлэхэд 229 өдөр зарцуулж байгаа хэвийн ачаалалтайг судалгаа харуулж байгаа, мөн эрүүгийн хэргийн шүүгчид жилд 75 хэрэг шийдвэрлэхэд ачаалал хэвийн байна гэснээс үзвэл Монгол улсын хэмжээнд нэг эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч 75 хэрэг шийдвэрлэдэг байхаар ажлын ачааллын норматив тогтоох боломжтой байна.
- Судалгаанд хамрагдсан 6 дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид ногдох хэргийн тоо харилцан адилгүй байгаа тул ажлын ачааллыг тэнцвэржүүлж аль болох нэг шүүгчид 75 хэрэг ногдох байдлаар ачааллыг хуваарилах шаардлагатай.

2. ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН АЖЛЫН АЧААЛАЛ

Судалгаанд хамрагдсан 6 Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2017 онд нийт 79.3 шүүгч ажилласан байх ба иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгчид 310 хэрэг ногдож байна. *Улмаар шүүгчдээс жилд хэдэн хэрэг шийдэх нь ажлын ачаалал хэвийн байх талаар асуухад нэг шүүгч дунджаар 200 хэрэг жилдээ шийдэх нь шүүхийн шийдвэр чанартай, үндэслэл бүхий шийдвэр гарна гэж хариулсан бөгөөд 6 дүүргийн иргэний хэргийн нэг шүүгчид 310 хэрэг ногдож, үүнийг шийдвэрлэхэд ажлын 323 өдөр зарцуулж байгаа нь ажлын ачаалал их байгааг харуулж байна. Дараах хүснэгтээс ажлын ачааллын задаргааг үзнэ үү.*

Хүснэгт №42 Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалал

	Шүүгчийн үндсэн үйл ажиллагаа	Дүүргийн иргэний хэргийн шүүгч
1	310 иргэний хэргийг шийдэхэд	282 өдөр
2	Шүүгч бүрэлдэхүүнтэй хуралд ороход	14 өдөр
3	Гомдлын хуралд	8 өдөр

4	Шүүгчдийн зөвлөгөөнд	7.8 өдөр
5	Шүүгч сургалтад	10 өдөр
6	Шүүгч ёс зүйн хороонд	1.2 өдөр
	Нийт	323 өдөр

Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн нэг шүүгч 345 хэрэг шийдвэрлэсэн бол Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн шүүгч 249 хэрэг шийдвэрлэсэн байгаа нь ачаалал дүүргүүдийн дунд харилцан адилгүй байгааг харуулж байна. Иймд нийслэлийн 6 дүүргийн иргэний хэргийн шүүгчдийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх шаардлагатай байж болох юм.

Судалгаанд хамрагдсан Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд 1357 хэрэг буюу нэг шүүгчид 295 хэрэг шийдвэрлэсэн бол Өвөрхангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд 761 хэрэг буюу нэг шүүгчид 282 хэрэг шийдвэрлэсэн үзүүлэлттэй байна. Үүнээс үзвэл сум дундын шүүхийн шүүгчдийн ажлын ачаалал харьцангуй ойролцоо байна. Харин Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сумын дундын нэг шүүгчид 80 иргэний хэрэг, 9 эрүүгийн хэрэг ногдож байгаа нь ажлын ачаалал бага байгааг харуулж байна. Ингээд иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй хүчин зүйлийг дор авч үзье.

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй хүчин зүйл

Судалгааны багийн зүгээс шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж буй хүчин зүйлсийг тодруулах зорилгоор шүүгчдээс ганцаарчилсан ярилцлага авсан. Уг ярилцлагаар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн 95 хувь ачаалалтай гэж үзсэн.

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй гол хүчин зүйлд нэгдүгээрт, шүүгчийн орон тоо хүрэлцээгүй, дутуу мөн шүүх хуралдаан их хойшилдог гэж нийт судалгаанд оролцсон шүүгчдийн 42.9 хувь нь хариулсан бөгөөд хоёрдугаарт, шүүгчийн туслах, нарийн бичгийн ур чадвар, тогтворгүй байдал гэж 17.9 хувь нь үзсэн байна. Гуравдугаарт, шүүх хуралдаан хийх заал, танхимын хүрэлцээ муу байна гэж судалгаанд оролцсон шүүгчдийн 14.3 хувь нь үзсэн байна.

Шүүгчийн орон тоо: Нийслэлийн 6 дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нийт 78 шүүгч, 6 ерөнхий шүүгчийн орон тоо, нийт 84 шүүгчийн орон тоо батлагдсан байх бөгөөд 2017 оны байдлаар 6 дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд 79 шүүгчийн орон тоотойгоор хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Үүнээс үзвэл шүүгчийн батлагдсан орон тоондоо хүрч ажиллаж чадаагүй, мөн түүнчлэн одоо байгаа орон тоог нэмж батлуулах шаардлагатай байна.

Шүүх хуралдаан хойшлох: Хэргийн оролцогчийн хүсэлтээр хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хойшилсон шүүх хуралдаан 84 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл шүүх хурал хэргийн оролцогчийн өмгөөлөгч авах, хэргийн материалтай танилцах, өмгөөлөгчийн хурал давхцах, өмгөөлөгч өвдөх, нотлох баримт бүрдүүлэх хүсэлт гаргах, нэхэмжлэлийн шаардлага нэмэгдүүлэх зэрэг хүсэлтээр хойшилдог. Үүнээс үзвэл өмгөөлөгчөөс хамаарах шалтгаанаар хурал хойшилдог болох нь харагдана.

Шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй хоёрдахь том хүчин зүйл нь шүүгчийн туслах, нарийн бичгийн орон тоо болон ур чадвар дутуу байдал байна. Шүүхийн захиргааны ажилтнууд тогтвор суурьшилгүй байгаа нь ажлын ачаалал нэмэгдүүлэх, ажлын уялдаа холбоог алдагдуулах хандлагатай байна.

Шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй гурав дахь том хүчин зүйл нь шүүх хуралдааны танхимын хүрэлцээний асуудал байна. Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхүүд нь нэг газар байрлаж байгаа бөгөөд 39 шүүгчид 9 хурлын заал ногдож байгаа нь байх ёстой тооноос 4-өөр цөөн байна. Энэ нь хурлын цаг болоход өмнөх хурал тарахгүй байх, хурлын заал олдохгүй байх үндсэн шалтгаан болж байна. Харин Хан-Уул, Сонгинохайрхан, Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд 35 шүүгчид 7 хурлын танхим ногдож байгаа нэг таван шүүгчийн дунд 1 хурлын танхим ногдоно гэсэн үг юм.

Санал, зөвлөмж

- Судалгаанд хамрагдсан 6 дүүргийн иргэний хэргийн анхан шатны нэг шүүгчид 310 хэргийг шийдвэрлэхэд 323 өдөр зарцуулж байгаа нь ачаалал ихтэйг харуулж байна. Шүүгч жилд 230 өдөр ажиллана гэж үзвэл 93 өдрөөр ажлын ачаалал илүү байгаа бөгөөд үүнийг ажлын өдөр болон амралтын өдөр ажиллаж нөхөж байна. Илүү ажиллаж буй 93 өдөр нь ажлын 744 цаг болж байгаа бөгөөд шүүгч жилд 1840 цаг ажиллах ёстой гэж үзвэл 40 хувиар илүү ачаалалтай ажиллаж байна. Иймд шүүгчийн орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай байгаа ба тухайлбал 6 дүүрэгт шүүгчийн орон тоог 31-ээр нэмэгдүүлэх тооцоолол гарч байна.

3. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН АЖЛЫН АЧААЛАЛ

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн ажлын ачааллын ерөнхий төлөв байдал

Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 2017 онд нийт 75.5 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүгчид 25.3 хэрэг ногдож байна. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд (Улаанбаатар) нэг шүүгчид 50.5 хэрэг ногдож байгаа нь дунджаас 2 дахин их хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

Судалгаанд хамрагдсан Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 47 хэрэг буюу нэг шүүгчид 15.66 хэрэг шийдвэрлэсэн бол Өвөрхангай

аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 27 хэрэг буюу нэг шүүгчид 9 хэрэг шийдвэрлэсэн үзүүлэлттэй байна.

Үүнээс үзэхэд судалгаанд хамрагдсан орон нутгийн захиргааны хэргийн анхан шатны шүүх харьцангуй ачаалал багатай бөгөөд Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхтэй харьцуулахад 3 дахин ачаалал багатай ажилладаг болох нь харагдаж байна. Ингээд захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй хүчин зүйлийг дор авч үзье.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй хүчин зүйл

Судалгааны багийн зүгээс шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж буй хүчин зүйлсийг тодруулах зорилгоор шүүгчдээс ганцаарчилсан ярилцлага авсан. Уг ярилцлагаар Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн 83.3 хувь ачаалалтай гэж үзсэн.

Үүний шалтгааныг тодруулахад шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй гол хүчин зүйлд 1/ Шүүгчийн орон тоо /50 хувь/, 2/ Нотлох баримт цуглуулахад хүндрэлтэй байдал /50 хувь/ 3/ хэрэг маргааны ээдрээ төвөгтэй байдал /20 хувь/, 4/ шүүх хуралдаан хойшлолт /50 хувь/, 5/ Шинжээчээс шалтгаалах, 6/ Шүүхийн ёс зүйн хороонд тайлбар гаргах, 7/ Шүүхийн ерөнхий зөвлөл өөрөө ачааллыг нэмэгдүүлэх 8/ Улсын Их Хурал, аймаг, нийслэл сум, орон нутгийн сонгуультай холбоотой ачаалал нэмэгдэх, 9/ Захиргааны ажилтнууд болох шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүгчийн туслахын ур чадваргүй байдал, ажлын тогтвор суурьшил, мөн эдгээр ажилтнуудын орон тоо хүрэлцээгүй байдал, 10/ шүүх хуралдааны танхимын хүрэлцээгүй байдал, 11/ улирлаас хамаарсан ачаалал зэрэг хүчин зүйлүүд ажлын ачаалалд нөлөөлдөг гэж үзсэн байна.

Эдгээр хүчин зүйл нь шүүгчийн ажлын ачаалалд их бага хэмжээгээр нөлөөлж байгаа боловч судалгааны багийн зүгээс эдгээр үзүүлэлтээс дараахь хүчин зүйлүүдийг онцолж байна.

- Шүүгчийн орон тоо

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар анхан шатны шүүхийн шүүгчийн орон тоог баталсан.¹⁴⁴ Энэхүү тогтоолоор Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 20 орон тооны шүүгч ажиллах ёстой боловч өнөөг хүртэл 5 шүүгчийн орон тоо дутуу ажиллаж байна.

Үүнээс үүдэн шүүгчийн ажлын ачаалал өндөр болсныг харгалзан Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор томилолтын 6 шүүгчийг ажиллуулж, одоогоор нийтдээ 21 шүүгч ажиллаж байна. Эдгээр

¹⁴⁴ <http://www.legalinfo.mn/annex/details/7304?lawid=11941>

шүүгчид 2017 оны байдлаар 50.5 хэрэг ногдож байгаа бөгөөд шүүгчдээс авсан ганцаарчилсан ярилцлагаар нийт шүүгчдийн 83.3 хувь нь ачаалалтай гэж үзсэн байна.

Улмаар шүүгчдээс жилд хэдэн хэрэг шийдэх нь зохистой талаар асуухад нэг шүүгч дунджаар 42 хэрэг жилдээ шийдэх нь шүүхийн шийдвэр чанартай бөгөөд үндэслэл бүхий шийдвэр гарна гэж хариулсан байна.

Үүнээс дүгнэж үзэхэд Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан шүүгчийн тоогоор бүрэн ажиллуулах нь Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачааллыг бууруулахад нэн тэргүүний зорилт болох нь харагдаж байна.

Харин орон нутгийн шүүгчийн орон тооны тухайд Төв болон Өвөрхангай аймгийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид тус бүр 3 шүүгчтэйгээр шүүн таслах ажиллагаа явуулж байгаа нь шийдвэрлэж буй хэргийн тоотой харьцуулахад ачаалал зохистой байгаа гэж үзэж байна.

- Улирлаас хамаарсан ачаалал

Судалгааны явцад шүүгчдийн зүгээс шүүгчийн ажлын ачаалалд улирлаас шалтгаалсан ачаалал нөлөөлдөг гэж үзсэн. Өөрөөр хэлбэл ярилцлага авсан шүүгчдийн 75-80 хувь улирлаас хамаарсан ачаалал байгаа гэж үзсэн байна. Тухайлбал, 9-12 дугаар сард ачаалал өндөр байдаг ба үүний шалтгаан нь 7, 8 дугаар сард шүүгч нар ээлжийн амралтаа авдаг, үүнтэй холбоотойгоор бусад шүүгчийн хэргийг өөр дээрээ давхар авсны улмаас ажлын ачаалал нэмэгддэг гэж хариулсан байна. Иймээс дээр дурдсан шүүгчийн орон тоог нэмэх талаар анхаарах шаардлагатай.

- Нотлох баримт цуглуулахад хүндрэлтэй байдал

Шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж байгаа өөр нэгэн хүчин зүйлд талуудаас нотлох баримт цуглуулах ажиллагаа болох нь харагдаж байна. Шүүгч нараас авсан ярилцлагаар захиргааны шүүх нь өөрийн онцлог чиг үүрэг болох мөрдөн шалгах зарчмын дагуу талуудаас нотлох баримт цуглуулдаг. Энэ чиг үүргийн дагуу төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас нотлох баримтыг гаргуулан авахад заримдаа нотлох баримтыг гаргаж өгөхгүй зэргээр шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлдэг гэж үзсэн. Үүнээс үүдэн шүүх хуралдаан хойшлох, улмаар шүүгчийн хийх ажиллагаа нэмэгддэг байна.

Иймээс хэргийн оролцогч буюу талуудаас нотлох баримтыг хуульд заасан хугацаанд гаргаж өгөхгүй байгаа байдал нь шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж байгаа нэгэн хүчин зүйл болж байгаа байдалд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс анхаарал хандуулж, хууль тогтоомжийг боловсронгуй болгоход анхаарах шаардлагатай.

- Шүүх хуралдаан хойшлох

Шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлдэг өөр нэгэн хүчин зүйл бол талууд шүүх хуралдааны хойшлуулдаг явдал юм. Шүүгч нараас авсан ярилцлагаар шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлдэг нэг хүчин зүйл бол талуудын хүсэлтээр шүүх хуралдааныг хойшлуулах явдал юм гэж хариулжээ.

Тухайлбал, Шүүхийн ерөнхий зөвлөлийн хэргийн хөдөлгөөний хэлтсээс авсан мэдээллээр захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдийн хувьд 2016 оны 09 дүгээр сарын 05-наас 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 225 нэхэмжлэл хүлээн авсан байна. Нийт хүлээн авсан нэхэмжлэлийн 128 буюу 56.8 хувь нь Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд ногдож байна. Шүүх хуралдаан хойшилж байгаа тоон мэдээллээс үзэхэд 7 хоногт тогтмол 100-аас дээш хурал хойшилж байгаа нь энэ асуудалд анхаарал хандуулах шаардлагатай болохыг харуулж байна.

- Шүүхийн ёс зүйн хороонд тайлбар гаргах

Монгол Улсын шүүхийн ёс зүйн хорооноос гаргасан тайлан мэдээллээр 2017 оны байдлаар шүүгчийн ёс зүйн зөрчилд буруутгагдсан шүүгчид харьяаллын хувьд 90.8 хувь хувь нь анхан шатны шүүхийн шүүгч, 6 хувь нь давж заалдах шатны шүүх, 3.3 хувь нь хяналтын шүүхийн шүүгчид холбогдуулан гаргасан байна.

Судалгааны ганцаарчилсан ярилцлагын явцад захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн зүгээс шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй хүчин зүйлд ёс зүйн хороонд тайлбар гаргах, ёс зүйн хорооны хуралд очиж суух нь тодорхой хэмжээгээр ачааллыг нэмэгдүүлдэг гэж хариулсан. Тухайлбал, нэг шүүгч дунджаар 1-2 удаа ёс зүйн хороонд тайлбар гаргадаг боловч энэ нь ачаалал ихтэй үед нэмэлт ачаалал үүсгэдэг гэж үзсэн байна.

Түүнчлэн ёс зүйн хороонд тайлбар гаргахтай холбоотой өөр нэгэн асуудал бол тухайн хэрэг хянан шийдвэрлэгдэж дуусаагүй үед тухайн хэрэгтэй холбоотой гомдлыг талууд гаргах нь шүүгчийн сэтгэлзүйд нөлөөлөх эсэх тухай тухай асуудал юм. Үүнийг зарим шүүгчид шүүгчийн хараат бус байдлыг хөндөж байна гэж үзэж байсныг цаашид анхаарах шаардлагатай.

- Шүүхийн захиргааны байгууллагаас ачааллыг нэмэгдүүлэх

Захиргааны хэргийн шүүхийн шүүгчдийн ачааллыг бууруулахад Шүүхийн ерөнхий зөвлөл болон тамгын газраас ямар ажил гүйцэтгэж байгаа талаар асуухад нийт судалгаанд хамрагдсан шүүгчдийн 40 хувь нь томилолтын шүүгч ажиллуулж байгаа, 30 хувь нь зохион байгуулсан тодорхой ажил байхгүй, 20 хувь нь нарийн бичгийн дарга, шүүгчийн туслахын чиг үүргийг салгасан зэргээр дэвшилттэй ажил зохион байгуулсан гэж хариулсан байна. Хэдийгээр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүгчийн ажлын ачааллыг бууруулах талаар шат дараалсан арга хэмжээ авч байгаа боловч ШЕЗ-тэй холбоотой дараахь санал гарч байсан.

Тухайлбал, Шүүхийн ерөнхий зөвлөл нь спортын арга хэмжээ зохион байгуулах, хуулийн төсөлд санал авах, судалгаа бөглүүлэх зэргээр шүүгчийн

ажлын ачааллыг нэмэгдүүлдэг гэжээ. Иймээс Шүүхийн ерөнхий зөвлөлөөс энэхүү ачаалалд нөлөөлж буй байдалд цаашид анхаарал хандуулах шаардлагатай.

- Шүүхийн захиргааны ажилтан, албан хаагч

Энэхүү судалгааны явцад шүүгч нарын зүгээс ажлын ачааллыг бууруулах зорилгоор шүүгчийн туслах руу шилжүүлэх боломжтой ажил байдаг эсэх, хэрэв байдаг бол ямар төрлийн ажиллагааг шүүгчийн туслахаар хийлгэж болох талаар асуухад судалгаанд хамрагдсан шүүгч нарын 30 хувь нь шүүгчийн туслахад шилжүүлэх ажил байхгүй гэж хариулсан бол нотлох баримт цуглуулах эрх хэмжээтэй болгох гэж 30 хувь нь хариулсан байна.

Шүүгч нарын зүгээс шүүгчийн ажлын ачааллыг бууруулахад гол үүрэг гүйцэтгэдэг хүн бол шүүгчийн туслах, шүүхийн нарийн бичгийн дарга учраас эдгээр ажилтны орон тоо, цалин, нийгмийн баталгааг хангахад анхаарах шаардлагатай талаар санал гаргаж байсан.

Энэхүү судалгааны явцад зарим шүүгчид шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга нарын цалин хэтэрхий бага байгаатай холбоотойгоор эдгээр ажилтнууд тогтвор суурьшилтай ажиллаж чадахгүй байна. Үүнтэй холбоотойгоор шинэ хүн сургах болгонд шүүгчийн ажлын ачааллыг давхар нэмэгдүүлж байна гэж хариулж байсан. Иймээс шүүгчийн туслах, нарийн бичгийн даргын орон тоог нэмэх, тэдгээр ажилтны цалин, нийгмийн баталгааг хангах талаар анхаарах шаардлагатай.

Захиргааны хэрэг шийдвэрлэхэд зарцуулж буй хугацаа

Судалгаагаар Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид дангаар шийдвэрлэсэн хэрэг 194 өдөр, бүрэлдэхүүнтэй хэрэгт орж шийдвэрлэсэн хугацаа 3 өдөр, бусад ажиллагаанд 18.8 өдөр зарцуулдаг байна. Энэ нь нийтдээ 215.8 ажлын өдөр зарцуулдаг байна.

Харин судалгаанд хамрагдсан Төв аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн дангаар шийдвэрлэсэн хэрэг 60.2 өдөр, бүрэлдэхүүнтэй хэрэгт орж шийдвэрлэсэн хугацаа 0.93 өдөр, бусад ажиллагаанд 5.8 өдөр нийтдээ 67 ажлын өдөр зарцуулдаг байна.

Өвөрхангай аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажилласан ачааллын тухайд нэг шүүгчийн дангаар шийдвэрлэсэн хэрэг 34.57 өдөр, бүрэлдэхүүнтэй хэрэгт орж шийдвэрлэсэн хугацаа 0.53 өдөр, бусад ажиллагаанд 3.35 өдөр, нийтдээ 38.45 ажлын өдөр зарцуулдаг байна. Ингээд нэг шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх хугацааг дор хүснэгтээр үзүүлье.

Шүүгчийн хийх ажил	Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч	Төв аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч	Өвөрхангай аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч

1	50.5 захиргааны хэргийг шийдвэрлэх	194 өдөр	60.2 өдөр	34.57 өдөр
2	Шүүгч бүрэлдэхүүнтэй хуралд суух	3 өдөр	0.93 өдөр	0.533 өдөр
3	Шүүгчдийн зөвлөгөөнд оролцох	7.8 өдөр	5.8 өдөр	3.35 өдөр
4	Шүүгч сургалтад оролцох	10 өдөр		
5	Шүүгч ёс зүйн хороонд тайлбар гаргах	1.09 өдөр		
	Нийт	215.8 өдөр	67 өдөр	38.45 өдөр

Захиргааны хэргийн шүүгчийн ажлын байрны зураглал

Судалгааны хүрээнд Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нарын ажлын байран дээрээ гүйцэтгэж буй ажиллагаанууд тус бүр дээр ажлын өдрүүдэд зарцуулж буй хугацааг бүртгэж, үүнд шинжилгээ хийхэд дараах ажлын зураг авалт хийгдсэн байна.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч ажлын 5 өдрийн дунджаар 1 өдөрт ажлын цагийн 55% буюу 245.4 минутыг (4 цаг 5 минут) хавтаст хэрэгтэй танилцах, шүүхээс гарах эрх зүйн акт боловсруулах, нотлох баримт цуглуулах зэрэг ажилд, 9% буюу 39.4 минутыг (39 минут) шүүх хуралдаан даргалах болон шүүх хуралдааны бүрэлдэхүүнд ороход зарцуулдаг бол үүний дараагаар өдрийн ажлын цагийн 5% буюу 22.8 минутыг (22 минут) шүүхийн шийдвэр боловсруулах, хянах, албажуулах, шүүх хуралдааны тэмдэглэл хянах, баталгаажуулах ажлуудад зарцуулдаг байна.

Эндээс захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч шүүх хуралдаанаас өмнөх үеийн үйл ажиллагаанд цаг хугацаа их зарцуулж буйг харж болно. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт №43 Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын байрны зураглал

№	Шүүгчийн гүйцэтгэх ажил, чиг үүрэг	Даваа гараг	Мягмар гараг	Лхагва гараг	Пүрэв гараг	Баасан гараг	Нийт цаг	1 өдрийн дундаж цаг
1	Шүүх хуралдаанаас өмнөх шүүгчийн ажиллагаа	320	246	282	271	108	1227	245.4
2	Шүүх хуралдааны үеийн шүүгчийн ажиллагаа	12	107	30	0	48	97	39.4
3	Шүүх хуралдааны дараах	12	0	36	0	66	114	22.8

	шүүгчийн ажиллагаа							
4	Бусад	120	120	100	142	216	698	139.6
5	Нийт /минутаар/	464.0	473.0	448.0	413.0	438.0	2236.0	447.2
6	Нийт /цагаар/	7.7	7.9	7.5	6.9	7.3	37.3	7.5

Үүнээс үзэхэд захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч долоо хоногт дунджаар 2400 минут (40 цаг) ажиллах ёстойгоос 2236.0 минут (37.3 цаг) буюу 164.0 минутаар (2 цаг 44 минут) дутуу ажилласан байна. Шүүгч өдөрт 480 минут (8 цаг) ажиллахаас 447.2 минут (7.5 цаг) буюу 32.8 минутаар (32 минут) дутуу ажилласан байна.

Санал, зөвлөмж

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх болон Төв, Өвөрхангай аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачааллын судалгаагаар дараахь санал, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 42 дугаар тогтоолын 2 дугаар хэсрэлтээр Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 20 орон тооны шүүгч ажиллахаар баталсан боловч өнөөг хүртэл 5 шүүгчийн орон тоо дутуу ажиллаж байна. Иймээс тус шүүхэд батлагдсан орон тооны шүүгчийг дээрх тогтоолд заасны дагуу томилох;

2. Судалгаанд хамрагдсан орон нутгийн шүүхүүд Төв болон Өвөрхангай аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчидтэй харьцуулахад харьцангуй ачаалал багатай байгааг анхаарч, Улаанбаатар хот болон орон нутгийн шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэхэд анхаарах;

3. Шүүгчийн орон тоо дутуу байгаатай холбоотойгоор шүүгч нарт улирлаас хамаарсан ачаалал үүсэж байна. Иймээс энэхүү ачааллыг бууруулахын тулд дээр дурдсан шүүгчийн орон тоог нэмэх талаар анхаарах шаардлагатай.

4. Шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлэхэд хэргийн оролцогч талуудаас нотлох баримт гаргаж өгөхгүй байх ажиллагаа нөлөөлж байна. Иймээс хэргийн оролцогч буюу талуудаас нотлох баримтыг хуульд заасан хугацаанд гаргаж өгөхгүй байгаа байдалд анхаарал хандуулж, хууль тогтоомжийг боловсронгуй болгоход анхаарах шаардлагатай.

5. Шүүгчийн ажлын ачаалалд хэргийн оролцогч болох талуудаас шүүх хуралдааныг хойшлуулах байдлаар ачааллыг нэмэгдүүлж байна. Иймээс ШЕЗ-өөс энэ асуудалд анхаарал хандуулах шаардлагатай.

6. Шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж буй хүчин зүйлд Шүүхийн ёс зүйн хороонд тайлбар гаргах асуудал хамаарч байна. Иймээс тухайн хэрэг хянан шийдвэрлэгдэж дуусаагүй үед тухайн хэрэгтэй холбоотой гомдлыг талууд гаргах нь шүүгчийн сэтгэлзүйд нөлөөлөх, улмаар шүүгчид шүүгчийн хараат бус байдлыг хөндөж байгаа эсэхэд цаашид анхаарах шаардлагатай.

7. Судалгааны явцад шүүгч нарын зүгээс ажлын ачааллыг нэмэгдүүлж буй хүчин зүйлд шүүгчийн туслах, шүүхийн нарийн бичгийн даргын ажлын байрны тогтвор суурьшил ба ажлын чадавх нөлөөлдөг гэж үзсэн. Энэ нь тухайн ажилтны цалин нийгмийн баталгаатай холбогдох учраас эдгээр ажилтны орон тоо, цалин, нийгмийн баталгааг хангахад анхаарах шаардлагатай.

ХАВСРАЛТ.АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ОРОН ТОО, АЖЛЫН НОРМАТИВЫГ ХАНГАХ НЬ:

Нэг.Анхан шатны шүүхийн шүүгчийн орон тоо, ажлын ачааллын өнөөгийн байдлыг харьцуулах нь

Шүүхийн ажлын ачааллын ерөнхий төлөв байдал

Энэхүү судалгаа нь шүүгчийн ажлын ачааллыг тодорхойлохдоо тоон болон чанарын мэдээлэлд тулгуурласан болно. Юуны өмнө, 2017 оны статистикийн мэдээлэлд тулгуурлан шүүхийн бодит ажлын ачааллыг шүүгчийн тоо, нэг шүүгчид ногдсон хэргийн тооны хувьд харьцуулан харж болно. 2017 онд нийслэл дэх эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд нийт 47.6 шүүгч ажилласан, нэг шүүгчид 73.4 хэрэг ногдсон, нийслэл дэх иргэний хэргийн анхан шатны шүүхэд нийт 79.3 шүүгч ажилласан, нэг шүүгчид 310 хэрэг ногдсон, харин нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нийт 21 шүүгч ажилласан, нэг шүүгчид 50.5 хэрэг ногдсон тус тус үзүүлэлттэй байна. Энэ бол нийслэл дэх анхан шатны шүүхийн бодит ажлын ачааллын талаарх анхдагч тоон үзүүлэлт юм.

Дээрх бодит ажлын ачааллын үзүүлэлтийг ажлын өдрөөр тооцож үзвэл, эрүүгийн хэргийн шүүгч өөрт ногдож буй хэргийг шийдвэрлэхэд 229 өдөр, иргэний хэргийн шүүгч өөрт ногдож буй хэргийг шийдвэрлэхэд 323 өдрийг зарцуулж байгаа юм. Иргэний хэргийн шүүгчид ногдож буй хэргийн тоо их, үүнийг даган ажлын ачаалал даган мөн их байна.

Хүснэгт №44 Хүснэгт №45. Нийслэл дэх анхан шатны шүүхийн ажлын ачааллын ерөнхий төлөв байдал (2017 оны байдлаар)

	Эрүүгийн шүүх		Иргэний шүүх		Захиргааны шүүх	
	Шүүгчийн гүйцэтгэсэн ажил		Шүүгчийн гүйцэтгэсэн ажил		Нийслэлийн шүүгчийн гүйцэтгэсэн ажил	
1	73.4 хэргийг шийдвэрлэхэд	204 өдөр	310 хэргийг шийдвэрлэхэд	282 өдөр	50.5 хэргийг шийдвэрлэхэд	194 өдөр

3	Шүүгч бүрэлдэхүүнтэй хуралд	9 өдөр	Шүүгч бүрэлдэхүүнтэй хуралд ороход	14 өдөр	Шүүгч бүрэлдэхүүнтэй хуралд суух	3 өдөр
4	Шүүгчдийн зөвлөгөөнд	5.75 өдөр	Гомдлын хуралд	8 өдөр	Шүүгчдийн зөвлөгөөнд оролцох	7.8 өдөр
5	Шүүгч сургалтад	10 өдөр	Шүүгчдийн зөвлөгөөнд	7.8 өдөр	Шүүгч сургалтад оролцох	10 өдөр
6	Шүүгч ёс зүйн хороонд	0.5 өдөр	Шүүгч сургалтад	10 өдөр	Шүүгч ёс зүйн хороонд тайлбар гаргах	1.09 өдөр
7			Шүүгч ёс зүйн хороонд	1.2 өдөр		
	Нийт	229.5 өдөр	Нийт	323 өдөр	Нийт	215.8 өдөр

Шүүхийн ажлын ачаалал газар зүйн байрлал, хүн амын тоо, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтээс хамаараад харилцан адилгүй байгаа нь эрүү, иргэн, захиргааны аль ч салбарын хувьд ажиглагдаж байна. Тухайлбал, өнгөрсөн оны байдлаар Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч 91 хэрэг шийдвэрлэсэн бол Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн шүүгч 49 хэрэг шийдвэрлэсэн бол Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч 91.2 хэрэг шийдвэрлэсэн бол Өвөрхангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч 58 хэрэг шийдвэрлэжээ. Дурдсан хугацаанд Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч 345 хэрэг шийдвэрлэсэн бол Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч 249 хэрэг шийдвэрлэсэн байна. Түүнчлэн, Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч 295 хэрэг шийдвэрлэсэн бол Өвөрхангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч 282 хэрэг шийдвэрлэсэн үзүүлэлттэй гарчээ. Харин, Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч 15.66 хэрэг шийдвэрлэсэн бол Өвөрхангай аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч 9 хэрэг шийдвэрлэсэн байна. Үүнээс үзэхэд судалгаанд хамрагдсан орон нутгийн захиргааны хэргийн анхан шатны шүүх харьцангуй ачаалал багатай бөгөөд нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхтэй харьцуулахад 3 дахин ачаалал багатай болох нь харагдсан. Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сумын дундын шүүхийн нэг шүүгчид 80 иргэний хэрэг, 9 эрүүгийн хэрэг ногдсон мэдээлэл байна. Энэ мэдээллүүд нь өнөөдөр шүүх байгууллагын хувьд хүний нөөцийн төлөвлөлт зохистой биш, шүүх байгууллагын ажлын ачаалал тэнцвэргүй, шүүгчийн болон бусад ажилтны ажлын байрны орон тоо оновчгүй байгааг харуулж байна.

Шүүгч нарын дунд явуулсан ганцаарчилсан ярилцлагаар шүүгчид өөрсдийн ачааллыг хэрхэн үнэлж байгааг тодорхойлсон. Судалгаанд оролцсон шүүгчдийн ажлын ачааллын өөрийн үнэлгээнээс харвал Нийслэл болон орон нутгийн

эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн 55 хувь, иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн 95 хувь, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн 83.3 хувь нь ачаалалтай ажиллаж байгаагаа илэрхийлсэн байна. Шүүгчийн өөрийн үнэлгээг талбараар нарийвчлан харвал Нийслэлд судалгаанд оролцсон эрүүгийн хэргийн шүүгчдийн 55.6 хувь, орон нутгийн шүүгчдийн 85.7 хувь нь ачаалалтай гэсэн хариулт өгчээ. Статистик мэдээллээс үзэхэд дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны нэг шүүгчид жилд 73 хэрэг, сум дундын эрүүгийн хэргийн нэг шүүгчид 65 хэрэг ногдсон байгаагаас харахад, эрүүгийн шүүхийн шүүгчдийн зүгээс, тэр дундаа орон нутгийн шүүгчдийн зүгээс өөрийн үнэлгээ нь бодит байдлаас нэлээд зөрүүтэй байгаа юм. Харин судалгаанд хамрагдсан иргэний болон эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн хувьд ажлын ачааллаа их гэж үнэлсэн нь бодит байдал дээр ч нэг шүүгчид ногдох хэргийн тоо хэмжээ өндөр байгаатай нийцэж байна.

Түүнчлэн, судалгаанд оролцсон шүүгч нарын зүгээс шүүгчийн нэг жилд шийдвэрлэх хэргийн зохистой тоо хэмжээний талаарх асуултанд хариулсан байдлыг сонирхож болно. Ингэж үзэхэд эрүүгийн хэргийн шүүгчид жилд 75 хэрэг, иргэний хэргийн шүүгчид жилд 200 хэрэг, харин захиргааны хэргийн шүүгчид жилд 42 хэрэг шийдвэрлэх нь ажлын хэвийн ачаалал гэж үзжээ. Бодит ажлын ачааллын үзүүлэлт болон шүүгч нарын зүгээс зохист хэмжээг тодорхойлж буй үнэлгээг харьцуулан үзвэл эрүүгийн хэргийн шүүхийн өнөөгийн ачаалал хэвийн, иргэний хэргийн ажлын ачаалал 50 хувиар хэтэрсэн, харин захиргааны хэргийн ажлын ачаалал гурав дахин их байна гэсэн дүр зураг харагдаж байна.

Хүснэгт №45 Шүүгчийн бодит ачаалал болон ачааллын талаарх өөрийн үнэлгээ, хүлээлт (Нийслэл дэх анхан шатны шүүхийн 2017 оны мэдээ ба судалгааны дүн)

№	Утга	Эрүүгийн шүүх	Иргэний шүүх	Захиргааны шүүх
1	Нэг шүүгчийн шийдвэрлэсэн хэргийн тоо	73,4	310	50,5
2	Ачаалал их гэсэн өөрийн үнэлгээ өгсөн шүүгчийн хувь	55	95	83,3
3	Нэг шүүгчийн жилд шийдвэрлэвэл зохих хэргийн тоо (хүлээлт)	75	200	42

Шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй хүчин зүйлс

Өмнөх бүлгүүдэд шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх судалгааны үр дүнгүүдийг шүүхийн салбар бүрээр авч үзсэн билээ. Энд шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй нийтлэг болон онцлог хүчин зүйлсийн талаар дүгнэж байна.

Шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж байгаа анхдагч бөгөөд нийтлэг шалтгаан нь өнөөдрийн шүүхийн байгууллагын орон тооны хүрэлцээгүй байдал

болж байна. Судалгаанд оролцсон шүүгчдийн зүгээс өнөөдөр бүх салбар шүүхийн шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлэхэд хамгийн их нөлөө үзүүлж байгаа хүчин зүйл бол шүүгчийн орон тооны дутмаг байдал хэмээн үзсэн байна. Шүүгчийн орон тооны хүрэлцээг шийдвэрлэх бодлогын орчин бүрдсэн ч, өнөөдөр түүний хэрэгжилт хангалтгүй байгаа нь шүүгчийн ажлын ачааллыг бууруулах боломжгүйд хүргэж байна. Тухайлбал, УИХ-ын 2016 оны 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар анхан шатны шүүхийн шүүгчийн орон тоог баталсан. Энэхүү тогтоолоор нийслэлийн 6 дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 70 орон тооны шүүгч ажиллах ёстой боловч, 2017 оны байдлаар 47 шүүгчийн бүрэлдэхүүнтэй ажилласан байна. Түүнчлэн, нийслэлийн 6 дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нийт 78 шүүгч, 6 ерөнхий шүүгчийн орон тоо, нийт 84 шүүгчийн орон тоо батлагдсан байх бөгөөд 2017 оны байдлаар 6 дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд 79 шүүгчийн орон тоотойгоор хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Мөн дээрх тогтоолоор нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 20 орон тооны шүүгч ажиллах ёстой боловч өнөөг хүртэл 5 шүүгчийн орон тоо дутуу ажиллаж байна. Энэ нөхцөл байдлыг харгалзан ШЕЗ-өөс ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор томилолтын 6 шүүгчийг ажиллуулж, одоогоор нийтдээ 21 шүүгч ажиллаж байна. Харин орон нутгийн шүүгчийн орон тооны тухайд Төв болон Өвөрхангай аймгийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид тус бүр 3 шүүгчтэйгээр шүүн таслах ажиллагаа явуулж байгаа нь шийдвэрлэж буй хэргийн тоотой харьцуулахад ачаалал зохистой байгаа гэж үзэж байна.

Шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж байгаа удаах нийтлэг хүчин зүйл бол шүүх хуралдаан хойшлох явдал болох нь мөн судалгааны дүнгээс харагдаж байна. Ялангуяа, анхан шатны эрүү болон иргэний шүүхийн шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлөх нөлөөллөөр шүүгчийн орон тооны дараа хоёр дахь хүчин зүйл болж буй юм. Шүүхийн салбарын статистикаас үзэхэд хэргийн оролцогчийн хүсэлтээр хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хойшилсон шүүх хуралдаан 84 хувийг эзэлж байгаа ба ерөнхийдөө шүүгчидтэй хийсэн ярилцлагын мэдээллээс харахад практик дээр хэргийн оролцогч өмгөөлөгч авах, хэргийн материалтай танилцах, өмгөөлөгчийн хурал давхцах, өмгөөлөгч өвдөх, нотлох баримт бүрдүүлэх хүсэлт гаргах, нэхэмжлэлийн шаардлага нэмэгдүүлэх зэрэг хүсэлтээр хойшилдог. Шүүхийн захиргааны ажилтны орон тоо, ур чадвар, тогтвор суурьшилтай ажиллах асуудал нь шүүгчийн орон тоо болон шүүх хурал хойшлохтой харьцуулахад ажлын ачаалалд нөлөөлөх хувьдаа харьцангуй доогуур үзүүлэлттэй байгаа ч, басхүү нийтлэг хүчин зүйл юм. Энэ хүчин зүйл нь Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хүрээнд илүү жин дарж байна.

Дээр дурдсанчлан, шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлдөг нийтлэг хүчин зүйлээс гадна, шүүхийн салбаруудын шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлдөг онцлог хүчин зүйлүүд байгаа юм. Тухайлбал, эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалалд эрүүгийн болон зөрчлийн тухай хуулиуд шинэчлэгдэн батлагдсан, түүнчлэн, шүүхийн тойргийн тогтолцоо хүчингүй болсон нь ихээхэн нөлөөлж байна. Тухайлбал, 2017 оны 7 сарын 1-ээс эрүүгийн суурь болон процессын шинэ хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор шүүгчийн ажлын

ачаалал ихэссэн ба эдгээр хуулиар урьдчилсан хэлэлцүүлэг хийх, гэм буруугийн болон ял оногдуулах хурлыг хоёр үе шаттайгаар хийх, хохирол нөхөн төлөх хүсэлттэй холбоотойгоор шүүх хуралдааныг хойшлуулж дахин хурал зарлах зэргээр нэг хэргийн хүрээнд хийх шүүх хуралдааны тоо өсчээ.

Судалгааны дүнгээс цааш сонирхвол, Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалалд шүүх хуралдааны танхимын хүрэлцээ багагүй нөлөө үзүүлдэг гэжээ. Тухайлбал, Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхүүд нэг газар байрлаж байгаа бөгөөд 39 шүүгчид 9 хурлын заал ногдож байгаа нь байх ёстой тооноос дөрвөөр цөөн байна. Мөн Хан-Уул, Сонгинохайрхан, Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд 35 шүүгчид 7 хурлын танхим ногдож байгаа ба таван шүүгчийн дунд нэг хурлын танхим байна гэсэн үг. Энэ нь хурлын цаг болоход өмнөх хурал тарахгүй байх, хурлын заал олдохгүй байх үндсэн шалтгаан болж байна.

Түүнчлэн, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн хувьд хувьд нотлох баримт цуглуулах болон шүүхийн ёс зүйн хороонд тайлбар гаргах нь ажлын ачааллыг нэмэгдүүлэх үндсэн хүчин зүйл болдог байна. Монгол Улсын шүүхийн ёс зүйн хорооноос гаргасан тайлан мэдээллээр 2017 оны байдлаар шүүгчийн ёс зүйн зөрчилд буруутгагдсан шүүгчид харьяаллын хувьд 90.8 хувь хувь нь анхан шатны шүүхийн шүүгч, 6 хувь нь давж заалдах шатны шүүх, 3.3 хувь нь хяналтын шүүхийн шүүгчид холбогдуулан гаргасан байна. Судалгааны ганцаарчилсан ярилцлагын явцад захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн зүгээс шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж буй хүчин зүйлд ёс зүйн хороонд тайлбар гаргах, ёс зүйн хорооны хуралд очиж суух нь тодорхой хэмжээгээр ачааллыг нэмэгдүүлдэг гэж хариулсан. Тухайлбал, нэг шүүгч дунджаар 1-2 удаа ёс зүйн хороонд тайлбар гаргадаг боловч энэ нь ачаалал ихтэй үед нэмэлт ачаалал үүсгэдэг гэж үзсэн байна. Эдгээр хүчин зүйл нь салбар шүүхийн чиг үүрэг, ажлын онцлогоос хамаарч байгаа нь тодорхой юм.

Судалгааны хүрээнд шүүгчийн ажлын ачаалал улирлаас хамааран хэрхэн өөрчлөгдөж байгааг тодорхойлох зорилт тавьсан юм. Ингэж үзэхэд, шүүхийн бүхий л салбарын хувьд улирлаас хамааран ачаалал нийтлэг хэлбэлзэл байгаа нь харагдлаа. Судалгаанд оролцсон шүүгчдийн 75-80 хувь нь улирлаас хамаарсан ачаалал байгаа гэжээ. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн ачаалал 6,7,8 саруудад ихээхэн нэмэгддэг, мөн жилийн сүүлээр 12 сард харьцангуй ихэсдэг бол бусад саруудад ачаалал нэмэгдэхгүй жигд байдаг гэжээ. Иргэний хэргийн анхан шатны шүүхийн ачаалал ерөнхийдөө жилийн ихэнхи саруудад ачаалал өндөртэй байдаг гээд тэр дундаа 9,10 сард хамгийн их нэмэгдэж, 5,6,7 саруудад мөн нэмэгдэх хандлагатай болдог байна. Харин захиргааны хэргийн анхан шатны шүүхийн ажлын ачаалал 9,10,11,12 саруудад ихээхэн өндөр байх ба бусад саруудад нэмэгдэхгүй дүр зураг харагдаж байна. Эдгээрт шууд утгаараа шууд байдлаар прокурорын үйл ажиллагаа, шүүгч нарын амралт авах үйл явц зэрэг нь ачааллыг ихэсгэхэд нөлөөлдөг байна.

Шүүгч хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулж буй хугацаа

Шүүгчтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын хүрээнд шүүгчдийн хэргийг шийдвэрлэхэд гүйцэтгэх стандарт үйл ажиллагаануудыг шүүх хуралдааны өмнөх, шүүх хуралдааны үеийн, шүүх хуралдааны дараах гэсэн хүрээнд ангилан шүүгчдээр өөрсдөөр нь нэг бүрчлэн зарцуулж буй хугацааг тодорхойлуулсан юм.

Хүснэгт №46 Шүүхийн стандарт үйл ажиллагаануудын гүйцэтгэхэд зарцуулж буй хугацаа

	Хэрэг шийдвэрлэхэд гүйцэтгэх ажиллагаа	Хугацаа /мин/	Хэрэг шийдвэрлэхэд гүйцэтгэх ажиллагаа	Хугацаа /мин/	Хэрэг шийдвэрлэхэд гүйцэтгэх ажиллагаа	Хугацаа /мин/
1	Хэргийн материалтай танилцах, эрүүгийн хэргийг шүүгч хүлээн авах	300	Хэрэг, нэхэмжлэлтэй танилцах, иргэний хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэх	10	Нэхэмжлэлтэй танилцах	30
2	Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх/урьдчилсан хэлэлцүүлэг	60	Шүүхээс гаргах эрх зүйн акт боловсруулах, хянах, албажуулах	20	Захиргааны хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэх /захирамж гаргах, хянах/	30
3	Шүүхээс гаргах эрх зүйн акт боловсруулах, хянах, албажуулах	180	Хэргийн материалтай дахин танилцах, /хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой нотлох баримт хангалттай цугласан эсэхийг шалгах, дүгнэх/	60	Шүүх хуралдааны бэлтгэл хангах: /хэргийн материалтай танилцах, нотлох баримт судлах/	60
4	Хэргийн материалтай дахин танилцах, /хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой нотлох баримт хангалттай цугласан эсэхийг шалгах, дүгнэх/	180	Шүүх хуралдааныг даргалах	30	Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах	30
5	Шүүх хуралдааныг даргалах	270	Шүүхийн шийдвэр боловсруулах, хянах, албажуулах	60	Нотлох баримт цуглуулах, албан тоот төлөвлөх	30
6	Шүүх шийтгэх тогтоолыг хянах, албажуулах	300	Шүүх хуралдааны тэмдэглэлийг хянах, баталгаажуулах	30	Шүүхээс гаргах эрх зүйн акт боловсруулах, хянах, албажуулах	240
7	Шүүх хуралдааны тэмдэглэлийг хянах, баталгаажуулах	45	Нийт	210	Шүүх хуралдааныг даргалах	60

	Нийт	1335			Шүүх хуралдааныг хойшлуулах	30
					Шүүхийн шийдвэр боловсруулах, хянах, албажуулах	440
					Шүүх хуралдааны тэмдэглэлийг хянах, баталгаажуулах	60
					Нийт	1010

Ийнхүү үйл ажиллагаануудыг гүйцэтгэх хугацааг минутаар илэрхийлэн, улмаар нэг жилд нэг шүүгчид ногдож байгаа хэргийн тоонд тулгуурлан нэг шүүгчийн нэг жилд хэргийг шийдвэрлэхэд зарцуулах ажлын өдрийг тооцоолсон билээ. Ингэж үзэхэд, нийслэл дэх эрүүгийн хэргийн хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч нэг жилд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулж буй хугацаа = 1335 минут (нэг хэргийг шийдвэрлэхэд зарцуулах хугацаа) × 73.4 (нэг эрүүгийн шүүгчид бүтэн жилд ногдож буй эрүүгийн хэрэг) хэрэг = 97989 минут:60минут=1633цаг:8 цаг=204 өдөр болж байна. Өөрөөр хэлбэл дүүргийн эрүүгийн хэргийн нэг шүүгч 73.4 хэргийг ажлын 204 өдөрт шийдвэрлэнэ гэсэн тооцоолол гарч байна. Харин иргэний хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч нэг жилд ИХШХШТХ-ийн 115 дугаар зүйлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулж буй хугацаа= 634 минут (ИХШХШТХ-ийн 115-аар нэг хэргийг шийдэхэд зарцуулах хугацаа) × 166.1 хэрэг (нэг жилд нийт ИХШХШТХ-ийн 115-аар шийдвэрлэсэн хэргийн тоо) =105307 минут:60минут=1755 цаг:8 цаг=219 өдөр болж байна. Эцэст нь, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч нэг жилд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулж буй хугацаа= 2500 минут (ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлээр нэг хэргийг шийдэхэд зарцуулах хугацаа) × 28.6 хэрэг¹⁴⁵ =71500 минут:60минут=1191 цаг:8 цаг=148 өдөр гэсэн тооцоолол бий болжээ.

Хүснэгт №47 Шүүхийн үе шатанд үйл ажиллагааг гүйцэтгэхэд зарцуулж буй хугацаа

Шүүх/Үе шат	Эрүүгийн шүүгч		Иргэний шүүгч		Захиргааны шүүгч	
	Ээдрээ төвөгтэй	Хөнгөн	Ээдрээ төвөгтэй	Хөнгөн	Ээдрээ төвөгтэй	Хөнгөн
Шүүх хуралдааны өмнөх шүүгчийн ажиллагаа	1570	590	925	420	1580	610

¹⁴⁵ 2017 оны байдлаар Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч дунджаар жилд 50.5 хэрэг шийдвэрлэдэг гэж үзвэл үүний 56.7 хувийг тооцсон болно.

Шүүх хуралдааны үеийн шүүгчийн ажиллагаа	1480	378	695	238	825	265
Шүүх хуралдааны дараах шүүгчийн ажиллагаа	408	410	533	176	2100	640
Нийт	3458	1378	2153	834	4505	1515

Ажлын байрны дүр зураг

Энэхүү судалгааны хүрээнд хэрэглэсэн гол аргын нэг бол хронометраж бөгөөд шүүгчийн ажлын ачааллыг тодорхойлох нэг үндсэн арга зам нь ажлын 5 өдрийн туршид сонгон авсан талбаруудад шүүгчийн өдөр тутмын үйл ажиллагааны ажиглалт юм. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч ажлын 5 өдрийн дунджаар өдрийн ажлын цагийн 22% буюу 120.7 минутыг (2 цаг) хэргийн материалтай танилцах, хавтаст хэрэгт түүвэр хийх, урьдчилсан хэлэлцүүлэг хийх зэрэг ажилд, 36% буюу 199.3 минутыг (3 цаг 19 минут) шүүх хуралдаан даргалах болон шүүх хуралдааны бүрэлдэхүүнд ороход зарцуулдаг бол үүний дараагаар өдрийн ажлын цагийн 34% буюу 190.3 минутыг (3 цаг 10 минут) шийтгэх тогтоол бичих, шүүх хуралдааны тэмдэглэл хянах ажлуудад зарцуулдаг байна. Эндээс эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч шүүх хуралдаанаас өмнөх болон шүүх хуралдааны үеийн үйл ажиллагаанд зарцуулах цаг өдөр тутам өндөр байгааг харж болно. Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч ажлын 5 өдрийн дунджаар өдрийн ажлын цагийн 24% буюу 134.9 минутыг (2 цаг 14 минут) хавтаст хэрэгтэй танилцах, шүүхээс гарах эрх зүйн акт боловсруулах зэрэг ажилд, 33% буюу 188.2 минутыг (3 цаг 8 минут) шүүх хуралдаан даргалах болон шүүх хуралдааны бүрэлдэхүүнд ороход зарцуулдаг бол үүний дараагаар өдрийн ажлын цагийн 18% буюу 100.9 минутыг (1 цаг 40 минут) шүүхийн шийдвэр боловсруулах, хянах, албажуулах, шүүх хуралдааны тэмдэглэл хянах, баталгаажуулах ажлуудад зарцуулдаг байна. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч ажлын 5 өдрийн дунджаар 1 өдөрт ажлын цагийн 55% буюу 245.4 минутыг (4 цаг 5 минут) хавтаст хэрэгтэй танилцах, шүүхээс гарах эрх зүйн акт боловсруулах, нотлох баримт цуглуулах зэрэг ажилд, 9% буюу 39.4 минутыг (39 минут) шүүх хуралдаан даргалах болон шүүх хуралдааны бүрэлдэхүүнд ороход зарцуулдаг бол үүний дараагаар өдрийн ажлын цагийн 5% буюу 22.8 минутыг (22 минут) шүүхийн шийдвэр боловсруулах, хянах, албажуулах, шүүх хуралдааны тэмдэглэл хянах, баталгаажуулах ажлуудад зарцуулдаг байна. Эндээс захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч шүүх хуралдаанаас өмнөх үеийн үйл ажиллагаанд цаг хугацаа их зарцуулж буйг харж болно. Гэхдээ, энэ бүхэн нь шүүгч ажлын цагаар ажлын байран дээр хийж гүйцэтгэж байгаа үйл ажиллагаа болон тэдгээрт зарцуулж буй хугацааны дүр зургийг гаргаж байгаа ба шүүгч хүн хэрэг шийдвэрлэх бүхий л үе шатанд гүйцэтгэх ёстой стандарт үйл ажиллагаа дээрх хронометражийн үр дүнд бүрэн дүүрэн гарч ирэхгүй байгаа юм. Энэ нь шүүгч нар тэдгээр ажлуудын багагүй хэсгийг ажлын бус цагаар ажил дээрээ болон гэртээ хийж байгааг давхар нотлон харуулж байна. Мөн энэ нь чанарын судалгааны явцад олсон мэдээллээс тодорхой харагдсан болно.

Хоёр. Анхан шатны шүүхийн шүүгчийн орон тоо, ажлын нормативыг тогтооход харгалзах хүчин зүйлсийн талаарх зөвлөмж

Шүүх, иргэд, олон нийтэд шүүхийн үйлчилгээг бүрэн хүргэхийн тулд шүүхийн нөөцийг буюу шүүгч, шүүгчийн туслах, шүүхийн захиргааны бусад ажилтныг зохистой хуваарилах асуудалтай тулгардаг. Шүүхээр шийдвэрлүүлэхээр ирсэн бүх хэрэг маргааныг шийдвэрлэхэд хэдэн шүүгч, шүүгчийн туслах, шүүхийн захиргааны бусад ажилтан шаардлагатайг тооцоолсноор шүүх, шүүгчийн ажлын ачааллыг нарийвчлан хэмжих боломжтой¹⁴⁶.

Олон улсын практикт шүүгчийн ажлын ачааллыг тооцох, үнэлэхэд дараах гурван уламжлалт аргачлалыг хэрэглэдэг: Тодорхой хэрэг, маргаанд зарцуулж буй минутаар ачаалал тооцох буюу “Хэргийн ачааллаар үнэлэх аргачлал” /*the weighted caseload method*/, Делфи /*Delphi method*/ аргачлал, Норматив аргачлал /*the normative method*/. Тухайн аргачлалын онцлогийг харьцуулан авч үзэхэд дараах онцлог харагддаг.

1. Хэргийн ачааллаар үнэлэх аргачлал нь хэргийг маргааны төрөл, нарийн төвөгтэй байдлаар нь ялгаж, шүүгчийн ижил төсөөтэй хэрэг шийдвэрлэсэн давтамж, зарцуулсан хугацааг тодорхойлсны үндсэн дээр шүүгч тодорхой хэрэг маргаан хянан шийдвэрлэхэд зарцуулсан нийт цагийн нийлбэрийг тооцон гаргадаг. Энэхүү томьёолол нь хэргийн ачааллын үнэлгээг гаргана. Тус аргачлал нь хэргийг нарийн төвөгтэй байдлаар нь жишиж/хэмжсэний үндсэн дээр шүүгчийн ажлын ачааллыг тодорхойлдог боловч практик дээр шүүгчийн гүйцэтгэдэг бусад ажиллагааг тооцон оруулаагүй юм. Түүнчлэн энэхүү аргачлал нь шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас өмнө болон дараа гүйцэтгэсэн ажлыг тооцдоггүйгээрээ шүүгчийн ажлын ачааллыг дутуу үнэлдэг талтай.

Хэргийн ачааллаар үнэлэх аргачлал нь шүүгчийн ажлын ачаалал, шүүхийн нөөцийн хэрэгцээг тодорхойлоход түгээмэл хэрэглэгддэг аргачлал юм¹⁴⁷. Тус аргачлал нь Америкийн нэгдсэн улсад 1970-д оноос хойш хэрэглэгдэж бүрэн хэвшсэн байна. “Мужийн шүүхүүдийн үндэсний төв” нь энэхүү аргачлалын судалгааг 11-н мужид хийсэн бөгөөд 2000 оны байдлаар АНУ-ын 15 муж тус аргачлалаар шүүгчийн ажлын ачааллыг тооцон гаргаж байна¹⁴⁸.

Европын улсуудын хувьд ХБНГУ 1970-д оны эхэн үед хэргийн ачааллын судалгааг анхан болон давж заалдах шатны шүүхүүдэд хийж байсан¹⁴⁹ бөгөөд энэ чиглэлээр нэлээн туршлага хуримтлуулсан нь Нидерланд улс юм¹⁵⁰. Сүүлийн

¹⁴⁶ Cf Wisconsin Director of State Courts Office, Judicial Needs Assessment 2006, Final Report, p.7.

¹⁴⁷ Cf Stenz, “Improving Weighted Caseload Studies in Limited Jurisdiction Courts”, 1988-1989 The Justice System Journal 13, no.3, p.379.

¹⁴⁸ Cf. B.J.Ostrom et al., Florida Delphi based-Weighted Caseload project, History of the Project, 2000, pp.3 et seq.

¹⁴⁹ ‘Richterzeitstudien’ Cf. Bundesrechtsanwaltskammer, Tatsachen zur Reform der Zivilgerichtsbarkeit, Vol.II,1974 pp.60 et seq.; Bundesrechtsanwaltskammer, Tatsachen zur Reform der Zivilgerichtsbarkeit, Vol.I,1974 pp.182 et seq.; G.Griebeling, Die Arbeitszeit des Richters, DRiZ 71pp.228 et seq; R.Zwiesele&R.Bender, ‘Betriebswirtschaftliche Methoden und Vorschläge zur Verbesserung der Justizorganisation’;


¹⁵⁰ R.Depre et al., Etude de faisabilité de la mise en oeuvre d’un instrument de mesure de la charge de travail destinée au siege, p.3.

жилүүдэд “хэргийн ачаалал” нь судалгааны ач холбогдол бүхий сэдэв болж тус сэдвийн хүрээнд олон судалгаа, шинжилгээний ажил хийгдэж байна. Тухайлбал, шүүхийн удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, боловсронгуй болгох үүднээс Бельгийн вант улсын хууль зүйн яамнаас хэргийн ачааллын талаар хэд хэдэн судалгаа хийсэн бол, Швейцари улс мөн сүүлийн жилүүдэд цөөнгүй судалгаа хийжээ. Шүүгчийн ажлын ачааллыг судалж буй дээрх туршлагыг нэгтгэн үзвэл,

1. Судалгаанд хамрагдах шүүх, хэрэг маргааны төрлийг сонгох
2. Тодорхой нэг хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд хийгдэж буй ажиллагааг тодорхойлох
3. Хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд шүүгчийн зарцуулж буй дундаж цагийг тооцоолох
4. Өөр өөр төрлийн хэрэг маргаан хянан шийдвэрлэхэд хийгдэж буй төстэй ажиллагаануудын дундаж цагийг тооцоолох
5. Шүүгчийн ажиллаж буй дундаж цагийг 1 хэрэг, маргаанд зарцуулсан хугацаагаар үржүүлэхэд тодорхой 1 хэрэг маргаан хянан шийдвэрлэх “ажиллагааны ачаалал” гарна
6. Үүссэн хэрэг бүрийг “ажиллагааны ачаалал”-р үржүүлснээр тухайн хэрэгт зарцуулах нийт хугацаа гарна
7. Тодорхой 1 хэргийг хянан шийдвэрлэхэд ногдох шүүгчийн дундаж цагийг тооцно
8. Тодорхой 1 хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулсан нийт хугацааг шүүгчийн ажлын дундаж цагт хуваана

2. Норматив аргачлал¹⁵¹ нь шүүгчийн ажлын ачааллыг тооцоход эдийн засгийн хувьд хамгийн хэмнэлттэй бөгөөд маш энгийн аргын нэг гэж үздэг. Норматив аргачлал нь нэг тойрогт байршилтай шүүхүүдийн хэргийн ачааллыг харьцуулах замаар буюу тухайн тойрог дахь нийт хэргийн тоог нийт шүүгчдийн тоонд хувааж гаргадаг. Ингэснээр нэг шүүгчид оногдох хэргийн тоог ойролцоогоор гаргадаг. Тус аргачлалын сул тал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны **дундаж практик** нь **зохистой практик** гэж тооцоход хүргэдэг нөхцөл байдал юм.

¹⁵¹ Монгол Улсын хувьд шүүгчийн хэргийн ачааллыг энэхүү аргачлал дээр үндэслэн гаргаж байгаа нь харагдаж байна.



Эх сурвалж: Court performance around the world. World bank technical paper No.430

Хүснэгтээс үзэхэд тус аргачлалаар тооцох нь дараах сул талтай. Юуны өмнө тухайн улс орнуудын шүүх тогтолцооны онцлог, шүүхийн үйл явцтай уялдаатай бөгөөд харилцан адилгүй байдаг. Тэрчлэн хүн амын тоо, гэмт хэргийн статистикийн өсөлт зэрэг нь шүүхийн ажлын ачааллыг нэмэгдүүлдэг болох нь харагдаж байна.

3. Делфи аргачлал нь шүүгчийн ажлын ачааллыг тооцохдоо тухайн салбарын шинжээч, мэргэжилтэн /шүүгч болон хуулийн салбарын бусад мэргэжилтэн/ нарын санал дээр үндэслэн өөр өөр төрлийн хэрэг, маргаанд зарцуулагдах дундаж хугацааг тооцон гаргадаг. Тус аргачлалаар шүүгчийн ажлын цагийг урьдчилан тооцоолон гаргаснаар шүүхийн нөөцийн хэрэгцээг тодорхойлдог. “Делфи” аргачлал нь “Хэргийн ачааллаар үнэлэх” аргачлалтай төстэй боловч шүүгчийн ажлын ачааллын үнэлгээ нь субъектив бөгөөд зорилтот бүлгийн тодорхой туршлагаас хэт хамааралтай байдаг сул талтай.

Дээрх гурван аргачлал нь шүүхийн хэргийн ачаалал шүүгчийн ажлын ачаалалд хэрхэн хамаарч буй тоон үзүүлэлтийн харилцан уялдааг гаргаснаар шүүхүүдэд шүүгчийн ажлын ачааллыг үнэлэхэд хэрэглэгддэг үндсэн хэмжүүр болдог ач холбогдолтой байна. Хэдий тийм боловч эдгээр аргачлал нь шүүгчийн ажлын ачааллыг бүрэн хэмжээгээр хангалттай тооцоолох аргачлал болдоггүй. Тухайлбал, шүүгчийн хэрэг үүсгэхээс өмнөх, шүүхийн шийдвэрийн дараах болон шүүгчийн гүйцэтгэдэг бусад ажлыг тэр бүр тооцоолдоггүй байна.

АНУ-ын Холбооны болон мужийн шүүхүүд шүүх, болон шүүгчийн ажлын ачааллыг тооцоолохдоо тухайн мужийн нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, өмгөөлөгчдийн тоо, шүүгчийн ажил үүргийн шаардлагаар өөр муж, газруудад явахад зарцуулсан хугацаа зэргийг харгалзан үзэж тухайн муж бүрийн онцлогт тохируулан дээрх гурван аргачлал дээр үндэслэсэн *Hybrid буюу Холимог* аргачлал боловсруулсан байдаг.

Дээрх гурван уламжлалт арга дээр суурилан, Монгол Улсын шүүх институцийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачааллыг холимог аргачлалаар тооцсон үр дүн бол энэхүү судалгааны тайлан, дүгнэлт, санал

зөвлөмж болно. Энэхүү аргачлалын хүрээнд дараах таван хүчин зүйлсийг харгалзан шүүгчийн ажлын ачааллыг тооцох нь зүйтэй байна.

1. Хэргийг хянан шийдвэрлэж буй шүүгчийн хэрэг үүсгэхээс өмнөх, хэрэг үүсгэсний дараах буюу тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд гүйцэтгэж буй бүхий л ажиллагааг тооцсон;
2. Шүүх хуралдааны **хугацаа** ба **чанарыг** ажлын байрны зураг авалтад тулгуурлан харьцуулан тооцсон;
3. Шүүгчийн жилд ажиллаж буй дундаж цаг.¹⁵²
4. Нэг жилд шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэсэн нийт тоог тооцсон;
5. Тухайн анхан шатны шүүхэд ажиллаж буй шүүгчдийн тоо;

Дурдсан хүчин зүйлсийн эхний 2 хүчин зүйлс өмгөөлөгчийн үйл ажиллагаа, прокурорын үүрэг, хариуцлага, хэргийн зохигч болон нэхэмжлэгчийн зан хандлага, эрх зүйн соёл, хууль шүүхийн мэдлэгээс ихээхэн хамаардаг хувьсах хүчин зүйлс болно.

Дараагийн бүлэг хүчин зүйлс бол шүүгчийн шүүхийн шийдвэр бичиглэх, гаргах шууд хэлэхэд шүүгчийн бүтээгдэхүүн үйл явцтай уялдаатай хүчин зүйлс болно.

Анхан шатны шүүхийн шүүгчийн орон тоо, ажлын нормативыг тогтоох хүчин зүйлсийг тухайн судалгааны үр дүнд тулгуурлан тогтоож болох талаар дараах санал зөвлөмжийг дэвшүүлж байна.

- Эрүү, иргэн, захиргааны анхан шатны шүүхийн хувьд аль алинд нь ачаалал их байгааг харгалзаж, наад зах нь УИХ-аас тогтоосон шүүхийн ажиллавал зохих орон тоонд хүргэж ажиллуулах, мөн шүүгчийн орон тоог нэмэгдүүлэх, иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн орон тоог 40 хүртэл хувиар нэмэгдүүлэх шаардлага байна.
- Шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж буй хүчин зүйлд Шүүхийн ёс зүйн хороонд тайлбар гаргах асуудал хамаарч байна. Иймээс тухайн хэрэг хянан шийдвэрлэгдэж дуусаагүй үед тухайн хэрэгтэй холбоотой гомдлыг талууд гаргах нь шүүгчийн сэтгэлзүйд нөлөөлөх, улмаар шүүгчид шүүгчийн хараат бус байдлыг хөндөж байгаа эсэхэд цаашид анхаарах шаардлагатай.
- Судалгааны явцад шүүгч нарын зүгээс ажлын ачааллыг нэмэгдүүлж буй хүчин зүйлд шүүгчийн туслах, шүүхийн нарийн бичгийн даргын ажлын байрны тогтвор суурьшил ба ур чадвар нөлөөлдөг гэж үзсэн. Энэ нь тухайн ажилтны цалин нийгмийн баталгаатай холбогдох учраас эдгээр ажилтны орон тоо, цалин, нийгмийн баталгааг хангахад анхаарах шаардлагатай.

¹⁵² National Council of Juvenile and Family courts, Juvenile and Family Court Journal 64, no.2, Spring, 2013

- Шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлэхэд хэргийн оролцогч талуудаас нотлох баримт гаргаж өгөхгүй байх ажиллагаа нөлөөлж байна. Иймээс хэргийн оролцогч буюу талуудаас нотлох баримтыг хуульд заасан хугацаанд гаргаж өгөхгүй байгаа байдалд анхаарал хандуулж, хууль тогтоомжийг боловсронгуй болгоход анхаарах шаардлагатай.
- Шүүгчийн ажлын ачаалалд хэргийн оролцогч талуудаас шүүх хуралдааныг хойшлуулах байдлаар ачааллыг нэмэгдүүлж байна. Иймээс ШЕЗ-өөс тухайн асуудлыг нарийвчлан судлах шаардлагатай.
- Судалгааны явцад шүүгчийн ачаалал төдийгүй, шүүхийн туслах, нарийн бичгийн ажлын ачааллын асуудал давхар хөндөгдөж буйтай холбоотойгоор ажлын ачааллын судалгааг цаашид бусад шүүхийн тамгын газрын нэгжүүд дээр хийвэл зохино.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачааллын хувьд:

- Судалгаанд хамрагдсан 6 дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны нэг шүүгчид 73.4 хэргийг шийдвэрлэхэд 229 өдөр зарцуулж байгаа хэвийн ачаалалтайг судалгаа харуулж байгаа, мөн эрүүгийн хэргийн шүүгчид жилд 75 хэрэг шийдвэрлэхэд ачаалал хэвийн байна гэснээс үзвэл Монгол улсын хэмжээнд нэг эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч 75 хэрэг шийдвэрлэдэг байхаар ажлын ачааллын норматив тогтоох боломжтой байна.
- Судалгаанд хамрагдсан 6 дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид ногдох хэргийн тоо харилцан адилгүй байгаа тул ажлын ачааллыг тэнцвэржүүлж аль болох нэг шүүгчид 75 хэрэг ногдох байдлаар ачааллыг хуваарилах шаардлагатай.

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачааллын хувьд:

- Судалгаанд хамрагдсан 6 дүүргийн иргэний хэргийн анхан шатны нэг шүүгчид 310 хэргийг шийдвэрлэхэд 323 өдөр зарцуулж байгаа нь ачаалал харьцангуй ихтэйг харуулж байна. Шүүгч жилд 230 өдөр ажиллана гэж үзвэл 93 өдрөөр ажлын ачаалал илүү байгаа бөгөөд үүнийг ажлын өдөр болон амралтын өдөр ажиллаж нөхөж байна. Илүү ажиллаж буй 93 өдөр нь ажлын 744 цаг болж байгаа бөгөөд шүүгч жилд 1840 цаг ажиллах ёстой гэж үзвэл 40 хувиар илүү ачаалалтай ажиллаж байна.
- Иймд шүүгчийн орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай байгаа ба тухайлбал 6 дүүрэгт шүүгчийн орон тоог 31-ээр нэмэгдүүлэх тооцоолол гарч байна.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачааллын хувьд:

- Монгол Улсын Их Хурлын 2016 оны 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 20 орон тооны шүүгч ажиллахаар баталсан боловч өнөөг хүртэл 5 шүүгчийн орон

тоо дутуу ажиллаж байна. Иймээс тус шүүхэд батлагдсан орон тооны шүүгчийг дээрх тогтоолд заасны дагуу томилох; Шүүгчийн орон тоо дутуу байгаатай холбоотойгоор шүүгч нарт улирлаас хамаарсан ачаалал үүсч байгаа тул энэхүү ачааллыг бууруулахын тулд дээр дурдсан шүүгчийн орон тоог нэмэх талаар анхаарах шаардлагатай.

- Судалгаанд хамрагдсан орон нутгийн шүүхүүд Төв болон Өвөрхангай аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчидтэй харьцуулахад харьцангуй ачаалал багатай байгаад дүн шинжилгээ хийж, Улаанбаатар хот болон орон нутгийн шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэхэд анхаарах.



ЛАВЛАГАА



**ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ШҮҮГЧ ӨӨРИЙН
ДОТООД ИТГЭЛ ҮНЭМШЛИЙГ ТАЛУУДАД ИЛ БОЛГОХ ХЭРЭГЦЭЭ
ШААРДЛАГА: ЯПОН УЛСЫН ЖИШЭЭН ДЭЭР¹⁵³**

Оршил

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь талуудын санаачилга, хүсэлтэд тулгуурлаж явагдана. Шүүгч төвийг сахисан, шударга байх зарчмын дагуу шударга, төвч царай гаргаж (Poker face), хэргийн талаарх өөрийн дотоод итгэл үнэмшлийг талуудад ил болгохгүй байх, ийнхүү ил болгох нь шүүхийн шийдвэрээр хязгаарлагдана гэсэн үзэл хандлага давамгайл байсаар ирсэн. Гэтэл сүүлийн жилүүдэд хэргийг үнэн зөв, шуурхай шийдэх, эрх зүйн маргаантай харилцаа, маргааны зүйлийг зөв олж тогтоох, талуудыг эвлэрүүлэхэд шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлийг талуудад ил болгох нь зайлшгүй чухал гэж үзэх болсон байна.

Манай улсын хувьд энэ талаарх шүүхийн практик нэг мөр болж төлөвшөөгүй, энэ сэдвийн чиглэлийн судалгааны бүтээл ч ховор байна. Иймд энэхүү өгүүллээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шүүгчийн дотоод итгэл үнэмшлийг ил болгох талаар онол, практик харьцангуй сайн төлөвшсөн Япон улсын жишээн дээр тус асуудлыг товч авч үзэж, танилцуулахыг зорив.

Нэг. Шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлийг талуудад ил болгох талаарх онолын үзэл хандлага

Уламжлалт хандлагаар шүүгч шударга, төвийг сахих зарчмын дагуу хэргийн талаарх өөрийн дотоод итгэл үнэмшлийг талуудад ил болгох нь зөвхөн шүүхийн шийдвэрээр хязгаарлагдана гэж үздэг байв. Гэтэл сүүлийн жилүүдэд иргэний хэрэг, маргааныг үнэн зөв, зүй зохистой шийдвэрлэхийн тулд шүүх талуудын байр суурийг сайтар сонсож, тэдэнтэй хамт тухайн хэргийн талаар нэгдсэн ойлголтод хүрэх нь чухал бөгөөд үүний тулд аль болох өөрийн дотоод итгэл үнэмшлийг талуудад ил болгох нь зүйтэй гэсэн үзэл хандлага гарч ирсэн юм. Онолын үүднээс шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлийг талуудад ил болгохыг идэвхтэй буюу дэмжих, идэвхгүй буюу шүүмжлэлт гэсэн 2 хандлага байдаг¹⁵⁴.

1.1. Идэвхтэй буюу дэмжих хандлага

Уг хандлага нь шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлийг талуудад ил болгохыг дараах үндэслэлээр зөвтгөдөг байна¹⁵⁵. Үүнд:

1-рт шүүхийн шатан дахь эвлэрлийг хөхүүлэн дэмжихэд ач холбогдолтой гэж үздэг. Өөрөөр хэлбэл шүүгч хэрэгт цугларсан нотлох баримтыг шинжлэн судалсны дараа тухайн хэргийг хэрхэн шийдвэрлэх талаарх өөрийн дотоод итгэл үнэмшлийг талуудад ил болгох нь талуудын хувьд тухайн хэрэгт ялах, ялагдах баттай таамаглалыг бий болгох тул энэ нь эргээд талуудын хооронд эвлэрэл амжилттай болох түлхэц болдог байна.

¹⁵³ Энэхүү лавлагааг Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судлаач-багш Б.Хонгорзул /LL.M/ боловсруулсан болно.

¹⁵⁴ Ясүи Фүкүока их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш "Шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлийг ил болгох хэрэгцээ шаардлага: Нотлох үүргийг хөнгөвчлөх үед ил болгох дотоод итгэл үнэмшил" 4-р тал.

¹⁵⁵ 1-р ишлэлийн 5-р тал.

2-рт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч болон талууд маргааны зүйлийн талаар нэгдмэл ойлголттой байх нь нотлох баримт шинжлэн судлах ажиллагаа үр дүнтэй болох, шүүхийн шийдвэр үнэн зөв гарахад ач холбогдолтой тул шүүгч маргааны зүйлийг хэрхэн ойлгож байгаа талаарх өөрийн үзэл бодлыг талуудтай хуваалцаж, харилцан ойлголцох нь чухал байдаг.

3-рт шүүгч хэргийн нөхцөл байдлыг зөв тогтоохын тулд зохимжит арга хэлбэрээр урьдчилан өөрийн дотоод итгэл үнэмшлийг талуудад ил болгож, талуудад ойлголтын зөрүүгээ засах боломж олгосноор шүүгчид хэргийн нөхцөл байдлын талаарх итгэл үнэмшил зөв бүрэлдэж, үүний үр дүнд үнэн зөв шийдвэр гаргах боломжтой болох юм.

Мөн ийнхүү шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн талаарх өөрийн дотоод итгэл үнэмшлийг талуудад ил болгох нь шүүгч болон талуудын хооронд зөв харилцаа үүсэх нэг арга тул энэ нь талуудад маш ойлгомжтой, тодорхой байх шаардлагатай байдаг байна.

1.2. Идэвхгүй буюу шүүмжлэлт хандлага

Харин шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлийг талуудад ил болгоход шүүмжлэлттэй ханддаг байр сууринаас харахад шүүгч нь шударга, төвийг сахисан байх шаардлагатай тул үргэлж Poker face царай гаргах ёстой гэж үздэг байна. Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөрийн дотоод итгэл үнэмшлийг ил болгосноор талуудын эсэргүүцлийг бий болгох эрсдэлтэй, өмгөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн хэрэг хэрхэн шийдвэрлэгдэх талаар ойлголт, төсөөлөлттэй болсон байх тул шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлийг ил болгох нь тийм ч үр дүнтэй биш. Мөн шүүгч талуудыг эвлэрүүлэхийн тулд тухайн хэргийн талаарх өөрийн дотоод итгэл үнэмшлийг талуудад ил болгож, тодорхой нэгэн эвлэрлийн санал гаргах нь талуудад өөрийн үзэл бодлыг тулгасан гэх эрсдэлд хүргэх аюултай бөгөөд эвлэрэл амжилтгүй болбол шүүгч өөрийн ил болгосон дотоод итгэл үнэмшилдээ баригдан, чөлөөтэй шийдвэр гаргахад нь хүндрэл учирч болзошгүй гэж үздэг байна.¹⁵⁶

Хоёр. Шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлийг талуудад ил болгохын ач холбогдол

Ач холбогдол нь дараах 2 зүйлд оршиж байна. Үүнд: 1-рт тухайн хэргийн маргааны зүйлийг зөв олж тогтоох, 2-рт талуудыг эвлэрүүлэхэд ач тустай юм.¹⁵⁷

2.1. Маргааны зүйлийг тогтоох

Талуудын шаардлага болон татгалзлын үндэслэл болох тайлбараас шууд маргааны зүйл тогтоогдохгүй тул нотолгооны ач холбогдол багатай, хэрэгт хамааралгүй маргааны зүйлийг хасч, нотолгооны өндөр ач холбогдолтой, хэрэгт хамааралтай маргааны зүйлийг олж тогтоох нь чухал юм. Үүний тулд 1-рт талууд болон шүүгч нар маргааны зүйлийн талаар нэгдмэл ойлголттой байх нь чухал тул маргааны зүйлийн талаарх шүүгч өөрийн үзэл бодлыг илэрхийлэх, 2-рт хууль тайлбарлах, тайлбар гаргах, нотлох үүргийн хуваарилалт, хууль зүйн асуудлаар талуудын байр суурь зөрчилтэй байх тохиолдолд шүүгч өөрийн байр суурийг илэрхийлснээр тэдний хооронд нэгдмэл ойлголт бий болж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа зөв зохистой үргэлжлэх, 3-рт нотлох баримт

¹⁵⁶ 1-р ишлэлийн 6-р тал.

¹⁵⁷ 1-р ишлэлийн 7-р тал.

шинжлэн судлах ажиллагаанд шүүгч нотолбол зохих нөхцөл байдлын талаар өөрийн ойлголт, шийдвэрийг ил болгох гэсэн 3 хүчин зүйл үүнд хамаардаг.

2.2. Талуудыг эвлэрүүлэх

Нотлох баримт шинжлэн судалсны дараах талуудад ил болгох шүүгчийн дотоод итгэл үнэмшил нь шүүхийн шийдвэрийг урьдчилан танилцуулж буйтай бараг ижил тул талуудыг эвлэрүүлэхэд түлхэц болдог байна. Үүнтэй холбоотойгоор шүүгч талуудад эвлэрлийн санал гаргаж, талуудыг эвлэрүүлэхэд талуудаас шүүгчид хэргийн талаарх өөрийн дотоод итгэл үнэмшлийг ил болгохыг шаардах эрхтэй гэсэн үзэл хандлага гарсан. Ингэснээр талууд урьдчилан таамаглагдаж буй шүүхийн шийдвэртэй, эвлэрлийн саналыг харьцуулах байдлаар шийдвэрээ гаргах боломжтой болох юм. Иймд шүүгч талуудыг эвлэрүүлэхийн тулд ил болгож буй дотоод итгэл үнэмшил нь талуудыг зөвхөн шаардсан үед л хязгаарлагдах бөгөөд зохигч талуудын эрх байхаар зохицуулах нь зүйтэй гэж үздэг байна.

Гурав. Шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлийг талуудад ил болгоход анхаарах зүйлс

Шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлийг талуудад ил болгохдоо түүнийг хэрхэн илэрхийлж, хүргэх вэ гэдэг дээр анхаарах ёстой. Өөрөөр хэлбэл шүүгчийн дотоод итгэл үнэмшлээ илэрхийлж буй үг хэллэг тодорхой, ойлгомжтой байх, яагаад ийм дотоод итгэл үнэмшил төрсөн талаарх үндэслэлээ тайлбарлах, дотоод итгэл үнэмшлийг талуудад ил болгож буй зорилгоо хэрхэн зөв оновчтой тайлбарлахаас хамаарч тэр нь талуудад зөвөөр ойлгогдох үндэс бүрддэг байна.¹⁵⁸

Мөн шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлийг талуудад ил болгохын өмнө түүний агуулгыг тодорхой болгох шаардлагатай.¹⁵⁹ Тодорхойлбол дотоод итгэл үнэмшлийн объект (маргааны зүйлийг тодорхойлохтой холбоотой шүүгчийн байр суурь, хууль зүйн холбогдолтой асуудлын талаарх шүүгчийн байр суурь, нотолгоо шаардлагатай хэргийн нөхцөл байдлын талаарх шүүгчийн байр суурь уу гэдгийг тодорхой болгох), тухайн объектоо хэрхэн үнэлж дүгнэж байгаа болох (маргаантай нөхцөл байдлыг зөв тодруулсан эсэх, хэрэглэгдэх хэм хэмжээний сонголт, агуулга, зөв оновчтой байдал) тухайн объектын талаарх дотоод итгэл үнэмшлийн баттай түвшин зэрэг нь тодорхой байх ёстой.

Шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлийг талуудад ил болгохдоо урьдчилсан шинжтэй гэдгийг онцолсноор талуудын эсэргүүцэл болон тэдний тайлбар үндэслэл хэт тэлэхээс сэргийлэх талтай ч илэрхийлэл нь ойлгомжгүй болох магадлалтай байдаг байна. Мөн яагаад ийм дотоод итгэл үнэмшил төрсөн тухай үндэслэл, түүнийг ил болгож буй зорилгоо тайлбарлахгүйгээр дүгнэлт байдлаар өөрийн дотоод итгэл үнэмшлийг илэрхийлэх нь талуудад энэ ямар үндэслэл, шалтгаанаар ил болж буй шүүгчийн байр суурь болох талаар талууд зохистой шийдвэр, дүгнэлт гаргаж чадахгүйд хүргэдэг аж.

Дөрөв. Монгол Улсын нөхцөл байдал

Дээр авч үзсэн Япон улсын туршлага, судалгаан дээр үндэслэн манай улсад эрх зүйн маргаантай харилцаа, маргааны зүйлийг олж тогтоох, талуудыг эвлэрүүлэхэд шүүгч

¹⁵⁸ Яао "Маргааны зүйлийг тогтооход шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлийг ил болгох тухай: Шүүгчийн дотоод итгэл үнэмшил яагаад талуудад хүрэхэд бэрхшээлтэй байдаг вэ?" 161-р тал.

¹⁵⁹ 5-р ишлэлийн 162-р тал.

өөрийн дотоод итгэл үнэмшлийг талуудад ил болгож буй эсэхийг холбогдох шүүхийн статистик, баримтаас судлан үзье.

2015 онд хяналтын шатны шүүх 1155 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэснээс шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан нь 103 хэрэг буюу 9 хувийг, 2016 онд 1469 хэрэг шийдсэнээс мөн шалтгаанаар буцаасан нь 177 хэрэг буюу 12 хувийг, 2017 онд 1704 хэрэг шийдсэнээс адил шалтгаанаар буцаасан нь 196 хэрэг буюу 11.5 хувийг тус тус эзэлсэн үзүүлэлттэй байна. Хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан хэд хэдэн үндэслэл шалтгаан байх боловч түүний дотроос анхаарал татахуйц дараах 2 шалтгаан байна. Үүнд нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл тодорхой бус байснаас эрх зүйн харилцаа тодорхой бус болсон /2015 онд 19.4 хувь, 2016 онд 21 хувь/ эрх зүйн харилцааг буруу тодорхойлсон, хууль буруу хэрэглэсэн /2015 онд 18.4 хувь, 2016 онд 17 хувь/ гэх шалтгаан юм.

Эдгээр нөхцөл шалтгаан шүүхийн практикт тогтмол ажиглагдаж байгаагаас улбаалан Улсын дээд шүүхээс “Эрх зүйн маргаантай харилцааг тогтоох, хуулийн холбогдох зохицуулалтыг зөв тайлбарлан хэрэглэх шүүгчийн ажиллагаа” гэсэн зөвлөмж хүртэл гаргажээ. Тус зөвлөмжид зохигчдын хоорондох маргаан ямар харилцаанаас үүссэн болохыг зөв тогтоохгүйгээр маргааны зүйл тодорхой бус болохоос гадна маргааны зохицуулсан хуулийн холбогдох зүйл заалтыг шүүх оновчтой хэрэглэж чадахгүй тул шүүхийн шийдвэр нэг талаас үндэслэл бүхий болохгүй, нөгөө талаас хууль ёсны байх хуулийн шаардлагад нийцэхгүй юм.¹⁶⁰ Энэ утгаар шийдвэр, магадлалын хүчингүй болж, өөрчлөгдөх үндсэн шалтгаан болж буй эрх зүйн маргаантай харилцааг буруу тогтоох, улмаар тухайн харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээг тохируулан хэрэглэхгүй байх асуудалд онцгой анхаарал хандуулах нь чухал гээд эрх зүйн маргаантай харилцаа, маргааны зүйл, хэргийн нөхцөл байдал гэж юу болохыг тодорхойлж өгчээ.

Дээрхээс үзэхэд эрх зүйн маргаантай харилцаа, маргааны зүйлийг зөв тогтооход шүүх төдийлөн идэвх санаачилга гаргахгүй байгаа нь ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл шүүх нэхэмжлэлийн шаардлага, үндэслэлийг зөв тодруулах, тухайн маргаанд хөндөгдөж буй эрх зүйн харилцаа, талуудын хоорондох маргааны зүйлийг зөв тогтоохын тулд талуудын тайлбар, үндэслэл, мэтгэлцээнийг сайтар сонсох, ойлгомжгүй асуудлыг тухай бүр нь талуудаас тодруулах, хэргийн нөхцөл байдлын талаарх өөрийн ойлголтыг талуудад илэрхийлэх замаар талууд болон шүүгчид хэргийн талаар нэгдсэн ойлголтод хүрэх нь чухал бөгөөд үүнд шүүгчийн тодруулах асуулт, дотоод итгэл үнэмшлийн илэрхийлэл тун ач холбогдолтой юм.

Гэвч манай шүүхийн практикт шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад буюу ялангуяа эрх зүйн маргаантай харилцаа, маргааны зүйлийг зөв тогтооход өөрийн дотоод итгэл үнэмшлийг /хэргийн талаарх өөрийн үзэл бодол, байр суурь/ ил болгох талаар нэгдсэн ойлголт байхгүй, практик ч нэг мөр болон төлөвшөөгүй байна. Мөн энэ чиглэлийн онолын судалгаа ч нарийн хийгдээгүй байна.

Мөн нөгөө талаас жил бүрийн шүүхийн статистикаас харахад хялбаршуулсан журмаар буюу ИХШХШТХ-ийн 74-р зүйлээр шийдсэн хэргийн тоо 30-35 хувийг эзэлдэг¹⁶¹ бөгөөд үүн дотроос нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, биелүүлсэн зэрэг нэг талын буултаас гадна 2 талын

¹⁶⁰“Эрх зүйн маргаантай харилцааг тогтоох, хуулийн холбогдох зохицуулалтыг зөв тайлбарлан хэрэглэх шүүгчийн ажиллагаа” Улсын дээд шүүхийн зөвлөмжийн 2016 оны дугаар №2-ийн 1-р тал.

¹⁶¹ Шүүхийн ерөнхий зөвлөл “Шүүн таслах ажиллагааны нэгдсэн тайлан” 2015, 2016, 2017 он.

хоорондын харилцан тохиролцоо, эвлэрлээр шийдэгдсэн хэргийн тоон үзүүлэлтийг мэдэх боломжгүй байдаг. Үүнээс шалтгаалаад талуудыг эвлэрүүлэхэд шүүгч эвлэрэх боломжтой эсэхийг сануулахаас гадна өөрийн зүгээс талуудыг эвлэрүүлэхийн тулд талуудтай уулзаж ярилцах, эвлэрлийн санал гаргах зэрэг арга хэмжээ авдаг шүүгч хэр байдаг эсэхийг мэдэх боломж тааруу байдаг. Шүүхийн ажлын ачааллаас шалтгаалаад энэ чиглэлийн арга хэмжээ авдаг шүүгч ч цөөн байдаг нь дамжиггүй бөгөөд шүүгч төвийг сахисан, шударга байдлын зарчмын дагуу өөрөө талуудыг эвлэрүүлэхээс илүүтэйгээр шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын туслалцаа авахыг санал болгодог болов уу /Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд энэ талаар зохицуулсан байдаг/.

Гэтэл шүүхийн статистикаас үзэхэд хэрэг үүсгэсний дараах эвлэрүүлэн зуучлалын хэрэглээ жилд 300 орчим хэргээр хязгаарлагдах бөгөөд эвлэрэл амжилттай болсон нь тун бага байна.¹⁶² Энэ нь талууд эвлэрүүлэн зуучлалын талаарх мэдлэг ойлголт дутуу, хэрэг хянан шийдвэрлэх шат дамжлага нэмэгдэж бидэнд чирэгдэл үүсгэж байна гэж ойлгодогтой холбоотой байж болох юм.

Энэ тохиолдолд шүүгч эвлэрүүлэн зуучлалын ач холбогдлын талаар талуудад тайлбарлан таниулах чиг үүргээ сайн биелүүлэхээс гадна хэргийг эвлэрүүлэн зуучлалд шилжүүлж, эвлэрүүлэн зуучлагч тухайн хэргийг эхнээс нь судалж, ойлгох хугацаа авахгүйн үүднээс Япон улсын туршлагатай нэгэн адилаар хэргийн нөхцөл байдлыг хамгийн сайн ойлгож байгаагийн хувьд өөрөө талуудад эвлэрлийн санал гаргах нь илүү шуурхай бөгөөд эвлэрэл амжилттай болох магадлал өндөр юм. Гэхдээ мэдээж төвийг сахисан, хөндлөнгийн байр сууриа алдахгүй байх, тухайн эвлэрлийн санал нь шүүхийн эцсийн шийдвэрээс илүү талуудад ач тустай байх зэргийг харгалзан үзэх нь зүйтэй. Эвлэрлийн санал гаргах нь шүүгч талуудад дотоод итгэл үнэмшлээ ил болгож буй нэг хэлбэр бөгөөд талууд ч мөн адил хэрэв эвлэрэхийг хүсвэл Японы туршлагын нэгэн адил тухайн хэргийн талаарх шүүгчийн байр суурийг сонсохыг шаардах нь зөв шийдвэр гаргахад нь нөлөөтэй байна.

Дүгнэлт

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь зохигчийн санаачилга буюу хүсэлтийн үндсэн дээр явагдах буюу диспозитив зарчим, талуудын тэгш эрхт мэтгэлцээн дээр буюу мэтгэлцэх зарчимд тулгуурладаг. Шүүгчид төвийг сахисан, шударга байх зарчим үйлчилдэг. Иймд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд талууд идэвх санаачилгатай оролцоно. Шүүгч бол төвийг сахисан, шударга байх зарчмын үүднээс шударга, төвч царай гарган сууна. Хэргийн талаарх дотоод итгэл үнэмшлийг зөвхөн шүүхийн шийдвэртээ тусгах замаар илэрхийлнэ гэсэн энэ ойлголт өнөө цагт өөрчлөгдөж байгааг Япон улсын жишээнээс харж болно. Өөрөөр хэлбэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад буюу эрх зүйн маргаантай харилцаа, маргааны зүйлийг зөв тогтоох, талуудыг эвлэрүүлэх үед шүүгч нь хэргийн талаарх өөрийн дотоод итгэл үнэмшлийг талуудад ил болгох нь хэрэг үнэн зөв, шуурхай шийдэгдэхэд ач тустай байна.

Харин манай улсын хувьд шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөрийн дотоод итгэл үнэмшлийг ил болгох нь зөв зүйтэй эсэх, ил болгох нь зөв гэж үзвэл шүүгчийн төвийг сахисан, шударга байдлын зарчмыг зөрчилгүйгээр хэрхэн зөвөөр талуудад өөрийн дотоод итгэл үнэмшлийг ил болгох талаар практик нэг мөр болон төлөвшөөгүй болох нь шүүхийн статистик, холбогдох баримт бичгээс ажиглагдав. Энэ

¹⁶² Шүүхийн ерөнхий зөвлөл "Шүүн таслах ажиллагааны нэгдсэн тайлан" 2015, 2016, 2017 он.

талын судалгааны бүтээл ч мөн ховор байна. Иймд энэхүү өгүүллээр шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлийг талуудад ил болгох хэрэгцээ шаардлага, ач холбогдол, мөн анхаарах зүйлсийг Япон улсын жишээн дээр товч авч үзэж, танилцуулахыг зорив. Цаашид энэ талын судалгаа шинжилгээг гүнзгийрүүлбэл Монгол Улсад зөв практик төлөвшин тогтоход тустай гэж үзэж байна.



ШҮҮГЧИЙГ ТОМИЛОЛТООР АЖИЛЛУУЛАХ ЗОРИЛГО, НӨХЦӨЛИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЭХ СУРВАЛЖ, СТАНДАРТ БОЛОН БУСАД УЛСЫН ТУРШЛАГА¹⁶³

Нэг.Шүүхийн бие даасан байдлын тухай НҮБ-ын 1985 оны зарчим¹⁶⁴

НҮБ-ын “Шүүхийн бие даасан байдлын тухай” 1985 оны зарчмын 11-14 дэх хэсэгт шүүгчийн бүрэн эрхийн нөхцөл, баталгааг тусгасан. Ингэхдээ тус зарчмын 14 дэх хэсэгт “Тухайн шүүх дотор шүүгчид хэрэг хуваарилах нь шүүхийн захиргааны дотоод асуудал байна” гэж¹⁶⁵, 13 дахь хэсэгт “Шүүгчийг дэмжих тогтолцоо нь бодит хүчин зүйлс, ялангуяа ур чадвар, шударга байдал, туршлагад үндэслэх ёстой” гэж заасан.¹⁶⁶ Түүнчлэн тус зарчмын 7 дахь хэсэгт “Шүүх эрх мэдлийн байгууллага чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх нь НҮБ-ын гишүүн улсын үүрэг мөн” гэж заасан.¹⁶⁷

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2018.01.15-ны өдрийн 01 дүгээр тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсан “Шүүгч томиллолтоор ажиллах нийтлэг журам”-ын 2.1-т эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүн таслах ажиллагааг хуульд заасан дэг журам, хугацааны дагуу явуулах нөхцөлийг бүрдүүлэх, шүүхийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор шүүгчтэй зөвшилцсөний үндсэн дээр түүний гаргасан хүсэлтийн дагуу 1-3 сарын хугацаанд адил шатны шүүхэд томиллолтоор ажиллуулж болох талаар заасан. Мөн шүүгчийн цалин хөлс, баталгааг хэвээр хадгалах, алдагдуулахгүй байх талаар тус журмын 2.9-т, томиллолтоор ажиллах хугацааг зөвхөн нэг удаа 1-3 сарын хугацаагаар сунгах талаар тус журмын 2.8-д тус тус заасан байна.¹⁶⁸ Мөн тус журмын 2.2-т зааснаар анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчээс ирүүлсэн шүүгчийг томиллолтоор авч ажиллуулах саналыг шийдвэрлэхэд 1/ Хөдөлмөрийн тухай хуулийн 104, 106 дугаар зүйлийн дагуу шүүгч чөлөө авсан, 2/ хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүгч урт хугацаагаар чөлөө авсан, 3/ шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлсэн, 4/ нэг шүүгчид ногдох хэргийн дундаж ачаалал, 5/ бусад зайлшгүй шаардлагыг үндэслэхээр зохицуулсан байна.

Энэ нь шүүгчийг томиллолтоор ажиллуулах талаарх Монгол Улсын зохицуулалт нь НҮБ-ын “Шүүхийн бие даасан байдлын тухай” 1985 оны зарчмын 7, 13, 14 дэх хэсэгт заасан нөхцөлийг хангасан бөгөөд шүүхээс шүүн таслах үйл ажиллагааны чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэх нөхцөлийг хангахад шууд чиглэсэн болохыг харуулж байна.

¹⁶³ Энэхүү лавлагааг ШСМСХ-гийн судлаач Л.Галбаатар бэлтгэв.

¹⁶⁴ Basic Principles on the Independence of the Judiciary /Adopted by the Seventh United Nations Congress on the Prevention of Crime and the Treatment of Offenders held at Milan from 26 August to 6 September 1985 and endorsed by General Assembly resolutions 40/32 of 29 November 1985 and 40/146 of 13 December 1985/ <http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/IndependenceJudiciary.aspx>

¹⁶⁵ 14. The assignment of cases to judges within the court to which they belong is an internal matter of judicial administration.

¹⁶⁶ 13. Promotion of judges, wherever such a system exists, should be based on objective factors, in particular ability, integrity and experience.

¹⁶⁷ 7. It is the duty of each Member State to provide adequate resources to enable the judiciary to properly perform its functions.

¹⁶⁸ Шүүгч томиллолтоор ажиллах нийтлэг журам <http://www.judcouncil.mn/main/6804--.html>

Хоёр. Европын шүүхийн зөвлөлийн сүлжээний зөвлөмж /ENCJ/

2.1. “Уян хатан шүүхийн талаарх Парисын тунхаг”

Европын шүүхийн зөвлөлийн сүлжээнээс /European Network of Councils for the Judiciary/ 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр Парис хотноо баталсан “Уян хатан шүүхийн талаарх Парисын тунхаг”-ын 9 дэх хэсэгт “Шүүхийн бүх үйл ажиллагаа өндөр чанартай байх нөхцөлийг Шүүхийн зөвлөл нь бүрдүүлж, дэмжиж ажиллах хэрэгтэй” гэж заасан.¹⁶⁹

Шүүгчийг томилолтоор ажиллуулах нь эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагааг доголдуулахгүй байх буюу чанартай байлгахтай шууд холбоотой болохын хувьд эрх зүйт ёсыг хангах талаарх тэргүүлэх байгууллага болох Европын шүүхийн зөвлөлийн сүлжээний зөвлөмжтэй нийцэж буйг харуулж байна.

2.2. “Өнөөгийн эдийн засгийн уур амьсгал дахь шүүх эрх мэдлийн байгууллагад учрах сорилт, боломжийн талаарх Вильнюсийн тунхаг”

Түүнчлэн Европын шүүхийн зөвлөлийн сүлжээнээс 2011 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Вильнюс хотноо баталсан “Өнөөгийн эдийн засгийн уур амьсгал дахь шүүх эрх мэдлийн байгууллагад учрах сорилт, боломжийн талаарх Вильнюсийн тунхаг”-ын 1 дэх зөвлөмжид “Шүүхийн ажиллах хүч эдийн засгийн хямралд өртөх нөлөөллийг бууруулах буюу тэрхүү хямралаас сэргийлэхийн тулд хүний нөөцийг дахин хуваарилах, тэрхүү нөлөөлөлд хамгийн их өртсөн шүүхийг бэхжүүлэх түр зуурын тусгай арга хэмжээ болон зохион байгуулалтын арга хэмжээ авах ёстой” гэж заасан.¹⁷⁰

Шүүгчийг томилолтоор ажиллуулах нөхцөл нь шүүхийн төсөв, орон тооны хүртээмжгүй байдлаас болж шүүн таслах үйл ажиллагаа доголдохоос сэргийлэхтэй холбоотой тул “Өнөөгийн эдийн засгийн уур амьсгал дахь шүүх эрх мэдлийн байгууллагад учрах сорилт, боломжийн талаарх Вильнюсийн тунхаг”-ын холбогдох зөвлөмжид нийцэж байна.

Гурав.Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн зөвлөмж /CCEJ/

3.1. 10 дугаар зөвлөмж

Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлөөс 2007 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Страсбург баталсан 10 дугаар зөвлөмжийн 48 дахь хэсэгт “Шүүхийн бие даасан байдлыг хангах онцгой асуудлын нэг нь ... шүүгчийг дэмжих үйл

¹⁶⁹ The Paris Declaration on resilient justice /European Network of Councils for the Judiciary – ENCJ/ https://www.ency.eu/images/stories/pdf/GA/Paris/enci_paris_declaration_adopted_ga.pdf

¹⁷⁰ Vilnius Declaration on Challenges and Opportunities for the Judiciary in the Current Economic Climate /European Network of Councils for the Judiciary – ENCJ/ https://www.ency.eu/images/stories/pdf/opinions/enci_vilnius_declaration_final_10_june_2011.pdf

ажиллагааг хууль тогтоох, гүйцэтгэх байгууллага бус шүүхийн зөвлөл бие даан хэрэгжүүлэх нь илүү тохиромжтой” гэж заасан.¹⁷¹

Монгол Улсын хувьд ихэвчлэн орон нутагт буй шүүгчийг нийслэл дэх шүүхүүдэд томилолтоор ажиллуулж буй бөгөөд орон нутаг дахь шүүгчдийн шүүн таслах үйл ажиллагааны ур чадварыг дэмжих нэг арга хэлбэр юм.

3.2. 15 дугаар зөвлөмж

Мөн Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлөөс 2012 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Парис хотноо баталсан “Мэргэшсэн буюу дагнасан шүүгчийн тухай” 15 дугаар зөвлөмжийн “vi” хэсэгт “Зарчмын хувьд ерөнхий чиг үүргийн шүүгч болон мэргэшсэн шүүгч нь тэгш байдалтай байна”, “x” хэсэгт “шүүхийн зөвлөл буюу түүнтэй адилтгах байгууллага нь бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэхдээ ерөнхий чиг үүргийн шүүгч болон мэргэшсэн шүүгчид адил тэгш хандана” гэж тус тус заасан.¹⁷²

Ийнхүү зөвлөмж гаргах үндэслэлээ Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлөөс 47-49, 51 дэх дэд хэсэгт тайлбарласан байна. Тодруулбал, 47 дахь дэд хэсэгт “Шүүгчийг мэргэшүүлэх, шүүхийг дагнуулах нь олон давуу талтай хэдий ч шүүхэд ирэх хэргийн тоо маш бага байх, шүүгч тус бүрийн ачаалал харилцан адилгүй байх зэрэг эрсдэлтэй. Энэхүү эрсдэлийг шийдвэрлэх хүчин зүйл нь шүүх, шүүгчдийг иргэдэд ойртуулах буюу шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх явдал мөн” гэжээ.

“Шүүгч томилолтоор ажиллах нийтлэг журам”-д шүүгчтэй зөвшилцсөний үндсэн дээр түүний гаргасан хүсэлтийн дагуу 1-3 сарын хугацаанд адил шатны шүүхэд томилолтоор ажиллуулж болох талаар заасан нь ерөнхий чиг үүргийн шүүгч болон мэргэшсэн шүүгчид ялгамжтай бус, адил тэгш хандсан гэж үзэх нөхцөл юм. Тодруулбал, сум дундын шүүхийн шүүгчийг эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхэд, эдгээр шүүхийн шүүгчийг сум дундын шүүхэд томилолтоор ажиллуулах боломжтой тул “Шүүгч томилолтоор ажиллах нийтлэг журам” нь Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн “Мэргэшсэн буюу дагнасан шүүгчийн тухай” 15 дугаар зөвлөмжийн холбогдох хэсэгтэй нийцэж байна.

Дөрөв.Гадаадын зарим улс дахь шүүгчийг томилолтоор ажиллуулах зохицуулалт

“Дэлхийн шударга ёсны төсөл”-өөс тухай бүр “Эрх зүйт ёсны индексийн тайлан”-г 113 улсыг хамруулан 3000 гаруй шинжээчийн оролцоотойгоор гаргадаг. 2017-2018 оны “Эрх зүйт ёсны индексийн тайлан”-гийн үзүүлэлтээр эхний 20 байрт

¹⁷¹ Opinion no.10(2007) of the Consultative Council of European Judges (CCJE). Strasbourg, 23 November 2007 <https://rm.coe.int/168074779b>

¹⁷²Opinion (2012) No. 15 of the Consultative Council of European Judges on the Specialisation of Judges adopted at the 13th plenary meeting of the CCJE (Paris, 5-6 November 2012) <https://rm.coe.int/16807477d9>

орсон улсын төлөөллөөс сонгон авч¹⁷³, тэдгээр улс дахь шүүгчийг томиллоор ажиллуулах зохицуулалтыг энд танилцуулж байна.

4.1. АНУ-ын зарим муж улсын зохицуулалт

АНУ-ын Пенсилвани муж улсад шүүгчийг томиллоор буюу түр зуур шилжүүлэн ажиллуулах нөхцөлийг 1966 онд Дээд шүүхээс батлагдаж, хүчин төгөлдөр болсон 701 дүгээр дүрмээр тодорхой зохицуулсан байна.¹⁷⁴ Тодруулбал, даргалагч шүүгч нь тухайн шүүхэд нэмэлт шүүгч хэрэгцээтэй болсон бол энэ тухай итгэмжлэлээ шүүхийн туслах ажилтнаар дамжуулан албан хүсэлтийн хамт Шүүхийн тамгын газарт гаргана. Хүсэлтийг бичгээр үйлдэж, цахим хэлбэрээр дамжуулна. Хүсэлтийг Ерөнхий шүүгч захирамж гарган шийдвэрлэх бөгөөд энэхүү захирамжийг цахим хэлбэрээр Пенсилвани муж улсын Шүүхийн захиргаанд дамжуулна. Үүний дараа тус захирамжийг Шүүхийн захиргаанаас Дээд шүүхэд уламжилна. Томиллоор ажиллуулах хугацаа нь томиллоор ажиллуулах захирамжид өөрөөр заагаагүй бол томиллоор ажиллаж буй шүүгч албан үүргээ гүйцэтгэж дуусах буюу томиллоор ажиллуулах хугацаа дуусах хүртэл үргэлжилнэ.

Харин Мичиган муж улсын хувьд, Мужийн шүүхийн Администраторын бичгээр гаргасан зөвшөөрөлд тусгайлан заагаагүй бол, зөвхөн Мужийн шүүхийн Администратор, түүний орлогч Администратор болон Бүсийн Администратор шүүгчийг томиллоор ажиллуулахыг зөвшөөрөх эрхтэй.¹⁷⁵

Мөн Миннесота муж улсын хувьд, тус муж улсын Шүүхийн дүрмийн 63.04 дэх хэсэгт зааснаар шүүгч ашиг сонирхлын зөрчилтэй буюу тухайн хэрэгт татгалзсан бөгөөд түүнийг орлох өөр шүүгч байхгүй тохиолдолд энэ тухай холбогдох мэдэгдэл хүлээн авсны дараа ерөнхий шүүгч нь тухайн шүүхийн шүүгчийг өөр дүүргийн шүүхэд томиллоор ажиллуулж болно. Томиллоор ажиллах шүүгч нь шүүх хуралдааныг даргална. Шүүгчийг томиллоор ажиллуулах хүртэл тухайн шүүх хуралдааныг хойшлуулна.¹⁷⁶

4.2. Австрали улсын зохицуулалт

Австрали улсын “Шударга шүүхэд хандах” тухай 2010 оны хуулийн 22а, 22b хэсэгт шүүгчийг томиллоор ажиллуулах талаар зохицуулсан байна.¹⁷⁷ Ингэхдээ шүүгчийг давж заалдах, хяналтын шат болон ердийн шүүхэд Ерөнхий захирагч /Governor-General/ томилно. Хэрэв ерөнхий шүүгч, ерөнхий шүүгчийн орлогч, захиргааны хэргийн шүүгч нь давж заалдах, хяналтын шатанд давж заалдах шатны шүүгчээр томиллоор ажиллаагүй бол Ерөнхий захирагч тэрхүү шүүгчийг

¹⁷³ Rule of Law around the World: Scores & Rankings. WJP Rule of Law Index 2017–2018. p.16-17 https://worldjusticeproject.org/sites/default/files/documents/WJP_ROLI_2017-18_Online-Edition_0.pdf

¹⁷⁴ Assignment and Transfer of Judges <https://www.pacode.com/secure/data/201/chapter7/s701.html>

¹⁷⁵ Judicial Assignment Procedures. State Court Administrative Office. Revised June 2016

<http://courts.mi.gov/Administration/SCAO/Resources/Documents/standards/Assign%20Procedures.pdf>

¹⁷⁶ Minnesota Court Rules. Civil Procedure- Rule 63.Disability or Disqualification of Judge; Notice to Remove; Assignment of a Judge. https://www.revisor.mn.gov/court_rules/rule.php?type=cp&id=63

¹⁷⁷ Access to Justice (Family Court Restructure and Other Measures) Bill 2010 <https://www.legislation.gov.au/Details/C2010B0015>

давж заалдах шатны шүүгчээр ажиллуулахаар томилж болно. Мөн ердийн шүүхэд томилолтоор ажиллаагүй захиргааны хэргийн шүүхийн шүүгчийг ердийн шүүхэд Ерөнхий захирагч томилолтоор ажиллуулахаар шийдвэрлэж болно. Ингэхдээ давж заалдах шатны шүүхийн шүүгчийн тооноос хэтрэхээр бол тухайн шүүгчийг давж заалдах шатны шүүхэд томилолтоор ажиллуулж болохгүй.

Үүнээс гадна шүүгчийг томилох комисс нь тухайн шүүгчийг тодорхой газар нутагт томилолтоор ажиллуулахаар шийдвэрлэж болно. Ингэхдээ ерөнхий прокурор болон ерөнхий шүүгч зөвшөөрөөгүй тохиолдолд шүүгчийг өөр нутаг дэвсгэрт томилолтоор ажиллуулж болохгүй. Мөн шүүгчийн зөвшөөрөөгүй байршилд тухайн шүүгчийг томилолтоор ажиллуулж болохгүй.



ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮГЧИЙН ТОДРУУЛАХ ЭРХИЙН ТУХАЙ ЯПОН УЛСЫН ТУРШЛАГА¹⁷⁸

НЭГ. ОРШИЛ

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа талуудын санаачилга буюу хүсэлтийн үндсэн дээр явагдах бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэх, төгсгөх талаар талууд бие дааж шийдвэрлэх эрхтэй гэсэн диспозитив зарчим үйлчилдэг¹⁷⁹. Мөн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нэхэмжлэгч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч нэхэмжлэлийн шаардлага, маргааны үйл баримт, хариуцагчийн гэм бурууг нотолж, түүний татгалзлыг үгүйсгэх, хариуцагч түүний өмгөөлөгч нь нэхэмжлэлийн шаардлагыг татгалзах, түүнийхээ үндэслэлийг нотлох үүргийг хүлээх мэтгэлцэх зарчимд тулгуурладаг¹⁸⁰. Мэтгэлцэх зарчмаар талууд нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй.

Ийнхүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг талуудад даалгадаг нь иргэний процессын ерөнхий зарчим боловч шүүгч шударга, төвийг сахисан байдал, талуудын тэгш байдлын зарчмыг зөрчилгүйгээр талуудын тайлбар, үндэслэл, хэргийн үйл баримт, нотолгоотой холбоотой тодруулах асуулт талуудад тавих, хэрэг хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримт хангалттай бүрдээгүй байна гэж үзвэл дутуу байгаа нотлох баримтыг бүрдүүлэх талаар талуудад хэлж сануулах, тайлбар хийх нь тухайн хэргийг үнэн зөв, шуурхай шийдвэрлэхэд ач холбогдолтой.

Гэвч энэ талаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой зохицуулалт байхгүй бөгөөд практик ч төлөвшөөгүй байна. Өгүүлэгч нь 2017 оны 10 дугаар сард Багануур, Багахангай, Налайх дүүргээс бусад нийслэлийн иргэний хэргийн анхан шатны 6 дүүргийн тодорхой тооны шүүгчдийн дунд анкетын судалгаа явуулсан. Судалгааны үр дүнгээс харахад “Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шаардлагатай нотлох баримт бүрдээгүй байна гэж үзвэл дутуу байгаа нотлох баримтыг гаргаж өгөхийг талуудад хэлж сануулдаг уу?” гэсэн асуултад хариулсан 21 шүүгчийн 13 нь үгүй гээд иргэний хэргийн шүүгчид ийм эрх байхгүй. Нотлох баримт гаргах, цуглуулах нь талуудын үүрэг бөгөөд шүүгч төвийг сахисан байр суурийг хадгалан, цугларсан нотлох баримтын хүрээнд шийдвэрээ гаргана. Шүүгч нь өөрийн хүсэл зоригоор нотлох баримт бүрдүүлэх нь хууль бус гэж хариулсан.

Харин 8 шүүгч нь тийм гээд нотлох баримт гаргасан эсэхийг шүүгчийн туслахаар дамжуулан нягтална. Шүүгчийн шударга, төвийг сахисан байдалд харшлахааргүй хэмжээнд сануулж болно. Талуудын эрх, үүргийг тайлбарлах

¹⁷⁸ Энэхүү лавлагааг Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судлаач-багш Б.Хонгорзул /LL.M/ боловсруулсан болно.

¹⁷⁹ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах зарчим, иргэний хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаа, цаашид анхаарах асуудал “Монгол Улсын Дээд шүүхийн зөвлөмж дугаар 1”, 2017 он

¹⁸⁰ Мөн тэнд

замаар сануулна. Талуудаас шаардлага болон татгалзлаа хэрхэн яаж нотолж байгааг нь лавлан асууна. Талуудад өөрсдийн тайлбар, үндэслэлийг нотлох үүрэгтэй болохыг тайлбарлаж өгнө гэж хариулснаас үзэхэд хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой тодруулга асуулт, тайлбарын талаар нэгдсэн үзэл баримтлал шүүгчдийн дунд байхгүй байгаа нь ажиглагдсан юм.

Энэ талаар Японы Иргэний процессын хуульд тодорхой заасан байх бөгөөд шүүхийн жишиг, онолын тайлбарт ч үүнийг дэмжсэн байх ба мэтгэлцэх зарчмыг зөрчих бус түүний дутагдалтай талыг нөхөх ач холбогдолтой гэж үздэг байна. Иймд энэхүү лавлагаагаар шүүгчийн тодруулах эрхийн тухай тус орны хууль эрх зүйн зохицуулалт, тэдгээрийн тайлбарыг товч танилцуулж байна.

ХОЁР. ЯПОН УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БОЛОН ОНОЛЫН ТАЙЛБАР

2.1. Шүүгчийн тодруулах эрхийн ач холбогдол

Шүүгч нь шүүх хуралдаан болон шүүх хуралдаанаас гадуур хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой харилцааг тодруулах үүднээс хэргийн үйл баримт болон хууль зүйн асуудлаар зохигч талуудад асуулт тавьж, нотолбол зохих хэргийн үйл баримтыг зохигч талуудад сануулж болох тухай Японы Иргэний процессын хуулийн 149.1, 149.2-т заасныг шүүгчийн тодруулах эрх гэж нэрлэдэг ба шүүгчийн үүрэг ч гэж ойлгодог. Учир нь энэ эрхийг зохистой хэрэгжүүлснээр мэтгэлцэх зарчмын дутагдалтай талыг залруулж, зохистой, шударга шүүн таслах ажиллагааг явуулах нь шүүхийн үүрэг гэж үздэг тул шүүх энэ үүргээ биелүүлэхгүй байснаар дээд шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл бий болох юм /Японы Иргэний процессын хуулийн 312.3, , 325.1, 325.2, 318.1/.

Энэ зохицуулалтын зорилгыг шүүхийн жишигт “Мэтгэлцэх зарчмын дутагдалтай талыг залруулах, эрх зүйн харилцааг тодорхой болгох, хэргийн бодит үнэнийг шүүн тунгааж, үнэн зөвөөр шийдэхэд оршино” гэж үзээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц, хэрэгт холбогдох нотлох баримтаас харахад шаардах эрхийн үндэслэлийг зөв тогтоож, түүнийг хангах урьдчилсан нөхцөлүүдийг зөв нотолбол нэхэмжлэгчийн шаардлагыг хүлээн зөвшөөрч, талуудын хоорондох маргааныг шийдвэрлэх боломжтой байтал нэхэмжлэгч зөв тайлбар гаргахгүй байх, мөн зөв тайлбар гаргахгүй байгаа нь илтэд нэхэмжлэгчийн буруу ойлголт, анхааралгүй байдалтай холбоотой гэж үзэхээр бол түүнийг нь шүүх нэхэмжлэгчид тайлбарлаж ойлгуулж өгөх нь зөв гэсэн шүүхийн шийдвэр хүртэл гарч байжээ¹⁸¹.

Харин онолын тайлбарт 1. Хэргийн бодит үнэнд нийцсэн зохистой шийдвэр гаргах, 2. Талуудын тэгш байдлыг хангах зарчмыг хэрэгжүүлэх, 3. Шүүх болон талуудын мэдээллийн ялгаатай байдал болон талуудын хоорондох хүчний

¹⁸¹ 伊藤真・山本和彦[編]『民事訴訟法の争点』(有斐閣、2009年)、164頁。Ито Макото, Ямамото Казухико “Иргэний процессын эрх зүйн онолын асуудлууд” (Юүхикаку хэвлэлийн газар, 2009 он), 164-р тал

тэнцвэргүй байдлыг нөхөх зорилготой гэж үздэг байна¹⁸². Товчхондоо энэ зохицуулалт нь мэтгэлцэх зарчмын дутагдалтай талыг залруулах, түүнийг нөхөх зорилготой юм.

Талууд шүүгчийн асуултад хариулах хуулиар олгогдсон үүрэг байхгүй боловч хариулахгүй байснаар өөрийн тайлбар болон нотолгоо шүүгчид зөвөөр ойлгогдохгүй байх магадлалтай бөгөөд шаардлагатай тайлбарыг хийгээгүй тохиолдолд уг тайлбартай холбоотой гаргасан нотлох баримт үнэлэгдэхгүй байх боломжтой юм /Японы Иргэний процессын хуулийн 157.2/.

2.2. Тодруулах эрхийг хэрэгжүүлэх хэлбэр

Бүрэлдэхүүнтэй шүүх хуралдаанд даргалагч шүүгч асуулт тавих /Японы Иргэний процессын хуулийн 149.1/ бөгөөд бусад шүүгч даргалагч шүүгчид мэдэгдсэнээр асуулт тавьж болно /Японы Иргэний процессын хуулийн 149.2/.

Шүүх хуралдаанаас гадуур шүүх энэ эрхийг хэрэгжүүлж болох бөгөөд /Японы Иргэний процессын хуулийн 149.1/ талуудын тайлбар, нотолгооны аргад өөрчлөлт орохуйц чухал зүйлийн талаар тодруулга хийхдээ түүний агуулгыг эсрэг талд мэдэгдэх ёстой /Японы Иргэний процессын хуулийн 149.4/. Ингэснээр эсрэг тал хариу тайлбар гаргахад шаардлагатай бэлтгэлийг хангах боломжтой болох юм. Шүүх хуралдаанаас гадуур шүүгч энэ эрхээ хэрэгжүүлэхдээ шүүгчийн туслахаар дамжуулах бөгөөд тодруулах асуултын агуулгын талаар тэмдэглэл үйлдэх ёстой /Японы Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмын 63.1, 63.2/.

2.3. Тодруулах эрхийг хэрэгжүүлэх хүрээ, хязгаар

Шүүхийн тодруулах эрх нь дараах үндсэн 2 төрөл байна¹⁸³. Үүнд 1. Талуудын тайлбар, үндэслэл тодорхойгүй, ойлгомжгүй, зөрчилдөөнтэй байгаа тохиолдолд шүүх түүнийг нь тодруулж, залруулах /Идэвхгүй буюу нөхөх хэлбэрийн тодруулга/, 2. Талуудын тайлбар, үндэслэл дэх хэргийн үйл баримтын тухай мэдүүлэг нь тохиромжгүй, оновчтой биш байх эсхүл талууд тохиромжтой, оновчтой тайлбар, үндэслэлийг гаргахгүй байх тохиолдолд шүүх түүнийг нь хэлж, залруулах /Идэвхтэй буюу залруулах хэлбэрийн тодруулга/. Идэвхгүй хэлбэрийн тодруулгыг хийхгүй байх нь хууль зөрчсөн хэрэг болох боловч идэвхтэй хэлбэрийн тодруулгыг хийхгүй байх нь хууль зөрчсөн хэрэг болох эсэхийг тухайн хэргийн нөхцөл байдал, талуудын эрх ашгийг харгалзан үзсэнээр шийддэг байна¹⁸⁴.

Тодруулбал 1. Ялах ялагдах магадлал (шүүгч оновчтой тодруулга, тайлбар хийснээр талуудын ялах, ялагдахад нөлөө үзүүлж, шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт чухал өөрчлөлт орох магадлал өндөр байгаа тохиолдолд шүүгчийг

¹⁸² 東京弁護士会民事訴訟問題等特別委員会[編]『民事訴訟代理人の実務Ⅱ争点整理』(青木書院、2011年)、247頁。Токиогийн Өмгөөлөгчдийн холбооны дэргэдэх Иргэний процессын эрх зүйн асуудлыг судлах тусгай хороо "Иргэний хэргийн өмгөөлөгчийн практик 2 Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг" (Аоки хэвлэлийн газар, 2011 он), 247-р тал

¹⁸³ 2-р ишлэлийн 248-р тал

¹⁸⁴ 2-р ишлэлийн 249-р тал

тодруулга, тайлбар хийх үүрэгтэй байсан гэж үзнэ), 2. Талуудын тайлбар, мэдүүлгийн эрх зүйн үндэслэлийн ойлгомжгүй байдал (талуудын тайлбар болон нотлох баримтаар тодорхой болсон тухайн хэргийн үйл баримтаас харахад шаардах эрхийн үндэслэлийг зөв сонгоогүй, хэрэглэх ёстой материаллаг эрх зүйн хэм хэмжээний талаар шүүгч болон талуудын хооронд зөрүүтэй байдал байвал түүнийг засаж залруулахын тулд шүүгчийг тодруулга, тайлбар хийх үүрэгтэй байсан гэж үзнэ), 3. Найдлага тавих боломж (шүүхээс тодруулга, тайлбар хийхгүй бол талууд оновчтой тайлбар, үндэслэл, нотолгоог гаргаж чадахааргүй бол шүүгчийг тодруулга, тайлбар хийх үүрэгтэй байсан гэж үзнэ), 4. Талуудын тэгш байдал (холбогдох нөхцөл байдлыг тодруулах нь талуудын тэгш байдалд илтэд сөрөг нөлөөтэй бол шүүгчийг тодруулга, тайлбар хийх үүрэггүй байсан гэж үзнэ), 5. Бусад нөхцөл (шүүгч идэвхтэй хэлбэрийн тодруулга, тайлбар хийснээр тухайн хэргийг шийдвэрлэж, дахин маргаан гарахаас сэргийлвэл шүүгчийн энэ үүргийг хүлээн зөвшөөрнө. Харин эсрэгээрээ шүүгч тодруулга, тайлбар хийснээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг илтэд удаашруулах тохиолдолд шүүгчийн энэ үүргийг хүлээн зөвшөөрөхгүй) гэсэн хүчин зүйлсийг харгалзан үзэж, шүүгч идэвхтэй хэлбэрийн тодруулга, тайлбар хийх үүрэгтэй байсан эсэхийг шийднэ¹⁸⁵.

Мөн шүүх тодруулга, тайлбар хийх эрхээ хэтрүүлсэн тохиолдолд талууд гомдол гаргах, тодорхой тохиолдолд шүүхийн шийдвэрээр тайлбарыг хэрэгсэхгүй болгох боломжтой /Японы Иргэний процессын хуулийн 150-р зүйл/. Гэвч ерөнхийдөө шүүх эрхээ хэтрүүлсэн тохиолдолд хууль бус хэмээн шийдвэрийг нь хүчингүй болгох, шүүхийн тодруулга, тайлбарт хариулсан талуудын тайлбар, мэдүүлгийг хууль бус, хүчингүй гэж үзэх нь практикт ховор байна¹⁸⁶.

2.4. Шүүгчийн тодруулах эрхийн эсрэг шүүмжлэлт хандлага

Дээр өгүүлсэнчлэн шүүхийн жишигт шүүгчийн тодруулах эрхийг харьцангуй өргөнөөр хүлээн зөвшөөрч, хэрэгжилтийнх нь хүрээ хязгаарын талаар тодорхой үнэлэх хэмжүүр байхгүй байхад практикт түгээмэл ашиглаж байгааг шүүмжлэх хандлага байдаг¹⁸⁷. Өөрөөр хэлбэл шүүх талуудыг хэт удирдан чиглүүлж байгаа бөгөөд энэ нь талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдан чиглүүлэх зарчимд харшилж байна гэсэн хандлага байдаг.

Нөгөөтээгүүр өмгөөлөгч нар өөрсдийн тайлбар, үндэслэлд хэргийн бусад нөхцөл байдалтай зөрчилдөх нөхцөл байдал тогтоогдох эсхүл нэгэнт тогтсон шүүхийн жишигтэй зөрчилдөх тайлбар, үндэслэл байвал түүнийг шүүх сануулах төдий байхаас түүнийг давсан тайлбар, дүгнэлт хийх нь зохисгүй юм гэсэн хандлага ч байдаг¹⁸⁸. Гэвч мөн энэ хандлагын эсрэг бүхнийг талуудын санал санаачилга, хариуцлагад тохоох нь хэр оновчтой эсэх, бодит байдалд хэрэг хянан

¹⁸⁵ 2-р ишлэлийн 249-р тал

¹⁸⁶ 2-р ишлэлийн 250-р тал

¹⁸⁷ 2-р ишлэлийн 251-р тал

¹⁸⁸ 2-р ишлэлийн 252-р тал

шийдвэрлэх ажиллагаанд өндөр хариуцлага, санаачилгатай оролцож чадах зохигчид хэр байдаг билээ гэсэн эсрэг байр суурь ч байдаг¹⁸⁹.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Манай улс Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд диспозитив болон мэтгэлцэх зарчмын үзэл санааг тусгасан бөгөөд энэ зарчмаар талууд шаардлага болон татгалзлынхаа үндэслэлийг нотолж, нотлох баримтыг шүүхэд гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй.

Гэтэл практикт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд талууд тайлбар, үндэслэлээ цэгцтэй, ойлгомжтой илэрхийлэх, шаардлага, татгалзлынхаа хууль зүйн үндэслэлийг зөв тодорхойлох, хэрэгт ач холбогдол бүхий, шаардлагатай нотлох баримтыг гаргаж өгөх тал дээр учир дутагдалтай тал байдаг бөгөөд шүүх энэ алдаа дутагдлыг нь хэлж сануулах, тайлбарлах нь хэргийн үйл баримтыг зөв тогтоох, хэргийг үнэн зөв, шуурхай шийдэх, талуудын тэгш байдлыг (нэг тал зөвхөн өмгөөлөгчтэй байгаа тохиолдолд) хангахад тустай. Өөрөөр хэлбэл шүүх энэ эрх (үүрэг)-ийг хэрэгжүүлснээр мэтгэлцэх зарчмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зөвхөн талуудад даатгаснаар гарах дутагдлыг залруулах боломжтой байж болох бөгөөд энэ талаар дэлгэрүүлэн судлах, Монгол Улсын иргэний процесст нийцэх эсэхийг сайтар тунгаах хэрэгцээ байхыг үгүйсгэхгүй юм.

Ингэснээр цаашид иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэтгэлцэх зарчим, талуудын тэгш байдлыг хангах зарчим, шүүгчийн төвийг сахисан, шударга байх зарчимд харшлахгүйгээр шүүгчийн тодруулах эрхийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тусгах хэрэгцээ шаардлагыг илрүүлж, оновчтой хуульчилбал энэ талаарх шүүхийн практик нэг мөр болж, төлөвшихөд ач холбогдолтой гэж үзэж байна.

¹⁸⁹ 遠藤ほか・〈座談会〉争点整理(下)・11頁〔垣内優介発言〕, Эндо “Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн тухай хурлын материал”-ын 11-р тал Какиүчи Юүсүкэгийн хэлсэн үгнээс дам ишлэв.

**“БАРЬЦАА АВАХ” ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТ, ОНЦЛОГ¹⁹⁰**

Нэг. Монгол Улсын эрх зүйн зохицуулалт, уламжлал

2017.05.15-ны өдөр батлагдаж, 2017.07.01-ний өдрөөс эхлэн үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “барьцаа авах” таслан сэргийлэх арга хэмжээг тусгасан. Энэ нь 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд “эд хөрөнгө барьцаалах”, 1963 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд “хөрөнгө барьцаалах” гэж нэрлэгдсэн таслан сэргийлэх арга хэмжээг уламжлан авсан зохицуулалт болжээ.¹⁹¹ Энэхүү таслан сэргийлэх арга хэмжээ авах нөхцөл, онцлог зохицуулалтыг дараах хэсэгт авч үзэв.

1.1. Эрүүгийн процессын хуулийн зохицуулалт /Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль; Эрүүгийн байцаан шийтгэх хууль/

Дараах хүснэгтэд “барьцаа авах” таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх нөхцөл, зохицуулалтыг 1963, 2002, 2017 оны Эрүүгийн процессын хуулийн хүрээнд харьцуулав.

Хүснэгт 1. Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээний уламжлал, шинэчлэл

№	Нөхцөл	1963 оны ЭБШХ	2002 оны ЭБШХ	2017 оны ЭХХШТХ
1	Зорилго	мөрдөн байцаагч, прокурор, шүүхээс дуудсан цагт саадгүй ирж байх /97/	хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхээс дуудсан цагт саадгүй ирж байх /67.1/	шүүх, прокурорын дуудсан цагт ирэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх /14.6-5/
2	Барьцааны зүйл	бэлэн мөнгө буюу бусад үнэ бүхий зүйл /97/	мөнгө, бусад үнэ бүхий зүйл /67.1/	мөнгө /14.6/
3	Барьцааны хэмжээ	байгууллага, барьцаа өгөгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр хэргийн байдалд тохируулан тогтооно /97/	гэмт хэргийн ангилал болон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хувийн болон эд хөрөнгийн байдлыг харгалзан тогтооно /67.3/	яллагдагчийн холбогдсон гэмт хэргийн шинж, хувийн байдлыг харгалзан тогтооно /14.6-4/
4	Барьцаа өгөх этгээд	яллагдагч өөрөө, эсхүл бусад хүн, байгууллага /97/	сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө, эсхүл бусад хүн, байгууллага /67.1/	яллагдагч өөрөө, эсхүл бусад хүн, хуулийн этгээд /14.6/. Үүнд төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн

¹⁹⁰ Тус лавлагааг ШСМСХ-гийн судлаач Л.Галбаатар гүйцэтгэв.

¹⁹¹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2017/: 14.1, 14.6, 14.8, 11.10(2)

Эрүүгийн байцаан шийтгэх хууль /2002/: 62.1.3, 67.1-67.4

Эрүүгийн байцаан шийтгэх хууль /1963/: 87, 97, 316

Хүснэгт 1. Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээний уламжлал, шинэчлэл

№	Нөхцөл	1963 оны ЭБШХ	2002 оны ЭБШХ	2017 оны ЭХХШТХ
				оролцоотой хуулийн этгээд хамаарахгүй
5	Барьцааны зүйлийг хүлээн авах	уг арга хэмжээ авч байгаа байгууллагын дансанд шилжүүлэх /97/	тусгай дансанд шилжүүлэх буюу бэлнээр авах /67.1/	тусгай дансанд байршуулна /14.6, 14.7/
6	Барьцааны зүйлийг буцаан олгох/шилжүүлэх нөхцөл	цаашид хэрэглэх шаардлагагүй болсон /99/	гэмт хэргийн ангилал болон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хувийн байдлыг харгалзана /70.1/	эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгосон, эсхүл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон
7	Зөрчсөнөөс үүсэх үр дагавар	барьцаанд өгсөн зүйлийг шүүгчийн захирамжаар улсын орлого болгоно.	барьцаалсан эд хөрөнгийг шүүгчийн захирамжаар улсын орлого болгоно /67.4/	цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ болгон өөрчилж, барьцааг улсын орлого болгох /14.8/
8	Үйлдэх баримт	барьцаа авсан тухай протокол үйлдэж, хуулбарыг барьцаа өгөгчид гардуулна /97/	эд хөрөнгө барьцаалсан тухай баримт үйлдэж, хуулбарыг барьцаа өгөгчид болон ТСАХ авагдаж байгаа этгээдэд гардуулна /67.2/	гүйлгээний баримтыг тэмдэглэлд хавсаргах ба баримтын хуулбарыг яллагдагч, барьцаа гаргагчид өгнө. /14.7/

1.2. Шүүхийн ерөнхий зөвлөлийн баталсан журмын зохицуулалт

2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зохицуулалттай уялдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2014.01.10-ны өдрийн “Эд мөрийн баримт болон барьцааны мөнгө, үнэ бүхий зүйлийг шийдвэрлэх журам батлах тухай” 03 дугаар тогтоолын 5 дахь хэсэгт “Барьцааны мөнгө, бусад үнэ бүхий зүйлийг хүлээн авах”, 6 дахь хэсэгт “Барьцааны мөнгө, үнэ бүхий зүйлийг шилжүүлэх, буцаан олгох”, 7 дахь хэсэгт “Барьцааны мөнгө, үнэ бүхий зүйлийг улсын орлого болгох”-той холбоотой хэсгийг зохицуулжээ.¹⁹²

Энэхүү журамд дараах хэлбэрээр зохицуулжээ. Үүнд:

¹⁹² Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 03 дугаар тогтоолын хавсралт “Эд мөрийн баримт болон барьцааны мөнгө, бусад үнэ бүхий зүйлийг шийдвэрлэх журам” http://103.11.195.37/san/hr/table3_full/34

- Барьцааны мөнгө, үнэ бүхий зүйлийг Шүүхийн тамгын газрын даргын тушаалаар томилогдсон шүүхийн захиргааны ажилтан баримт үйлдэж хүлээн авах /5.1/
- Шүүхийн тусгай дансанд шилжүүлэх /5.2/
- Үнэ бүхий зүйлд чанарыг тодорхойлсон мэргэжлийн байгууллагын баталгааг заавал шаардах /5.3/
- Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу холбогдох этгээдэд барьцааны зүйлийг буцаан олгох, ийнхүү олгох/шилжүүлэхдээ хоёроос доошгүй хөндлөнгийн гэрч байлцуулах /6.1/
- Тусгай дансанд байршуулсан хугацааны хүүг шүүгчийн захирамжаар улсын орлого болгох /6.3/
- Барьцааны зүйлийг улсын орлогод шүүгчийн захирамжаар шилжүүлэх ажиллагааг Шүүхийн тамгын газрын дарга эрхлэн гүйцэтгэх /7.1/.

2017 оноос үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны явцад үйлдэх тэмдэглэлийн болон шийдвэрийн маягтыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална” гэж заасан ёсоор “барьцаа авах” таслан сэргийлэх арга хэмжээг шүүхээс хэрэгжүүлэх үеийн харилцааг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс журамлах боломжтой байж болохоор байна.

Хоёр.Гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт, онцлог

Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ нь зарим улсын эрүүгийн хууль тогтоомжид тусгагдсан байна. Тухайлбал, нийтлэг эрх зүйн тогтолцоонд /common law/ хамаарах АНУ, Англи, Уэлс, Шотланд, Ямаик зэрэг улсад мөрдөгч, прокурор, шүүхээс дуудсан цагт саадгүй ирж байх үүрэг хүлээлгэн барьцаа авахтай холбоотой асуудлыг дэлгэрэнгүй зохицуулжээ.

Үүнээс гадна иргэнлэг эрх зүйн тогтолцоонд /civil law/ хамаарах ОХУ¹⁹³, ХБНГУ¹⁹⁴, Япон¹⁹⁵, Чех¹⁹⁶ зэрэг улсад барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээг эрүүгийн процессын хуульд зохицуулжээ.

1.1. Иргэнлэг эрх зүйн тогтолцоотой орны зохицуулалт

Хүснэгт 2. ОХУ, ХБНГУ, Япон улс дахь барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээний онцлог

№	Улс	Хууль	Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээний нөхцөл
---	-----	-------	---

¹⁹³ Criminal-Procedural Code of the Russian Federation No. 174-Fz of December 18, 2001 <http://www.wipo.int/edocs/lexdocs/laws/en/ru/ru065en.pdf>

¹⁹⁴ The German Code of Criminal Procedure - 7 April 1987 https://www.gesetze-im-internet.de/englisch_stpo/englisch_stpo.html#p0952

¹⁹⁵ Japan - Code of Criminal Procedure (Act No. 131 of July 10, 1948, as amended in 2006) http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=214811

¹⁹⁶ Czech National Council. "Criminal Procedural Code of the Czech Republic, §73a (9)". Collection of the laws of the Czech Republic (in Czech). Prague. 141 (1961). Retrieved 14 July 2012. <https://portal.gov.cz/app/zakony/zakonPar.jsp?page=6&idBiblio=30139&recShow=100&n=141~2F1961&rpp=15#parCnt>

		тогтоомж	Зорилго	Барьцааны зүйл	Барьцааны төрөл, хэмжээ	Барьцааны зүйл буцаан олгох
1	ОХУ	Эрүүгийн процессын хууль, 98.5, 106	Мөрдөгч, прокурор, шүүхийн өмнө дуудсан цагт саадгүй ирж байх; шинээр гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх	Үнэт цаас, үнэ бүхий зүйл	Сэжигтэн, яллагдагчийн холбогдсон гэмт хэргийн шинж, хувийн байдал, барьцаа өгөгчийн эд хөрөнгийн байршлыг харгалзан тогтооно	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусах үед шүүхийн шатанд шүүгч шийдвэрлэнэ. Бусад үе шатанд прокурор, мөрдөгч шийдвэрлэнэ
2	ХБНГУ	Эрүүгийн процессын хууль, 116а	-	Бэлэн мөнгө, хувьцаа, бонд	Шүүгч тодорхойлно	-
3	Япон	Эрүүгийн процессын хууль, 88-98	Цагдан хоригдож буй яллагдагч дуудсан цагт саадгүй ирж байх	Бонд, үнэт цаас, бэлэн бус мөнгийг илэрхийлэх бусад этгээдийн бичгээр гаргасан баталгаа	Шүүгч тодорхойлно. Гэмт хэргийн шинж, нөхцөл, нотлох баримтын үнэ цэн, яллагдагчийн хөрөнгө, яллагдагчийн хувийн байдлыг харгалзана.	Шүүхийн шатанд цагдан хорих хугацаа дууссан үед
4	Чех	Эрүүгийн процессын хууль §73а (9)	31 төрлийн хүнд гэмт хэргийн яллагдагчид энэ арга хэмжээг хэрэгжүүлэхгүй /хүн амины хэрэг, бие махбодид гэмтэл учруулах, хүчиндэх, дээрэм, нийтийн аюулгүй байдалд хор учруулах г.м/		Шүүх хохирлыг барагдуулах шийдвэр гаргаж, хохирогч тал гурван сарын дотор гомдол гаргавал барьцааны зүйлийг буюу түүний хэсгийг хохирлыг нөхөн төлүүлэхэд ашиглаж болно. Үүнээс бусад тохиолдолд барьцааны зүйлийг буцаан олгоно.	

1.2. Нийтлэг эрх зүйн тогтолцоотой орны зохицуулалт

Хүснэгт 3. Нийтлэг эрх зүйн тогтолцоотой улс дахь барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээний онцлог

№	Улс	Хууль тогтоомж	Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээний нөхцөл		
			Зорилго/ Барьцааны зүйл	Барьцааны төрөл, хэмжээ	Барьцааны зүйл буцаан олгох

Commented [U1]: Хүснэгтийн толгойг "Барьцаа авах ТСАХ-г хэрэглэхийг хориглосон тохиолдол, ТСАХ-г цуцлах үндэслэлийн талаар" гэх байдлаар өөрчлөх

Хүснэгт 3. Нийтлэг эрх зүйн тогтолцоотой улс дахь барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээний онцлог

№	Улс	Хууль тогтоомж	Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээний нөхцөл		
			Зорилго/ Барьцааны зүйл	Барьцааны төрөл, хэмжээ	Барьцааны зүйл буцаан олгох
1	АНУ ¹⁹⁷	Барьцааны шинэтгэлийн хууль	Калифорни зэрэг олон мужид "барьцааны хуваарь" гаргаж, холбогдсон гэмт хэргийн төрөлтэй уялдуулсан барьцааны хэмжээний жагсаалтыг зөвлөмж болгодог. Барьцаа нь 1/ баталгаат бонд, 2/ баталгаа гаргах, 3/ барьцаагүй батлан даалт, 4/ батлан даалтын батламж, 5/ өмчийн бонд, 6/ цагаачлалын бонд, 7/ бэлэн мөнгө, 8/ урьдчилан сэргийлэх үйлчилгээ зэрэг төрөлтэй	Хүчирхийллийн гэмт хэрэг, бүх насаар хоригдох буюу цаазаар авах ялтай гэмт хэрэг, 10 жилээс дээш хорих ялтай мансууруулах бодисын гэмт хэрэг, давтан гэмт хэрэгт холбогдсон болон гэрчид хөндлөнгөөс нөлөөлөх зэргээр шүүн таслах үйл ажиллагааг доголдуулах эрсдэлтэй яллагдагчид тус арга хэмжээг хэрэглэхгүй.	
2	Англи, Уэлс ¹⁹⁸	Барьцаа авах арга хэмжээний хууль	Энэ арга хэмжээний зорилго нь шүүхийн дуудсан цагт ирэх үүрэг хүлээлгэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх, яллагдагч нь гэрчид нөлөөлөхөөс сэргийлэх, яллагдагчид өөрийгөө хамгаалах боломж олгох юм. Барьцаа өгөх таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн нь гэмт хэрэгт тооцогдохгүй ч яллагдагчийг баривчлах, шүүхэд авчрах нөхцөл болно.	Хуульд өөрөөр заагаагүй бол шүүгчийн зүгээс яллагдагчид барьцаа санал болгох үүрэгтэй. Хэрэв 1/ яллагдагч мэдүүлэг өгөхөөс татгалзах, хэргийн нотлох баримтыг өөрчлөх, 2/ цуглуулсан нотлох баримт яллагдагчид барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авахад тохиромжгүй бол энэ арга хэмжээг хэрэглэхгүй. Мөн А ангиллын хар тамхи хэрэглэсэн яллагдагчид хэрэглэхгүй	

Commented [U1]: Хүснэгтийн толгойг "Барьцаа авах ТСАХ-г хэрэглэхийг хориглосон тохиолдол, ТСАХ-г цуцлах үндэслэлийн талаар" гэх байдлаар өөрчлөх

¹⁹⁷ "Pre-trial Court Appearances in a Criminal Case". American Bar Association.

¹⁸ U.S. Code Chapter 207 - Release and Detention Pending Judicial Proceedings <https://www.law.cornell.edu/uscode/text/18/part-II/chapter-207>

¹⁹⁸ Dell, Susanne. "The Bail Act 1976". The British Journal of Criminology 17.2 (1977): 185-188. Academic Search Complete. Web.

UK - Criminal Justice Act 2003 <http://www.legislation.gov.uk/ukpga/2003/44/contents/enacted>

Хүснэгт 3. Нийтлэг эрх зүйн тогтолцоотой улс дахь барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээний онцлог

№	Улс	Хууль тогтоомж	Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээний нөхцөл		
			Зорилго/ Барьцааны зүйл	Барьцааны төрөл, хэмжээ	Барьцааны зүйл буцаан олгох
3	Шотланд ¹⁹⁹	Барьцаа, шүүхийн томилгооны хууль	Бүх төрлийн гэмт хэрэгт холбогдсон хүнд энэ арга хэмжээг хэрэглэж болно. Ингэхдээ, эрүүгийн хэргийн дээд шүүхээс барьцаа авах эсэхийг эцэслэн шийдвэрлэнэ	Хүчирхийлэл, бэлгийн гэмт хэрэг, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг болон тэдгээртэй ижил төрлийн бусад гэмт хэрэгт холбогдсон яллагдагчид барьцаа өгөхийг хязгаарлаж болно. Барьцаа өгөх арга хэмжээнээс татгалзсан бол энэ тухай яллагдагч давж заалдах боломжтой.	
4	Ямайка ²⁰⁰	Барьцаа авах арга хэмжээний хууль	1.Шинээр гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх 2.Бэлэн мөнгө, чек	1.400 мянган ямайка доллароос хэтрэхгүй байх /3217 ам.доллар/ 2. Барьцаалах арга хэмжээг үргэлжлүүлэх шаардлагагүй болсон.	

Commented [U1]: Хүснэгтийн толгойг “Барьцаа авах ТСАХ-г хэрэглэхийг хориглосон тохиолдол, ТСАХ-г цуцлах үндэслэлийн талаар” гэх байдлаар өөрчлөх

Гурав.Дүгнэлт

“Барьцаа авах” таслан сэргийлэх арга хэмжээний зорилгын хувьд:

“Барьцаа авах” таслан сэргийлэх арга хэмжээ нь эрх зүйн тогтолцооны ялгаанаас үл хамааран улс орнуудын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэгэн адил зорилготой байна. Тодруулбал, барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээний зорилго нь шүүхийн болон шүүхийн бус шатанд шүүгч, прокурор, мөрдөгчийн дуудсан цагт ирэх үүргийг яллагдагчид хүлээлгэх, яллагдагчийг дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх, гэрчид нөлөөлөхөөс сэргийлэх, яллагдагчид өөрийгөө хамгаалах боломж олгох юм.

Барьцааны зүйлийн хэмжээний хувьд:

ОХУ, Япон зэрэг улсад барьцааны зүйлд тодорхой хэмжээ дурдахгүйгээр яллагдагчийн холбогдсон гэмт хэргийн шинж, хувийн байдал, барьцаа өгөгчийн эд хөрөнгийн байдал, нотлох баримтын үнэ цэнг харгалзан тогтоох нөхцөл нийтлэг байна.

¹⁹⁹ Scottish Parliament. Bail, Judicial Appointments etc. (Scotland) Act 2000 as amended [www.legislation.gov.uk](http://www.legislation.gov.uk/CriminalProceedings.etc.(Reform)(Scotland)Act2007)

²⁰⁰ Jamaica - The Bail Act, 2001 http://moj.gov.jm/sites/default/files/laws/Bail%20Act_0.pdf

АНУ-ын хувьд барьцааны зүйлийн хэмжээг холбогдсон гэмт хэрэгтэй уялдуулан зөвлөмж хэлбэрээр тодорхойлжээ. Ямаик улсын хувьд барьцааны зүйлийн дээд хэмжээг тодорхойлсон онцлогтой байна.

“Барьцаа авах” таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхгүй байх нөхцөлийн хувьд:

Харин ямар гэмт хэрэгт буруутгагдаж буйгаар нь яллагдагчид барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэх талаар харилцан адилгүй байна.

Тухайлбал, АНУ-д хүчирхийллийн гэмт хэрэг, бүх насаар хоригдох буюу цаазаар авах ялтай гэмт хэрэг, 10 жилээс дээш хорих ялтай мансууруулах бодисын гэмт хэрэг, давтан гэмт хэрэгт холбогдсон болон гэрчид хөндлөнгөөс нөлөөлөх зэргээр шүүн таслах үйл ажиллагааг доголдуулах эрсдэлтэй яллагдагчид тус арга хэмжээг хэрэглэхгүй.

Англи, Уэлсийн хувьд яллагдагч мэдүүлэг өгөхөөс татгалзах, хэргийн нотлох баримтыг өөрчлөх, цуглуулсан нотлох баримтын хэмжээ, хамаарал нь яллагдагчид барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авахад тохиромжгүй бол энэ арга хэмжээг хэрэглэхгүй. Мөн А ангиллын хар тамхи хэрэглэсэн яллагдагчид хэрэглэхгүй. Шотландын хувьд хүчирхийлэл, бэлгийн гэмт хэрэг, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг болон тэдгээртэй ижил төрлийн бусад гэмт хэрэгт холбогдсон яллагдагчид барьцаа өгөхийг хязгаарлаж болохоор зохицуулжээ.

Япон улсын хувьд Эрүүгийн процессын хуулийн 89 дүгээр зүйлд нь заасан ёсоор яллагдагч 1/ цаазаар авах буюу бүх насаар нь хорих ялтай, нэг жилээс багагүй хугацаагаар хорих ялтай гэмт хэрэг, 2/ арван жил хүртэл хорих ялтай гэмт хэрэг, 3/ гурван жилээс дээш хугацаагаар хорих ялтай хэрэгт буруутгагдсан, 4/ яллагдагч нотлох баримтыг нуун дарагдуулах буюу устгах эрсдэлтэй, 5/ яллагдагч нь хохирогч, гэрч буюу түүний төрөл садангийн хүнд бие махбодийн болон эд хөрөнгийн хохирол учруулж болзошгүй бодит эрсдэлтэй, 6/ яллагдагчийн нэр, оршин суугаа газар тодорхой бус бол барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байхаар зохицуулсан.

Чех улсын хувьд хүн амины хэрэг, бие махбодод гэмтэл учруулах, хүчиндэх, дээрэмдэх, нийтийн аюулгүй байдалд хор учруулах зэрэг 31 төрлийн хүнд гэмт хэргийн яллагдагчид энэ арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байхаар тусгажээ.

Барьцааны зүйл буцаан олгохын хувьд:

Барьцааны зүйлийг буцаан олгох асуудлыг дараах хэлбэрээр шийдвэрлэхээр холбогдох улсын хувьд зохицуулсан байна. Үүнд:

- эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусах үед шүүхийн шатанд шүүгч шийдвэрлэх, бусад үе шатанд прокурор, мөрдөгч шийдвэрлэх /ОХУ/,
- шүүхийн шатанд цагдан хорих хугацаа дууссан үед /Япон/,
- шүүхийн шийдвэр гарснаас хойш 3 сарын дараа /Чех/,
- барьцаалах арга хэмжээг үргэлжлүүлэх шаардлагагүй болсон /Ямаик/.

Монгол Улсын хувьд:

Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ нь Монгол Улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны түүхэн уламжлалтай юм. Тодруулбал, тус таслан сэргийлэх арга хэмжээг авахдаа яллагдагчийг шүүх, прокурорын дуудсан цагт ирэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх үүрэг хүлээлгэх бөгөөд барьцааны зүйл нь мөнгө байна.

Харин барьцааны зүйлийн дээд, доод хэмжээг хуульчлаагүй бөгөөд яллагдагчийн холбогдсон гэмт хэргийн шинж, хувийн байдлыг харгалзахаар тусгажээ. Мөн эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгосон, эсхүл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон бол барьцааны зүйлийг буцаан олгох/шилжүүлэхээр хуульчилжээ.

Дээр дурдсан зүйлстэй уялдуулан 2017 оноос үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны явцад үйлдэх тэмдэглэлийн болон шийдвэрийн маягтыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална” гэж заасан ёсоор “барьцаа авах” таслан сэргийлэх арга хэмжээг шүүхээс хэрэгжүүлэх үеийн харилцааг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс журамлах, энэ хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2014.01.10-ны өдрийн “Эд мөрийн баримт болон барьцааны мөнгө, үнэ бүхий зүйлийг шийдвэрлэх журам батлах тухай” 03 дугаар тогтоолыг шинэчлэн батлах боломжтой байна.


Дөрөв.Санал

Дээр дурдсан дүгнэлтийн дагуу Монгол Улсын нөхцөлд прокурор, шүүхээс яллагдагчид мөнгөн хэлбэрээр барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авахтай холбоотой дараах асуудлыг журамлах нь зүйтэй байна. Үүнд:

- Яллагдагчид мөнгөн хэлбэрээр барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээг прокурор авахтай холбоотой харилцааг Улсын Ерөнхий прокурорын тушаалаар, шүүх авахтай холбоотой харилцааг Шүүхийн ерөнхий зөвлөлийн тушаалаар зохицуулах;
- Шүүхээс яллагдагчид мөнгөн хэлбэрээр барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авахад барьцааны мөнгөний дээд хэмжээг гэмт хэргийн төрөл буюу ял шийтгэлийн хэмжээ тус бүрээр зөвлөмж хэлбэрээр тогтоох;
- Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх эсэхийг тогтоохдоо яллагдагч нь гэрч, шүүн таслах үйл ажиллагааны бусад оролцогчид нөлөөлөх эсэх, нотлох баримтыг өөрчлөх, устгах эсэх, цугларсан нотлох баримт тус таслан сэргийлэх арга хэмжээ авахад тохиромжтой эсэхийг харгалзахыг зөвлөмж хэлбэрээр тогтоох;
- Үүнээс гадна барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхгүй байх нөхцөлийг гэмт хэргийн төрөл /хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, авлигын гэмт хэрэг, хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг/ буюу ял шийтгэлийн хэмжээ тус бүрээр зөвлөмж хэлбэрээр тогтоох.

ТӨРИЙН АЛБАН ХААГЧ АЖИЛ, АЛБАН ТУШААЛААС ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР ЧӨЛӨӨЛӨГДСӨНТЭЙ ХОЛБООТОЙ ХОХИРОЛ УЧИРСАН БАЙДАЛ²⁰¹

2012-2017 оны байдлаар захиргааны хэргийн анхан шатны шүүх ажил, албан тушаалаас үндэслэлгүй халагдсантай холбоотой нийт 1314 маргаан хянан шийдвэрлэжээ. Энэ нь анхан шатны шүүхээс шийдвэрлэж буй төрийн албаны маргааны 62.4% болж байна. Үүнийг дараах графикт харуулав.



Дээрх графикаас харахад, нэг жилийн хугацаанд ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөнтэй холбоотой **маргааны тоо багадаа 78, ихдээ 465 буюу дунджаар 219** байна.

Шүүхийн статистикийн маягтад ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөнтэй холбоотой учирсан хохирлын талаар байхгүй тул, шүүхийн шийдвэрийн цахим сангаас /shuukh.mn/ сүүлийн 3 жилийн хугацаанд /2016-2018/ яамны төрийн нарийн бичгийн дарга хариуцагчаар татагдаж, төрийн албан хаагчийн нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг түүвэрлэн авч судлав.

Хүснэгт 1. Яамны төрийн нарийн бичгийн дарга хариуцагчаар татагдаж, төрийн албан хаагчийн нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн тоо, 2016-2018

Хариуцагч-ТНБД/	Анхан шатны шүүхээс шийдвэрлэсэн ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөнтэй холбоотой маргааны тоо, 2016-2018 он		
	2016	2017	2018
ТНБД-БОЯ	1	1	1
ТНБД-ГХЯ	1	-	1
ТНБД-ХЗДХЯ	-	1	1
ТНБД-ХХАХҮЯ	1	3	-
ТНБД-БХБЯ	-	1	-
ТНБД-БСШУЯ	1	1	1
ТНБД-ЗТХЯ	-	1	-
ТНБД-УУХҮЯ	-	1	-
ТНБД-ХНХЯ	-	-	1
ТНБД-ЭХЯ	-	1	-
ТНБД-ЭМЯ	-	1	-

²⁰¹ Энэхүү лавлагааг Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судлаач Л.Галбаатар бэлтгэв. 2018.10.02

Дээрх хүснэгтээс харахад, 13 яамны 11 яам буюу Сангийн яам, Батлан хамгаалах яамнаас бусад яамдын төрийн нарийн бичгийн даргын зүгээс төрийн албан хаагчийг үндэслэлгүйгээр чөлөөлж, хохирол учруулсан байна.

Төрийн албан хаагчид учирсан хохирлын хувьд, шүүхээс ажилгүй байсан хугацааны цалин хөлстэй тэнцэх олговрыг /мөн нэмэгдэл, нэг удаагийн буцалтгүй тусламж хамаарна/ хариуцагчаас гаргуулахаар болон эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөхийг хариуцагчид даалган шийдвэрлэж байна.

2016-2018 онд яамдын төрийн нарийн бичгийн дарга нарын зүгээс төрийн албан хаагчийг үндэслэлгүйгээр чөлөөлж нийт 184,055,749 /нэг зуун наян дөрвөн сая тавин таван мянга долоон зуун дөчин есөн төгрөг/ төгрөгийн хохирол учруулжээ. Эндээс харахад, 2016-2018 онд нэг яамны төрийн нарийн бичгийн дарга дунджаар 11,503,484 төгрөгийн хохирол учруулж байна.

Ингэхдээ төрийн албан хаагчийг багадаа 1 сар 14 хоног, ихдээ 36 сар 18 хоног, дунджаар 400 хоног буюу 13.3 сарын хугацаанд ажилгүй байлгажээ. Үүнийг дараах хүснэгтэд харуулав.



Хүснэгт 2. Төрийн албан хаагч үндэслэлгүй халагдсантай холбоотой учирсан хохирол, 2016-2018

№	Хохирлын төрөл	Хамрах хугацаа	Хохирлын хэмжээ /төг/	Хохирсон байдал	Нэхэмжлэгч	Хариуцагч	Хохирлын талаарх шийдвэр
1	цалин хөлстэй тэнцэх олговор	7 сар 15 хоног	9,325,803.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан тушаалаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн	Д.Б	ТНБД-БСШУЯ	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018.04.02-ны өдрийн 207 дугаар шийдвэр
2	цалин хөлстэй тэнцэх олговор	36 сар 18 хоног	41,356,033	Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын Импортын бодлого евразийн эдийн засгийн комисс хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн	Б.Д	ТНБД-ГХЯ	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018.01.18-ны өдрийн 34 дүгээр шийдвэр
3	цалин хөлстэй тэнцэх олговор	16 сар 8 хоног	13,329,612.	Баянгол дүүргийн дотоод аудитын албанд мэргэжилтний албан тушаалаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн	Г.З	ТНБД-ХНХЯ	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018.01.18-ны өдрийн 32 дугаар шийдвэр
4	цалин хөлстэй тэнцэх олговор; нэг удаагийн буцалтгүй тусламж	9 сар	33,071,097.	Барилга, хот байгуулалтын яамнаас үндэслэлгүйгээр чөлөөлөгдсөн	Н.Т	ТНБД-БХБЯ	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017.11.14-ний өдрийн 840 дүгээр шийдвэр
5	цалин хөлстэй тэнцэх олговор	30 сар 4 хоног	14,567,668.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас үндэслэлгүйгээр чөлөөлөгдсөн	Р.Э	ТНБД-ХХАХУЯ	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017.06.12-ны өдрийн 459 дүгээр шийдвэр

6	цалин хөлстэй тэнцэх олговор	30 сар 4 хоног	12,817,768.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас үндэслэлгүйгээр чөлөөлөгдсөн	Б.М	ТНБД-ХХАХҮЯ	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017.06.12-ны өдрийн 459 дүгээр шийдвэр
7	цалин хөлстэй тэнцэх олговор; нэмэгдэл	6 сар 6 хоног	9,292,140.	Эрчим хүчний яамнаас үндэслэлгүйгээр чөлөөлөгдсөн	Ж.М	ТНБД-ЭХЯ	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017.06.16-ны өдрийн 483 дугаар шийдвэр
8	цалин хөлстэй тэнцэх олговор	4 сар 4 хоног	4,270,639.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын Санхүүгийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалаас үндэслэлгүйгээр чөлөөлөгдсөн	П.Э	ТНБД-ХХАХҮЯ	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017.05.10-ны өдрийн 352 дугаар шийдвэр
9	цалин хөлстэй тэнцэх олговор	7 сар 3 хоног	6,009,304.	Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стандарт, нормативын хэлтсийн Салбарын техник, технологи, инноваци хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалаас үндэслэлгүйгээр чөлөөлөгдсөн	Н.Б	ТНБД-ЗТХЯ	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017.03.14-ний өдрийн 181 дүгээр шийдвэр
10	цалин хөлстэй тэнцэх олговор	6 сар 9 хоног	4,044,245.	Уул, уурхай хүнд үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалаас үндэслэлгүйгээр чөлөөлөгдсөн	Д.Ж	ТНБД-УУХҮЯ	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017.02.23-ны өдрийн 147 дугаар шийдвэр
11	цалин хөлстэй тэнцэх олговор	1 сар 14 хоног	2,731,800.	Эрүүл мэндийн яамны Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газрын даргын албан тушаалаас үндэслэлгүйгээр чөлөөлөгдсөн	С.Т	ТНБД-ЭМЯ	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017.02.21-ний өдрийн 137 дугаар шийдвэр

12	цалин хөлстэй тэнцэх олговор	6 сар 5 хоног	6,825,142.	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалаас үндэслэлгүйгээр чөлөөлөгдсөн	Д.У	ТНБД-ХЗДХЯ	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017.02.21-ний өдрийн 138 дугаар шийдвэр
13	цалин хөлстэй тэнцэх олговор	-	1,631,834.	Соёл, шинжлэх ухаан, биеийн тамир, спортын салбарын тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн төлөвлөлт, зохицуулалт хариуцсан мэргэжилтний албан тушаалаас үндэслэлгүйгээр чөлөөлөгдсөн	М.Н	ТНБД-БСШУЯ	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017.01.12-ны өдрийн 34 дүгээр шийдвэр
14	цалин хөлстэй тэнцэх олговор	3 сар 20 хоног	4,688,138.	Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтэст нягтлан бодогч албан тушаалаас үндэслэлгүйгээр чөлөөлөгдсөн	Д.Л	ТНБД-ГХЯ	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016.11.30-ны өдрийн 988 дугаар шийдвэр
15	цалин хөлстэй тэнцэх олговор	-	14,218,646.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас үндэслэлгүйгээр чөлөөлөгдсөн	П.У	ТНБД-ХХАХҮЯ	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016.11.17-ны өдрийн 935 дугаар шийдвэр
16	цалин хөлстэй тэнцэх олговор	22 сар 3 хоног	14,644,177.	Ойн үрийн аж ахуй, тарьц суулгацын хангамж, ногоон байгууламжийн удирдлага зохицуулалт хариуцсан мэргэжилтний албан тушаалаас үндэслэлгүйгээр чөлөөлөгдсөн	Ч.М	ТНБД-БОЯ	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016.11.07-ны өдрийн 887 дугаар шийдвэр
17	цалин хөлстэй тэнцэх олговор	-	32,587,736.	Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан тушаалаас үндэслэлгүйгээр чөлөөлөгдсөн	Ц.Б	ТНБД-БСШУЯ	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016.07.05-ны өдрийн 495 дугаар шийдвэр